



СЭТГҮҮЛЧИД ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ...

Улаанбаатар хот 2003 он.

Гарчиг

Өмнөх үг 4

**Хэсэг 1. НҮБХЭДКГ-ын дэмжлэгтэйгээр
Глоб Интернэйшнл төрийн бус байгууллагаас
зохион байгуулсан “Хүний эрх” сонины аяны
явцад төвийн хэвлэлд нийтлэгдсэн нийтлэлүүд**

Өдрийн сонин

1.1 Хүүхэд хил дамжуулан худалдаж байна уу, <i>Э.Энэрэл</i>	5
1.2 Ээж ээ, би гэрээ цэвэрлээд л гэртээ байна. Таныг дагаж байхгүй. Намайг битгий солиоч, <i>Э.Энэрэл</i>	6
1.3 Бодоцгооё, <i>Э.Энэрэл</i>	10
1.4 Алганы хонхор хазахтай адил боломж, <i>Б.Золбаяр</i>	11
1.5 Ялгаа, <i>Б.Золбаяр</i>	12
1.6 Суугаа ба босоог ялгах хэрэгтэй, <i>Б.Золбаяр</i>	13

Зууны мэдээ

1.7 Гэмт хэрэгтэн ч гэсэн эдлэх эрхтэй, <i>А.Тунгалаг</i>	14
1.8 Ээжээ би жаахан тоглоё л доо, <i>А.Тунгалаг</i>	16
1.9 Жаргалтай газар хүн тогтдоггүй, <i>А.Тунгалаг</i>	17
1.10 Үүргээ умартсан эрх, <i>Д.Түмэнжаргал</i>	19
1.11 Sexual harassment, <i>Д.Түмэнжаргал</i>	20
1.12 Намайг тайван байлгаач..., <i>Д.Түмэнжаргал</i>	22

Монголын мэдээ

1.13 Хүн хог новш мэт амьдарч хог новш мэт үхэх ёстой гэж үү, <i>З.Мэндсайхан</i>	22
1.14 Цагаачилна гэдэг эх орноо орхино гэсэн үг биш, <i>З.Мэндсайхан</i>	25
1.15 Би үхмээргүй байна, <i>З.Мэндсайхан</i> ,	27
1.16 Нийслэлдээ ирж суурьшина гэдэг, гадаадад явж амьдрахаас хэцүү болжээ. <i>Г.Жамъян</i>	30
1.17 Үндсэн хуульд байхгүй “давуу эрх” буюу дарга нарын даварсан эрх, <i>Г.Жамъян</i> ,	32
1.18 Арван нэгэн даргын өргөдлийн хувь заяа хэрхэн шийдэгдэх бол? <i>Г.Жамъян</i> ,	34

Үнэн

1.19 Эсэргүүцсэн нь нотлогдоогүй л бол хүчингийн хэрэг биш гэж үү, <i>Б.Батзаяа</i>	35
1.20 Үрчлүүлэх нэрийдлээр өндөр үнээр хүүхдээ худалджээ, <i>Б.Батзаяа</i>	36
1.21 50 мянган төгрөгөнд хазаарлагдсан эрх, <i>Б.Батзаяа</i>	39
1.22 Зарлалд “дарлагдсан” хүний эрх, <i>Ш.Батболд</i>	40
1.23 Кондуктор аа, би нэгжүүлмээргүй байна, <i>Ш.Батболд</i>	41
1.24 Хориотой “тоглоом”, <i>Ш.Батболд</i>	43

Өнөөдөр

1.25 Хилсээр хорихоо хэзээ болих бол?, <i>А.Баасандорж</i>	44
1.26 “Сонгогдох”-ыг байг гэхэд сонгох эрхийг нь эдлүүлье, <i>А.Баасандорж</i> ,	46
1.27 Би аюулгүй орчинд амьдармаар байна, <i>А.Баасандорж</i>	47
1.28 “Эр цэргийн албанаас эсэн мэнд ирээрэй”, <i>А.Баасандорж</i>	49
1.29 “Зохиогчийн эрхийг зөрчсөөр л байх уу?”, <i>А.Баасандорж</i>	50

1.30 “Хуулиас дээгүүр эрх гэж байдаггүй”, <i>А.Баасандорж</i>	51
---	----

Улаанбаатар таймс

1.31 Чамлахаар чанга атга, юун хүний эрх..., <i>С.Сосор</i>	52
1.32 Авьяасыг үнэлж авьяастнаа хүндэлж чаддаг бил үү, бид?, <i>С.Сосор</i>	53
1.33 Дутуу баяр, дундуур сэтгэлтэй хүүхдүүд ..., <i>С.Сосор</i>	54
1.34 “Харьд үрчлүүлсэн хүүхдийн заяа хаашаа эргэх бол?”, <i>Д.Цээпилмаа</i>	56
1.35 “Нас өндөрсөх тусам хүний эрх гортигт орж хязгаарлагддаг”, <i>Д.Цээпилмаа</i>	57
1.36 “Даатгалгүй, мөнгөгүй хүмүүст эмнэлэг даанч хол”, <i>Д.Цээпилмаа</i>	58

Хэсэг 2. Английн Хүүхдийг Ивээх Сан, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илчилж, хүчирхийллийг зогсооё” төслийн хүрээнд сонинуудад хэвлэгдсэн нийтлэлүүд

2.1. Сургууль баяр баясгалангийн газар л байх ёстой. , <i>А.Баасандорж</i>	60
2.2. Сурагчдынхаа тал хувийг цагаан хуудастай төгсгөсөн багшид хүлээлгэх хариуцлага байхгүй гэж үү? , <i>Д.Цээпилмаа</i>	61
2.3. Үглэж зэмлэх нь хүүхдэд хүчирхийлэл болдгийг та мэдэх үү?, <i>Д.Цээпилмаа</i>	63
2.4 Хаалга тогших, хонх дуугарах бүрийд хүүхдүүд орон доор нуугддаг, <i>Д.Цээпилмаа</i>	65

Хэсэг 3. Өдөр тутмын сонинуудад хэвлэгдсэн хүний эрхийн асуудлыг хөндсөн зарим нийтлэлүүд

3.1 Д. Пунцаг: Эвлэрэл манай эрүүгийн хуульд цоо шинээр орж ирсэн, <i>Ш. Сүхбаатар</i>	68
3.2 Хотод шилжин ирэгсдийг хураамжаас чөлөөлөх зөвлөмжийг Хүний Эрхийн Комисс нийслэлийн удирдлагад хүргүүлжээ, <i>С.Гантуул</i>	69
3.3 Ч.Эрдэнэ-Очир: Цаазлах ял сонсох бүртээ бараг л ухаан алддаг байлаа, <i>Г.Жамъян</i>	71
3.4 Хилсээр нэг жил хоригдсон хүнд сая төгрөг олголоо, <i>У.Саран</i>	75
3.5 Чи хэргээ хүлээсэн ч, эс хүлээсэн ч таван метр цементэн цооногийн ёроолд л үхнэ, <i>Н.Энхбаатар</i>	76
3.6 Г.Отгонбямбаа: Намайг С.Зоригийг хөнөөсөн хэрэгт сэжиглэх хорьж, амьдралыг минь алдуулсан, <i>Э.Тэнгэр</i>	79
3.7 Албан тушаалаа урвуулан ашигласан хэргийг хэн хэрэгсэхгүй болгодог вэ? /УЕПГ-аас судалгаа хийжээ/, <i>Р.Мөнхбат</i>	80
3.8 Төр, иргэн хоёрын харилцааны тухай монголын иргэдийн бодол санаа /социологийн судалганы дүн/, <i>Б.Батчулуун</i>	82
3.9 Монголын шоронд байгаа хоригдлууд албан хаагчдын зодуурт тарчилдаг, <i>Б.Энхзаяа</i>	86

Хэсэг 4. Хавсралт

4.1 Хүний эрхийн түгээмэл тунхаглал	91
4.2 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	91
4.3 Монгол Улсын Үндсэн хууль	91
4.4 Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	91
4.5 Иргэний хуулийн “7”, “392” дугаар зүйлийг хэрэглэх тухай Улсын Дээд шүүхийн зөвлөмж	92
4.6 Чөлөөт хэвлэлийн дүрэм /Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний хороо/	95
4.7 Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах олон улсын байгууллагууд	96
4.8 Сэтгүүлчдийн баримтлах зарчим	98

ӨМНӨХ ҮГ

Хүний Эрхийн Үндэсний Комисс нь хуулиар хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих чиг үүргийнхээ дагуу хэвлэл мэдээллийн байгууллагуудтай идэвхитэй хамтран ажилладаг.

Энэхүү номыг хэвлүүлэх санаачлагыг Хүний Эрхийн Үндэсний Комиссоос дэмжсэн явдал нь нийгэмд оршиж буй хүний эрхийн хурц асуудал болон зөрчлүүдийг нээн илрүүлж, тэдгээрт олон нийт, улс төрчид, төрийн албан тушаалтнуудын анхаарлыг хандуулахад сэтгүүлчдийн оруулах хувь нэмрийг өсгөх, энэ талаар тэдний ажлыг дэмжин урамшуулахад чиглэгдэж буй болно.

Тус ном нь дөрвөн үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын дэмжлэгтэйгээр Глоб Интернэйшнл төрийн бус байгууллагаас “Хэвлэл мэдээллийн аян хэрхэн явуулах вэ” төслийн хүрээнд зохион байгуулсан “Хүний эрх” сонины аяны явцад төвийн хэвлэлд нийтлэгдсэн 36 нийтлэл
- Английн Хүүхдийг Ивээх Сан, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илчилж, хүчирхийллийг зогсооё” төслийн хүрээнд орон нутгийн сонинуудад хэвлэгдсэн зарим нийтлэлүүд
- Өдөр тутмын сонингуудад хэвлэгдсэн хүний эрхийн хурц асуудлыг хөндсөн зарим нийтлэлүүд
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой олон улсын болон үндэсний эрх зүйн бичиг баримтуудаас бүрдсэн хавсралт орж байна.

Сэтгүүлчид хүний эрхийг хамгаалах, сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь тэд цаг ямагт олон нийтийн нүд, чих байдаг. Үнэн зөв, ил тод мэдээлэл нь нийгмийг эрүүлжүүлэх, тунгалаг байлгахад зөвхөн эерэгээр нөлөөлдөг. Тиймээс сэтгүүлчдийн бодол санаа, үзэгний үзүүрийг хүний эрхийн асуудлаар байнга хурцалж байхыг Хүний Эрхийн Үндэсний Комисс цаашид хичээх болно.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

1.1 ХҮҮХЭД ХИЛ ДАМНУУЛАН ХУДАЛДАЖ БАЙНА УУ*Э.Энэрэл**Өдрийн сонин, 2002.12.19, №308 /1181/*

Хүн ер нь сонин амьтан . Түүхэн хөгжлийнхөө явцад нэг нь нэгийгээ боолчилж , адилхан л гар хөлтэй, ижилхэн нэг бөндгөртэй атлаа эд бараа шиг зарж , наймаалцаж байсан нь бий. Нэгэн үед хүний наймаа ид хүчээ аван хөгжиж байсан бөгөөд боолчуудыг хүч тэнхээтэйгээс нь эхлээд үс, шүдийг нь хүртэл шалган үнэ хаялцаж авч байсныг бид кино, номноос зөндөө л харж, уншиж байсан даа. Энэхүү хүн наймаалах, боолчлох явдлыг үгүй болгож чадсанаар хүчээ авсан хүний эрхийн ёс зүйд энэ явдал хамгийн тэсвэрлэшгүй зүйл. Гэвч хүний эрхийг дээдэлсэн шинэ зуунд хүнийг худалдах, наймаалах явдал байсаар байгаа билээ. Ялангуяа хүүхдийг худалдах явдал. Хамгийн сүүлчийн дэлхийг дэлдийлгэсэн жишээ гэхэд америк бүсгүй төрүүлсэн ихэр охидоо интернэтээр “үрчлүүлнэ” хэмээн зарлаад санаанд оромгүй их үнээр Английн гэр бүлд зарсан билээ. Гэхдээ нутаг нэгтэн нэг айлд өмнө нь арай багахан мөнгөөр хүүхдүүдээ зарсан байсан бүсгүй шуналаасаа болж наймаа буцсан нь хэрэг зарга болж, хүний эрхийн байгууллагуудын анхаарлыг татсан. Юутай ч багагүй хугацаанд сонин хэвлэлийн хуудаснаа байнга зураг нь тавигдаж байсан бөөрөнхий хар нүдтэй охид асрамжийн газар очиж, нэлээд мөнгөөр хүүхэдтэй болох шахсан гэр бүлийнхэн энэ дэлхийн хамгийн муу хүмүүс болж зарга дууссан. Ийм явдал дэлхийн өнцөг булан бүрт ил биш ч байнга явагдсаар байдгийн тод жишээ энэ билээ. Тэгвэл хаа газрын муу зүйлсээс хоцрохгүй байгаа Монголд энэ байдал ямар байна вэ? Аз болоход одоогоор манайд ийм гэмт хэрэг илрээгүй байгаа ажээ. Гэхдээ ийм төрлийн хэрэг гарах нөхцөл нь бүрдсэн хэмээн хүний эрхийн байгууллагын шинжээчид үздэг байна. Хүүхэд худалдах гэмт хэрэгт хамгийн түрүүнд өртөх магадлалтай хэсэгт биеэ үнэлэгч охид ордог байна. Насанд хүрээгүй биеэ үнэлэгчдийн хувьд хэсэг бүлэг хүмүүс ашиг хонжоо олох зорилгоор ашигладаг бөгөөд нэмүүхэн ашгийн төлөө тэднийг хил давуулан худалдаж байгааг ч үгүйсгэх аргагүй юм. Хүний эрхийн шинжээчдийн хийсэн судалгаагаар 10-22 насны 16 эмэгтэйн 12 нь бусдын хүчинд автан биеэ үнэлдэг болсон гэдэг нь тогтоогджээ.

Тэгэхээр тэд хүчинд автан бусдад худалдагдаж, эрх чөлөө хүний эрх нь бусдын уланд гишгэгдэх нь ойлгомжтой байгаа биз ээ. Мөн энэ бүлгийн хүмүүсээс гадна үрчлэгдэх нэрийн дор хил дамнуулан хүүхдийг худалдах явдал гарч байгааг цагдаа, хуулийн байгууллагууд болон хүүхэд асрах байгууллагын ажилтнууд үгүйсгэхгүй байгаа явдал юм. Хэдийгээр тэдэн настай тэр гэдэг хүүхдийг тэндэхийн иргэн үрчилж аваад бусдад худалдсан гэсэн хэрэг илрээгүй ч ийм тохиолдол байж болохыг үнэндээ үгүйсгэх аргагүй юмаа. Гадаадын иргэдэд хүүхэд үрчлүүлэх асуудлыг 1999 онд батлагдсан тусгай журмын дагуу Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн алба шийдвэрлэх болжээ. Өөрөөр хэлбэл 1999 оноос эхлэн монгол хүүхэд хуулийн дагуу гадаадын гэр бүлд өсөн торних болсон гэсэн үг.

Тэр цагаас хойш энэ оны наймдугаар сар хүртэл 38 монгол хүүхэд харийн аав, ээжтэй болжээ. Ихэвчлэн АНУ, Герман , Японы иргэд хүүхэд үрчлэн авах хүсэлт тавьдаг бөгөөд 80 хувь нь 0-3 насны хүүхэд байдаг байна. Уг нь зөвшөөрлөө аваад үр хүүхдээ аваад нутаг буцсан ч тэдгээр харийнхан хүүхдийн бие , амьдрал ахуй нь ямар байгаа талаар байнга мэдэгдэх ёстой байдаг аж. Энэ нь нас насны хувьд өөр. Тухайлбал 0-3 насны хүүхдийг хагас жилд, 4-8 настаныг нэг жилд, 8-16 насны хүүхдийн талаар хоёр жилд нэг удаа Хүүхэд үрчлэлтийн алба, ХНХЯ, ИБМТ-д болон эцэг эхэд нь мэдэгдэж байх ёстой байдаг. Гэвч журам ёсоор байнга мэдэгдэж байгаа нь ховор учраас тэдгээр хүүхдүүд хүн худалдаалах явдалд өртсөн байхыг үгүйсгэж болохгүй байгаа юм.

Уг нь ийм маягаар үрчлэгдсэн хүүхэд 16 нас хүрээд харьяалалаа өөрөө сонгох эрхтэй байдаг ч худалдагдсан бол энэ эрхээ эдэлж чадахгүй билээ. Харийнханд хүүхэд

үрчлүүлэхдээ эцэг, эхийн бие махбод, сэтгэл мэдрэлийн хувьд эрүүл, эрүүгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй тэрч байтугай санхүүгийн чадавхийг нь ч харгалзан үздэг ч баримт бүртгэлээрээ “сайн” хүн уг ажиллагаанд орсон байх талтай билээ. Ээж, аавгүй өнчин жаалууд элэг бүтэн, өмсөх идэхээр дутахгүй ертөнцийн нэгэн өнцөгт монгол цустайгаа мэдрэн амьдрахад болохгүй гэх газаргүй ч олон зууны уламжлалтай хүн худалдаалах наймааны золиос болоод байвал дэндүү эмгэнэлтэй. 2001 онд шинэчлэгдэж, харьцангуй боловсронгуй болсон гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журам ёсоор үрчлэгч этгээд хүүхдийг ашиг олох зорилгоор бус үрчлэх ёстой гэдэг ч үүнийг хянах арга зам бидэнд алга. Тэгэхээр энэ асуудалд хэрхэн яаж хандвал дээр билээ? За яахав, дандаа хүүхдийн заяа дутсан амьдралаа монгол хүүхдээр тэгшитгэх гэсэн сайн хүмүүс тааралдаж байсан гэж бодъё. Тэгвэл насанд хүрээгүй хүүхдийг хилийн чанад уруу дагуулж яваад ирэхдээ хамт ирсэн эсэхийг нь шалгадаг механизм үгүй шүү дээ. ХБНГУ-д суралцдаг үеэл эгч маань охиноо санаад танилаараа хүүхдээ түр хугацаагаар авахуулсан юм. Харин өнөөх хүнийг нь хилээр буцан орж ирэхэд дагуулж явсан хүүхэд чинь хаана байна гэж хэн ч асуугаагүй гэнэ лээ.

Монгол улсын эрүүгийн хуулийн “хүн худалдах, худалдан авах” 113 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дугаарт “Насанд хүрээгүй хүнийг худалдсан бол 5-аас дээш 10 хүртлэх жилийн хугацаагаар хорих ял шийтгэхээр” заасан байдаг. Хэдийгээр манай улсад хүүхэд худалдсан гэмт хэрэг илрээгүй ч гарах нөхцөл нь бэлэн байгаа гэдгийг хэн хүнгүй бодох л хэрэгтэй байхаа.

1.2 ЭЭЖЭЭ, БИ ГЭРЭЭ ЦЭВЭРЛЭЭД Л ГЭРТЭЭ БАЙНА. ТАНЫГ ДАГАЖ БАЙХГҮЙ. НАМАЙГ БИТГИЙ СОЛИОЧ

Э. Энэрэл

Өдрийн сонин, 2003.01.04, №003 /1192/

Сүүлдээ намайг хоёр хүүхдээ хоёуланг нь ав гэхээр нь би зөвшөөрсөн. Тэгээд өнгөрсөн арванхоёрдугаар сарын таванд би хоёр охинтой болох дөхсөн. Гэтэл тэд намайг телевизийн нэвтрүүлгээр хүүхдүүд солигдсон нь үнэн, Уранзаяа төрөлхийн өвчтэй хүүхэд, хоёр хүүхэдтэй болсондоо баяртай байна гэсэн зүйл ярих болзол тавьсан.

Төрөх газар хүүхдүүд солигдсон тухай Солонгосын киног зүрх шимшрэн үзэж байсан Монголчууд өнгөрсөн намраас эхлэн жинхэнэ ийм явдлын тухай сонсох болсон билээ. Сонсох байтугай энэ талаар бэлтгэсэн хэд хэдэн цуврал нэвтрүүлэг үзэж уг явдалтай холбоотой тэдгээр хүмүүстэй танил болж, дотроо хоёр ээжийг өрөвдөн бас битүүдээ хэн нэгэнд арай илүү тал татаж байсан биз ээ. Юутай ч нэвтрүүлгийн төгсгөлд хүүхдүүд дассан гэр орондоо, ээнэгшин өссөн ээжтэйгээ үлдэх болж, шүүхдээд явж байсан хосууд эвлэрсэн нь олон хүнийг баярлуулсан билээ. Хүүхдүүд хоёр аав, ээжтэй болж, хүссэн үедээ уулзалдаж байна гэсэн Америк киноны “happy end” хүмүүст ихэд таалагдсан учир одоо ч хааяа нэг тэдний тухай санахаараа тийм л байгаа гэж бодож байгаа байх. Гэтэл бодит байдал эсрэгээр байгаа тухай сонслоо. Ингээд юу болоод улс даяар эвлэрсэн тухайгаа зарласан залуучууд бодлоо өөрчилснийг лавлахаар Дарханы гэр бүлийг сурсан боловч Хөвсгөл аймагт байгаа гэнэ. Ингээд хотын ээж гэхээр хүмүүс сайн мэдэх Б. Пүрэвтуяатай уулзлаа.

- Та Минж-Од охинтойгоо, Даваажаргал Уранзаяа охинтойгоо үлдэх болсон тухай телевизээр ярьж байсныг чинь харсан. Харин одоо байдал юу болоод байгаа хэрэг вэ? Яагаад ийм шийдэлд хүрцгээв?

- Хүмүүс ч энэ хэргийг сайн мэдэх болж дээ. Хамгийн анх шүүхэд солигдож байсан байж магадгүй, тогтоож өгөөч гэж цаад тал хүсэлт гаргасны дагуу солигдсон нь үнэн байна гэсэн шийдвэр гаргасан. Харин миний хувьд дөрвөн жилийн турш ямарч ажиг сэжиггүй явсан хүн гэнэт ийм зүйл сонсоод яах билээ дээ. Тэгээд Нийслэлийн шүүхэд давж заалдсан. Тэгээд л Чингэлтэй дүүргийн шүүх дээр хэрэг буцаж ирсэн. Үүнийг ч хүмүүс бараг мэдэж байгаа байхаа. Тэр үеэс ч телевизийн нэвтрүүлэг явж, тэд нар гуйж нэг эвлэрээд, буцаж муудалцаад сүүлдээ бид хүмүүсийн мэдэх тэр ойлголцолд хүрсэн л дээ. Хоёр ээж нь болох бид хөтлөлцөөд сонинд очиж ярилцлага өгч байлаа. Үүнд ч телевизийн нэвтрүүлэг нөлөөлсөн. Гэвч гадны нөлөөнөөс буцаад муудалцсан. Тэдний

ах, эгч нь Хөвсгөлөөс ирээд “Та нар буруу шийдвэр гаргасан байна. Хоёр айлын дунд хүүхдүүд яваад золбин болно.” Гэсэн учир дахиад л бид үл ойлголцсон байдалтай болсон юм. Сүүлдээ намайг хоёр хүүхдээ хоёуланг нь ав гэхээр нь би зөвшөөрсөн. Тэгээд өнгөрсөн арванхоёрдугаар сарын таванд би хоёр охинтой болох дөхсөн. Гэтэл тэд намайг телевизийн нэвтрүүлгээр хүүхдүүд солигдсон нь үнэн, Уранзаяа төрөлхийн өвчтэй хүүхэд, хоёр хүүхэдтэй болсондоо баяртай байна гэсэн зүйл ярих болзол тавьсан. Харин би хөөрхий охиныг өвчтэй гэж зарлахыг хүсээгүй. Тэгээд ч авбал олонд зарлахгүй авъя гэсэн учраас дахиад л муудалцсан. Энэ явдал эхэлснээс хойш би зөндөө л их юм бодох болсон л доо. Тэгээд шүүхийн шийдвэр буцлаа ч анх гарснаараа л гардаг гэж хүмүүсийн хэлэхийг сонсохлоор хоёр гурван сараар үргэлжилсэн энэ маргаан дахиад л үргэлжилнэ. Энэ бүгдийн цаана хүүхдүүд л зовно гэж санасан. Тэгээд энэ бүгдийн ард хэн хохирох вэ гэдгийг зөндөө л бодсон. Бидний энэ хэрүүл маргааны шуурганд хүүхдүүд л зовж байсан шүү дээ. Миний охин эрүүл саруул хүүхэд гэхэд л хэрүүл маргаанаас ч тэрүү халуурч, бүлээрч байсан болохоор бие нь тааруу Уранзаяад ч хэцүү байгаа байх. Магадгүй ингэж байтал эмчлүүлж, янзалж болох хугацаа нь алдагдчих юм болов уу гэж айсан. Үнэндээ бас л миний хүүхэд Уранзаяа тэнд өвчтэй байгааг нь дуулаад байх надад хэцүү. Тэдний хүслийг биелүүлэхгүй байгаад байвал энэ хэрүүл тэмцэл дуусахгүй байсан. Энэ тохиолдолд хүүхдүүд л зовно гээд би өөрөө ийм шийдвэр гаргасан л даа. Надад дэндүү хэцүү байсан ч охидод маань л хэрэгтэй гэж санаад би тэдэнтэй уулзан хүлцэл өгсөн.

- Тэгээд л охидоо буцаагаад солисон хэрэг үү?

- Шүүх дээр эвлэрэлийн гэрээ гэж байгуулдаг юм билээ. Хүссэн хугацаанд нь уулзуулж байна гэж ирээд л хоёр тал бичиж гарын үсэг зурсан. Тэр үед намайг хэзээ өгөх хугацаагаа бич гэхэд нь би “Тэдэнд өгнө гэж би бичиж чадахгүй нь. Та нар хэзээ авах хугацаагаа бич” гэсэн юм. Харин тэд 27-нд авна гэсэн нь хэдхэн хоногийн дараа болох өдөр байсан даа. Би “Та нар хэд ч хонох байсан хамаагүй манайд байж байгаад яв” гэсэн учир тэд ч манайд хэсэг байсан. Манай охин чинь их хөөрхөн ш дээ. Цэцэрлэгт орос хэлний ангид явдаг болохоор хоёр ёлконд орох байсан юм. Тэгээд тэрэнд нь оруулаад л аваад явахаар болсон.

- Минжээ явна гэдгээ мэдээд яаж байсан бэ?

Нөгөө аав, ээж нь вокзал дээр гаргаж өгөөд яах вэ уйлаан майлаан болоод хэцүү гэрээсээ гаргаад өгчих гэсэн л дээ. Тэгэхээр нь би нээрээ ч тийм юм гэж бодсон. Охин минь дандаа л дагаж минь байдаг байхгүй юу. Тэгээд намайг гэртэй үлдээд өөрөө явах болохоор баяртай, зүгээр байдаг юм. Эхэндээ Дархан явна гээд сүрхий байсан. Тэгээд ч нөгөө хоёрыг энэ хооронд аав, ээж гэдэг болчихсон байсан, би ч ээж аав чинь сайн хүмүүс, Дарханд очоод гоё гэрт очно гээд өмнө нь ч зөндөө хэлчихсэн байсан болохоор гайгүй байсан. Гэтэл яг явах гээд хувцсыг нь өмсүүлсэн чинь уйлаад аймаар юм болсон. Үнэхээр ярихад ч хэцүү. Хүүхэд тэр бүрийг ойлгохгүй гэж бодолтгүй юм билээ. Тэднийг “Та нар энэ хүүхдээ аваад зайл” гээд, надад болохоор “Би чамтай хамт амьдармаар байна. Намайг битгий явуулаач” гээд л гуйгаад байсан. Яг кино дээр гардаг шиг хэцүү гээч. Одоо хүртэл гуйж байсныг нь бодохоор дэндүү хэцүү. (Бүсгүйн нулимс хацрыг нь даган урссаар байсан. Түүний энэ яриаг сонсоод жаахан охин ээжээсээ сална гэдэг ямар хэцүү байсныг төсөөлөхөд л нулимс тэсэхгүй урсаж байсан...)

Хөөрхий минь хүүхэд болохоор намайг үгэнд орохгүй болохоор солих гээд байна гэж бодсон уу, “Ээжээ би таныг ажил дээр чинь дагаж байхгүй. Гэртээ үлдээд л гэрээ цэвэрлээд л байж байна. Намайг үлдээгээч” гээд л уйлаад байсан. Уг нь охин маань эрх л дээ. Тэгээд ч амралтын өдөр гэртээ үлдэнэ гэж байхгүй, намайг дагаад л манай ажил дээр байж байдаг юм. Тэгээд л хөөрхий ээж нь тэгээгүй ш дээ гээд байхад л “Битгий намайг солиоч, би үгэнд чинь сайн орно гээд л байсан” Үнэхээр хэцүү... Тэр үед манай захирал хамт байсан юм. Тэгтэл охин маань манай захиралд “Ээж намайг солих гээд байгаа юм. Битгий соль гээч” гээд байсан. Тэгээд л сүүлдээ хүчээр машинд суулгаж аваад, дараа нь орж ирээд хувцсыг нь аваад явсан даа... Тэр үед би өөрөө солих талаар ярьсан болохоор сэтгэлдээ охиноо өрөвдөж байсан ч больёо доо гэж дуугарч чадаагүй.

- Харин Уранзаяа яаж байсан бэ. Ээж, аавыгаа дагаж уйлсан уу? Одоо яаж байгаа вэ?

-Уранзаяа маань амар дассан. Эхлээд тэднийг хувцсаа өмсөөд эхлэхээр нь дагаад гутал, хувцсаа өмсөөд л зогсч байсан. Сүүлдээ уйлж, дуулаад хэд явахаар болж, хэд

буцаж байхад хувцсаа тайлаад “Би явахгүй. Ээжтэйгээ үлдэнэ” гээд л үлдсэн. Түг түг гээд хөөрхөн ярина л даа. Одоо цэцэрлэгт Минжээгийн оронд явж байгаа. /уйлав/ Хааяа охины минь таних тэмдэгтэй сандал, шүүгээ хоосон байхыг нь харахаар хэцүү л байх юм аа. Нас барчихсан ч юм шиг...

-Уранзаяа цэцэрлэгтээ давгүй байна уу?

-Давгүй ээ. Цэцэрлэгийнхэн нь энэ байдлыг мэдэж байгаа болохоор хэрэндээ л охиныг минь халамжилж, намайг ирэхэд цэвэрхэн хөөрхөн л хүүхэд сууж байдаг шүү дээ. Манай охин чинь нүд нь жаахан тийм шүү дээ. Тэгээд ээж охин хоёр нүдээ эмчид үзүүлсэн. Нэг тал нь 1.5, нөгөө нь 2 гэсэн үзүүлэлттэй муу байсан. Одоо Уранзаяа шил зүүж байгаа. Тэгээд удахгүй охиноо эмчид үзүүлж, эдгээж хөөрхөн охин болгоно доо.

-Уучлаарай, Уранзаяа чухам юу нь...

-Хэлж ярьж байгаа юм сайн ойлгодог. Уг нь зүгээр ээ. Дутаж байсан хайр халамжийг нь өгөөд, эмнэлэгт сайн үзүүлнэ гэж бодож байна. Гэхдээ Минжээ маань их сэргэлэн, хэлэмгий доломгой болохоор харьцуулалтгүй л дээ. Хааяа охин маань солигдоогүй бол хөөрхөн л охин байх байсан даа гэж боддог л юм. Гэлээ гээд хэндээ ч гомдох вэ дээ.

-Үнэнээр нь хэлээрэй. Таван жилийн турш хайрлаж, энхрийлж өсгөсөн охины чинь оронд төрсөн ч гэсэн төдийлөн дасч, эзэнгшээгүй хүүхэд байхаар яг адил харьцаж чадах юм уу?

-Би энэ явдлаас хойш уймраад юм бодоод суучихдаг болчихсон. Хааяа Уранзаяа “Ээж ээ” гээд дуудахаар огт танихгүй хүүхэд ээж гээд байгаа юм шиг санагддаг. Уг нь хүн чинь хүүхдийнхээ дууг багаас нь сонсоод олон хүүхдийн дунд уйлж байхад хүртэл ялгагдаг болчихдог ш дээ. Хоёр охин маань биеэр ялгаатай л даа. Минжээгийн Уранзаяад таарах зарим нэг хувцас байдаг л даа. Гэхдээ өмсүүлье гэхээр харам санагдаад байдаг. Уг нь хэнээсээ ч харамлах билээ дээ гэж бодсон ч гэсэн Минжээгийнхээ үлдсэн хувцаснуудыг нэг чемоданд хийгээд хадгалчихсан. Би үүнийг насан туршдаа хадгалж явна аа.

-Минжээгээ явахад нь юу юу өгч явуулав аа?

-Яахав дээ уг нь охины минь хувцас нь нэг муу биш ч гэсэн хуучин болсон болохоор бүх хувцсыг нь шинэчилж өгөөд явуулъя гэж бодсон. Амьдрал маань тийм хангалуун биш ч охиндоо ээлжийн хувцсыг нь л бэлтгэж өгье гэж санасан. Энэ фенг-шүгийн бугуйн зүүлтээр охиныхоо гэдэс нь өвдсөн үед үрээд өгдөг юм л даа. Тэгэхээр охин минь зүгээр боллоо гэдэг. Минжээ маань “Ээжээ та надад үүнийг өгөөд явуулаарай. Тэнд би өвдвөл яах юм бэ” гэж байсан юм. Гэтэл би гэж амьтан уймраад үүнийг өгч явуулахаа мартчихаж... /Амьдын хагацал үзээд байгаа энэ бүсгүйн нулимсыг юу ч тогтоож дийлэхгүй юм шиг санагдаж байлаа/

-Минжээ энэ хэрэг явдлыг хэзээнээс мэдэж эхэлсэн бэ?

-Хүүхэд болохоор нарийн ширийнийг нь яаж ойлгох вэ. Ямарч байсан намайг уйлахаар л дагаад бүлтгэнэдэг болчихсон байсан. Телевизийн нэвтрүүлгээр дуучин А. Долгор “Номинталст”-ийн Дээгийгийн дуулдаг дуу явж байсан шүү дээ. Сүүлд нь автобусанд явж байсан чинь “Ээжээ чи уйлах уу” гэлээ. Гэтэл тэр дуу явж байж л дээ. Би ч мэдээгүй. Намайг уйлах вий гэхээс л айдаг болчихсон байсан. Одоо охин минь тэр дууг сонсоод ээжийгээ бодож л байгаа байх даа.

-Өөрөө энэ шийдвэрийг гаргасны эцэст юунд ч тэгэв дээ гэж бодож байна уу?

-Би өөрийгөө бодсон бол ийм шийдвэрт хүрэхгүй л байсан. Хэрэв ингэхгүй л бол энэ хэрүүл хэзээ ч төгсөшгүй зүйл байсан. Үргэлжлээд л байх юм бол хүүхдүүд дунд нь үрэгдэнэ. Хугацаа алдаад Уранзаяаг эмчлүүлэх хугацаагүй болчихвол яах вэ гээд. Хамгийн гол нь шүүхийн шийдвэрээр охиныг минь тэдэнд өгчихвөл би уулзаж, харж чадахгүй байх гэж бодсон. Харин эвээр шийдвэл би охинтойгоо уулзаж байж чадна шүү дээ. Хүн хайртай хүнийхээ төлөө ямар ч бүтэшгүй зүйлийг хийж чаддаг юм байна гэдгийг би одоо л биеэрээ мэдэж байна. Би миний төрсөн хүүхэд тэр газарт өвчтэй байна гэдгийг мэдсэн тохиолдолд Уранзаяагийн төлөө ямар нэг зүйл хийхийг хүснэ. Бас төрсөн эцэг эх нь магадгүй надаас илүү хүүхдийнхээ төлөө юм хийж чадах ч юм билүү, бас тэдний төрсөн үр хүүхэдтэйгээ байх хүслийг нь хүндэтгээд ийм шийдвэрт хүрсэн. Би уг нь хүнд муу юм хийгээгүй. Гэтэл ингэж их зовж байх гэж. Одоо миний хамгийн их хүсэж байгаа зүйл бол шаналсны минь хариуд ирэх ач тус хоёр охинд минь тусаасай л гэж бодох юм.

-Уранзаяа ч дасаад сүрхий байгаа юм байж, харин Минжээ яаж байгаа бол оо? Охинтойгоо ярьсан уу?

-Би гэрээс гараад явахад л тэдэн рүү залгасан. Харин тэд утсаа салгачихсан. Тэгээд хэд хоног ёстой элий балай мэт л байлаа. Нэг өдөр эгч нь яриад Хөвсгөл явсан гэсэн. Харин нөгөө ээж нь өчигдөр залгасан. “Охин маань чамайг санахгүй, тоглож наадаад байна” гэсэн үг надад хатуу санагдсан ч нээрээ охинд минь хэцүү биш байгаа бол гэж бодохоос сайхан байна. Магад Уранзаяа дасаад сүрхий байгаа шиг байж болно л доо.

-Тэд Хөвсгөлд амьдрах юм болов уу?

-Үгүй, Дархандаа буцаж ирнэ гэсэн. Одоо охин минь сурснаа улам хөгжүүлээд цааш явах, мартаж хоёрын зааг дээр л байгаа хүүхэд. Тиймээс би тэдэнд гадаад хэл амархан сурах янзтай, хөөрхөн нугардаг. Тэр сургуульд нь явуулаарай гэж захьсан.

-Энэ бүх явдалд нөхөр чинь яаж хандаж байсан бэ?

-Нөхөр маань чи л юу гэж шийднэ. Тэрүүгээр чинь больёо гэж байсан. Миний л сэтгэлийг дагана гэж байсан.

-Энэ бүх эмгэнэлт явдлын буруутан нь хэн юм бэ гэж боддог уу?

-Энэ явдалд би ямарч буруугүй. Намнан, Даваажаргал нар ч гэсэн. Охидууд бүрч буруугүй асрагч л сольж өгсөн гэж байгаа. Чухам ямар хүн байсныг нь мэдэхгүй. Үнэндээ мэдлээ гээд их л болж хариуцлагагүй байсан гэж ажлаас нь хална биз. Гэтэл өнөөдөр бүгд л амьдрах гэж яваа хүмүүс, тэдний цаана хөөрхөн жаалууд байгаа. Ер нь хэн ч буруутай юм. Хааяа үнэхээр цөхрөх юм.

-Аймгийн төрөх газар төрсөн юм байна. Даваажаргалыг таньдаг байсан уу?

-Танихаар барах уу. Нөхөр нь миний үеэл шүү дээ.

-Тэр өдөр чинь хэдэн оны хэдэн байсан билээ.

-1997 оны 8 сарын 25-ны өдөр. Хөвсгөл аймгийн төрөх газар төрсөн юм. Би хэн надад хүүхэд авчирч өгснийг санах ч үгүй байгаа юм. Энэ чиний хүүхэд гээд л өгсөн. Тэгээд л би охиноо хөхүүлж, өдий хүрсэн шүү дээ.

-Охин чинь хэд болтлоо хөхсөн бэ?

-Гурван нас хүрсэн. Саяны хэрэг явдал өрнөөд би охиноо эрхлүүлээд мөөм хөхнө гээд байхаар нь хөхүүлж байсан юм. Гэтэл хөхөөд байсан чинь сүү орчихсон ш дээ. Одоо сүү гардаг... Явдаг өдрөө “Ээжээ би мөөмөө хөхье” гээд уйлсан даа. Багтарч, ядраад “Ээжээ би мөөмөө идээд унтъя л даа” гээд л гуйгаад байсан...

-Охиноо явуулсанаас хойш утсаар ч яриагүй юу?

-Яриагүй ээ, Даваажаргал л ярьсан. Уг нь охиныхоо дуу хоолойг сонсвол хичнээн сайхан байх билээ. Гэхдээ миний охинд хэцүү болчих болов уу гэж л бодох юм. Миний охины хайртай эмээ нь байдаг юм. Охиноо явуулахад Хөвсгөлд байсан болохоор уулзаж чадаагүй юм. Одоо тэнд байгаа болохоор уулзъяа гээд очихоор нь уулзуулчихаарай гэж би хэлсэн. Одоогоос 27 жилийн өмнө намайг нэг настай байхад аав, ээж минь нас бараад ах нартайгаа би ээжийнхээ ахынд өссөн юм. Тэднийх 3 хүүхэдтэй, би ахтайгаа 10 дугаар анги төгстөлөө хүүхэд шиг нь л байсан. Хүүхдүүдээс нь би хамгийн түрүүнд хүүхэд гаргасан болохоор миний охиныг анхны ач гээд сүйд байдаг байсан юм. Манай охин ч эмээ, өвөө гээд... Тэр эмээтэйгээ уулзаж чадаагүй юм л даа. Харин одоо Хөвсгөлд байгаа дээр нь уулзах байх даа.

-Өөрөө Солонгосын “Зүрхэнд шингэсэн намар” гэдэг киног үзэж байсан уу? Кино гарч эхлэх үед энэ хэрэг явдал эхэлчихсэн байсан уу?

-Тэр үед мэдэж эхэлж байсан. Би тэр киноны утга санааг нь мэднэ л дээ. Гэхдээ би энэ киног үзэх дургүй. Эхлэхээр нь гараад л явчихдаг. Үзэхэд хэцүү байдаг юм. Тэр кинонд төрсөн охиндоо нөгөө охиныхоо хувцасыг өмсгөдөггүй дээ. Одоо л би тэр эмэгтэйн сэтгэлийг ойлгож байна. Би яагаад ч юм охин маань эргэж ирээд хувцсыг нь Уранзаяад өмсүүлсэн байхыг хараад гомдох вий гэж санадаг юм.

Энэ дуулиант хэрэг дэндүү гэмээр өрөвдмөөр, харамсмаар юм. Өчүүхэн багаас нь хэлд, хөлд орохыг нь харж баясч өссөн үрээ элгийг нь дагуулж байна гээд өгөөд явуулчихсан энэ эхтэй ярьж суухдаа үнэхээр өрөвдөж байлаа.

Охинтой нь уулзуулахгүй байх вий дээ гэхээс айж байгаа тэрээр “шинэ” хүүхдийнхээ төлөө хэдийнээ санаа тавиад эхэлжээ. Ажлынхан нь “шинэ” охинд зориулж тоглоом, хувцас сэлт ч цуглуулж эхэлсэн гэнэ лээ. Гэхдээ энэ хэрэг ингээд л дууссан гэж үү.

Томчууд хэрэлдэж, эвлэрч хүүхдээ сольцгоогоод л бүх зүйл хэвийн болно гэж үү? Томчууд өсгөсөн хүүхдээ хайрлах сэтгэлээ, төрүүлсэн хүүхдэдээ шилжүүлэх гэж

зовж байх үед бяцхан хүүхдүүд огч шаналахгүй байгаа хэрэг үү? Уг нь андуураад авсанаа солиод л орхидог бараа таваар байсан бол болох байх л даа. Гэтэл үнэндээ бяцхан амьтдын жижигхэн зүрх нь өвдөж л байгаа. Тэд хүн л болохоор багаасаа үлгэж өссөн. Мөөмөө, эрхэлж өссөн ээж ааваа санана. Уранзаяа дотроо юу бодож байгаагаа төдийлөн нээдэггүй хүүхэд болохоор юу бодож, хэрхэн шаналж байгааг хэн мэдэх билээ.

Минж-Од холын Хөвсгөлд ээжийгээ, мөөмөө санаж яаж уйлж, дэвхцэж байгааг хэн төсөөлөх билээ. Хүүхэд төрсөн эцэг эх дээрээ байх ёстой гэсэн үг, өгүүлбэрийг дагаад л энэ тохиолдолд шийдвэрийг гаргана гэвэл дэндүү өрөөсгөл. Хэрэв миний төрсөн хүүхэд биш гээд эцэг эх байх үүргээсээ татгалзвал тэр л биз. Харин хорвоод мэндэлсэн өдрөө л томчуудын золиос болсон бяцхан охидын жаахан зүрхийг шархлуулж, ганц эдгээр өдрүүд ч бус насан туршдаа зовох үүсвэрийг тавьж байвал томчууд бид ямар хариуцлага хүлээх вэ?

1.3 БОДОЦГООЁ.

Э. Энэрэл

Өдрийн сонин, 2003.01.14, №011/1200/

ДОХ өвчтэй бас нэгэн хүн бүртгэгдлээ гэсэн мэдээллийг олон нийт өнгөрсөн долоо хоногт хүлээн авлаа. Тэр хүн нь нас тогтсон, өндөр боловсролтой, гадаадад олон жил амьдарсан эмэгтэй хүн байсан нь монголчуудын уг өвчний талаархи мэдээлэл, хандлагыг нэлээд өөрчилж байх шиг. ДОХ-ын талаар хүн төрөлхтөн мэдэж эхэлсэн тэр цаг үед Америкчууд үүнийг гомочуудын л өвчин хэмээн өөрсдөөсөө холдуулж байсан нь талаар болж, ойр дотны хүмүүс нь халдвар авч, улмаар баян хүн өвддөггүй мэтээр ойлгодог нь олон баримтаар ялагдсан билээ. Тэгвэл манайд бүртгэгдсэн өмнөх тохиолдлууд нь харьцангуй эрсдэлтэй бүлгийн хүмүүст хамаарч байсан болохоор тийм хүмүүст л энэ өвчнийг тусна гэдэг монголчуудын ойлголт ч бас нуран нурсаар байна. ДОХ-той болон ХДХВ-тэй монголчуудын тоо бидний найдаж байдагчлан нэг гарын хуруунд багтах бус түүнээс олон байдаг нь улам бүр батлагдаж байгаа үед бид ийм өвчтэй хүмүүсийн талаарх ойлголтоо өөрчилмөөр санагдана. Хүний эрхийг дээдлэн эрхэмлэх болсон энэ дэлхийд уг өвчнөөр өвчилсөн хүмүүсийн эрх байнга зөрчигдөж, ялгаварлан гадуурхалтад үргэлж өртөж байдаг ч сүүлийн үед ертөнц нийтийн хандлага өөрчлөгдөж байгааг нэг хэсэг нь болох бид ч мэдрэх хэрэгтэй юм.

Хатуу чанд гэгддэг урд хөршид маань хүртэл ХДХВ, ДОХ-той хүмүүсийн эрхийг хамгаалах хууль нэгэнт гарчээ. Гэхдээ ихэнх оронд урьд нь батлагдсан сөрөг заалт, журмууд хэвээр байгаа нь үнэн. Тухайлбал нэлээд орны ДОХ-ын тухай хуульд ДОХ-той болон ХДХВ тэй эмэгтэй жирэмсэн болсон тохиолдолд ургийг таслан зогсооно гэсэн утгатай үг, өгүүлбэр бий.

1994 онд батлагдсан манай улсын ДОХ-ын тухай хуульд ч энэ заалт байдаг. Харин сүүлийн үед дэлхийн газар бүрт ийм утга бүхий заалтаа өөрчлөлт хийхийг шаардсан хурал жагсаал гарч, энэ өвчинтэй холбоотой салбарынхан нь ч үүнийг хөндөн ярьж тэмцэх болсон билээ. Энэ нь учиртай. Ийм өвчтэй эмэгтэйн хэвлийд ураг бий болмогцоо халдвар авдаг гэвэл худлаа. Уг эхээс төрсөн хүүхдийн 35-40 хувь нь ХДХВ-ийн халдвартай байдаг бөгөөд үлдэх хувьд нь эрүүл хүүхэд төрнө гэсэн үг. Тэгээд ч урагт өвчнийг халдаахгүй байх зорилготой янз бүрийн, тун ч үр ашигтай эм олноор гарсан бөгөөд Тайландад гэхэд л өвчний халдварлах магадлалыг 9 хүртэл хувь бууруулсан эм гарсан. Энэ тохиолдолд бүсгүй хүн хүүхэдтэй больё хэмээн хүсэх нь зүйн хэрэг биз. Магад үр хүүхэдтэй болж амжаагүй ХДХВ-тэй бүсгүй нас нөгчсөний хойно ээж, аав минь үнэрлэж сууг даа хэмээн үр удмаа үлдээхийг хүсэх нь гажууд хүсэл биш.

Тийм ч учраас ДОХ-той хүмүүсийг ялгаварлан гадуурхах нь дээд хэмжээндээ хүрч, хүний эрх зөрчигдөж байгаа талаар илүү хүчтэй дуугарах болсон нь үнэн. Бид ч тэдний эрхийг хангаж, ялгаварлан гадуурхахгүй байхыг хичээх цаг болжээ. Магадгүй яагаад тэр өвчтэй хүмүүсийг хамгаалаад байна хэмээн та гайхаж болох юм. Гэхдээ тэднийг ялгаварлан гадуурхдаггүй, эрхийг нь зөрчдөггүй тийм орчин бүрдүүлэх нь бидэнд л хэрэгтэй билээ.

Та нэгэнтээ “тэр ДОХ-ын шинжилгээ гэдгийг нь сайн дураараа өгөөд орхих юм сан” гэж бодож байсан биз дээ. Гэвч та эргэлзсэн. Хэрэв өвчний халдвартай гээд гарчихвал

яха билээ гэж айсан. Тийм биз дээ. ХДХВ–тэй гээд гарвал сонин хэвлэлээр шуугина, хүмүүс танаас жийрхэн холдож, нүүрээ бууруулах болно, ингэж зовж байхын оронд нэг мөсөн үхэх юм чинь гэсэн бодол хүмүүст төрөх нь лавтай. Та ДОХ-той хүмүүсийг хүлээж авдаггүй, ялгаварлан гадуурхдаг, эрхийг нь зөрчдөг тийм нийгэмд байгаа учраас энэ бодлоосоо салдаггүй байна. Харин энэ бодлоосоо салахгүй бол өөрөө мэдэлгүй бусдад өвчнөө тараагчдын тоо олширч, өвчин нь урхагшиж амьдрах хугацаа нь хомсдсон хүмүүс нэмэгдэнэ. Монголд гарсан сүүлийн 2 тохиолдол бидэнд сургамж болох ёстой билээ. ХДХВ байхдаа бус бүр ДОХ өвчин болоод мэдэгдсэн нь энэ өвчин монгол хүний биед ороод багагүй хугацаа өнгөрснийг илтгэнэ. Тэгэхээр бид үүнтэй тэмцэнэ гээд энэ өвчний халдвар авсан хүмүүсийг үзэн ядаж, нийгмээс тусгаарлаж, эрхийг нь хязгаарлаад амжилт олохгүй, харин өвчнөө эртнээс мэдэж, бусдад санамсаргүй халдахаас нь сэргийлж чадвал л харин дийлэх биз ээ. Бодоцгооё.

1.4 АЛГАНЫ ХОНХОР ХАЗАХТАЙ АДИЛ БОЛОМЖ

Б. Золбаяр

Өдрийн сонин, 2002.12.06, № 297 /1170/

Ийм болохоор төр засаг энэ асуудалд нилээд бодитой анхаарч, төсөв зардлыг нэмэхгүй бол Монгол улсын иргэн гэмт хэрэгтний тоо улам улам өсч, хар цагааны зааг ялгаа бүдгэрэн бүдгэрсээр байж мэдэх ажээ. Ийм бүдгэрлийн цаана бүхий л Монголын хувь заяаны хэлтэрхий нэгж иргэний амьдрал луужингүйдэж байх ёсгүй.

Алганы хонхор хазахтай адил гэх хэллэг бий. Энэ зүйрлэлийг биелэлт, бүтээмжит магадлалын хамгийн доод төвшинд хамааруулахад огтхон ч буруутахгүй. Ийм дорой, үлбэгэр хандлага хүний эрхийг хамгаалах гол салбар өмгөөлөлийн албанд “амьдрахчаа” болж байгаа аж. Хулгайч худалч, баян тарган, гэмт хэрэгтэн хэн ялгаагүй хүний эрхийн, нийгмийн өмнө хүн л байх ёстой. Харин хүмүүжиж төлөвшсөн бурангуй араншингаас ч юм уу, хувь тавилангийн шоглоомоор ч юм уу золгүйгээр шүүхийн өмнө очигсод цөөнгүй. Тэдний энэхүү үйлийн үрт учралыг үнэнээр дэнслэх, энгийнээр хэлбэл буян болох ажлыг өмгөөлөгчид хийдэг. Гэвч энэхүү энэрэл хишгийг хүртэгсэд ихэнхдээ нийгмийн доод давхаргын, “буян даадаггүй” зовлонт амьтад байдаг нь харамсалтай боловч үнэн. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн Ц. Итгэл өөрийн ажил хэрэг дээрээ “нүүрэлсэн” ийм жишээг баталж байна. Түүнд олон ийм тохиолдол байгаагийн зөвхөн нэг нь алдарт 90 саяын Гансүхийг өмгөөлсөн нь юм. Тэр энэ хүнийг өмгөөлж дөрвөн удаа шүүх хуралд оролцохдоо нэг ч төгрөг аваагүй байна. Энэ бол зөвхөн шүүх хуралд өмгөөлөх ажил гүйцэтгэсний нь тоо. Уулзаж мэдүүлэг авч, ажиллах процессээ бүрдүүлэхэд өмгөөлөгчөөс ямар зардал гарсныг хувиасаа тамхи, чихэр боов аваачиж өгснөөс нь эхлэн нарийвчлан тооцвол мундахгүй зардал гардаг аж. Хэдий үйлчилсэн хөлсөө аваагүй ч Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс томилдог, томилогдохоос ч өөр аргагүй болохоор аргагүй буян хийх л болдог байна. Ерөөсөө өмгөөлөгч хүний ажлын ерөнхий зарчим өгөөмөрлөл, нигүүлслэлийн шүтэлцээнд оршдог байх. Гэхдээ худлаа юмыг мянга давтал үнэн болдог хэмээх нэгэн хэлц бий. Энэ байдлаас хамааруулж үзвэл өмгөөллийн энэ тогтолцоо өмгөөлүүлэгчийн эрхийг хэр хангаж байна гэдэгт эргэлзээ төрөхөөр байна. Энэ нийгмийн маань хөдөлгөгч хүч нь мөнгө гэдгийг хэн ч мэднэ. Мөнгө хэзээнээс үнэтэй байсан, улам үнэд орсоор буй. Тэгвэл хөлс мөнгөгүй ажил хийхэд дуртай хүн байх уу гэсэн гэнэн гэхэд инээдтэй асуултад ямар хариу ирэх нь ойлгомжтой. Тэгэхээр дургуйд хүчгүйн үлгэр өмгөөллийн албанд нүүрлэсэн байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Ингэхээр л хэдий ял хийсэн ч өмгөөлүүлэх эрхтэй зовлонт хүмүүсийн эрх чөлөө хэрхэн шийдэгдэж байгаа бол гэдэгт эрхгүй эргэлзээ төрмөөр.

Монгол улсын шинэ, хуучин хуулинд хүнийг өмгөөлүүлэх эрхээр хангах, төлбөрийн чадваргүйгийн нь зардлыг төр даана гэсэн заалт дурайн бий. Энэ дагуу улсын төсвөөс 9 сая төгрөгийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчдийн зардал олгохоор тусгасан ч энэ мөнгө Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дансанд анх удаа өнөө жил л орж ирээд байгаа аж. Өмнөх жилүүдэд өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй хэрэгтнүүдийн олон олон шүүх хуралд үүрэгт ажлаа хийгээд мөнгөө авч чаддаггүй байсан байна. Энэ бүхний цаана шүүгдэгсдийн хувь заяа хэрхэн шийдэгдэж байсныг таахад нэн бэрхтэй.

Өнөө жил анх удаа зорилгот дансандаа орж ирсэн 9 сая төгрөг Монголын төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчдийн “ачаар” зохих эзэндээ ямархуу байдлаар анх эхлэн хүртэгдэх гэж байгааг сонирхоё. Нийт мөнгөний 3 сая нь Нийслэлд хувиарлагдсан бол аймгуудад 250 мянган төгрөг л ногдож байгаа аж. Энэ хувиарлалтыг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэсэн гэмт хэргийн дөрвөн нөхцлийг өмгөөлсөн байдлыг харгалзан нэг удаагын өмгөөлөлд 6-8 мянган төгрөг ногдохоор бодож өгч байгаа аж. Яг энэ байдал нь өмгөөлүүлэгч, өмгөөлөгч хоёрт алганы хонхорхойг хазахтай адил боломж олгож байгаа хэрэг гэвэл болохоор байна. Алганы хонхорхойг хазахтай адил боломжоос хүний эрх, иргэний хувь тавилан дэнслэгдэнэ гэдэг дэндүү магадлалгүй тогтолцоо юм. 9 сая төгрөг гэдэг үнэндээ өдгөө цагийн эдийн засаг, болон зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдогсдын хувьд өмгөөлөгчдөө зарцуулахад нэг их проблем болох мөнгө биш.

Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл өдөрт 3-10 өмгөөлөгчийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчид томилдог бол жилд 350 өмгөөлөгчийг ийм алба “хашуулдаг” аж. Энэ бол МӨХ-ны буруу биш ээ. Харин ч тэднийг талархан сайшаах ёстой санагдана. Ийм болохоор төр засаг энэ асуудалд нэлээд бодитой анхаарч, төсөв зардлыг нэмэхгүй бол Монгол улсын иргэн гэмт хэрэгтний тоо улам улам бүр өсч, хар цагааны зааг ялгаа бүдгэрэн бүдгэрсээр байж мэдэх ажээ. Ийм бүдгэрлийн цаана бүхий л Монголын хувь заяаны хэлтэрхий нэгж иргэний амьдрал луужингүйдэж байх ёсгүй.

1.5 ЯЛГАА

Б.Золбаяр

Өдрийн сонин, 2003.01.06, №004 /1193/

Өнгөрөгч сарын 23-ны өдөр Английн өмнөд Лондоноос нэгэн эмэгтэйг цагдаа нар баривчилжээ. Зочид буудалд байж байгаад ийн “эрх чөлөөгөө хасуулагч “ нэг л зүйлд бууртгагдаж. Тэр нь сайхь эх хүүхдээ орхиж одсонд байгаа юм. Хүүхдээ хөсөр хаясан нь сонгодог нийгмийн иргэний өмнө байж болшгүй зүйл нь мэдээж. Хүүхдээ орхиж болохгүйг номлох, тэр ч бүү хэл орхисныг нь олж уулзуулах нь ч уг нийгмийн түгээмэл үүрэг зорилго. Энэ хэрэг явдлын хамгийн сонирхолтой нь уг эхийг хүүхдээ орхиж явсныг мэдсэн нь их энгийн. 12 настай сурагч нь хичээлдээ халтар хувцастай ирснийг багш нар анзаарч, улмаар гэрт нь ээж нь байхгүй байгааг мэдэж цагдаагийнханд мэдээлжээ. Ингээд л нэгэн сурагчийн нь хувцас “хэвийн биш” байсны төлөө уг эх эрэн сурвалжлагдаж өдгөө шүүхийн өмнө яллагдах болоод байна. АНУ, Английн нийгэмд хүүхдийг харгалзан хүмүүжүүлэх, тэдний эрхийг хүндэтгэх ийм зүй тогтол нэгэнт “өглөө цай уух нь үнэн” гэдэг шиг загвар болж бэхэжжээ. Энэ загвар, хэв байдлыг зөрчиж байдаг, зөрчсөн цөөн тохиолдлын нэг нь өгүүлсэн дээрх жишээ бөгөөд соёлт ертөнцөд энэ болчимгүй явдлын эсрэг үйл ажилагааны дархлаа, бэхчилт улам бүр зузааран нандигнашиж байдаг аж. Дэлхийн нийтийн хүүхдэд хандах хандлага, ийм хүндэтгэлт байдал нь манай практикт харин эсрэгээрээ байх нь түгээмэл. Хамгийн ойрхны жишээ татъя. Өнгөрөгч 7 хоногт нэгэн золгүй явдал болов. Зүүн Сэлбийн 4-р гудамжинд амьдардаг Ц.Баатарсүрэн гэгчийн 8 сартай охин орон дээрээс хувинтай усанд унаж нас баржээ. Хатуухан хэлэхэд наймхан сартай тийм нялзрай амьтанд хэтэрхий ахадсан үхэх “шалтаг” тулгажээ. Хувинтай усанд үйлгэх нь бүү хэл 16 нас хүрээгүй ямар ч хүүхдийн амьдрах, амьд явах эрхийн төлөө аав, ээжүүд тэмцэж, орших “шалтаг”—ийг нь хаах ёсгүй. Монголд хүүхдийн амьдрах, өсөн бойжих эрх чөлөө энэ мэтээр зөрчөгдсөөр байна. Бид 5-6 -хан насны хүүхдүүдээ эрэгтэй, эмэгтэй ялгалгүй хурдан морь уралдуулж, айдас хуруулдаг. Түүнчлэн хөдөөгийн малчдын хүүхэд хүн болох нь чухам л “зураг төөргийн” хэрэг байдаг. Нялх нойтон үрсээ унтуулчихаад, мөлхдөг, хөлд орох аядсан нэгийг нь бүсээр, бурантагаар орны хөлөөс уячихаад малдаа, аргал түлшинд явж л орхидог. Өнөөх орон дээр унтсан нялх сэрээд унавал яана, уяж орхисон нь уяандаа ороогдоод яачихсан бол гэж бодохоос зүрх шимширдэг юм. Гэвч ийм байдал манай хөдөөд байж л байдаг, байгаа ч билээ. Үүнд эргэлзэх зүйл алга. Хувцас халтартсаныг багш нь анзааран эх нь явчихсаныг Англичуудын мэдэх, хувинтай усанд унаж амь алдсаныг, хөдөө цайдмын гэрт уягдаж хэдэн цагаар орхигдсоныг бидний сонсон дуулах хоёрын хооронд мөн ч их зай, зааг ялгаа байна даа. Бас тэнгэр газар шиг өөр энэ хоёр эрх зөрчигдөгсдийн эцэг эх, асран хүмүүжүүлэгчдэд ноогдох шийтгэл нь ч хэтэрхий зөрүүтэй аж. Дээр дурдсан англи эмэгтэй ямар нэгэн байдлаар зэм шийтгэл амсах нь тодорхой.

Харин орон дээрээс усанд унаж эрсэдсэн хүүхдийн, аргалд, хонинд явсан эцэг эхийгээ хүлээн уяатай тэлчлэх хүүхдийн аав, ээжид ямар хариуцлага тооцох вэ. Амьдрал юм чинь яах вэ дээ, үйлийн үр нь л тэр байлгүй гэсээр байцгаах уу Дээрх жишээнүүдээс хүүхдийн эрхийн хэм хэмжээ, түүнийг сахин хамгаалах үйл ажиллагаа дэндүү зааг ялгаатай нь харагдаж байгаа биз.

1.6 СУУГАА БА БОСООГ ЯЛГАХ ХЭРЭГТЭЙ

Б.Золбаяр

Өдрийн сонин, 2003.01.11, №009/1198/

Нэг согтуу гудманд багана тэврээд унтчихжээ. Гудмаар эргүүл хийж байсан цагдаа нар түүнийг ердөө тоохгүй юм гэнэ. Зүй нь бол “халуун аршаан”-ы пянд нэрвэгдсэн мөнөөх эрийг эрүүлжүүлэхийн цагдаа дуудаж зохих газар нь хүргэх ёстой байдаг. Согтуу баганаа тэврээд л зогсоод байж. Үнэндээ түүнийг шууд л эрүүлжүүлэхэд өгмөөр байв, гудамжинд явагсад бүгд л түүнийг харж, жигших нь сэтгэлд таагүй. Тийм байдалтайгаар багагүй цаг өнгөрч сайхь нанчдад дийлдсэн эр багана тэврэх шалтагийг нь тавьсан хатуу дарсаа “ялах” аядаад хөл дээрээ яваад өгч. Хэдий хөл дээрээ явах аядах ч цагдаагийн дэргэдүүр шүрэгчсэн түүнийг манайд бол үг хэлгүй “эрүүлжүүлдэг” дээрээ. Гэтэл мөнөөх энэрэнгүй цагдаа нар түүнийг явуулаад гудам тойруулчихлаа. “Үгүй ээ мөн хачнаа. Яасан ч залхуу цагдаатай орон бэ. Нөгөөх нь нэг газар очоод мажийчихвал тоохгүй бололтой юм” гэж бодсон минь том эндүүрэл байж билээ. Тэнд хүний эрх хэмээх халдашгүй нандин хэрмийг сэтлэхгүй байхын утга, агуулгыг хэрэгжүүлсэн гайхалтай зарчим үйлчилж байсан юм билээ хэмээн нэгэн танил минь Улаанбаатарынхаа гудманд ойчиж, босч явсан нэг согтууг харснаас үүдүүлэн ийн ярсан юм. Энэхүү хүний эрхийг хангахад гайхалтай соёлч хандсан орон нь Польш л доо. Тэнд үйлчилсэн энэ хачин зарчим нь өнөөх согтуу хөл дээрээ зогсч, чадаж байсанд л учир нь байж. Польшид хэвтсэн эсвэл суучихсан согтууг л эрүүлжүүлэх хууль дүрэмтэй аж. Аль нэг газар хэвтэтлээ, суутлаа “тасарчихаагүй хэн боловч эрүүлжүүлэгдэхгүй алтан дүрэм тэнд үйлчилдэг байна. Хөл дээрээ л бол хэцнээс зүүгдээд унтчихсан байсан ч эрүүлжүүлэхийн хаалга татахгүй байх ажээ. Энэ бол хүний эрхийг дээдэлсэн сонгодог жишээ чухам мөн бизээ. Харин манайд энэ байдал ямархуу байгааг маш энгийн жишээн дээр анзаарч болно. Багахаан уучихаад гэргий хүүхдэдээ очих гээд яарч яваад автобусанд орох гээд яльгүй шургачихсан нь цагдаад харагдаад мөнөөх үйлчилгээний тэргэндээ сууж чадаагүй үлдчихвэл “эрүүлжүүлэхэд” зочилж л орхино. Мэдээж мал болтлоо согтогсдын тухайд энд ярилтгүй. Гэвч найз нөхөд, анги хамт олонтойгоо дарвих тохиолдол цөөнгүй гардаг. Жаахан оочиж л таараа, бас жаахан дайвчиж л таараа. Иймэрхүү тохиолдолд манай цагдаа нар өнөөх золгүй “амьтныг” эрүүлжүүлж л орхидог. Энд би архидан согтуурагсдыг “хөхүүлэн дэмжих” гэсэнгүй. Ер нь бол соёлт ертөнцөд хүний эрхийг тэгж дээдэлдэг юм байна гэдгийг л өгүүлэх гэсэн юм. Манай цагдаа нар энэ нийтлэлийг уншчихаад “нэг иймэрхүү юм болчихдог юм шүү” гээд мушийж ч магад. Бас “Би нэг эрүүлжүүлэгдэхдээ дээр өгүүлсэн жишээнээс нь зуу дахин эрүүл байж байгаад орчихжээ. Ер нь эрүүлжүүлэхтэй холбоотой хууль дүрмийг өвлийн цагт л биш бол иймэрхүү байдлаар шийдэх нь зүйтэй” хэмээн мэтгэгсэд ч тоолход олноор гарч ирж мэдэх юм. Тийм болохоор хэдий архичин, согтуу ч бай хүний эрхийг дээдлэхүйн жишээ энэ мэтээс биелэн хангагдаж явдаг байна.

Хүндэт цагдаа нараа, эрхэм эрүүлжүүлэгчдээ:

Хэн нэгэн зохисгүй этгээдийг эрүүлжүүлээ гэж бодъё. Гэтэл нөгөөх чинь “Би гэртээ харьчихаж чадахаар байсан. Та нар намайг тавиад явуулчихаач. Тэр хүний эрх чинь хаана байна аа” гэж хашгирвал Польшийн гудамжинд болсон тэр нэгэн явдлыг хааяа ч гэсэн санаж байгаарай даа. “Ноён цагдаа та хүний эрх хөндчихөөгүй биз” гэж өөрөө өөрөөсөө асууж байгаарай. Та лав бууруудахгүй ээ. Магадгүй амьдралдаа хийсэн хамгийн зөв алхам маань тэр байж дээ гэж хожим дурсах ч юм билүү. Нэг юм мартаж дөхлөө. Польшид хүнийг эрүүлжүүлэхдээ “суугаа ба босоог нь ялгах хэрэгтэй” гэлцдэг юм гэнэ лээ шүү.

1.7 ГЭМТ ХЭРЭГТЭН Ч ГЭСЭН ЭДЛЭХ ЭРХТЭЙ

А.Тунгалаг

Зууны мэдээ, 2002.12.16, № 300

Одоогоос яг жилийн өмнө. Малын хулгайн хэрэгтээ зургаан жилийн ял сонссон, 27 настай Ганбат Зайсан дахь дамжин өнгөрүүлэх буюу 401 дүгээр ангийн эмнэлэгт амьсгал хураажээ. Ганбатын биеийн байдал эрс муудсан, түүнийг цагдан хорих шаардлагагүй байхад бүтэн жил хорьсон мөртлөө үхэхийг нь мэдэнгүүт шүүх хурлыг өрсөн хийжээ.

Тэр үед талийгаач дамжинд ирээд хоёр, ялаа сонсоод 12, цагдан хоригдоод 357 хоноод байлаа. Ганбатыг нас барснаар жилийн өмнө нээсэн 035296 тоот хавтаст хэрэг хаагдаж. Хүний эрхийн комисс 2001 оны 71 дэх гомдлыг хүлээж авах нь тэр.

Хүнээс авлагаа нэхэхээр гэрээсээ гарсан Ганбат 2000 оны арванхоёрдугаар сард хоёр хүнтэй цуг бусдын 40 адууг тууж яваад Налайхын цагдаа нарт баригджээ. Харин хамт явсан Батцэнгэл нь зугтан алга болсон байна.

Эрж сурж тэмдэглүүлсэн мал зүсээрээ, газар холдоогүй тул Налайхынхан тэр даруй данс бүртгэл хөтөлж, адууг эздэд нь буцаажээ. Баригдсан хоёр залуу ч хэргээ дор нь хүлээж. Тэд 72 цаг саатуулагдаж, цаашлан Ганц худагт хоригдож байгаад 2001 оны нэгдүгээр сараас Төв аймгийн Цагдаагийн газрын мэдэлд шилжжээ. Төв аймгийн мөрдөнд ирж, ахлах дэслэгч Ц.Батмөнхөд харъяалагдсанаар Ганбатын эрлэгт дуудуулах зам шулуудсан гэхэд болно.

Анхнаасаа хэргээ хүлээсэн Ганбатыг 11 сар хорихдоо Төв аймгийнхан 14 хоног байцаасан Налайхныхнаас илүүг хийж гавьсангүй. Батцэнгэлийг сурвалжилж хорьсон, эзэн нь тогтоогдохгүй байсан 23 толгой малын хэргийг Ганбатад нэмж хүлээлгэснээс өөр зүйл хийсэнгүй. 2001 оны арваннэгдүгээр сард яаран сандран шүүх хурлыг хийн ял сонсгожээ.

Болсон явдал ердөө л энэ. Хэрэг хийж, хүний мал хулгайлсанд нь талийгаачийн эцэг, эх ах дүүс өмөөрсөнгүй. Гагцхүү үүний эцэст хүүгийнх нь амийг авч салсанд туйлаас гомдолтой байна.

Талийгаачийн эх Г.Оюунчимэг Хүний эрхийн комисс, шүүхэд гаргасан өргөдөлдөө хэд хэдэн баримт дурдан, хүүгийнх нь үхэлд буруутай Төв аймгийн мөрдөн хорих анги, байцаагч Ц.Батмөнх, хорих эмнэлгийн ажилтнуудаас гомдол нэхжээ. Зарим баримтаас дэлгэвэл:

– Ганбат анх хоригдохдоо эрүүл байсныг Ганц худгийн урьдчилан хорих ангид хийсэн үзлэг гэрчилдэг. 55 кг жинтэй байсан Ганбат Төв аймгийн мөрдөнд жил хүрэхгүй хоригдохдоо 13 кг турж, тураалын гуравдугаар зэрэгт орсон төдийгүй өвчтөний түүхэнд бичсэнээр хурц хөндийт уушгины сүрьеэгийн хүндрэлээр цус алдсанаас нас баржээ. Талийгаачийн ясыг барьсан ШШБЕГ-ын хорихын нэгдсэн эмнэлгийн эмч нарын тодорхойлсноор “Ганбат нилээд удаан хугацаагаар өвдсөн бөгөөд хүндэрсэн хойноо тэднийд ирсэн тул эмчилгээ хийсэн ч нэмэр болоогүй аж. Эмчилгээг 3 сар ядаж 10 хоногийн өмнө эхэлсэн бол амийг нь аврах бололцоотой байсныг эмч нар тэмдэглэжээ.”

– Гэм буруутайг нь шүүх тогтоотол хүнийг гэмт хэрэгтэн гэж үзэхгүй байх заалт бий. Харамсалтай нь сэжигтнээр хэрэгт татагдан, цагдан хоригдож байгаа бүх хүнд учирдаг зовлон Ганбатыг тойрсонгүй.

“... Хэргийг шууд хүлээсээр байтал санаатай удааж, элдэв янзын эзэнгүй хэрэг тохож, хүүг минь дарамталж, камер хэсүүлэн зодуулж байсныг 2001 оны наймдугаар сарын 29-нд эргэж очиход “Би бушуухан хэргээ шийдүүлэн гармаар байна. Намайг шургууд хийгээд, камер хэсүүлээд байна. Миний бие дийлэхээ болилоо” гэсэн хүүгийг минь үнэхээр цөхөрсөн үг гэрчилнэ.” **/Хүний эрхийн комисст гаргасан гомдлоос/**

Зодож дарамтлахаас гадна эргэлтээр аваачсан зүйлийг нь өгөхгүй байх, өгсөн мөнгийг мөрдөн байцаагч замаас нь авч, “материал канондуулсан, аваачсан эм тариаг цаг тухайд нь хийхгүй “мартдаг”, эсвэл хорих байрны бага дарга “энэ тариа хэрэггүй, бие нь даахгүй” гээд буцаачихдаг зэрэг эргээд бодоход эргэлзмээр, асуумаар олон зүйл Ганбатын ар гэрийнхэнд байдаг юм билээ. “Хэрвээ хууль сахиулагчид хуулиа мөрдсөн бол хүү минь амьд байх байсан” гэдэгт талийгаачийн эх эргэлзэхгүй байгаа. Эмнэлэгт хэвтүүлж нарийн шинжилгээ хийлгээ гэхээр Төв аймагт харъяаллын бус гэдэг, тэгсэн мөртөө Төв аймагт хэрэг гарсан гээд өөр газар руу шилжүүлдэггүй, батлан даалтад авъя

гэхээр гарсан хохирлын тал болох 350 мянган төгрөг нэхдэг, хэргээ анхнаасаа хүлээсээр байтал мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй гэсэн шалтгаан дурдаж, цагдан хорих хугацааг найман удаа сунгасан нь хүнд сурталынх байв уу, эсвэл хууль зөрчсөн ажиллагаа байсан уу гэдэг одоо ч ойлгомжгүй л байна. Мөрдөн байцаалт ингэж удааширч, хүний хувь заяа дэнсэн дээр байх үед түүний төлөө санаа тавих үүрэгтэй прокурор нь ч хаа байсан юм, өмгөөлөгч нь ч юу хийж байсан юм бүү мэд ээ.

Ганц тодорхой зүйл бол гуч хүрээгүй залуу хэдэн адуу хулгайлаад хүний үзээгүйг үзэн зовж, “цаазлуулснаас” хойш яг жил өнгөрч байна. Ганбатын эцэг, эх, эгч дүүс нь эрдэнэт амийг нь хэнээс, хаанаас нэхэхээ мэдэхээ больж, арга тасраад гомдол гаргажээ.

Гомдлын хариуд хүний эрхийн комисс:

“... Мөрдөн байцаагч Ц.Батмөнх яллагдагч Ганбатын холбогдсон хэргийг шалгаж шийдвэрлэхэд хойрго хандаж, ... яллагдагчийн эрүүл мэндийн байдлыг үл ойшоож, түүнийг удаан хугацаагаар хүнд нөхцөлд хорьж, хүнлэг бусаар хандсантай холбоотойгоор Ганбат хүндээр өвчилж нас барсан байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан “Хүн амьд явах эрхтэй ... Хэнд боловч хүнлэг бус хэрцгий хандаж болохгүй” гэсэн заалтуудад харшилсан, хүний эрхийн ноцтой зөрчил юм.” Гэсэн хариуг өгсөн байна.

Харин ЦЕГ ажил үүрэгтээ хайнга хандсан мөрдөн байцаагчаа цол бууруулж шийтгээд л болж. Хүний эрхийг зөрчсөн тухай Хүний эрхийн комиссын албан тоотод УПЕГ хариу өгсөнгүй. Ингэж таг чиг байгаа нь ажлаа хийж чадаагүй Төв аймгийн прокуроруудаа өмөөрснийх үү, эсвэл аливаа гомдол, саналд хайхрамжгүй хандаж сурчихсан зангийнх уу? Харин өмгөөлөгчдийн холбоо өмгөөлөгч Сувдмаагаа шууд л өмгөөлжээ. Эцэст нь тэдний мэдэлд байж, тэдэнд хувь заяагаа даатгасан иргэн Ганбат амь насаараа хохироод үлдэв. Гомдлоо нэхэж амжаагүй түүнийхээ өмнөөс ах, дүүс, эцэг, эх нь буруутнуудад зэм хүртээхийг шаардаж, амь насных нь хохирлыг Төв аймгийн цагдаа, прокурор, хорих байрны хүмүүсээс нэхэмжилжээ. Хамаг учир нь мөнгөнд биш харин дахин ийм явдал аль болох цөөн гаргахын төлөө л өнгөрснийхөө ясыг өндөлзүүлэн дуугарах болсноо Ганбатын ах дүүс учирласан.

Харин хэл ам гараад эхлэхээр буруугүй буруутнуудад өөрсдийгөө хайцаалах үг ч бас олджээ. Мөрдөн байцаагчид “Одоо үйлчилж байгаа хууль, тогтоомжууд, манай хуулийн байгууллагын бүтэц, тогтолцоо хэн нэгэн хэрэгтэн болон иргэнийг дарамталсан байдлаар хэрэг хүлээлгэхийн эсрэг байдаг. Мөрдөн байцаагчдын үйл ажиллагаанд, прокурор, өмгөөлөгчөөс гадна удирдлагууд өдөр бүр хянаж байдаг” хэмээн ярих дуртай. Энэ нь “дарамталж хэрэг хүлээлгэх явдал Монголд байхгүй, байх ч боломжгүй асуудал” хэмээн тойруугаар хэлээд байгаа хэрэг. Мөрдөн, шоронд байдаг дэглэлт, хүний ёсноос гадуур тамлалт, байцаагч, хянагчдын дээрэнгүй зүй бус авирын тухай яриа дэгдээд байдгийг тэд тайлбарлахдаа “хэрэгтнүүд шүүхийн явцад ялаас зайлсхийх гэж зохиодог” гэсэн хариугаар ам тагладаг. Тэгвэл Ганбатын гэрийнхэн болоод тэднийг төлөөлж буй хуульч, өмгөөлөгчдөд тавих асуулт байна.

1. Яагаад байцаагч Ц.Батмөнх анх удаа хэрэгт холбогдож, хийснээ шууд хүлээсэн хүнийг батлан даалтад өгөлгүй 11 сар хорив. Байцаалт авахаа зарим үед 1-2 сараар “мартчихдаг” байцаагч Ц.Батмөнх цагдан хорих хугацаагаа сунгахыг хэзээ ч мартаагүй. Харин яагаад найман удаа сунгахдаа зургаад нь “мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй” гэсэн ганцхан шалтгааныг дурддаг байв.

2. Ганбатаас авсан есөн удаагийн байцаалтын зургаад талийгаач бие өвдөж байгаагаа хэлж, есдүгээр сараас хойш хэргээ хурдан шийдүүлэхийг гуйдаг болжээ. Хэрвээ хэргийг нь шийдэхгүй ингэж удаах байсан юм бол яагаад эмчилгээ хийж болоогүй юм бэ. Энэ асуултад ар гэрийнхнээс нь авчирсан пенициллин, витаминь комплекс, новокайныг тарьсан, Төв аймгаас түргэн дуудаж үзүүлсэн, шижилгээ хийлгэсэн зэрэгхэнийг дурдана. Гэхдээ талийгаачийг үхлүүтээр дамжинд шилжүүлтлээ сүрьеэтэй гэдгийг нь мэдээгүй, тогтоогоогүй.

Хүний эрхийн комиссын 71 тоот гомдлыг шалгасан баримтад нэг ноцтой өгүүлбэр бий. “Ер нь Төв аймгийн мөрдөнгөөс Ганбат шиг тураалтай, сүрьеэтэй, амь тавих дөхсөн хүмүүс ирдэг” гэж ШШБЕГ-ын харъяа хорихын нэгдсэн эмнэлгийн эмч тайлбар өгсөн байдаг. Нээрээ яагаад Төв аймгийн мөрдөн хатуу ширүүн, хүнд нөхцлөөрөө Монголд алдартай болсон юм бэ. Яагаад ганц худагт мөрдөгдөж байгаа архаг хэрэгтнүүд хүртэл Төв аймгийн

мөрдөнд очихоос жийрхдэг вэ. Хэрвээ энэ нь худлаа байсан юм бол яагаад энэ олон жил ам дамжин яригдаж ирэв. Хүний эрхийг зөрчиж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй аймгийн прокурор, өмгөөлөгчид нь дуугардаггүй нь ямар учиртай юм бэ. Энэ мэт олон асуултад иргэн Ганбатын хэргээ шийдүүлж “цааз” авсан түүх хариулт ч, баримт ч болох шиг.

Иргэн Г.Оюунчимэг Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төвийн тусламжтайгаар хүүгийнхээ амь насны хохирлыг нэхэмжлэн шүүхэд хандаж, анхан шатны шүүх дээрээ ялагдах хүлээжээ. Гэвч давж заалдаад байна. Энэ хэргийг дараагийн шатанд өмгөөлөхөөр ажиллаж буй тус төвийн тэргүүн М.Ичинноровоос хэргийг өмгөөлөх болсон шалтгааныг лавлавал:

- *Нэгдүгээрт, энэ асуудал дээр Ганбатыг гэмт хэрэгтэн гэж үзэж, түүнд хайнга хандсан. Өнөөдөр гэмт хэрэг хийсэн хүнийг яаж ч болно гэх хандлага манайд түгээмэл байна. Жирийн хүнтэй харьцуулахад гэмт хэрэг хийсэн хүний эрх тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг хэдий ч бүх хүнд олгогдох салшгүй олон эрхийг эдлэх ёстой. Тэр эрхийг нь төр хангах л ёстой байсан.*

- *Хоёрдугаарт, өнөөдөр байгууллага, албан тушаалтны буруугаас, хүний эрхийг зөрчих, хүнлэг бусаар хандах, зарим тохиолдолд санаатайгаар хүний амь хохироочихоод байхад буруутай этгээдээр амь насны хохирлыг арилгуулах ёс манайд байдаггүй. Тийм болохоор бид энэ асуудлыг шүүхийн практикт тогтоох шаардлагатай болсон гэж үзэж байгаа юм.*

- *Гуравдугаарт, Ганбат бол шүүхээр хэргээ шийдүүлтлээ буюу 2001 оны арваннэгдүгээр сарын 30 хүртэл гэмт хэрэгтэн биш байсан. Шүүхээс албан ёсоор тогтоогоогүй байхад гэм буруутайд тооцож үл болдог.*

Энэ зарчим алдагдах л юм бол гэмт хэрэг хийгээгүй хүн сэжигтнээр цагдан хоригдохдоо янз бүрийн дарамт шахалтад автаж, хийгээгүй хэргээ хүлээх, улмаар хэзээ нэгэн цагт үхэж болох нөхцөл бүрддэг. Тийм учраас цагдан хоригдож буй хүн ял шийтгэл эдэлж байгаа хүмүүсээс илүү таатай нөхцөлөөр хангагдах ёстой боловч манайд бол эсрэгээрээ, урьдчилан хорих байрны нөхцөл шоронгийнхоос ч хүнд. Үүнийг олон улсад нөхцөлөөр дарамталж хэрэг хүлээлгэх арга барил гэж үздэг. Ганбатын хэрэг дээрээс ч нөхцөлөөр дарамталсан баримт бий. Ийм учраас манай байгууллага энэ хэрэг дээр онцгойлон анхаарч байгаа юм.

Эцэст нь дүгнэхэд:

“Хэрэгт холбогдсон иргэн хүн төрийн байгууллага, түүний албан тушаалтнуудын мэдэлд байцаагдаж, төрийн байранд нь хоригдож байгаад тураалд орж, нийгмийн хурц халдварт өвчинд нэрвэгдэж, улмаар амь насаа алдаж байгааг юугаар ч зөвтгөх аргагүй юм” /Хүний эрхийн комиссын дүгнэлтээс/

1.8 ЭЭЖЭЭ, БИ ЖААХАН ТОГЛОЁ Л ДОО

А.Тунгалаг

Зууны мэдээ, 2002.12.18, №311 /1197/

Хүүхдийн эрх зөрчигдөж хүчирхийлэл дарамтад өртсөн тухай бишгүй л ярьж бичдэг. Тэгвэл энэ удаа төрсөн эцэг, эхийнхээ “халамжинд” дарамтлуулж яваа хүүхдүүдийг өмөөрмөөр санагдлаа.

Өмгөөлөх гэсэн охин минь Хулан гэж нэртэй нэгдүгээр ангийн сурагч. Охины эцэг, эх түүнийг зургаан нас хүрэх үү, үгүй юу сургуульд оруулжээ. Хулан өглөө жирийн сургуульдаа явж, дөрвөн цагийн хичээлийнхээ дараа гэртээ ирж, үдийн хоолоо идчихээд хэлний сургуульдаа яарна. Тэнд англи хэл заалгадаг. Хулангийн аав, ээж охиноо жилд 500-800 ам.долларын төлбөртэй гадаад хэлний сургалттай сургуульд оруулж болох байсан ч “монгол ч үгүй, англи ч үгүй” эрлийз болгохоос сэргийлж, жирийн сургуульд оруулж, гадаад хэлийг дугуйланд, тусгай багшаар заалгахаар болжээ.

Энэ нь мөнгөнд хэмнэлттэй нөгөөтөйгүүр ерөнхий боловсролын суурь тавигддаг 1-7 дугаар ангидаа эх хэлээрээ хичээл заалгавал охинд нь ойлгомжтой, ашигтайг тооцсон хэрэг. Тэгээд ч жирийн сургуульд ч гэлээ жилд 40 мянган төгрөгийн хандивтай тооны гүнзгийрүүлсэн ангид охин нь сурч байгаад сэтгэл хангалуун байдаг. Хойтонгоос охиноо драмын сургуульд сургана. Боломж олдвол миссийн, дууны гээд тэмцээнд оруулж, багаас

нь “од” болгох хүсэлтэй. Том болохоор нь гадаадад сургах төлөвлөгөө ч бий. Энэ бүхэнд багагүй зардал гарна. Гэвч охиныхоо ирээдүйд хөрөнгө оруулахын тулд эцэг, эх нь бүхнээ зориулахад бэлэн. Хулан хэлний сургуулиасаа тарж гэртээ ирээд, цайгаа уунгаа хэсэг амсхийгээд дахиад л ширээний ард сууна. Энэ бол түүний үүрэг. Харин хоол хийх, дэлгүүр явах, гэрээ цэвэрлэх гээд гэрийн бүх ажлыг тэднийд суудаг хамаатных нь ах амжуулна. Хулан зөвхөн хичээлээ сайн давтаж, онц сурах л ёстой. Охиныг нь сайн харж, хоёр сургуульд зөөж, хичээлийг нь сайн давтуулаад байвал хойтон дээд сургуульд оруулахаар амласан тул хамаатны ах нь Хулангийн даалгаварыг яс хийлгэнэ. Охин ядарч, хичээл хиймээргүй санагдахаараа чаддагаараа түүнд л эрхэлж тунина. Ах нь түүнийг аргадаж, “хичээлээ хурдан хийчих, тэгээд хүүхэлдэйн кино үзээрэй” гэнэ.

Тоо, цагаан толгой, дээр нь “father, mother”-г цээжлэх. Охин яаж ийж байгаад хүүхэлдэйн кино үзэх гэж мэрийнэ. Харамсалтай нь түүнд тийм аз завшаан тэр бүр олдохгүй. Тэр зөвхөн дотроо, сэтгэлээрээ л гүйж, барбигаа тэвэрч, эсвэл компьютер тоглож, хориод минут тааваараа байв уу, үгүй юу хонх жингэнэж, ахиад л эрх чөлөөг нь хумиж орхино. Ээж ажлаасаа ирж байгаа нь тэр.

Ээж. Одоо ээжийн цаг. Ээж хоолоо идчихээд оройн цагаа охиндоо зориулж, даалгавараа хэрхэн хийснийг шалгадаг юм. Нэг үсэг баллах, нэг үг мартахыг ээж зөвшөөрөхгүй. Хэрвээ нэг л муруй бичиг, балласан тоо нүдэнд нь өртвөл ээж “дахиад бич” гэнэ. Энэ тохиолдолд охины ажлын өдөр аав, ээжийн зурагт үзэж дуустал үргэлжилж ч мэднэ. Хулан амралтын өдрийг тэсч ядан хүлээдэг. Аргагүй биз дээ. Тэр өдөр л түүнд гадаа гарч хоёр цаг тоглохыг зөвшөөрдөг. Гэхдээ бас болзолтой. Гадаа дулаахан бөгөөд ээж, аавынхаа үгнээс огт гараагүй, хичээлдээ дандаа “А”, “В” авсан бол тоглох эрхтэй. Ээж багштай нь үргэлж утсаар ярьдаг, сард нэг удаа уулздаг болохоор Хуланг ямар сурч байгааг дэндүү сайн мэднэ.

Иймэрхүү дүр зураг зөвхөн Хуланд хамаатай биш. Энд гайхаад байх зүйл ердөө алга. Хүүхдэдээ халамжтай эцэг эх, тэдний үгнээс гардаггүй, дуулгавартай хүүхэд. Хүүхдийн эрх зөрчсөн гэх юу байгаа юм хэмээн ундууцах хүмүүс гарч магадгүй. Тэгвэл эрүүл ахуйн эмч нарын зөвлөснөөр хүүхдээр ингэж өдөржин хичээл давтуулж болохгүй. Тэр бүү хэл, хичээл давтах цаг анги ангиар ялгаатай байдаг. Найман настны түвэггүйхэн хийчихдэг зүйлд зургаан настан багагүй зүдэрдэг тул хүүхэд өдөрт хэдэн цаг хичээл давтах ёстойг шинжлэх ухааны үндэстэй тогтоожээ. Үлдсэн цагт нь хүүхэд амрах, тоглох, гүйх, үймүүлэх ёстой. Гэтэл Хуланг хар даа. Удахгүй түүний толгой өвддөг, дээр нь хатгадаг болно. Хоёр жилийн дараа хараа нь муудна. Юм л бол ханиад хүрчихээд байдаг сульдаатай болохоос гадна биеийн тамирын хичээлд “сулхан” гэж багш нь дүгнэнэ. Хулангаас авах л юм нь хичээлдээ сайн.

Тоглох. Энэ эрхийн цаана хүүхдийн хэвийн өсөн торних, эрүүл саруул хүн болох нөхцөл нуугдаж байгаа юм. Тэгэхээр зургаан настай охиноор арван цаг хичээл давтуулдаг, халамжит ээж, аавуудыг шүүмжилмээр байгаа юм. Аав, ээж, багш гурвын үг үнэн гэж ойлгож, тэднийхээ үгэнд сайн орвол том болоод ачийг нь хариулна гэсэн чин хүсэл тээж яваа бяцхан охин хийх ёстойгоо л хийж буй. Гэтэл хүүхдийнхээ ирээдүйд санаа тавьж, багаас нь боловсролтой болгох гэж зүтгэж буй эцэг, эхийн буруу ч гэж юу байх вэ. 22 цаг өнгөрч байна. Хулан хичээлээ давтаж л сууна. Дотроо юу бодож байгаа бол. Тэр том болоод “хүүхэд насгүй” хүүхдүүдийн төлөө дуугарах болов уу яах бол.

1.9 ЖАРГАЛТАЙ ГАЗАР ХҮН ТОГТДОГҮЙ...

А.Тунгалаг

Зууны мэдээ, 2003.01.11, № 9

2002 оны тооллогоор манай улсад 541149 өрх бүртгэгджээ. Эдгээр өрхийн 83.7 хувийг эр хүн толгойлдог. Тэднээс гурвынх нь тухай цухас дурдахын учрыг төгсгөлд нь өгүүлье...

Оргийнх зургаан хүүхэдтэй, өнөр олуулаа айл. Өөрөө эдийн засагч мэргэжилтэй. Харин гэргий Цэвэлмаа нь Санхүүгийн техникум төгссөн, нябо хүн. Одоо гэртээ группт байдаг. Тиймээс сард хориод мянган төгрөг улсаас царайчилдаг Цэвэлмаа нөхөртэйгөө яаж эн зэрэгцэхэв. Ажилдаа ч, ар гэртээ ч Орги шиг нэр хүндтэй хүн үгүй. Хэдэн төгрөг

салгадгаа боддог уу, хүүхдүүд нь ч түүний үгэнд чих зөөлөн байдаг. Харин Орги архи, тамхинд ая тааваараа зарж, ах дүүдээ 50, 60 мянган төгрөг ил далд байнга өгдөг атлаа эхнэрийнхээ гар дээр тавьсан ганц дэвсгэртийг ч алдалгүй яс тооцно. Аавын дээрэнгүй байдал хүүхдүүдэд ч нөлөөлж, Цэвэлмаад хандах нь ширүүхэн, хэлсэн үгийг нь тээршаах янзтай болжээ. Гэтэл энэ амьдралын төлөө хамгийн их зүтгэсэн хүн нь Цэвэлмаа байлаа. Тэрээр эзэмшсэн мэргэжлээрээ тогтвортой ажиллаагүй, гавъяа байгуулж гийгүүлсэнгүй. Харин ч бүр цомхотголоор халагджээ. Зургаан хүүхдийг төрүүлж өсгөнө гэдэг цаг, хөдөлмөр шаардсан ажил. Хүүхдээ халуурч бүлээрч байхад сургууль хичээл эхлэх гээд ном дэвтэр цуглуулж сандарч тэвдэх үед ч Орги огт ажиггүй хөдөө гадаа томилолтоор явчихна. Энэ бүхэн ганц Цэвэлмаагийн үүрэг. Гэвч одоо хүн бүхэнд адлагдсан, уймраа, үглээ авгай болж. Амьдралаа, үр хүүхдээ дээдэлснийх нь төлөө амьдрал түүнд өгсөн хариу нь энэ.

Уйлах хүүхэдгүй санаа амар хөдөлбө, ажиллая гэхэд нас ч явж, бие нь мууджээ. Арга буюу аяга цайны сүүний мөнгө нөхрөөсөө царайчилна. Бусдын нүдээр харахад түүн шиг амар, жаргалтай хүн алга. Өссөн хүүхдүүд, сайн нөхрөөрөө тэжээлгэсэн авгай. Гэтэл мөн чанартаа...

Зулаа наймаа хийдэг. Үүрээр шахуу гэрээсээ гарч, үдшийн бүрий хүртэл зундаа хайлж, өвөлдөө хөлдөх шахан зах дээр зогсон гэрийнхнээ тэжээнэ. Зав зай гарах л юм бол Эрээн явах, хүүгийнхээ багштай уулзах гээд хөөцөлдөх, хийх ажил мундахгүй. Харин Тулга гэртээ. Гэрээ цэвэрлэх, хүүхдээ харах, хоол хийх ажилтай. Зулаа нөхрөө ажилд оруулах гээд яджээ. Эхний ажлыг Тулга цалин бага, нөхцөл муу гэж голов. Зулаагийн арай хийж гуйж оруулсан дараагийн ажлаас эзэнтэйгээ муудалцаад гарчээ. Гурав дахид нь авсан цалин ч үгүй, харин ч хэд гурван дампуу залуустай нийлж дарвиад байсан тул Зулаа гаргаж, Эрээн рүү бараанд явуулав. Гэтэл мөнгө ч үгүй, бараа ч үгүй, хөрзийсэн хар царайтай амьтан ирж Зулааг бүр мөсөн хашраав. Ганц төгрөгийн орлогогүй мөртлөө Тулга тамхи, автобусны мөнгө гээд эхнэрээсээ үргэлж татвар авна. Түүгээр ч зогсохгүй хааяа хэд хоног дарвин алга болж, Зулаад бөөн өр авчирна. Гэмшингүй царайлан ирснээсээ хойш хориод хоног гэрээ цэвэрлээд, томоотой байна. Найзуудынх нь атаархдагаар Зулаа шиг эрх мэдэлтэй хүн үгүй. Бүх асуудлыг шийднэ гэдэг сайхан гэнэ. Харин Зулаад юу нь сайхан байхав дээ. Сүүлийн үед түүний толгой өвдөж, зүрхээр нь хатгуулах болжээ. Амьдралаа бодохоос эмнэлэгт очих нь байтугай тайвуухан бие засах ч завгүй. Хүүхэд нь өсч сургуульд орлоо. Тэр хэрээр зардал нэмэгдлээ. Ядахад ганзагын наймаа хумигдаж, бэнчин багатай хүмүүс захаас шахагдаж буйг хэлэх үү. Харин Тулга яг хуучнаараа, ажилд орох янзгүй. Хайрлаж ижилссэнээ бодохоор хүүгийнхээ эцгийг Зулаа хөөж чадахгүй. Харин амьдралаа, ирээдүйгээ төсөөлөхөөр бачимдаад ирнэ. Өдөр хоног өнгөрсөөр л ...

Тэд тун жаргалтай хос. Ганхүү эхнэртээ халамжтай, хоолны шимтэйг идүүлж, хувцасны сайныг өмсгөх хүсэлтэй. Хулан ч сайхан хүүхэн. Боловсролтой, урлаг, гоо сайхны мэдрэмжтэй. Ганхүү гэрлэхдээ Хуланд ганц л болзол тавьсан нь “Чи ажил хийх хэрэггүй. Би чамайгаа юугаар ч дутаахгүй тэжээж чадна” гэсэн үг. Үнэхээр ч амласан ёсоороо Хуланг мөнгө, халамж, хайраар дутаасангүй. Гэвч хэсэг хугацааны дараа нөхрийх нь хайр халамж түүнд заримдаа тээртэй санагдах болжээ. Ажилгүй хүн уйдна. Найзуудтайгаа уулзая гэхээр “Тэр нь нөхөргүй, тэр нь ч нөхрөөсөө салсан, эсвэл хэн ч дээ айлгүй, чамайг буруу тийш уруу татаж магадгүй” гэж зөвлөсөөр үерхдэг хэдэн хүүхнээс нь холдуулжээ. Зурагт үзэхээр “наад савангийн дуурь чинь ёстой цагийн гарз”, ном уншихаар “дэмий ном уншаад, амраач” гэнэ. Уурлаж, зандчих биш аргадангуй хэлэх нөхрийнхөө нөхөрсөг зөвлөгөө, шүүмж, зааварчилгаас залхсан Хулан Ганхүүгийн хувьд удам дамжин өвлөсөн үнэт хөөрөгнөөс өөрцгүй санагдана. Гэтэл тэр нь чулуу, харин Хулан бол зүрхтэй, сэтгэлтэй хүн. Хүсэл мөрөөдөл, зорилго төлөвлөгөөтэй орчин үеийн бүсгүй. Ганхүү түүнийг мэдэхийн цаагуур мэдэх, боловсролтой, соёлтой, ухамсартай хүн атал Хуланг ажилд орохыг зөвшөөрөхгүй. “Жаргалтай газар хүн тогтдоггүй, жавартай газар мал тогтдоггүй” гэж үнэн юм даа.

Гэр бүлийн хүчирхийлэл гэхээр нөхөртөө, эсвэл эхнэртээ зодуулж, нүүдүүлсэн хүнээр төсөөлөн боддог. Тэгвэл нударганы амтыг үзүүлэхийг бус сэтгэлийн хайрын хүч хэрэглэхийг ч хэлж болдог ажээ. Тиймээс бусдын харахад жаргалтай дээрх гурван эмэгтэй ч бас хүчирхийлэлд өртөгсөд ...

1.10 ҮҮРГЭЭ УМАРТСАН ЭРХ

Д.Түмэнжаргал

Зууны мэдээ, 2002.12.05, №292

“Та хүний нармай нээж болно оо. Гэхдээ таны зангидсан гар цаад хүний хамрын үзүүрийн яг өмнө очоод л зогсох ёстой.” Хүний эрх гэдэг ойлголтыг яв цав мэдрүүлсэн ийм өгүүлбэр байдаг. Хүний эрх, эрх чөлөө гэсэн энэ үг Монголчуудын хувьд цоо шинэ зүйл биш. Ялангуяа эрх чөлөө гэдэг нь нүүдэлчдийн амьдралын хэв маягтай салшгүй хобоотой болохоор чухам л ус, агаарын нэгэн адил эрхэм юмных нь нэг байлаа. Үнэхээр ч хэдэн малынхаа эрхээр хаа дуртай газраа нүүдэллэн, цаг, нар хоёроо хэнээр ч цагдуулж яваагүй бидний хувьд эрх чөлөө гэдэг ойлголт өглөөний нартай уралдан босч, үдшийн гялаантай зэрэгцэн орон гэртээ ирэх тэртээ өрнөдийн тариачин боолууд, газрын эзэн помещикуудаас тэс өөр байсаар ирсэн билээ.

Социализмын үед ч ялгаагүй бид өөрсдийгөө хамгийн эрх чөлөөтэй ард түмэн хэмээн тунхаглан, хүний эрхийн хувьд хорвоод хосгүй хүмүүс хэмээн зарлах шахдаг байлаа. Хэдийгээр хүний эрх гэгч нь хэр нарийн нандин зүйл байдгийг тэр бүр ойлгохгүй ч тэртээ далайн цаана орших Америк гэдэг аймаар муухай хөрөнгөтөн оронд л хүний эрхийг улан дороо гишгэн, ард иргэдээ боолын боол, босгоны шороо мэтээр үздэг ойлголтыг бидний оюун тархинд суулган, үлгэр домог шиг өдөр бүр сурталддаг байсан нь өдгөө хэнд ч нууц биш болжээ.

Харин талын Монголын цаг тооллын бичиг цагаан морин жилийг заах үед, нөгөө бүхнээс илүү эрх чөлөөтэй, хүний эрхийг Америкчуудаас илүү дээдэлдэг монголчууд маань гэнэт бужигналдаж эхлэн, улмаар найман настай нялх балчраас наяд гарсан настан буурал хүртэл ойлгож, хүндэлж, шүтэж, биширч явсан бүхэн ёстой л орвонгоороо эргэж, бид бүхэн биеийн төдийгүй сэтгэлийнхээ хувьд хамгийн эрх чөлөөгүй ард түмэн болохоо мэдэрсгээв. Хорвоод төрсөн хоёр хөлт сүүн тэжээлтнийхээ хувьд хүний наад захын эрхээ хязгаарлуулсан, социализм хэмээх амьтны хүрээлэнгийн үзмэр болоод байснаа гуравдагч орны дурын хүний амнаас хангалттай олон удаа сонсоцгоосон. Харин одоо хүний эрх, эрх чөлөө гэж чухам юу болохыг ойлгож ядсаар 12 жилийн нүүрийг ардаа хийгээд байна. Энэ хугацаанд юутай ч болов энэ хоёр ойлголтыг аль ч орны, хэний ч хүүгийн өмнө нүүр улайхааргүйгээр цаасан дээр баталгаажуулж, шинэ Үндсэн хуулиа батлан, түүнийхээ хүрээнд цөөнгүй хууль төрүүлж, эдүгээ эрх чөлөөт монголчууд гагцхүү түүгээрээ л амьсгалах боллоо. Харамсалтай нь, өнгөрсөн 12 жилийн хугацаанд бид хүний эрх, эрх чөлөө гэсэн хоёр үгийг л сайн цээжилснээс бус, энэ үг чухам юуг илэрхийлж, цаанаа ямар ойлголтуудыг цогцоор нь багтааж явдаг талаар тун маруухан төсөөлөлтэй таваргаж иржээ. Хүний эрх, эрх чөлөө гэдэг үг зүгээр л маанийн үсэг шиг амны уншлага болсноос бус, амьдралдаа хэрэгжүүлэх, эрх гэдэг энэ айхтар үгийн ард үүрэг гэж түүнээс ч айхтар зүйл сүүдэр мэт дагалдаж явдгийг даанч нэг анзаарсангүй явж дээ гэхэд хилсдэхгүй. Тиймээс ч харц ард, хаад ноёд нь хүртэл хүний эрх, эрх чөлөө гэсэн үгийг нохойд барьдаг мод мэт үздэг болж, түүний мөн чанарыг ойлгоогүй цаад нөхөд нь мад тавиулсан шатрын ноён шиг яахаа мэдэхгүй суух дүр зураг хаа сайгүй харагдах болсон ажээ. Өөр нэг үг бас байдгийг бас эргэн саная. Манайхан сайн мэддэг. Гэвч мартчихдаг юм боловуу гэсэн сэтгэгдэл өөрийн эрхгүй төрдөг юм. Мартахаас гадна ор тас мэдэхгүй хүн ч цөөнгүй байдаг юм шиг санагддаг.

Ардчилал хэдэн зуун жилийн турш хөгжиж, суурин амьдралын шороо тоостой үе удмаараа зууралдсан цөөнгүй орны хувьд энэ үг бичигдээгүй л болохоос Үндсэн хуулиасаа илүү үйлчилдэг гэхэд болно. Энэ бол “Таны эрх бусдын эрхээр хязгаарлагдана” гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, “Та эрхтэй, мөн тэр ч эрхтэй” гэсэн сануулгыг албан ёсны хэлээр илэрхийлчихсэн хэрэг л дээ. Үүнийг задлаад л, энд тэндээс жишээ аван тайлбарлах шаардлага бараг үгүй. Нөгөө талаас, аливааг шууд утгаар нь ойлгодог хүмүүсийн хувьд энэ чинь юу гэсэн үг вэ гэдгийг цөөн ч болов үгээр тайлбарлах хэрэг гарч мэдэх юм. Тухайлбал, бид үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Мөн хэн нэгнийг хэвлэлийн хуудсаар зад шүүмжилж, эцэг, эхээс заяасан нэр төрийг нь олны дунд улайтал дуудаад хэлчих эрх бий. Тэгвэл нөгөө хүнд эрхтэнийхээ гажиг, согог, хувь хүнийхээ нууцтай холбоотой зүйлээр хараалгаж, доромжлуулахгүй байх эрх бас бий.

Эрхэм та хүнийг шүүмжилж, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй ч аливаа хувь хүнийг бие бялдар, оюун ухаанаар нь доромжлон гутаах ёсгүй гэсэн үүрэг хүлээсэн байдаг гэсэн үг. Харамсалтай нь бид үүнийг мартчихдаг. Ухаандаа эрхтэй гэдгээ алхам тутамдаа санадаг хэдий ч, чухам ямар үүрэгтэй вэ гэдгээ л мартчихдаг гэсэн үг. Өнөөдөр эмч хүн өвчтөнийг эмчлэх үүрэгтэй. Тэр үнэн. Тангараг хүртэл өргөчихсөн байгаа. Тиймээс алтан амь, амьдрал нь хором хормоор хэмжигдэн, үхэл сэхлийн дэнсэн дээр байгаа хүүхдээ эмнэлэгт авчирсан эцэг, эх эмчид “Чи эмчлэх үүрэгтэй” гэсэн цорын ганц шаардлага тавьдаг. Энэ зөв, учир нь иргэн та ингэж шаардах бүрэн эрхтэй. Гэхдээ үр хүүхэд, эцэг, эх, өөрийнхөө эрүүл мэндийн талаар байнга халамж анхаарал тавих ёстой үүргээ бас л мартчихсан харайж явдаг. Энд өөрийнхөө эрхийг илүүтэй эрхэмлэн дээдлэж, үүргээ мартагч хажуугаар бусдын үүргийг огтхон ч мартдаггүй хачирхмаар монгол зан харагдаад байгаа биз.

Өөр нэг жишээ хэлье. Шугамын автобусыг хаана ч хамаагүй зогсоож, тасалбар аваагүй нэгнийг заамдан гаргаж, тусгай автобусанд хорьж “матарлан”, байгаа мөнгөөр нь торгочихдог явдал цөөнгүй л байдаг. Хэн дуртай нь хүн баривчилж, нэгжин, хүний эрхийг ч ёстой улан дороо гишгэж байна даа гэлцэж байхтай та тохиолдож байсан л биз. Тийм ээ. Хүн дуртай унаандаа сууж, хүссэн чиглэлдээ зорчих эрхтэй. Энэ эрхийг хэн хүнгүй сайн мэднэ. Харин эрхэм иргэн та үйлчлүүлж буй унааныхаа хөлсийг төлөх ёстой. Энэ үүргээ умартсанаас л зөрчил үүсэх бөгөөд ийм үед хүний эрх зөрчлөө л гэхээс бус үүргийн тухайд огтхон ч дурсдаггүй нь харамсалтай. Эндээс харвал эрхгүй үүрэг, үүрэг хүлээгээгүй эрх гэж огтхон ч байдаггүйг амьдрал өөрөө баталж нотлоод байдаг. Гэвч бид нэгнийг нь дөвийлгөх хирнээ нөгөөг нь бараг мартдаг болж. Эрх, эрх чөлөө гэж чангаар хашгирах хэрнээ үүрэг гэдэг нэг талыг нь харахаараа дуу нь сулраад эхэлдэг болжээ. Хүний эрх, хүлээх үүрэг хоёр бол Сиамын ихрүүд шиг салшгүй холбоотой зүйл. Тиймээс бид хүний эрхийн талаар ярихдаа үүргийн тухай заавал дурсах ёстой гэж санагддаг. Ямар ч үүрэггүй бөөн эрх байж огтхон ч таарахгүй биз дээ.

Эцэст нь, бид хүний эрх гэдэг үгийг зөвхөн хоосон цээжилснээр нийгэм урагшлахгүй. Хүн юуны өмнө эрхээ тун сайн мэдэж байх шаардлагатай юм. Ингэснээр бусад нөхөд чинь ямар эрхтэйг сайтар ухамсарлахын дээр “таны эрх бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагдана” гэдэг үгийн мөн чанарыг ойлгох болно. Би эрхтэй, тэр эрхтэй, би үүрэгтэй, тэр үүрэгтэй гэдгийг ухамсарлаж чадвал сая миний зангидсан гар таны хамрын үзүүрийн өмнө очоод зогсох бизээ.

1.11 SEXUAL HARASSMENT

Д.Түмэнжаргал

Зууны мэдээ, 2002.12.23, № 306

Латин үсгээр бичсэн энэ хоёр үгийн учрыг тайлбарлахын өмнө тун ойрхны нэгэн жишээг та бүхэндээ толилуулья. Дээрх гарчгийн учрыг ойлгоход энэ жишээ тус болно байх хэмээн бодож байна.

Өнөр бүсгүй эмчийн мэргэжилтэй. Нөхөр нь багш бөгөөд сурган хүмүүжүүлэх ажилд амьдралынхаа 25 жилийг зориулсан юм. Эднийх хүү, охин хоёртой. Тэд сургуульдаа боломжийн дүнтэй суралцдаг агаад энэ айл сэхээтнүүдийн л нэгэн адил хоёр идэхгүй, хоосон хонохгүй өдөр сарыг өнгөрөөж байв.

Гэвч том хүү нь аравдугаар анги төгсч, их сургуулийн босго алхсанаас хойш энэ айлын санхүүгийн асуудал үе үе хүндрэх болж, эхнэрийнх нь монетон ээмэг, бөгж энд тэндхийн ломбардыг хэсэх шаардлага өөрийн эрхгүй тулгарч эхэлжээ. Ийнхүү ломбард хэмээх өвөрмөц банкинд сар бүр хүү төлж, хүний царай харж явснаас найз нөхдөөсөө бага хүүтэй зээл авч нэг муу ТҮЦ ч атугай босгоё гэж шийдэцгээв. Мэдээжийн хэрэг, ийм шийдвэр гаргахад хөрш айлынх нь ТҮЦ-тэй эмээ даралтаа үзүүлэхээр орж ирэхдээ хуучилсан яриа нөлөөлсөн аж. Тэгээд ямар ч байсан иймэрхүү юмтай байвал ядаж хоолны мөнгө сул орж ирэх юм гэдгийг тун сайн ойлгожээ.

Өнөр хүн нилээд орж, гардаг нэгэн дэлгүүрт лангуу тавих хэмжээний газар түрээсээр авч, гоо сайхны бараа худалдахаар шийдсэн байна.

Найз нөхөд нь туслахаар амласан мөнгөө өглөө. Түүгээр нь эхлээд аятайхан лангуу, тавиур хийлгэж тавилаа. Бараа бүтээгдэхүүний хувьд хүндрэл гарсангүй. Бөөний үнээр

өөрсдөө авчраад өгчихдөг компаниуд Монголд нилээд байдгийг мэдсэний дээр зарим нэг нь зээлээр хүртэл олгодог болохыг мэдэж. Өнөр сэтгэл тун өндөр байв.

Харин түүнд ийм худалдаа, үйлчилгээ эрхлэх эрхийн бичиг авах ажил тулгарч, нэлээдийг нь давсан боловч татварын хэлтэс дээр очоод л гацаж орхижээ. Байцаагч Өнөрт ийм, тийм хууль зөрчсөн байна, энэ тэр гэсэн юм хэлсэнгүй. Өнөр ч ийм зөвшөөрөл авах талаар хажуугийн лангууны бүсгүйгээс гайгүй сайн зөвлөгөө авсан болохоор түүнийг хоолонд урихаас эхлээд л гэдгэр занг нь засах замд оров. Гэтэл ахимаг эрийн сэтгэлийг ид насандаа яваа энэ бүсгүйн дайллага цайллага хангасангүй. Тэрээр огт өөр зүйл хүсч буйгаа үг яриа, үйл хөдлөлөөрөө илэрхийлж байв. Хэдийгээр ил цагаан хэлж чадахгүй ч хашир эрийн далд утгатай үгийн цаана “Чи надтай нэг шөнийг өнгөрөөчих. Тэгвэл хүссэн зүйл чинь нүд ирмэхийн зуур бүтнэ.” Гэсэн санаа нуугдаж байв. Мань эр ч энэ мэт аргаар эмс охидыг эрхшээлдээ оруулаад гаршчихсан болох нь мэдэгдэж, энэ надтай шөнийг өнгөрөөхгүй хаа холдох вэ гэсэн бардамналаа огтхон ч нуухгүй байлаа. Өнөр түүний дарамтыг хүлцэнгүйгээр хүлээж авах нэгэн биш байлаа. Тэрээр биеэ худалдан байж талхныхаа мөнгийг олох зөвшөөрөл авах нь эмч хүн, эмэгтэй хүний ёс зүйн хувьд яавч дагах зүйл биш гэдгийг ойлгож байсан учир эрхэм даргыг хоёр орой хоолонд оруулаад л энэ мунаг, мугуйд хүн бодлоо огт өөрчлөхгүйг мэдэж, зорьсон ажлаа орхихоос аргагүйд хүрчээ. Үүнийгээ ч нөхөртөө хэлэв. Ингээд найз нөхдөөсөө зээлсэн мөнгөөр авсан бараагаа бөөндөж зарав. Гайтай ТҮЦ-ээс үүдэн, Өнөрийн ээмэг, бөгж битгий хэл, хөргөгч, зурагт, хивс нь ломбардад залрах болсноор энэ түүх төгсчээ.

Миний бие татварын байцаагчийг яллаад, шоронд хатааж, шонд дүүжлээд өгөөч хүссэндээ үүнийг дурдсан юм биш. Мөн Өнөр бүсгүйн ёс журамтайг магтан дуулах гэсэнгүй.

Харин “хандрах” гэж манай залуучуудын ярьдаг нэгэн ойлголтын талаар та бүхэнтэй санал солилцох гэсэн юм. Тэгээд ч гарчигт байгаа англи үгийн утга гагцхүү үүнийг илэрхийлдэг бөгөөд “икс” гэсэн тодотгол хийсний дүнд түүний олон салаа утга цэгцэрч, ардчилал жинхэнэ утгаараа хөгжсөн өрнөд Европ, Америкт энэ үг хуульчлагдан, улмаар ягштал мөрддөг дүрэм болсон билээ. Sexual harassment. Энэ үгийн ард юу эс нуугддаг гэж бодно. Гэхдээ энэ нь манайхны хувьд гайхаад байхаар зүйл биш. Яагаад гэвэл хэн нэг албан тушаалтан, эсвэл ердөө л эрчүүдийн зүгээс ийм халдлагыг эмэгтэйчүүд бүсгүйчүүд рүү байнга хийсээр ирсэн юм. Тэд ямар нэг хүсэлт, гуйлтыг биелүүлснийхээ хариуд бэлгийн харьцаанд орохыг үг хэлээр биш ч үйл хөдлөлөөрөө тулган шаарддаг. Уг нь манай эрүүгийн хуульд энэ талаарх заалт бий нь бий. Дарга нь “цэргээ” оролдвол ингэнэ, тэгнэ гэсэн утгатай байдаг. Гэсэн хэдий ч ажилгүйдэл, ядуурал газар аваад ирэхээр эрчүүд бус ядарсан эмэгтэйчүүд л талхны мөнгө, үр хүүхдүүдийнхээ өмсч зүүх хувцасны төлөө тэдний дор хэвтэхэд бэлэн шахам явдаг нь хэнд ч нууц биш болсон учир хуулийн энэ заалт бүдгэрэн бүдгэрсээр ямартаа ч энэ зүйл заалтаар хэн нэгэн хүн өргөст торны цаана хоригдсон гэж дуулсангүй.

Тэгвэл ардчилал хөгжсөн болон манайхтай ижил гараанаас эхэлсэн орнуудад байдал огт өөр байна. Эмч Өнөрийг дарамталсан шиг татварын байцаагч бол өдийд ингэснийхээ төлөө дааж давшгүй торгуульд уначихсан байх ёстой. Тэнд эрхэм бүсгүй таны өгзөг, хөх рүү жоготой харц чулуудсан хүнийг шууд шүүхэд өгч болно. Тэгээд л “Энэ дарга миний зүг sexual harassment хийсэн” гээд суучихна. Хэрвээ хэн нэгэн ноён таны ташаан толгойг илээд авбал “үхэл нь ирсэн хулгана муурын сахлаар оролдов” гэгч л болно. Эмэгтэй хүн өдөж сөдөөгүй тохиолдолд нөгөө ажлын талаарх хүсэл бодлоо хамаа замбараагүй илэрхийлбэл халааснаасаа нилээд их мөнгө сул гоожуулахын дээр зарим тохиолдолд шоронгийн хаалга татах магадлал тун өндөр. Энэ бол эмэгтэй хүнийг хүндэтгэн үзэж байгаагийн дээд хэлбэр. Гэхдээ тэнд шүү дээ. Харин манайд бол эсрэгээр. Ийм ч учираас Өнөр ээмэг, бөгж, зурагт, хөргөгчөө ломбардад тавьчихаад хүн ардын эрүүл мэндийн төлөө өдөр шөнөгүй зүтгэж явна. Гэтэл түүнийг ийм байдалд оруулсан татварын байцаагч орой бүр шахам халамцуу, бас нэгэн бүсгүйгээр сугадуулаад зоогийн газрын хаалгаар үдүүлсээр. Энд хэний эрхийн талаар хөндөж буйг уншигч та эрх биш гадарласан биз ээ.

Бүсгүй заяа гэхээр л бусдын харцан дор бөхөлзөж, буруу зөрүү бүхнийг хүлцэнгүйгээр дагах ёстой гэж үү...

1.12 НАМАЙГ ТАЙВАН БАЙЛГААЧ...

Д.Түмэнжаргал

Зууны мэдээ, 2003.01.04, №3/1201

Америкт нэг нөхөр хөгжмөө хэтэрхий чангалсан хөршийндөө дайран орж, зургаан хүнийг буудаж хөнөөсөн хэрэг жил хагасын өмнө гарч, томоохон хэвлэлүүд энэ талаар шуугиж байсан билээ. “Энэ яасан айхтар хэрцгий амьтан бэ” гэж зэвүүцэхийн зэрэгцээ бас хөөрхий түүний зовлонг зах зухаас нь гадарлаж л байлаа. Ямар аргаа ядсандаа л тэгэх вэ дээ. Гэхдээ би түүнийг өмөөрч байгаа юм биш. “Хүн амар тайван амьдрах эрхтэй” гэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэг гол заалт бий. Манай улсын Үндсэн хуульд ч энэ талаар чухалчлан заасан. Хүн амьд явах эрхтэйн адил амар тайван амьдрах эрхтэй. Гэтэл өнөөдөр Монголд хамгийн их зөрчигдөж буй нь энэ эрх юм. Нэг их том яриад яахав, наад зах нь хөршүүдээ аваад үзье. Уг нь “хүн хөршөө сонгодоггүй” гэж үг бий. Тэр тусмаа олон давхар орон сууцны байранд амьдардаг бидний хувьд энэ бол гашуун үнэн. Гашуун гэдгийн тухайд тэр бүр сайн хөрштэй байх азтай хүн ховор байдаг юм. Манайхаар жишээ авъя. Дээд айлын залуу хосын хүүхэд нь үсэргээний морь шиг өдөржин пижигнэхтэй зэрэгцээд гэрийн эзэн ур дарх хийж өдөр шөнөгүй алх дөш хангинуулж, үдэш нь гэрээ диско бүжгийн талбар болгохоос гадна эхнэр, нөхөр хоёр долоо хоногтоо нэг удаа тоосоо гүвэлцэх нь дуу чимээ ихтэйг яана. Паараа нүднэ, учирлаж гуйна, ямар ч нэмэргүй төдийгүй тэгэхээс тэгэх гэсэн юм шиг улам л их шуугиан тарина. Одоо бид үүнд нь бүр дөжирсөн, цөхөрсөн, заримдаа мөнөөх Америк нөхөр санаанд ороход өөрөөсөө ч айх боллоо. Хамгийн аймшигтай нь бид цонхоор толгойгоо цухуйлгаж, угаасан хувцасаа өлгөхөөс айдаг болсон. Тэгж оролдох л юм бол нус, цэр, шанагаар угаадас тэргүүн дээр чинь бууна гэж мэд. Дөрөвдүгээр давхарын хөгшин манай доод давхарт байсан ч болоосой гэж харамсдаг болоод байна. Энэ мэтчилэн дааган чинээ нохой, үүдэн дээр маань дандаа бөөлждөг архичин, хонх дараад зугтдаг хүүхэд, гэрлийн байцаагч, сантехникийн засварчин намайг мөн ч тайван байлгадаггүй. Эцэст нь миний мөрөөдөл эзгүй арал болох шахаад байгаа. Энэ бүхэн сүйд болоод байхаар зүйл биш гэж хэн нэгэнд санагдаж болно. Иймхэн юман дээр хүний эрх гэж сүржигнээд байх байна гэж зэмлэж ч магад. Гэхдээ амьдрал бол амьдрал. Ахуйн жижиг сажиг зүйл дээр ч хүний эрх олонтаа зөрчигдөж байгааг бид тэр бүр анзаардаг билүү.

120 мянгатын хөгшчүүдийг бас өрөвдөх юм. Юм л бол шоу, буудлага пижигнэж, зүрх муутай, даралт ихтэй хөгшчүүл нь хэцүүддэг дуулддаг. Залуус хөгжиж, цэнгэж, дуулж, бүжиглэх эрхтэй боловч ахмад настнууд маань тайван, эрүүл байх эрхтэй шүү дээ. Польш зэрэг зарим улс оронд хүний амар амгалан байх эрхийг өчүүхэн төдий зөрчихөд л Иргэний шүүхэд ханддаг, хариуцлага хүлээлгэдэг юм билээ. Манай улсад ч бас ийм хууль зайлшгүй гаргах болжээ. Байнгын уур уцаартай, айдас түгшүүртэй байх нь амьдрал юм гэж үү.

Хүмүүс ээ, намайг тайван байлгаач ...

1.13 ХҮН ХОГ НОВШ МЭТ АМЬДАР Ч, ХОГ НОВШ МЭТ ҮХЭХ ЁСТОЙ ГЭЖ ҮҮ?

З. Мэндсайхан

Монголын мэдээ 2002.12.14, № 247

Монгол улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах эрхтэй.

/Монгол Улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйл/

Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. /Монгол Улсын Үндсэн хууль, 14 дугаар зүйл/

Бид амьдрах гэж тэмтчинэм

Хүмүүн бид энэ ертөнцөд амьдрах гэж л ирсэн. Амьдрах амьдрахдаа зовж бус, жаргаж явахыг хүсч ирсэн. Тэр хүслээ гүйцэлдүүлэх гэхдээ төрөхөд минь л хүний эрх,

үүргийг хамтад нь өгчихсөн байдаг. Яг л арга билэг лугаа адил. Нэг нь үгүй бол нөгөө нь оршиж байхгүйгээр.

Гэтэл эрхээ мэддэггүйдээ ч тэр үү, эсвэл хамгаалж чаддаггүйдээ ч тэр үү, ажил амьдралаараа хохирчихоод яваа хүн олон байх юм. Өөрөөр хэлбэл, хүн амын маань гуравны нэг нь гуйлгачин, хорин хувь нь ажилгүй байгаа тэр л хувь заяаны эргүүлгэнд хамтдаа явж байна гэсэн үг. Ямар ч амьдралын идэвхгүйгээр, ирээдүйн төсөөлөлгүйгээр голын урсгал дагаж буй зомгол шиг л байх юм. Уг нь Үндсэн хуулиар ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг нь өгчихөөд байхад шүү дээ. Зарим нь хийж үзээгүй мөртлөө цалин мөнгийг нь чамлахыг нь яана. Ихэнх нь хар бор, шалдир булдир ажил гээд шууд л голно. Гудамжинд лааз өшиглөөд явж байхад нь хэн нэгэн гарч ирээд “ийм өндөр цалинтай ажилд орж өгөөч” гэж гуйх юм шиг л бодоцгооно. Сонин болгоноор дүүрэн л ажилд авах зар байна даг. Эрүүлийг нь байтугай, тахир дутууг нь ажилд авъя гэж байна шүү дээ.

Гэхдээ бас учир байдаг юм байна. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгоход нийслэлийн хэмжээнд тулгарч байгаа гол бэрхшээл нь нэгдүгээрт, ажилд орохдоо танил тал хардаг /18.9 хувь/, хоёрдугаарт, цалин бага /14.4 хувь/, гуравдугаарт, мэргэжилгүй /11.2 хувь/ гэсэн шалтгаанууд байдаг аж. Энэ бол амьдралд байгаа бодит зүйлийг судалгаагаар гаргаж ирсэн баримт.

Монголчууд минь хэзээнээс ингэж аливааг хийхдээ танил тал хайгаад гүйдэг болчихов оо. Эмнэлэгт үзүүлэхэд ч, хүүхдээ цэцэрлэг, сургуульд өгөхөд ч, зөвшөөрөл, лиценз авахад ч бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд ч “танил тал байна уу” гэж бусдаасаа сураглаж байна. Үнэхээр ч танилгүй хүн ажилгүй байдаг бололтой. Үнэхээр ч өнгө мөнгө хардаг үе ирчихээд байгаа бололтой. Энэ нь өнөөдрийн төрийн болоод хувийн хэвшлийн аж ахуйнхны хүнд суртал, эрх тушаалаа хэтрүүлдэг явдал хүмүүсийг эрхгүй ийм зам сонгоход хүргэж байгаагийн нотолгоо.

Цалин бага байгаа нь ч үнэн. Судалгаанд хамрагдсан 180 гаруй хүний 77.8 хувь нь авч буй цалин, тэтгэвэр амьдралд хүрэлцдэггүй гэсэн хариулт өгчээ.

Бүр 80 гаруй хувь нь шүү дээ. Ингэхээр ажил хийгээд ч хэрэггүй мэт. Эрхбиш амьдралынхаа бор хоногийг өнгөрөөхөд хэрэгтэй юм болохоор дуртай, дургүй ч ажилтайгаа зууралдахаас биш яахав. Гэхдээ үүний цаана та бидний эрх зөрчигдөж байна. Яагаад гэвэл бид амьдралд хүрэлцээтэй цалин хөлс авах эрхтэй.

Мөн шинээр ажилд ороход ажил олгогчид хахууль авдаг /10.0 хувь/, нас, хүйсээр ялгадаг /5.6 хувь/ зэрэг шалтгаан ч хүний эрхийг зөрчихөд хүргэж байгаа билээ. Бие биеийнхээ гарыг хүндрүүлэхгүйгээр ямар ч ажил бүтэхээ байсан хорвоод бид амьдрах гэж тэмтчинэм. Тэгээд дээр нь өнгө мөнгө, царай зүс, нас, хүйсээр ялгаварлагдах зовлон нэмэгдээд буй.

Тиймээс энэ талаар Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х. Ганбаатарыг ямар бодолтой явдгийг нь сонирхсон юм.

- Шинээр ажилд авах хүмүүстээ нас, хүйс, царай зүсний шаардлага тавьсан ажлын зар сүүлийн үед нэлээд үзэгдэх боллоо. Ийм ажил олгогчид байдаг уу?

- Ер нь ажил олгогч ажилд авах хүндээ тавигдах шаардлагыг тогтоох эрхтэй. Гэхдээ Таны асуугаад байгаа шиг ажилд авах хүмүүсээ нас, хүйс, царай зүс гэх мэтээр шаардлага тогтоох нь хүний эрхийг хүндэтгэж үзээгүй, нилээд бүдүүлэг хандлагын нэг илрэл гэж ойлгохоос өөр аргагүй.

Ер нь ажил олгогчдын зүгээс иймэрхүү зар нийтлүүлэх нь сүүлийн үед нэлээд харагдах боллоо. Ажил олгогчийн иймэрхүү үйлдэл нь уг нь хуулиар хориглогдоогүй зүйл л дээ. Гэхдээ иргэний нэр төр, алдар хүнд болон ажил хэрэгт харш элдэв зар нийтлэхийг Зар сурталчилгааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн хоёр, 16 дугаар зүйлийн дөрөв, Хөдөлмөрийн тухай хуулийн долдугаар зүйлд ч тодорхой тусгасан байдаг гэдгийг эзэд анхаарах ёстой гэдгийг зөвлөмөөр байна.

- Энэ талаар ямар нэгэн ажлыг холбооны зүгээс зохион байгуулсан уу?

- Тун удахгүй манай холбоон дээр “Зар сурталчилгааны эрх зүйн үндэс” сэдэвт сургалтыг зохионо. Энэ сургалтаар дээр өгүүлсэн зүйлийн талаар хэлээд цэгцтэй мэдлэгийг ажил олгогчдод өгөх болно гэдгийг хэлэхийн ялдамд сонирхсон уншигчдыг оролцохыг урьж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан 1999 онд дэлхийн бизнесийн хүрээнийхэнд хандаж гаргасан “Глобал компакт” буюу даяаршлын тунхаглалд ч энэ тухай

байгаа билээ. Энэ тунхаглалд ёсөн зарчим дэвшүүлсэн бөгөөд хөдөлмөрийн хүрээнд хүрээнд гурван зарчим дэвшүүлсний нэг нь ажил олгогчийн зүгээс санаачлан “Хөдөлмөр эрхлэлт болон ажил мэргэжлийн хүрээнд ялгаварлан гадуурхах байдлыг арилгах ёстой” гэсэн зарчим бий. Өнгөрсөн зун манай холбооны шугамаар ОУХБ-аас мэргэжилтэн ирж, хүний эрхийг эздийн зүгээс санаачлан, хүндэтгэх тухай сургалт зохион байгуулахад ч олон улсын мэргэжилтнүүд хүний “зүсээр”, хүйсээр зааж зар тавьж байгаа. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон даяаршлын тунхаглалын үзэл санаатай харшилж байгаа зохисгүй үйлдэл гэсэн зөвлөмж ч өгч байсан билээ.

Манай хуулиудад ч арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг хатуу цээрлэн хориглосон байдаг гэдгийг анхаарах нь зүйтэй. Дээрх маягийн зарлал нь зарлал гаргаж буй ажил олгогчийн хүмүүнлэг чанарын тодорхойлолт нь болж, өөрийгөө олон нийтэд харуулж, үнэлүүлж байгаагийн илрэл гэдгийг ойлгох учиртай.

- Ер нь царайлаг хүмүүсийг ажилд авснаар ажлын үр бүтээмж нь өндөр байдаг тухай ямар нэгэн судалгаа байдаг уу?

- Ийм судалгаа манайд л лав хараахан байхгүй. Манай зарим бизнес эрхлэгчдийн дунд тиймэрхүү ойлголт байх шиг санагддаг. Нэн ялангуяа худалдаа, нийтийн хоол, баар, рестораны биенес эрхлэгчид ингэж боддог байж магадгүй. Манай холбоо ийм байр суурийг дэмждэггүй. Даяаршил гүнзгийрч байгаа өнөө үед дээрх ойлголт өөрчлөгдөж байгаа гэж бид найдаж байна.

Тэрээр ийн өгүүлсэн. Лавтай Монголын ажил олгогч эздийн холбоо хүнийг царай зүс, нас, хүйсээр нь ялгаварлахыг хүлээн зөвшөөрдөггүй л юм байна. Ямар ч байсан хүний эрхийг дээдэлдэг, энэ талаар ажил зохиодог нь ярианаас нь илт. Гагцхүү ажил олгогчид өөрсдөө энэхүү бичигдээгүй зарчмаасаа татгалзаж чадвал “Царай муутай төрсөн нь миний буруу юм уу” хэмээн уйлах охидын тоо багасах л байх. Гэтэл үүнээс ч долоон дор явдал амьдралд тохиолдсоор байна.

Дөчин хэдэн настай хүн ажил хийж болохгүй гэж үү?

Хүнийг мал шиг заазалж болдог ажээ. Үнэмшмээргүй байна уу. Хуулиар зөвшөөрөөгүй хэрнээ аль ч газарт нас, хүйс харгалздаг жаяг тогтчихоод байна. Гэтэл Монгол хүний тэтгэврийн нас 60-65. Ингэхээр тэтгэвэрт гарахаасаа 15-20 жилийн өмнө “заазлагдах” аюул ирчихээд байна. Уг нь нийгэмшсэн хүний хувьд эрх тэгш байдал гэдэг нь зөвхөн хууль үйлчлэх хүрээнд л байхаас, өмч хөрөнгө, өндөр нам, бяр чадал, царай зүс, оюун ухаан, ажил төрөлд байх ёсгүй юм гэнэ билээ. Яагаад гэвэл хүн гэдэг өөрөө гайхамшиг болохоор тэр. Тэгээд ч ардчилсан нийгэмд зөвхөн хүнийг л тахин шүтэж, хайрлан хамгаалж байх ёстой гэдэггүй бил үү.

Түүх өгүүлэхүй

Миний нэгэн танил оёдлын үйлдвэр нь ажилгүй зогсоход, ажилтай болчих санаатай нэлээд хэдэн албан газрын хаалгыг татсан юм даг. Тусгай дунд боловсролтой тэрбээр 42 настай. Яавч гэртээ зүгээр суугаад хэвтэж байх нас биш. Зарим байгууллага нь “орон тоо байхгүй” гэж. Энэ ч байж болох асуудал. Эцэст нь нэгэн цайны газраас зөөгч, үгүй ядаж угаагч хийе гэж гуйж л дээ. Гэтэл түүнийг бус хажууд нь явсан 20 хэдтэй охиныг “Харин чамайг ажилд авч болох юм шүү” гэжээ. Энэ үгийг сонсоод миний танилын тархиар нь татаад авах шиг болж. 40 хэдхэн насандаа мал шиг заазлагдаж байгаагаа ойлгож л дээ. Нулимс нь юу юугүй урсаад ирсэн гэсэн. Хэндээ гоморхож уйлах билээ. Ертөнцийн жамаар ирсэн дөч гаруйхан насандаа юу, эсвэл өөрийг нь ажилд аваагүй хүмүүст үү. Гэтэл цаана нь өөрийнх нь болоод үр хүүхдийнх нь амьдрал байгаа шүү дээ. Энэ л тэр эмэгтэйг юу юунаас илүү зовоосон байж таарна.

Бидний хэн маань ч өтөлж хөгшрөхөөс зайлна гэж үү. Хүссэн ч, хүсээгүй ч бидний араас нэхэн ирж буй цаг хугацааны буухиаг юугаар тогтоох юм бэ?

Гэтэл 40 нас гараад ирэхээр хүн, ажил хийж чадахгүй гэж ямар ухаантан нь өдгөөгийн ажил олгогчдын чихэнд шивнэчихсэн юм бол. Дэлхийн томоохон гүрнүүдэд харин ч дөч, тавин настнуудын амьдрал нь тогтчихсон, ажлын туршлагатай болчихсон гэж үнэлж, ажилд авах дуртай байдаг юм билээ. Нэг жижигхэн цайны газрын цэвэрлэгч бүү хэл, төрийн өндөр албан тушаалтнуудыг тавь, жараад насанд нь дэвшүүлэн ажиллуулдаг практик Азийн ихэнх оронд бий. Гэтэл манайд эсрэгээрээ.

“Хөгшрөөд хүн ажил хийх чадваргүй болдог гэж хэлж болох уу даа. Ямар ажил тэр билээ. Залуу хүнд тохирох, хүч чадал шаардсан ажлууд бий л дээ. Гэхдээ бие нь суларсан ч ухаан саруул өвгөн хүнд хийчихмээр юм ер байдаггүй хэрэг үү” гэж алдарт Цицерон тэртээд ам асууж байлаа. Гэтэл 40 нас гэдэг чинь үүнтэй зүйрлүүлэхэд залуу нас биз дээ. Ажлын аль ч зарыг эргүүлж үзэхэд 35-аас доош насны гэх нь элбэг байдаг. Энэ бүхэн 40-50 настнууд заазлагдаж байна гэсэн үг мөн биз дээ.

Үүнээс гадна хүнийг ажлаас халахдаа ч эрхийг нь зөрчиж байна. 2001 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн шүүх ажлаас үндэслэлгүй халагдсан гэсэн 239 өргөдөл хүлээн авснаас 153 хэргийг нь шийдвэрлэжээ. Хан-уул дүүргийн шүүх 2001 оны сүүлчийн хагас жилд 13 хүний маргаан шийдвэрлэсний 10-ыг нь буюу 77.7 хувийг нь ажлаас үндэслэлгүй халагдсан гэж тогтоосон байна. Энэ бол хүнийг тодорхой итгэл үнэмшилтэй байснаар нь ялгаварлан гадуурхаж, ажил хөдөлмөрөөс нь халж, солих зэрэг хууль, хүний эрхийг ноцтой зөрчсөн үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд улам нэмэгдэж байгаагийн илрэл. Ийм уламжлал тогтоод бараг арваад жилийн настай болжээ. Нөгөөтэйгүүр төрийн захиргааны байгууллагын албан тушаалтны хууль бус шийдвэр, үйлдэлтэй холбоотой гомдлыг дагнан шийдвэрлэх шүүх өнөөг хүртэл байдаггүй нь ч байдлыг улам хүндрүүлдэг аж. Сүүлийн жилүүдэд зөрчигдсэн эрхийнхээ талаар шүүхэд гаргадаг гомдол, нэхэмжлэл ихээхэн өсч, шүүхийн ачаалал ч, нэг шүүгчид ногдох иргэний хэрэг, маргаан ч ихээхэн нэмэгдсэн байна. 2000 онд анхан шатны нэг шүүгчид улсын дунджаар эрүү, иргэний 237 хэрэг ногдож байжээ. Байдал ийм байхад хүн хог новш мэт амьдарч, хог новш мэт үхэхээс аргагүй юм гэж бодогдохоор байна. Их л хатуу үг. Гэвч хэлэхээс аргагүй юм. Яагаад гэвэл Монголын тавиад хүн тутмын нэг нь сэтгэцийн согогтой, бараг тэн хагас нь архичин, гуравны нэг нь гуйлгачин, наймны нэг нь “угжуулагч”, хорь гаруй хувь нь ажилгүй байхад сайхныг ярьж, сэтгэлээ хуурах аргагүй байна. Эсвэл хүмүүс эрхээ мэддэггүй юм болов уу. Ер нь Үндсэн хуулиа уншсан хүн хэчнээн байдаг бол оо. Эрхийг нь хэлүүлэх гэвэл хичнээн нь ээрч муурах бол доо. Ихэнх нь “мэдэхгүй” гэж л хариулна. Эрхээ мэддэггүй хүн өөрийнхөө эрхийг хөндүүлээд зогсохгүй, мөн бусдын эрхийг ч зөрчдөг гэсэн. Үүнийг л иргэн бүр мэдэж байвал эрхээ эдэлж чадахын сацуу үүргээ ч ухамсарлах буй заа.

Иймээс бид хөдөлмөрлөх эрхийнхээ төлөө тэмцье. Ажил олгогчдын хөлөөс толгой хүртэл сонжих харцыг тэсвэрлэн өнгөрөөе. Тэгээд ажилтай болцгооё. Хог новш мэт амьдарч байгаад хог новш мэт үхвэл үр хүүхдийн маань гомдлын нулимс барагдахгүй болно.

1.14 ЦАГААЧИЛНА ГЭДЭГ ЭХ ОРНОО ОРХИНО ГЭСЭН ҮГ БИШ

3.Мэндсайхан

Монголын мэдээ 2002.12.28, №257

Би заримдаа боддог юм. Эзэн Чингис минь дэлхийн талыг эзэлж явахдаа халуун дулаан уур амьсгалтай, байгалийн их баялагтай газарт Монгол улсаа оршин тогтноулж болоогүй юм болов уу гэж. Тэгсэн бол ядаж л энэ их хүйтэн, зуд турханы аюулыг бид мэдэхгүй л байх байсан. Ядаж л хэдэн ээлжийн хувцас бэлдэж, дулаан цахилгаанд их хэмжээний мөнгө үрэхгүй л байх байсан. Хэрэв зээ Араб нутагт Монгол Улс байсансан бол өдийд дэлхийн баян улсуудын нэгэнд тооцогдоод явж байхгүй юу. Өнөөдрийн гуйлгачин, траншейны хүүхэд, Өвгөнтийн хөндийн архичин, ажилгүйчүүдийн армийн аль нь ч байхгүй байх байсан. Улс орны хөгжил дэвшил ч арай өөр байхсан.

Гэхдээ тайван амарлингуй ард түмнээ харахаар өөрийн эрхгүй сэтгэл уясаад байх юм. Өрөвдөхийн эрхэнд тэр. Цалин хөлснөөс нь хасаад байхад дуугүй л сууна. Цаг наргүй ажлаар шахаад байхад ч аанай л дуугүй. Авдаг бараа, амьдардаг сууцных нь үнэ хөлсийг нэмээд байхад ч аниргүй мэлтийнэ. Эдлэх ёстой эрхийг нь хасаад, эрх мэдлээр сүр далайлгаад байхад ч “галав юулж, ертөнц сөнөөгүйгээс хойш” гээд чимээ сураггүй сууж л байна. Ийм амар амгалан ард түмэн ийм л газар шороон дээр байхаас ч аргагүй мэт санагдах юм. Юун араб, юун халуун дулаан уур амьсгал. Хэрэвзээ тэнд байсан бол өдийд терроризм, алан хядлага, шашин хоорондын мөргөлдөөн гээд монголчуудын үзээгүй юмыг бидэнд үзүүлэх байсан байх л даа. Ингээд бодохоор өвөг дээдсээсээ бидэнд үлдээж өгсөн газар шороон дээрээ юугаар ч үл дутагдах амьдралыг бий болгох нь бидний зорилт

юм. Түүний тулд залуус маань харийн оронд очъё гээд байх боллоо. Үүнийг л би дэмжих гэсэн юм.

Тодруулбал, цагаачиллыг Өнөөдөр энэ харилцааг Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиар ерөнхийд нь харин Харьяатын тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль болон бусад хуулиар зарим нэг харилцааг зохицуулж байгаа аж. Юутай ч төр, засаг цагаачиллыг дэмжиж байна. Жил ирэх тусам Монгол Улсын иргэд гадаадад зорчих нь ихэсч буй нь үүний баталгаа билээ. Гэсэн ч гадагшаа явах хүсэлтэй хүмүүсийн тоо үүнээс ч их байгаа юм.

Хоёр жилийн өмнө гэхэд 83 оронд 508821 иргэн гарсан бол мөн онд тэдгээр орноос 495285 монгол иргэн эх орондоо эргэж ирсэн байна. Энэ бага тоо биш ээ. Гэхдээ үүнийг нэмэгдүүлэх боломж бий.

“Манай талаас цагаачлалд хязгаарлалт тавьсан явдалгүй. Гагцхүү энэ эрхээ эдлэх явдал нь улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, бусдын эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхолд нийцсэн байвал зохихыг шаарддаг” гэсэн хариултыг цагаачлах хүсэлтэй хүнд өгөх байх. Үнэхээр ч төр, засгийн зүгээс Монгол улсын иргэдэд гадаадад явах, тэнд оршин суухаар цагаачлахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй байгаа юм. Гэхдээ л өнөөдөр Монгол Улсаас гадаадад албан ёсоор цагаачилсан ганц л иргэн байгаа шүү дээ. Ингээд бодохоор цагаачлах эрхээ бүрэн дүүрэн эдлээгүй мэт.

Өнөөдөр 13536 хүн гадаадад үлджээ гэсэн тоо байдаг юм билээ. Энэ нь гадагш гарснаасаа буцаж ирснийгээ хасаад гаргасан тоо л доо. Гэхдээ албан бусаар хэчнээн ч хүн, хүний нутагт байна вэ дээ. Лав л ах дүү, төрөл төрөгсдөөс нь гадаадад байдаггүй нэг ч монгол айл байхгүй болсон байх. Дэлхийн 200 гаруй улстай. Түүний 83 -т нь монгол хүн очиж үзжээ. Арай л Сахарын элсэн цөл, Африкийн ширэнгэн ойд байдаггүй байх. Харин манайд 38 орны 742 иргэн удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй байдаг юм билээ. УИХ-ын 2001 оны 96 дугаар тогтоолоор 2000-2007 онд Монгол улсад оршин суух цагаач иргэдийн тоог тогтоосны зэрэгцээ жил бүр 100-гаас дээшгүй иргэдэд цагаачлах зөвшөөрөл олгож байх болсон юм. Бусад улс оронд ч ийм жишиг байдаг. Тэгвэл манай Засгийн газраас цагаачлах иргэдийг хүлээн авах хүсэлтэй байгаа улс орнуудтай гэрээ, хэлэлцээр хийж болохгүй гэж үү? Энэ асуудлыг төр, засгийн бус, хувийн хэвшлийнхэн л зохион байгуулж, зохицуулж шийдвэрлэж байгаа шүү дээ. Гэхдээ тэд ажил хийх зөвшөөрлийн бус, сургалтын виз л авч өгч чаддаг. Тэр нь 3 сараас 1 жилийн хугацаатай байдаг. Энэ хугацаанд ажил олж хийсэн нь азтай, хөлөө олоогүй нь хохирч үлддэг. Тиймээс аз туршин гуравдагч ч орон руу хулгайгаар гарахыг оролддог. Тэднийг аз түших нь ч бий, түшихгүй нь ч бий. Зарим сэтгэлийн хатгүй нь анхны бэрхшээлээс шантарч, гутарч, ажил хайх нь бүү хэл, бусдад дараа болж эхэлдэг. Харьд байдаг монголчууд бие биеэ түшээд авахдаа тийм ч дуртай биш. Аль болохоор зай барихыг хичээцгээдэг юм билээ. Энэ ч бас аргагүй. Бусдын төлөө ажиллаж байгаа бус, өөрийнхөө л төлөө юм чинь.

Хөгжиж буй орнуудын нэг болох Филиппин улс гэхэд Ирландад цагаач гаргах зөвшөөрөлтэй байдаг. Эмэгтэйчүүд нь эмнэлэг, эрчүүд нь барилга дээр ажилладаг юм билээ. Тухайн орны жишгийг бодвол бага цалин авдаг ч бас л подхийсэн мөнгө хураачихдаг бололтой. Монголчууд ч бас тэгж, ажиллаж чадна гэж боддог. Залуус маань хар бор ажилд нухлагдаад сурчихсан болохоор барилгын ажлыг төвөггүй хийх юм билээ. Энэ мэтээр бодож хэрэгжүүлэх ажил Засгийн газарт маань байна л гэж боддог. Цагаачлахыг хориглохгүй байгаа ч дэмжсэн бодлого явуулахгүй байгаа нь монголчуудыг хараар ажиллахад хүргэж, улмаар Монголын маань нэр сөвтэж байна. Цагаач гээд бүртгэгдчихвэл ажил хийхэд ч, амьдралаа төвхнүүлэхэд ч ашигтай тул ийм замыг нь сонгохыг хүсэхгүй хэн байхав. Иймдээ ч худал ярьж, жүжиглэхээс өөр аргагүй. Үүнийг нь үнэмшихээсээ итгэхгүй нь олонтаа.

Учир нь Монгол Улс ардчилсан орон. Тиймээс цагаачлах улс төрийн болоод нийгмийн шалтгаан байхгүйд тооцогддог. Гэтэл улс төрийнх нь байхгүй юм аа гэхэд нийгмийн шалтгаан нь байсаар байна шүү дээ. Хэн өнөөдөр тэтгэлээ сайхан амьдраад байгаа юм бэ? Хэдхэн хүн баячуудын тоонд орж явдаг ч тэдний ихэнх нь л их хэмжээний өртэй хүмүүс байдаг шүү дээ. Хүний амин хэрэгцээнд таарч тохирсон хоол, унд хэрэглэж, эрүүл мэндээ хамгаалж байгаа нь ч хэд билээ. Ихэнх маань л өлөн зэлмэн байгаа биз дээ. Цалин тэтгэвэр тэтгэмж нэмнэ гэж байхынхаа оронд гадагшаа гарах хүсэлтэй байгаа залуусыг чөлөөтэй

явуулах талаар төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлбэл яасан юм бэ? Тэгвэл ихээхэн хөрөнгө мөнгө хэмнэгдэнэ дээ. Энэ талаар зориуд анхаарч, бусад орны цагаачиллын хуультай танилцаж, боломжтой улсуудтай нь гэрээ, хэлэлцээр хийж болохгүй нь юу билээ. Тэгвэл харьд амьдрах монголчуудын маань эрх нь зөрчигдөх явдал ч багасна. Яагаад гэвэл албан ёсны зөршөөрөлтэй юм чинь. Өнөөдөр монгол хүмүүс очсон газрынхаа иргэдтэй ижил цалин авч, эмнэлгийн тусламж, нийгмийн халамж хүртэж чадахгүй байгаа нь үүнтэй л холбоотой. Ямар монголчууд бүгдээрээ гадагш гарчих гэж байгаа биш. Гэхдээ л оюуны өндөр чадвартай хүмүүсээ алдах аюул байхыг үгүйсгэхгүй. Тэгсэн ч тэд эх орон руугаа эцсийн эцэст бэдэрнэ шүү дээ. Эх орноо хаяад явчих зүрх, зориг монгол хүнд байдаггүй л гэж боддог.

Төрийн зүгээс дэмжээд өгвөл эндээ цалин нэмэх, ажлын байр бий болгох гэх мэт хэцүү асуудал бага ч гэсэн шийдэгдмээр санагдах юм. Дотоод дахь эдийн засгийн хүчин чадал өсч, ажилгүйдэл эрх биш багасах хүртэл ийм арга хэмжээ авч болмоор. Иймээс цагаачиллыг чөлөөтэй болгомоор байна. Хамаг залуус нь гадагшаа яваад, хэдэн хөгшид үлдэх нь гэж айх хэрэггүй. Энэ бол түр зуурын явдал. Хэдэн жилийн дараа тэд чинь өндөр хөгжилтэй орнуудын ноу-хау, ажлын зохион байгуулалт, харилцааны соёлоос суралцаад, өвөрлөөд ирнэ шүү дээ. Монгол минь Япон, Солонгосоос дутуугүй л хөгжилтэй болчихно. Тэр цагт тэр гадаад гэдэг рүү чинь зөвхөн дэлхийн гайхамшгийг үзэж, амарч, алжаалаа тайлах гэж л явах болно.

Өнөөдөр Австрали, Канад улс цагаач авах сонирхолтой байгаа. Үүн дээр нь дөрөөлөөд, тохиролцоод авч болохгүй нь юу билээ. Дотоодоосоо боловсрол, санхүүгийн хөрөнгө оруулалт хайх бус гадаадад гарснаасаа хүлээж суух цаг ирж болно шүү дээ. Нэгэнт бид дотоодынхоо нөөц боломжоор улс орноо хөгжүүлж чадахгүй нь тодорхойгоос хойш.

Монгол хүн гэдэг нутаг амьтай. Хүлэг морь шигээ нутгаа л гэж тэмүүлдэг. Нутагтаа буцах цаг боллоо гэж үзвэл тэд шахаж шаардуулахгүйгээр л хүрээд ирнэ. Лондонд амьдардаг монголчууд саяхан “Хурдынхныг” очиж тоглоход “Санаж байна” дууг нь сонсоод л бие биенээ тэврэн уйлаад байсан гэсэн. Үнэхээр ч утаат бор гэр, униартаж цэнхэртэх тал минь санагдаад байдаг юм билээ. Уртын дуу, морин хуурынхаа гайхамшгийг тэнд л илүүтэй мэдэрч, бишрэн шүтдэг юм билээ. Ядарсан муу Монголыгоо яагаад ч мартаж чадахгүй юм билээ дээ. Иймээс харийн нутагт тэднийгээ шингэчихвий гэж айсны хэрэггүй юм. Тэдэнд цагаачлах эрхийг нь эргээд олз омогтой ирэх үүрэг, хариуцлагатай нь хамт өгчихье. Эзэн Чингис минь дэлхийн талыг эзэлчихсэн хэрнээ энэ л муу Монголдоо эргэж ирсэн биз дээ? Тэрхүү мах цусанд шингэсэн нутгаа гэх үзэл биднээс тийм ч амар салчихгүй л болов уу. Гагцхүү улс орон маань л залуу хүн бүрийг ажлын байртай, орох оронтой болгочихвол хэн, тэр харийн нутгийн хамаг муу ажлыг хийе гэж зүтгэх вэ дээ. Гэхдээ тийм цагийг наашлуулахын тулд өнөөгийн залуусыг гадагш нь явуулъя гэсэн юм. Тэр цагт бидний Монгол өөр болно оо.

1.15 “БИ ҮХМЭЭРГҮЙ БАЙНА”

3. Мэндсайхан

Монголын мэдээ, 2002.01.11, №007

Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй./ Монгол Улсын Үндсэн хууль. 16 дугаар зүйл/

Хавдрын гурав, дөрөвдүгээр шатанд орсон өвчтнүүдийн эрх зөрчигдөж байна.

Өтлөх, өвдөх, үхэх гэсэн ертөнцийн гурван үнэнээс зайлж чадах хүмүүн бий билүү. Эс үхлээ ч гэсэн өвдөхийн аюулыг сөрөөд гарчих ид шид бидэнд үгүй. Бидний хэнийг маань ч дайран гарахгүй энэ зовлонгийн өмнө хүчин мөхөстдөг атлаа ганц хоног ч гэсэн амьд байхыг хүсдэггүй хүн байхгүй. Тэр тусмаа эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй хүн чинь тийм амархан хорвоог орхичихъё гэж бодохгүй биз дээ. Эцэг эх, хань ижил, үр хүүхэд нь ч дотно нэгнээ өвдөхөд эрлэгт бэлэглэчихье гэж хүсдэггүй. “Ядаж бараа нь харагдаад байж байг” гээд чадах чинээгээрээ л асарч халамжлахыг хичээдэг.

Хүн өвддөг. Өвчин нь дотроо эдгэрдэг, эдгэрдэггүй гэж байх юм. Рак гэж ярьдаг өмөн нь эдгэрдэггүй өвчний тоонд орно. Өнөөдөр дэлхий дээр жил бүр зургаан сая хүн

өмөн өвчнөөс нас барж, 10 сая хүнд шинээр онош тавьж байна. Харин Монголд жилд дунджаар 2200-гаад хүн хавдраар нас барж байгаагийн 74 хувь нь анх өвчин оношлогдсоноос хойш эхний жилдээ л нас бардаг аж. Ингээд харахаар хүний амийг л авч байж салдаг өвчин бол өмөн ажээ. Энэ өвчин амийг нь авахаасаа өмнө өвчтөнийг байх суухын аргагүй болтол нь өвтгөж, нүднээс гаргаж, бусдын гарт өгч, нэлээн тохуурхаж, бах таваа хангасны эцэст “мөнхийн амар амгалан” уруу явуулдаг байна.

Өглөө нь гэрээсээ инээгээд гарсан хүн орой нь үхчихдэг энэхүү мөнх бусын орчлонд өвдөх гэдэг бараг юу ч биш болох нь. Үхэх цаг, насаа сонгож болдоггүйн адил өвдөх өвчнөө ч бас сонгож болдоггүй хорвоо хойно. Иймээс бид л өөрсдийгөө өвчин эмгэгээс сэргийлж, зөв хооллож, зөв амьдарвал урт удаан жаргал эдлэх боломжтой аж.

Хэлж ирдэггүй, хийсч ирдэг өвчиндөө шаналан буй хүмүүсийн эдлэх эрхийн тухай энд хөндье гэсэн юм. Элэгний өмөнтэй, нарийнтсан, зүрхний дутагдлаар гуравдугаар шатанд орсон, тархинд хүнд харвалт өгснөөс ухаангүй байгаа зэрэг өвчтөнүүдийг ямар ч эмнэлэг хүлээж авдаггүй. Ар гэрийнхэнд нь “эмчилгээгүй” гэж хэлээд л гаргачихдаг. Ийнхүү тавилан нь хязгаарлагдмал болсон хүмүүс сайндаа л хоёр сараас жилийн “настай” байдаг байна. Хавдрын гурав, дөрөвдүгээр шатанд орсон өвчтөнүүд үнэ төлбөргүй эмчлүүлэх эрхийг нь Эрүүл мэндийн тухай хуульд тусгаад өгчихсөн боловч хууль, амьдрал хоёр зөрчилдсөөр байгаа аж.

Чухам яаж гэвч. Өвдөлт намдаах учиртай морфиныг үнэ төлбөргүй өгөх ёстой атал өнөөдөр тухайн өвчтөний ар гэрийнхэн хоногт эмэнд нь 3200-4200 төгрөг өгч байна. Ширхэг шахмал нь 1600-2100 төгрөгийн үнэтэй байдаг бөгөөд өвдөлтийн их, багаас хамааран хоногт 2-3 удаа ч тарих хэрэг гардаг ажээ.

Хэвтсээр цооролт үүссэн, хэвтрийн хатгаатай, маш их өвдөлттэй, гэдэс нь шингэнээр дүүрсэн, өтгөн, шингэнээ өөрийн мэдэлгүй гаргадаг учир бусдын асаргаанд орсон, өвчиндөө зовж шаналсан, турж эцсэн, тамир тэнхээгээ алдсан хүнийхээ өвдөлтийг намдаахын тулд байгаа мөнгөө түүндээ зориулахаас ч биш яахав. Гэхдээ ингэж чадахгүй айл, хүн маш их байна. Өвчтэй хүнтэйгээ зэрэгцээд өөрсдөө өлсч үхэлтэй биш дээ.

Гэтэл 12 цагийн үйлчилгээтэй гэгдэх энэхүү морфин нь гадаадаас тусламжаар орж ирдэг гэх юм. Австриас гэсэн байх шүү. Яахаараа тусламжаар ирсэн тариа үнэлэгдээд, хүн амын дунд зарагдаад байна вэ. Орлого нь хаашаа ордог юм бэ. Хуулиа мөрдөх юм бол үүнийг үнэ төлбөргүй л авах эрх эдлэх ёстой байхад.

12 цагийнхаас гадна 4-6 цагаар үйлчилдэг морфин сульфат гэвч эм байдаг гэсэн. Үүнийг хавдрын гурав, дөрөвдүгээр шатанд орсон хүмүүст хэрэглэхийг ДЭМБ-аас зөвшөөрч, зөвлөдөг аж. Сарын тун нь гэхэд 1.8-5.4 ам.доллар байдаг энэ эмийг нь болохоор оруулж ирдэггүй юм гэнэ билээ. Сонин байгаа биз. Тусламжаар орж ирснийг нь зараад байдаг, хямд байгааг нь болохоор оруулж ирдэггүй, эмнэлгийн үйлчилгээний ийм нэгэн гаж систем үйлчлээд байх шиг.

Уг нь Монгол Улс 1998 оноос хорт хавдрын үндэсний хөтөлбөртэй болсон юм гэсэн. “Өмөнгийн өвдөлтийг намдаах тухай” ДЭМБ-ын удирдамжийг ч монгол хэлнээ орчуулж, энэ дагуу нь хэрэглэхийг зөвшөөрсөн аж. Тэгсэн атлаа үйл ажил нь эсрэгээр яваад байдаг.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хорт хавдраас урьдчилан сэргийлэх хэмжээний ажил л хийгээд байдаг байна. Гэтэл ДЭМБ-аас зарим хорт хавдрыг эрт оношлох боломжгүй гэж үзэж байгаа аж. Урьдчилан сэргийлэх боломж маш хязгаарлагдмал байдаг ийм өвчнийг эрт оношилно гээд хөрөнгө мөнгөө цацаад байх шаардлагагүй гэнэ. Үүнийг өгүүлэхийн тулд баримт түшье.

Элэгний хорт хавдар –эрт оношлох, эмчлэх боломжгүй.

Ходоодных –эрт оношлох боломжгүй, зөвхөн хөнгөвчлөх эмчилгээ хийнэ.

Уушигных –урьдчилан сэргийлэх боломжтой, оношлох нь хязгаарлагдмал, хөнгөвчлөх эмчилгээ хийнэ.

Улаан хоолойнх –урьдчилан сэргийлэх, эрт оношлох, эмчлэх боломжгүй, зөвхөн хөнгөвчлөх эмчилгээ хийнэ.

Умайн хүзүүнийх –урьдчилан сэргийлж, эрт оношилж, эмчилж, хөнгөвчлөх эмчилгээ хийж болно.

Хорт хавдар гэдэг ийм л аймшигтай байдаг аж. Монголчуудын дунд элэг, ходоодны хорт хавдар хамгийн түгээмэл байна. Хамгийн эмчлэгддэггүй, эдгэрдэггүй нь шүү дээ.

Тиймээс өөрийнхөө төлөө нэлээд анхаарах шаардлага зүй ёсоор гарч ирж байгаа биз. Гэхдээ та бүхнийг айлгах гэж үүнийг бичээгүй. Ямар хавдар нь эмчлэгддэггүй талаарх энэ баримтыг ДЭМБ-ын зөвлөхөөр 14 жил ажилласан, Английн хөнгөвчлөх эмчилгээний олон улсын, төвийн олон улсын захирал Жан Стжернсоурд Монгол улсад өнгөрсөн оны 11-р сард болсон “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ” сэдэвт бага хурал дээр хэлсэн юм билээ. Тэгэхээр энэ өвчин хэр аюултай нь танд ойлгогдох буй заа.

Тиймээс энэхүү өвчний гурав, дөрөвдүгээр шатанд орсон өвчтнүүдийн эмчилгээг үнэ төлбөргүй болгоё гээд байгаагийн учир нь гэвэл онож тогтоогдсоноос хойш тэр маш богинохон “насалдагтай” холбоотой юм. Тэр хоёр сараас нэг жилийн настай байдаг гэж өмнө нь өгүүлсэн. Гэтэл тэдний хажууд чихрийн шижин, сүрьеэ өвчтэй хүмүүс 30-40 жил үнэ төлбөргүй эмчилгээ хийлгээд явж байгаатай яагаад харьцуулж болохгүй байна вэ. Нэгэнт тавилан нь хязгаарлагдмал болсон хүмүүст сэтгэл санааны хөнгөлөлт үзүүлж болохгүй гэж үү. Тэд ар гэрийнхэн нь өөрийнх нь төлөө яаж санаа тавьж, хоолныхоо мөнгөнөөс илүүчилж, зарим нь бүр ажилгүй болж байгааг харж л байгаа шүү дээ. “Эдэндээ төвөг удахаар бушуухан хорвоог орхих юмсан” гэсэн бодол үес үесхэн орж ирж байгаа. Ийм хүмүүст үнэ төлбөргүй эм, тариа олголоо гээд улс ч нэг их хохироод байх нь юу л бол.

Өмнө дурьдагдсан хөнгөвчлөх эмчилгээ гээчийг чухам юу юм бол хэмээн гайхаж байна уу. Хөнгөвчлөх эмчилгээ гэдэг нь эмчилгээгүй болсон өвчтөнд амьдралын төгсгөлийн шатанд зовиур шаналгаагүй байлгах, тайван амгалан өөд болгох үйлчилгээ юм байна. Жил бүр Монголын 1600 гаруй хүнд ийм эмчилгээ шаардлагатай болдог аж. Өндөр хөгжсөн орнуудад ийм хүмүүст зориулсан хоспис буюу буяны эмнэлэг олноор байдаг гэнэ.

Тэдгээр нь гэрийн, өдрийн, эмнэлгийн гэсэн хэлбэрээр ажилладаг байна. Харин монгол дөнгөж л үйл ажиллагаагаа эхэлж л байгаа аж.

Хавдар судлалын үндэсний төв дэх 10 ортой хөнгөвчлөх эмчилгээний тасаг нь хувийн эмнэлэг хэлбэрээр ажилладаг, үйлчилгээ нь төлбөртэй учир ийм хүмүүст амин чухал болох морфиныг нь өгдөггүй ажээ. Морфин авах эрхгүй байдаг гэсэн үг л дээ. Тэгэхээр тухайн хүний өвдөлтийн зовиур шаналгааг яаж ч хөнгөвчлөх юм билээ.

Хордлого тайлах. Тэжээх төдий л үйлчилгээ үзүүлдэг, өвдөлт намдаах эмчилгээ хийдэггүй энэ эмнэлэгт морфинтэй байх эрхийг нь өгч болдоггүй юм болов уу.

Бас нэгэн зүйлийг анхаарахгүй өнгөрч болохгүй юм. Хавдартай гэх хүмүүсийн ихэнхийг нь “эмчилгээгүй” гээд гэрт нь гаргадгийг Та бид бүгдээрээ л мэднэ. Гол нь эмчилгээгүй байгаадаа бус, эмнэлэгт нас барсан хүмүүсийнхээ тоог нэмэгдүүлэхгүй, гэхдээ ингэж ханддаг байна. Энэ нь эмнэлгийн үзүүлэлтэд муугаар нөлөөлөөд байгаа юм бол ЭМЯ-ны бүртгэлд “хөнгөвчлөх эмчилгээний нас баралт” гэж бүртгэж болохгүй гэж үү. Болохгүй юмгүй. Ийм шийдвэртэй болчихвол дүүрэг бүрийн эмнэлэг 2-3 ортой палат нээхдээ татгалзахгүй болов уу гэж санагдах юм. Нөгөөтэйгүүр тухайн өвчтөн насаараа эрүүл мэндийн даатгал төлсөн ч өөрт нь чухал хэрэгцээтэй болсон үед нөгөө даатгал нь огт үйлчилдэггүй. Энэ гаж системийг ч өөрчлөх цаг болсон. “Эмчилгээгүй” гэдгээр Үндсэн хуульд заагдсан “эмнэлгийн тусламж авах эрх” нь зөрчигддөг. Аймаар байгаа биз. Хатуухан хэлэхэд, тухайн өвчтөнийг үхээгүй байхад нь үхүүлчихдэг гэсэн үг. Ядаж л “эмчилгээгүй” гэсэн үг сонсоход сэтгэл санаагаар унаж, эмчилгээний үр дүн шууд буурдаг байна. Ийм сэтгэл нь ч, бие махбодь нь ч эмзэг болсон хүмүүсийн даатгалын асуудлыг дахин эргэн харж, тэдэнд ашигтайгаар шийдвэрлэх цаг болсон байх. Учир нь хавдраар өвчлөх явдал улам л залуужсаар байна. 40, 50 настнууд гол төлөв өвчилдэг байсан бол өдгөө 25 настай залуу ч элэг, ходоодны хавдраар нас барж байна шүү дээ.

Тавилан хязгаарлагдмал болсон хүмүүсийн ар гэрийнхнийх нь дунд судалгаа явуулахад 92 хувь нь тэднийгээ зовиур шаналгаагүй л байгаасай гэж хүсдэг нь тогтоогджээ. Хэн ч үхээсэй гэж хүсдэггүй байна. Хэрвээ зовиур шаналгаагүй бол, морфин үнэ төлбөргүйсэн бол үхэх тухай бодол тийм ч амархан төрөхгүй л байх л даа.

Морфин гэснээс энэ тариаг нэлээд чирэгдэл болж байж олж авдаг гэсэн шүү. Хортой эмийг тусгай бланкан дээр өчнөөн хүнээр гарын үсэг зуруулж, зөвшөөрүүлж авсныгаа харин ч нэг хяналтгүйгээр өвчтөнд хэрэглэдэг гэнэ лээ. “Өвдөөд байна” гэж орилонгуут л хийдэг энэ тариаг хавдрын эмчийн хяналтан доор хийх учиртай аж. Тун нь ихэдчихвэл амьсгал зогсохоос гадна бүр мөсөн “унтах” аюултай гэнэ. Наанадаж өтгөн нь хатаж, өвчтэй

биеийг нь улам тамирдуулдаг байна. Нас барлаа гэхэд өвчнөөс нь үү, морфиноос нь уу гэдгийг ч тогтоохын аргагүй аж. Учир нь гэртээ нас барсан тохиолдолд задлан хийдэггүй байна.

Ер нь яг хичнээн хүнд хөнгөвчлөх эмчилгээ шаардлагатай байдаг тухай нарийн тоо, бүртгэл ч байдаггүй аж. Ямар сайндаа Монголын хөнгөвчлөх эмчилгээ нийгэмлэгийнхэн дуслын шингэн үнэгүй тараахын тулд судалгаа явуулахад зөвхөн Сонгинохайрхан дүүрэгт 300 гаруй хүнд хэрэгтэй нь тогтоогджээ. Өвчтөний ар гэр, дүүргийн хавдрын эмч нарын хооронд ч холбоо байдаггүй байна. Эмчилгээгүй гэсэн болохоор хавдрын эмч дээр очдоггүй гэнэ. Ийм л зовлон дунд хавдрын гурав, дөрөвдүгээр шатанд орсон хүмүүс амьдралынхаа сүүлчийн өдрүүдийг өнгөрөөдөг ажээ. Тэдний тухай АУИС-ийн Ерөнхий мэргэжлийн тэнхимийн багш, анагаах ухааны доктор, дэд профессор, Монголын хөнгөвчлөх эмчилгээ нийгэмлэгийн тэргүүн, Олон улсын Зүүн Европын хөнгөвчлөх эмчилгээ нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн Д. Одонтуяа ярьсан юм. Тэр үүргээ биелүүлж байна. Түүний тэргүүлдэг нийгэмлэгийн ажилтнууд эмнэлгийнхэн, анагаахын оюутнууд, өвчтэй хүмүүсийн ар гэрийнхэнд сургалт явуулахаар төлөвлөж, хөнгөвчлөх эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалд тусгуулах, улсын төсвөөс энэ үйлчилгээнд зориулж хөрөнгө гаргуулах замаар санхүүжилтээ шийдвэрлэх зорилготой байгаа юм билээ. Тэдний зорилго биелэх болтугай гэж өнөөдөр энэ өвчнөөр шаналж буй хүмүүсийн өмнөөс би хүсч байна. Хүний амьдрал хайр халамжаар эхэлдэг шигээ хайр халамжаар төгсөх учиртай. Үүнд ЭМЯ ч онцгой анхаарах ёстой. Хүн бүр эмнэлгийн тусламж авах эрхээ эдэлье.

“Алга дарам газраа бурхан гуйсан ч бүү өг”

1. 16 НИЙСЛЭЛДЭЭ ИРЖ СУУРШИНА ГЭДЭГ, ГАДААДАД ЯВЖ АМЬДРАХААС ХЭЦҮҮ БОЛЖЭЭ

Галсангийн Жамъяан

Монголын мэдээ, 2002.12.07, №242 /991/

“Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” /Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 18 дугаар зүйл/

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19.1.2-т заасны дагуу Монгол Улсын иргэнд нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх газрын байршлыг тогтоох асуудлыг дараахь байдлаар шийдвэрлэнэ.

1. Нийслэлд бүртгэлтэй иргэн нийслэлд юм уу, аль ч аймаг сумын газарт
2. Дархан, Эрдэнэт хотод бүртгэлтэй иргэн тухайн хотдоо буюу нийслэлээс бусад аль ч аймаг, сумын газарт
3. Энэ зүйлийн 1.2 дахь заалтад зааснаас бусад иргэд нийслэл, Дархан, Эрдэнэтээс бусад аль ч аймаг, сумын газарт ... газар өмчилж болохоор заажээ. /Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн гуравдугаар зүйл/ Эндээс харахад хөдөөгийнхнөө нийслэл, Дархан, Эрдэнэтэд газар өмчилж амьдран суух эрхийг хуулиар хасан Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 18 дугаар зүйлийг зөрчсөн байгаа биз. Энэ тухай сурвалжилснаа толилуулж байна.

Газрын төлөө “дайн” дэгдэх нь

Монгол Улс нэг хүнд ногдох газрынхаа хэмжээгээр дэлхийд тэргүүлэх орны нэг. Гэвч хөдөөг хөгжүүлэх бодлого алдагдсан, хөдөөгийн хүн амын ядуурал туйлдаа хүрсэн, олон удаагийн ган зуд, байгалийн гэнэтийн үзэгдлүүдэд хүчин мөхөстөж амьжиргааны үндэс болсон малаасаа хагацсан зэргээс нөлөөлөн төв рүү, тэр дундаа улсынхаа нийслэл, Эрдэнэт, Дархан хот уруу тэмүүлэх явдал их болсон. Энэ нь ард түмний буруу биш л дээ. Нэгэнт Үндсэн хуулиндаа “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох ... эрхтэй” гээд заачихсан болохоор хот суурин газраа, ах дүүсээ, хүүхдүүдээ бараадъя гэсэн бодол хэнд ч төрөлгүй яахав.

Гэтэл Үндсэн хуулийн заалт хэвээрээ мөрдөгдөж байгаа хэрнээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиараа газраа өмчилж байнга оршин суух газрыг нь ялгавартай заан, нэг ёсондоо хөдөөгийнхнөө хот суурин газруудад амьдрах эрхгүй болгосон нь хүний эрхийг ноцтой зөрчсөн явдал боллоо. Өөрөөр хэлбэл, иргэд маань байгаа байгаа газартаа хадагдана гэсэн үг.

Монголд газрын тухай тэмцэл өдрөөс өдөрт хүчээ авч байна гэхэд нэг их хэтрүүлэг болохгүй болов уу. Хоёр гурван жилийн өмнө бэлчээрээ булаалдсан хөршүүд нэг нь нөгөөгөө хүйс тэмтэрч цуст аллага болсон. Үүнээс хойш тариа ногооны талбай, бэлчээрээ булаалдсан хэрэг зөрчил байнга сонсдож байлаа. Хамгийн сүүлд л гэхэд Завхан аймгийн Их-Уул сумын малчин Тогтох, Адъяасүрэн нар Архангай аймгийн Өндөр-Улаан суманд отроор очоод байхад нь өвөлжөөний эзэн “Н” газраа харамлаж маргалдсанаас цаад хоёр нь архины шилээр цохиж алсан байгаа юм.

Газрын төлөө цус урсах явдал цаашид юунд ч хүргэж болзошгүй гэдгийг саяхан нийслэлдээ улаан трактортойгоо давхиж орж ирсэн хэдэн тракторчны үйл ажиллагаа харуулж байна. Тэд янз бүрийн бодолтой л орж ирсэн байх. Гол нь одоо хувааж авчихаад, байгаа газар дээр хамжлага болохгүй, хувьдаа газартай больё гэсэн бодолтой хүмүүс байсныг хэн ч үгүйсгэхгүй болов уу. УИХ-ын дарга, Ерөнхий сайд хоёр маань тэр хэдэн тракторчинд “томорч” талбайд оруулж ирж байгаад “нэгмөсөн хашраана” гэж хүлээлгүй учир зүйгээ ололцон, Монгол Улсын иргэнийх нь хувьд хүндэтгэлтэй хандсан бол баригдаж тавигдахдаа хүртэл хурцдахгүй байсан шүү дээ. Засгийн газар, түүний хүчний байгууллагууд эхнээс нь л “дайсны анги нэгтгэлүүд” хот уруу довтолж байгаа юм шиг хэдэн давхар хамгаалалт гаргаад, гарц уулзвар болгон дээр бүсэлж хаагаад байх ямар хэрэг байв аа. Чөлөөтэй оруулаад төр, засгийн удирдлагууд хүлээж аван санал бодлыг нь сонсоод, хууль номоо сайхан тайлбарлаж ойлгуулаад “Одоо ингээд буц, гэрийнхэндээ өгөөрэй” гээд юухан хээхэн боож өгөөд явуулахад бүгд л “Төр, засаг минь” гэж залбираад сэтгэл хангалуун буцацгаах байсан даа. Хүний сэтгэл гэдэг хайлах, харлах хоёр нь амархан болохоор тэдэн дунд хоолойгоо боолгох хүртлээ “ноцолдох” хүн гарахгүй л байсан болов уу гэж боддог юм. Харин ч ухаантай, уужуухан бодолтой тракторчид таарсан. Тэр дунд УИХ-ын гишүүн У. Хүрэлсүх шиг хүн байгаад “Бид ч бас босч чадна шүү” гээд дайрсан бол юунд ч хүрч болох л байсан. Хууль гарсны дараа ингэж байгаа юм, хувьчлалын үеэр “дайн” болж магадгүй л байх.

Лаатай хороолол

Би өнөө намар баруун зүгийн замаар нэлээд хэдэн удаа явжээ. Замд байсхийгээд л гэр ачсан, мал ачсан машин. Эсвэл ханаа дугуйлаад хонож өнжиж байгаа хөдөөнийхөн. Зарим нь цөөн хэдэн малаа туучихсан, уртын замд ангаж, цангаж ядарчээ. “Хаана хүрэх нь вэ” гэхэд бүгд л “хот” гэнэ.

Би бодлоо. “Газрын шинэ хууль гарчихсан. Энэ хөдөөгийнхөнд хотын газраас олгохгүй. Хаашаа хөөгдөж туугддаг юм бол доо” гэсэн шиг сэтгэл эмзэглэж байсансан. Саяхан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шилжилт хөдөлгөөн хариуцсан алба уруу сурвалжлагаар очлоо. Нэлээн томхон танхим пиг дүүрэн хүн. Гутлын ул багтах зай бараг алга. Хөдөө, хотоос шилжиж ирэгсэд. Бас хот дотроо шилжилт хөдөлгөөн хийлгэж байгаа хүмүүсийн урт дараалал энэ. Хоёр цонхоор үйлчилж байгаа боловч удаан, залхуутайг нь яана. Миний уулзсан хүмүүс бүгд л “Улсынхаа нийслэлд ирж амьдарна гэдэг гадаадад явж амьдрахаас хэцүү болж” хэмээн толгой сэгсэрцгээнэ. Баянхонгор аймгийн Хүрээмарал сумаас орж ирсэн Б. Түдэв гуай:

-Хэцүү юмыг чинь одоо л үзэж байна. Манай хөдөөд бууж суух газраа заалгадаг биш дээ. Улс дотроо юм болохоор болох л байх гээд ороод ирсэн. Тэгсэн чинь болдоггүй юм байна. Манайх хөдөө 300-400 малтай, боломжийн амьдарч байсан. Сүүлийн хэдэн жилийн ган, зуднаар малаа бараад амьдрах аргагүйдээ тулан хэдэн хүүхдээ бараадан наашаа гарлаа. Хотод ирсэн чинь газар олддог юм биш. Зөндөө л газар байх юм. “Хүн авчихсан, барилга барина, шугам сүлжээ явсан, өндөр хүчдэлийн дор” гэхчилэн бүгд л нэг шалтгаантай. Дээгүүр албаны хүн таньдаг л бол алга дарам газар олдож болмоор юм. Арга ядаад униа шовойлгочихоод сууж байсан чинь Толгойтын баруун салаанд худалдах газар байна гэнэ. Очсон чинь 20х10 метрийн хэмжээний хашааг 700 мянгаар зарна гэж байна. Өр зээл хийгээд авчихлаа даа. Хүүхэд, хүргэнийхэнтэй хамт гурван гэрээрээ, бараг л дээр дээрээсээ буух нь холгүй амьдрах юм байна даа. Ер нь хотын газрыг чинь цөөн эрх мэдэлтэн хувааж авчихаад, хэсэглэж зараад байгаа юм биш үү гэж ярилаа. Энэ газар нь хотын захад, чулуу хайрган хөрс, автобусны буудлаас хэдэн км-ийн зайтай гэнэ. Өмнөговь аймгаас хоёр дүүгээ хотод шилжүүлж ирэх гэж ёстой л гадаадад явж амьдрахаас илүү зовлон үзлээ гэж Ц хэмээх залуу ярьж байна. Тэрбээр:

- Монголд хотын хүн, хөдөөний хүн гэсэн хоёр айхтар зааг татчихжээ. Газар өмчлөлийн хууль гэдэг нь түүнийгээ баталгаажуулж өглөө. Мөнгөгүй хүнд газар олдохгүй, бараг л усан дээр буух нь холгүй хөөгдөж явна даа гэсэнсэн.

Т. Оюун-Эрдэнэ гэдэг эмэгтэй:

-Газраас гадна шилжиж ирэхийн төлбөр гэж дааж давшгүй мөнгө. Том хүн 50 мянган төгрөг. Хүүхэд 24 мянган төгрөг. Бичиг баримт, наашаа цаашаа явсаар нэг хүн зуугаад мянган төгрөгт л багтаж байх шиг байна. Хэчнээн ч сар явав даа гэнэ.

Нэрээ хэлэхийг нууцалсан нэг залуу, Баянзүрх дүүргийн цайз-16-гийн буудлаас хойш 600 мянган төгрөгөөр жижиг хашаа авсан. Тэр хавьд олон зуун айл гэрэл цахилгаангүй, нийслэлийн “лаатай хороололд” амьдарч байна гэсэнсэн.

Нийслэлийн ойр орчим, аль боломжийн газруудыг цөөн тооны эрх мэдэлтэн хувааж авчихаад түүнийгээ баталгаажуулан хууль гаргасан дүр үзүүлж, ядуус, хөдөөгийнхний газар өмчлөх эрхийг хөсөрдүүлж байна гэсэн үг, уулзсан хүн бүхний амнаас унаж байлаа.

Татаастай хүмүүс

Нийслэлийн болон дүүргүүдийн газрын албадаар явж үзлээ. Зун, намарт байснаа бодвол хүний хөл татарсан байна. Гэхдээ л байнгын арав хорин хүнтэй. Сүхбаатар дүүргийн хот байгуулалт, газрын харилцааны албаны үүдэнд том самбар дээр, дүүргийн Засаг даргын захирамжийн хавсралт хадаатай байна. Энэ захирамжаар 274 айлын хашааны газрыг баталгаажуулжээ. Хамаг сонин хачин энд л байна. 274 айлын хашааны газрын 90 гаруй хувь нь нөгөөх нэг хүнд /айлд/ олгогдох ёстой 0.7 га-д хүрэхгүй байна. Ихэнх нь 0.02-0.04 га-д багтаж байх юм. Энэ бол жирийн иргэдийн газар. Гэтэл Бэлхэд амьдардаг Т. Алтансүхэд 400 га, Хангайн гудамжинд орших Д. Энхцэцэгт 240 га-г Засаг даргын захирамжаар баталгаажуулан олгожээ.

1994 оноос хойш хашааны газрын асуудлаар хөөцөлдөж яваа А гэдэг эмэгтэйтэй уулзлаа.

-Та зуны дэлгэр цагт ирсэн болоосой. Наадмын газар шиг л хүн, машин бужигнаж байдаг газар даа. Дарга нарын танил, дээрээ татаастай нэг нь дорхноо хамгийн сайхан газрын зөвшөөрөл аваад явчихна. Мань мэт нь хэдэн ч сар, жилээр явж мэднэ. 2, 4 дэх өдрүүдэд байцаагч нь явж газар үзэж хэмжиж баталгаажуулах ёстой. Унаа олоод ирнэ, явахгүй гэнэ. Их хэцүү шүү дээ. Та Бэлх рүү нэг өнгийгөөд харчихаарай. Баячууд, сайд дарга нар, эрх мэдэлтний ямар том хашаанууд байгааг харна аа. Ингэж хувааж авчихаад ядуус, хөдөөгөөс ирсэн хүмүүст “газар байхгүй” гээд халгаахгүй байгаа юм шүү дээ гэж ярилаа.

Ер нь дүүргүүдийн газрын албаар ийм л хэл яриатай. Газар өмчлөх эрхээ эдэлж чадахгүй байна хэмээн гомдож горойсон хүмүүсээр дүүрэн байна.

Эрхэм дээдэс ээ, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиа үйлчилж эхлэхээс нь өмнө эргэж нэг харвал ямар байна аа. Жирийн иргэд, ядуус, хөдөөгийнхөндөө хэтэрхий хатуу хандсан, эрх нь зөрчигдсэн хууль болсон юм биш үү. Амьжиргааны үндэс болсон малгүй, газаргүй болж байгаа хүмүүс юунд ч хүрч мэднэ. Улаан трактортангуудаас илүү, улс хөмрөх аюул нүүрлэхийг байг гэх газаргүй. “Хахсан хойно хашгирав” гэгч болуузай.

1.17 ҮНДСЭН ХУУЛЬД БАЙХГҮЙ “ДАВУУ ЭРХ” БУЮУ ДАРГА НАРЫН ДАВАРСАН ЭРХ

Галсангийн Жамъян

Монголын мэдээ, 2002. 12. 18, №249 /998/

“Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр, хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”

/Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 14-р зүйлийн 1/

...Би Улаанбаатар хотын мод боловсруулах комбинат гэж мянга гаруй хүнтэй том үйлдвэрт ажиллаж байлаа. Бидний хийсэн шар ширээ одоо ч Төрийн ордны өрөө тасалгаануудад тавиатай байдаг юм. Төрийн ордны өргөтгөлийн бүх хаалга, цонх бидний л хийсэн модон хийц байгаа. Манай комбинатын ажилтан уран Сүхээгийн сийлбэрлэсэн ширээ Төрийн ордны хүндэтгэлийн танхимд, улам өнгө ороод л байж байдаг юм.

Юуны учир энэ бүхнийг дурсав гэвэл Монголд гадны хүч хөрөнгөөр баригдсан ямар сайхан үйлдвэрүүд байсныг төсөөлөх гэсэн хэрэг.

1990-ээд оны үед нэг өглөө л өнөөх үйлдвэрээ цех, тасгаар нь салгаж авцгаагаад, уурын зуухаа хүртэл булаалдаж эхэлсэн. Тэгээд өнөөх том комбинат маань ор сураггүй арилж оронд нь оготны нүх шиг олон газраас танихгүй дарга нарын толгой шоволзох болж билээ. Яасан бэ? гэсэн чинь “давуу эрхээр” авцгаасан гэнэ. Давуу эрхээр авсан хүмүүсийг нь харвал саяхан л үйлдвэрт ирж байсан залуучууд, цөөн хэдэн жил үйлдвэр, цех удирдаж байсан хүмүүс, яамны түшмэлүүд байх юм. Насаараа модны үйлдвэрт зүтгэсэн нөгөө хөдөлмөрийн баатар Чулуунбаатар, Ардын их хурлын депутат байсан Дорж, Түдэв, кранист Баттөмөр, дарга асан Жалбийдандар, цахилгаанчин Дашцэрэн, Дэмбэрэл, цагтаа тэргүүний мастер гэж явсан Чимэддорж нар сандлын хугархай хөл ч үгүй хоцорсон байв. Хэрвээ “давуу эрх” гэж байдаг байгаад, хувьчлал нь түүгээр явагддаг байсан бол гуч дөчин жилийнхээ амьдралыг зориулсан энэ хүмүүс л эдлэх ёстой эрх байсан. Гэтэл тэгсэнгүй.

... Нэг өдөр ерөөнд маань хөгшин залуу нийлсэн арав гаруй хүн орж ирлээ. Нийслэлийн өмч хувьчлалын комисс Хан-Уул дүүргийн нэг хүнсний дэлгүүрийг “давуу эрхээр” хамт олонд нь өгчихөж. Давуу эрхээр авна гэж хөөцөлдөж байгаад гартаа оруулаад авсан дарга эмэгтэй нь нэг л өдөр худалдагч үйлчлэгчдээ халаад, дан өөрийн хамаатан, садан, найз нөхдөөрөө дүүргэчихэж. “Давуу эрхээ” эдлэх гэсэн жирийн ажилчид нь ингээд гудамжинд гарч, арга тасрахдаа сонинд хандсан нь энэ билээ. Сонинд үнэнийг бичээд ч тус нэмэр болоогүй. Хохирогчид шүүхэд олон удаа хандсан боловч шударгаар шийдвэрлэж өгсөнгүй. Нэг настайвтар эмэгтэй нь: “Арайхийж нэг болж бүтмээр болохоор л нэг том дарга хөндөлдчихөөд болохгүй юм. Яасан хатуу хорвоо вэ” гээд уйлж байсансан. Энэ маргаан олон жил үргэлжилсэн ч дарга нарын “давуу эрхийг” давж гарч чадаагүй юм даа.

... 2000 оны сонгуулиар Сэлэнгэд сурвалжлагаар явж байлаа. Нэр дэвшигчтэй уулзсан нэг хурал дээр ахимаг насны эр босч ирлээ. Зүүн-Хараагийн спиртийн үйлдвэрийг “давуу эрх” нэрийн дор яаж авалцаж өгөлцсөн тухай тун сонин зүйл ярилаа. Монголдоо нэгд орох энэ үйлдвэр маань Спирт бал бурмын бүхэл бүтэн хотхон юм гэнэ. Үйлдвэрийн байгууламжаас гадна гурван зуун айлын тохилог орон сууц, уурын зуух, цэцэрлэг, ясли гэхчилэн өчнөөн олон барилгатай бэсрэг хотхон гэдгийг ойлгуулж билээ. Тэр бүхэл бүтэн хотхоныг “давуу эрх” нэрийн доор 300 сая төгрөгөөр, өөрөөр хэлбэл, зөвхөн ажилчдынх нь сууцны үнээр л хэдэн хүнд өгчихсэн гэнэ. Тэгээд, дахин жинхэнэ ном журмаар нь хувьчлуулж өгөөч хэмээн санал тавьж байсансан. Үнэн бол хэцүү л юм даа гэж бодоод өнгөрсөнсөн.

Монголын олон үеийн хүмүүсийн хийж бүтээсэн зүйлийг ийнхүү “давуу эрх” нэрийн дор ах, дүү, хамаатан садан, найз нөхдөдөө “бэлэглэчихсэн” олон зуун тохиолдлыг би нэрлэж чадах юм. Тэгээд, Үндсэн хуулийн 18 зүйл эрхийн алинд ч ороогүй “давуу эрх” буюу дарга нарын даварсан эрх хаанаас гараад ирэв гэдгийг нэлээд ухаж төнхөж үзлээ. “Давуу эрх” гэдэг нэр томъёо анх Д. Бямбасүрэнгийн Засгийн газрын нэгэн хуралдааныг шадар сайд Да. Ганболд даргалж хийлгэсэн протоколд “...Зарим үйлдвэр, аж ахуй, үйлчилгээний газрыг одоо эзэмшиж байгаа эздэд нь давуу эрхээр олгож болох юм” гэсэн өгүүлбэр орсон байх аж. Эндээс л, Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй “давуу эрх” гэдэг нэр томъёо гарч, энэ нь яваандаа дарга нарын даварсан эрх болж улам хүчээ авч байна. Саяхан УИХ-аар баталж, ирэх оны хавраас хэрэгжүүлж эхлэх гэж байгаа Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд “давуу эрх” хэд хэдэн газар шургаад орчихжээ. Тариа ногооны газрыг эзэмшиж байгаа хүмүүст нь “давуу эрхээр” олгохоор заасан юм. Тэгээд ч Төр, засгийн удирдлага, эрх мэдэл бүхий хүмүүс, хамгийн үржил шимтэй, стратегийн ач холбогдол бүхий газруудаа хэнд давуу эрхээр өмчлүүлэх вэ гэдгээ аль хэдийнэ шийдчихсэн, ах дүү хамаатан саднуудаа аваачаад “зоочихсон” байгаа гэж нутгийн хүмүүс ярьж байна. Олон жил газартайгаа сэтгэл зүрхээрээ холбогдоод эцэс сүүлд нь хэн нэгний “давуу эрхэнд” газраасаа түргэгдсэн олон мянган тариаланчид, тракторчдын төлөөлөгчид алга дарам газрынхаа төлөө тэмцэж нийслэлдээ ирээд баривчлуулж, бороохойдуулаад байгаа нь нууц биш.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг сурталчлахаар хөдөөг зорьсон эрхэм түшээ, сайд дарга нар үр тарианы асар их талбайн эзэнгүй байгаа юм шиг, түүнээсээ дураараа өмчилж ав гэсэн зүйл ярьж яваа. Үндсэндээ энэ нь бол огт худлаа, атаршиж зэлүүд орхигдсон жаахан газар л байгаа юм гэнэ. Түүнийгээ зүгээрч өгчихгүй өндөр үнээр,

дуудлага худалдаагаар өгнө гэж гар хоосон үлдээд байгаа тариаланчдын зүрхэнд шар ус хуруулж байгаа ажээ.

“Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөнийхөн тусгай комисс гаргаж МАХН-ын удирдлага, Их Хурал, Засгийн газрынхантай холбоо бүхий /ах дүү, хамаатан садан, найз нөхөд/ хэн гэгч, ямар хүмүүс газрыг “давуу эрхээр” урьдчилж авчихаад, нөлөөллөө тогтоочихоод байгааг нэг бүрчлэн гаргаж ард түмэндээ танилцуулах гэж байгаа гэсэн. УИХ-ын эрхэм түшээ Р. Содхүү төрийн түшээгийн хүндэт суудал дээрээс ард түмнээ “битгий солиор” гэж загнаад байгаагийн учир утгыг ч тодорхойлж тавих юм гэнэ билээ.

Өнөөдөр ард түмэн бухимдлынхаа туйлд хүрээд байна. Гол нь тэд Монгол Улсын Үндсэн Хуульд байхгүй хэрнээ дарга нарыг даврааж байгаа “давуу эрхэд” үнэ цэнэтэй бүхнээ алдаж байгаагийнх.

1.18 АРВАН НЭГЭН ДАРГЫН ГАРЫН ҮСЭГТЭЙ ӨРГӨДЛИЙН ХУВЬ ЗАЯА ХЭЗЭЭ ШИЙДЭГДЭХ БОЛ?!

Галсангийн Жамъян

Монголын мэдээ, 2003.01.04, №002 /1008/

“Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй”

/Монгол Улсын Үндсэн хуулийн 14-р зүйлийн 5/

Миний өмнө Даваагийн Дамчаа гуайн өргөдөл дэлгээтэй байна. Би энэ өргөдлийг 11 даргын гарын үсэг, цохолттой болохоор нь сонирхсон юм. Уг нь ядарсан өндөр настны жирийн л нэг гуйлт. Гэхдээ 11 даргын гарын үсэг автлаа “үйл тамаа” үзэж яваа өргөдөл юм. Өргөдлийн хэсгээс сийрүүлбэл,

... Даваагийн Дамчаа миний бие 16 настайдаа хотын худалдааны харьяа өндөр дэлгүүрт /одоо дүрслэх урлагийн музей байгаа/ морин тэрэгчнээр орж, түүнээс хойш худалдааны байгууллагад тасралтгүй 44 жил ажиллаад өндөр насны тэтгэвэртээ гарсан. Тэтгэвэр ч гэж дээ, “Дээр үед ажиллаж байсан газрын чинь материал бүрдээгүй байна. Тасарсанд тооцно” гэхчилэн жил сараас минь хассаар 18 мянган төгрөгийн тэтгэвэр тогтоож өгсөн. Одоо хорин хэдэн мянган төгрөг авдаг. Хөгшин маань олон жилийн өмнө ойчиж, ганц охинтойгоо, хэдэн хүүхэдтэй нь хоёр өрөө байранд амьдардаг байлаа. 1992 онд охин маань хүнд өвчнөөр нас барж, нөхөр нь хэдэн хүүхдээ аваад хүнтэй суугаад явчихсан. Би байрандаа ганцаар үлдсэн. Түшиж тулах ах дүү, садан төрөл байхгүй. Тэтгэвэр маань өдрийн хоолноос илүү гардаггүй учир олон жилийнхээ байрны мөнгийг төлж чадаагүй. Байрны хөлсөө төлөхгүй бол байрыг чинь хураана гэдэг байлаа. Тэгээд орон сууцны конторынхон ярьж хэлэлцэж байгаад байрыг минь нэг өрөө байраар сольж өгөөд зөрүүгээр нь хөлс мөнгөний дутууг хаачихсан. Одоо байр, цахилгааны үнээ бас л төлж чадахгүйд хүрлээ. Нэг бол байраа хураалган гудамд гарах, нөгөө бол үнэ хөлсийг нь төлөх хоёрхон зам үлдлээ. Нийслэлийн худалдааны бараа баазад нярав байсан, хамгийн сүүлд 29 дүгээр дэлгүүрийн нярваар цөөн хэдэн жил ажилласан. Иймээс хотын худалдаа удирдах газраас нэг удаагийн буцалтгүй тусламж олгож өгнө үү? Д. Дамчаа” гэсэн товчхон өргөдөл л дөө.

Энэ хүн хотын худалдаа удирдах газар гэж байдаг, энэ олон дэлгүүр худалдааны газрууд ч тэндээ захирагддаг, өөрөө ч тэндэхийн ууган ажилчны нэг гэдэг сэтгэлээр ийнхүү өргөдөл биччихэж. Хорооны дарга нь ч энэ л сэтгэлгээгээр цохолт хийн Дамчаа гуайн аргагүй байдлыг тодорхойлжээ. Дүүргээс эхлээд байдал бишидсэн байна. Энэ хүний ажиллаж байсан дэлгүүр татан буугдсан, бараа бааз нь биеэ даасан өөр компани болсон. Та өргөдөл гаргах газраа тодруул. Өргөдөл хүсэлтийн байцаагч Чимиднамжил гэснээр цаашаа цохолт улам л тодорхойгүй, биеэсээ зайлуулсан, бусад уруу булзааруулж түлхсэн шинжтэй болсоор хамгийн сүүлд Үйлдвэр, худалдааны сайдын, “Д. Дамчаа гуайн өргөдөлтэй танилцлаа. Энэ асуудлыг нийгэм халамжийн журмаар шийдэх нь зүйтэй. Нийгмийн халамж, хөдөлмөрийн яаманд шилжүүлье” гээд төгссөн байна.

Ийм өргөдөл хүсэлтүүд хэчнээн сайд, дарга нарын гар дамжиж, хичнээн эрх мэдэлтний шүүгээ сейфэнд хадгалагдаж, ямар олон хоног сарыг улирааж байгаа бол? Уг нь хуучин тогтолцооны үед нийгмийн тустай хөдөлмөр хийж байсан хүмүүс хийсэн ажлынхаа тал хувьд ч хүрэх хөлс мөнгө авч байгаагүй юм билээ. Хийсэн ажлын хөлснийхөө

нэг хэсгийг “тэгшитгэн хуваарилуулж” ажил хийгээгүй хүмүүсийг тэжээдэг, нөгөө хэсгийг насан өндөр болсон хойноо юмуу, хөдөлмөрийн чадвараа алдвал тэтгэвэр тусламжийн журмаар авна гэж улсын санд үлдээдэг байж. Насан өндөр болоод түүнийгээ бүрэн дүүрэн авсан хүн байдаг эсэхийг мэдэхгүй. Зарим судлаачдын тооцоолсноор бол “үлдээсэн” хөрөнгөөсөө сэтгэлдээ хүрэхээр авсан хүн бараг байдаггүй юм гэсэн. Тиймээс Монгол Улс шинэ Үндсэн хууль батлахдаа, “Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гээд заачихсан байгаа. Энэ бол хуулиар нийтэд олгодог тэтгэвэр, тэтгэмжээс гадна “эд мөнгөний тусламж” авах эрхийг баталгаажуулж өгсөн. Хэдэн төгрөгийн буцалтгүй тусламж ч биш, аргагүй болсон үедээ эд хөрөнгийн туслалцаа авах эрхтэй гэсэн үг. Энэ дагуу өргөдөл хүсэлтээ гаргасан хүмүүсийн тун ялихгүй хувь нь эрхээ эдэлдэг, дийлэнх олонх нь эрх мэдэлтний өмнө бөхөлзсөөр сар, жилээр явж байгаа нь нууц биш юм. Зудад нэрвэгдэн огт малгүй болсон буюу тавиас дээш хувиар малаа хорогдуулсан айл өрхийн дөнгөж 10,6 хувь нь галын аюулд орон байргүй болсон, эд хогшлоо шатаасан айл бүлийнхний 21,2 хувь, амьдралын бололцоогүйгээс нэг удаагийн буцалтгүй тусламж хүсэгчдийн 32,7 хувь нь, гадаад дотоодын эмчилгээ сувилгаанд явах гэж хөрөнгө мөнгөний туслалцаа хүсэгчдийн 19,7 хувь нь гаргасан өргөдлийнхөө дагуу эд мөнгөний тусламж авчээ гэсэн судалгаа байдаг юм байна. Цаана нь үлдэж байгаа тэр олон өргөдөл хүсэлт, хаана хэний гараар дамжиж явна, ойлгомжтой биз.

Монгол орон өнөөдөр нийгэм, эдийн засгийн шилжилтийн түүхэн чухал үеийг дамжиж байгаа. Хүмүүсийн ажиллаж байсан байгууллага, үйлдвэр, аж ахуйн газрууд салж нийлээд алга болсон. Хуучин нэрээрээ, бүтэц бүрэлдэхүүнээрээ байгаа газар бараг үгүй. Хүмүүсийн шилжилт хөдөлгөөн замаа алдсан, хуучин хамт ажиллаж байсан хүмүүс хаана яваа нь мэдэгдэхээ больсон, үхэж үрэгдсэн гадаад дотоод яваад сураг тасарсан гэх зэргээс тусламж ч ийнхүү хүрэх ёстой эзэддээ хүрэхээ больсон байна.

Ямар ч байсан Монгол Улс Үндсэн хуульдаа тодорхой зааж, ийм нэгэн эрхийг баталгаажуулж өгсөн. Засаг, захиргааны бүх нэгж, байгууллага, пүүс, компаний эзэд хэн ч байлаа гэсэн, эрхийнхээ дагуу тусламж хүсээд яваа энэ олон хүний хүсэлтэд хөнгөн шуурхай хандаж, боломжийн хэрээр туслах дэмжиж байх нь нэг талаас үний ёс, нөгөө талаас хуулиа биелүүлж байгаа хэрэг билээ.

Хэн ч гэсэн би эрхийнхээ дагуу өргөдөл хүсэлтээ гаргасан гэж бодож яваа. Хүлээж авсан та ч гэсэн, би хуулийн дагуу шийдэж өгөх учиртай хэмээн хатуу ойлгоосой. Хуулийн өмнө адил тэгш эрх эдэлнэ гэдэг маань энэ.

1.19 ЭСЭРГҮҮЦСЭН НЬ НОТЛОГДООГҮЙ Л БОЛ ХҮЧИНГИЙН ХЭРЭГ БИШ ГЭЖ ҮҮ.

Б.Батзаяа

Үнэн, 2002.12.06, №239

Аливаа амьд амьтанд байгалиас дур хүслээ хангаж, бие сэтгэлийн таашаал эдлэн жаргах боломжийг заяасан. Тэр дундаа оюун ухаант хүмүүн бидэнд энэ маань хамгийн ариун нандин, эмзэг зүйл билээ. Өөрөөр хэлбэл бэлгийн харьцаа нь хайр сэтгэлийн илэрхийлэл, мэдрэмжийг илэрхийлдэг. Харин хүчирхийлэлд оршдоггүй. Гэтэл бэлгийн хүчирхийлэл буюу өөрөөсөө сул дорой нэгнийг эрхшээлдээ оруулан дур хүсэл, тачаалаа хангах, хүн ёсноос гажууд үзэгдэл бий болжээ. Гэхдээ энэ бол зуун зууны туршид үйлдэгдэж байсан хүн төрөлхтөний балмад зан авир. Хүний соёл иргэншлийн хөгжлийн өнөө үед энэ бол байж боломгүй зүйл. Ер нь ч тухайн улс орон хөгжиж, дэвжих тусам энэхүү балмад үйлдэл багасдаг гэсэн судалгаа бий. Харамсалтай нь Монголд өнөөдөр бэлгийн хүчирхийлэлд өртөгсөд олон. Гагцхүү гомдол гаргаад шүүх, цагдаагаар явах нь харьцангуй цөөн учраас тэр бүр анзаарагддаггүй байх. Дээхэн үед <хонины бэлчээрт өдөр бүр болж буй жирийн үзэгдэл> гээд ойшоож үзэхгүй тал ч байсныг нуух аргагүй. Энэ бүхний цаана хүний эрх хөсөр хаягдаж байна гэсэн үг. Гэхдээ эмэгтэйчүүдийнх шүү. Байгалиас заяасан уян налархай бие бялдар, хүний мөхөс байдлыг нь ашиглан тэднийг ямар учраас ийнхүү доромжлон гутаана вэ? Энэ дэлхий дээр амьдарч буй хэн ч болов нас хүйс, арьсны өнгөөр ялгаварлахгүй адил тэгш эрхтэй хэмээн тунхаглагддаг биз дээ.

Гэвч хүйсээр ялгаварлан гадуурхах үзэгдэл нь хүчингийн хэрэг дээр илүүтэй илэрч байдаг билээ.

Монгол Улсын хэмжээнд 1998-2000 онд нийт 1146 хүчингийн хэрэг гарчээ. ДОХ, БЗХӨ-тэй тэмцэх албанд хүчиндүүлсний улмаас өвчтэй эсэхээ үзүүлсэн охид, эмэгтэйчүүдийн тоо дээрх тооноос хавьгүй их байна. Иймээс хохирогч эмэгтэйчүүд маань зөвхөн эмнэлэгт үзүүлчихээд л шүүх, цагдаад хандаж төвөг удахыг хүсдэггүй бололтой. Нөгөө талаар хүчингийн гэмт хэрэг үйлдэгчдийн ихэнх нь хамаатан садан, гэр бүлийнхэн нь байдаг учраас хэн хэнийхээ нэр төрийг чухалчилдаг биз ээ. (Хүчиндэгч нь хохирогчийн хэн болохыг судалсан судалгааг мэргэжилтнүүд гаргажээ. Тэдний 10 хувь нь дагавар охиноо, 36 хувь нь танилаа, 14 хувь нь садангийн эгч, дүүгээ хүчиндсэн гэсэн байна.) Гэвч үүний цаана нөгөө л хүний эрх маань гээгдэн хоцорч үлджээ. Мөн охид, эмэгтэйчүүдийг өөрсдөө хүчингийн хэргийг “өдөөсөн” хэмээн буруутгах болон “бузартсан” гэх зэргээр жигшин үзэх хандлага олон нийтийн сэтгэхүйд давамгайлсан байдал ажиглагддаг учраас хохирогчид нэр төрөө болон хүчингийн гэмт хэргийг нуун дарагдуулах шалтгаан болж байна. Энэ мэт гэмт хэрэгтэн ялаас мултарч, бузар дур тачаалдаа дахин хэн нэгнийг урхидахгүй байхыг үгүйсгэх аргагүй. Гэхдээ тэд хэзээ нэгэн цагт жигшүүрт энэ үйлдэлдээ шийтгэл хүлээх нь гарцаагүй гэж найдъя. Мэдээж сэтгэл санаа болон бие эрхтэний хохирол амсч шүүх, цагдаад хандахаас өөр аргагүй болсон тохиолдол бий. Тэгвэл гэмт хэрэгтэнг Монгол Улсын хууль хэрхэн гэгсгээн цээрлүүлж байна вэ?

Улсын Дээд шүүхийн тайлбарт “хүчиндэх гэдэг нь гэмт этгээд хурьцал үйлдэх өөрийн санаа зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хохирогчийн хүсэл, зөвшөөрөлгүйгээр, түүний эсэргүүцэл, зоригийг няцааж, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, эсвэл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүчирхийлж хурьцал үйлдэхийг хэлнэ” гэжээ. Тэгэхээр энэ заалт ёсоор хурьцлыг үл зөвшөөрсөн байдлыг илтгэх хохирогчийн эсэргүүцэл байна гэж үзжээ. Гэтэл хурьцал нь урагдаагүй, бие махбодид нь гэмтэл учраагүй буюу тодорхой эсэргүүцэл үзүүлсэн буюу хурьцал үйлдэхийг зөвшөөрөөгүй нь илрээгүй тохиолдолд “хүчингийн гэмт хэрэг биш” гэж үзэх нь. Хуулиар шүү дээ. Хүчин мөхөс тэр бүсгүй заналхийлэгчийн өөдөөс ноцолдож, урж майжих гэх мэт эсэргүүцэл үзүүлбэл харин эргээд өөрөө амь насаа ч алдаж болох. Тэгээд ч гэмт этгээдээс гэмт хэрэг үйлдсэнээ нотлохыг шаарддаггүй атлаа хохирогчоос гэмт хэрэгтний хэмжээнд хүрч, урсан зодсон, хөхрүүлсэн, майжсан байхыг нь шаардах нь логик ухаанд нийцэхгүй юм. Ийнхүү хүчингийн хэргийн тодорхойлолтыг өөрчлөх цаг болсон мэт санагдана. Чингэвэл гэмт этгээдийн биенд ул мөр үлдээсэн л бол нотлох баримт болох мэтээр ойлгох өрөөсгөл байдлыг үгүй болгож, бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрөөгүй байдлыг нотлох боломж нээгдэнэ. Нөгөө талаар хүний эрх, ялангуяа хүйсээр ялгаварлан гадуурхагддаг гэдэг эмэгтэйчүүдийн эрхийн асуудал нэг шатаар урагшлах нь лавтай. Хүчингийн хэрэг ихэвчлэн итгэл эвдэх, хууран мэхлэх, эрх мэдэл болон эдийн засгийн хувьд эрхшээлдээ оруулах замаар үйлдэгддэг. Гэтэл манай хуулинд зөвхөн хүч түрэмгийлэн айлган сүрдүүлсэн үйлдлийг ийнхүү хүчинд тооцохоор заасан байдаг нь учир дутагдалтай юм. Нөгөө талаас хэргийг үйлдэгчид охид, эмэгтэйчүүд айж балмагдан цочролд орсноос эсэргүүцэх чадваргүй байсныг далимдуулж зөвшөөрсөн хэмээн тайлбарлаж, хариуцлагаас мултрах нэг нөхцөлийг бий болгож байгаа нь харамсалтай.

1.20 ҮРЧЛҮҮЛЭХ НЭРИЙДЛЭЭР ӨНДӨР ҮНЭЭР ХҮҮХДЭЭ ХУДАЛДЖЭЭ

Б.Батзаяа

Үнэн, 2002. 12.24, №251

Монголд хүний наймаа газар авчээ, гэвэл та гайхах байх. Харин эмэгтэйчүүдийн биеэ үнэлэхийг ийнхүү нэрлэж байгаа биз гэж эндүүрэн бодож магад. Гэтэл эгээ л бараа шиг үнэ хаялцан монгол хүнийг гадаадынхан худалдан авдаг гэнэ. Хүний наймааны хамгийн эрэлт ихтэй “бараа” нь хүүхдүүд, эмэгтэйчүүд бас эрчүүд. Гэхдээ тэдний нас залуу, чадал тэнхээтэй нь илүү гүйлгээтэй. Миний бичих энэ зүйл таны ой тойнд буухгүй л байх л даа. Монгол Улс ардчилсан, хүний эрх, эрх чөлөөг дээдэлнэ хэмээн “Үндсэн хууль”-даа тунхагласан атлаа хүний нийгмийн хамгийн бусармаг явдал манайд байна гэж үү хэмээн. Тэр байтугай олон улсын шинжээчдийн дүгнэлтээс үзэхэд Монгол Улс дамжуулан

худалдаалагдах хүмүүсийг гаргах ба дамжуулах орон болсон байх магадлалтай гэж үзжээ. Харин Монголчуудыг худалдан авагч орнууд нь Америк, Япон, Солонгос, Баруун Европ, Латин Америкийн өндөр хөгжилтэй орнууд болон Австрали, Сингапур зэрэг орнууд ордог ажээ. Манай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өдөр тутам зарлагдаж байдаг <гадаадад өндөр цалинтай ажилд зуучилна>, <хүүхэд үрчилнэ, үрчлүүлнэ>, <царайлаг охид бүсгүйчүүдийг гадаадад ажиллуулна> гэх мэт зарлалууд бол хүнийг худалдах, худалдан авах гэмт хэргийн халхавч болох нь тогтоогджээ. Үнэхээр өндөр цалин авч, амь амьжиргаагаа дээшлүүлэхийг хүсэхгүй хэн байхав, төрүүлсэн үрээ өсгөж чадахгүй бол боломжийн айлд өргүүлж сайн хүн болгоход юу нь буруу гэж, байгаль эхийн харамгүй заяасан бие бялдар, царай зүсийг ганц олдсон насандаа ашиглахгүй бол сайхан төрсний хэрэг юун гэх мэт зүйл бол хүний амьдралын л асуудлууд шүү дээ. Гагцхүү хүний энэхүү хүсэл тэмүүлэл, амьдралын төлөөх тэмцэл зэрэгт нь дөрөөлж хүн нь хүнээ худалдах, боолчлох, хүчирхийлэх, мөн хүний эд эрхтэнг зарах аймшигт хэргийн уурхай Монгол орон минь болчихсон юм уу гэсэн айдас хүйдэс төрөх боллоо.

Ер нь хүн төрөлхтөн үүсэж бий болсон цагаасаа эхлэн өмч хөрөнгө, эрх мэдлийг тодорхой хэмжээгээр эдэлж ирсэн билээ. Хүний нийгэм хөгжихийн хирээр өмч хөрөнгө, эрх мэдлийн ялгаа улам их гардаг нь зүй тогтол. Гэвч хүнийг өмч хөрөнгө мэт үзэж арилжиж байсан тэртээх боолын нийгмийн үеийг бид мэднэ. Гэтэл өнөөдөр хүнийг арилжих явдал нийгэм хөгжихийн хэрээр арга нь улам нарийсч байгаа дээрх төрлийн заруудаас харахад тодорхой. Монголчууд бидний итгэмтгий зан, гадаадын иргэн л бол биднээс илүү ухаантай, хөрөнгөтэй гэх гэнэн бодол гэмт хэрэгтнүүдийг өөгшүүлж байдаг юм биш биз.

Өндөр цалин амлаж боолчилжээ.

Сүүлийн үед сонин дээр гарч буй зарлалуудын гуравны нэг нь гадаадад өндөр цалинтай ажилд зуучлах. Адтай зарим нэг нь боломжийн хэдэн ногоон цуглуулаад ирдэг л биз. Гэвч дийлэнх нь хоосон гуяа ганзагалаад л ирэх нь энүүхэнд. Тэгж зовж зүдэрч яваад амьд мэнд ирсэн нь л яамай даа хэмээн олзуурхан боддог. Бодох нь ч зөв юм шиг. Ийм нэгэн жишээ дурдъя л даа.

С 22 настай. Цагаач ажилчин элсүүлэх зарлалын дагуу Монголын нэгэн компанийн зуучлалын дагуу явсан байна. Зорьсон газраа очсон эхний өдөр нь боомтод аваачиж усан онгоцонд суулгажээ. Уг онгоц нь далайн бүтээгдэхүүн боловсруулах хөвөгч үйлдвэр байсан бөгөөд ажиллагсдын ихэнх нь цагаач ажилчид байв. Тэрбээр өдөрт 12-14 цаг амралтгүй жил гаруй ажилласан байна. Хүнд нөхцөлд ажиллаж байхдаа тэрбээр өндөр цалин авна гэдэгт л итгэсээр явжээ. Ийнхүү бүтэн жил гаруй хуурай газар дээр ганц гишгэсэнгүй. Нэг л өдөр С-ийг ажиллах хугацаа чинь дууслаа гээд 1000 гаруйхан доллар өгч гэнэ. Хичнээн хэлж яриад, эсэргүүцэн тэмцсэн ч нэмэр болоогүй гэнэ. Удаан хугацаагаар хүнд нөхцөлд ажилласнаас үе мөчний, арьсны харшлын өвчин тусч, ядаргааны туйлд хүрсэн С энэхүү мөнгөө эмчилгээнд зарцуулаад дууссан байна. Тэгвэл сайхан төрснийхөө хүчинд сайхан амьдрах хүсэлдээ хөтлөгдөж гэнэдсэн охидын бас нэгэн баримт дурдъя.

165 см-ээс өндөр, царайлаг залуу охидыг ажилд зуучилна гэсэн зарлалын дагуу охид анх Б-тэй уулзжээ. Тэднийг бааранд бүжиглүүлж сард 3000 долларын цалин олгоно гэж тохиролцсоны дагуу тэд олон бэрхшээлийг даван туулж зорьсон газартаа хүрчээ. Гэтэл Б охидыг биеэ үнэлэхийг шаардаж, эс зөвшөөрвөл зодох, хоол өгөхгүй өлсгөх зэргээр биеийн болон сэтгэл санааны хувьд дарамталж байжээ. Энэ гэмт хэрэг илэрч, бусдыг хүчээр дарамталж байсан Б зохих ял шийтгэлээ хүлээсэн юм. Эдгээр жишээ бол худалдан боолчлон хөдөлмөрлүүлэх үйлдэл яахын аргагүй мөн.

Эл төрлийн гэмт хэрэг зохион байгуулалттай явагддаг учир тэр бүр илрэхгүй байх нь олонтой. Илэрсэн ганц хоёр холбогдогчийг нь байцааж саатуулаад мөрдөн байцаалт мухарддаг гэнэ. Тэгээд ч хэн нэгэнд хууртаж гадаадад хүчээр биеэ үнэлүүлж явсныгаа тэр бүр бусдад дэлгэхийг хүсэхгүй байх нь ойлгомжтой. Нөгөө талаар <дуртайдаа л тэгж яваа биз> гэх манайхан хэн нэгнийгээ нүд үзүүрлэн буруутгадаг шүү дээ. Энэ мэт шалтгаанаас үүдээд цагдаагийн байгууллагад хандсан нэг нь бодлоо өөрчлөн, нэхэмжлэлээ эргүүлэн авдаг гэнэ.

Хуурамчаар гэрлүүлж охиноо худалдсан нь.

Охид эмэгтэйчүүдийг дамжуулан худалдахаар нууцаар гаргах нэг арга нь <хуурамч гэрлэлт>. Монгол Улсад бүртгэгдэж буй гэрлэлтийн цөөн бус хувь нь гадаадын иргэнтэй

гэрлэлтээ батлуулж байна. Гэхдээ гэрлэлт бүрийг хуурамч гэж буруутгах гээгүйг эхэнд нь хэлэх нь зүйтэй болов уу. Хэдийгээр гэрлэлтийг зуучлалын бизнес нь хуулиар зөвшөөрөгдсөн боловч гадаадад гарч биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь энэхүү хуурамч гэрлэлтээр гадаадад гарсан байдаг гэж олон улсын шинжээчид дүгнэжээ. Монгол бүсгүйчүүд царайлаг, нуруулаг учраас энэ төрлийн гэмт хэрэгтнүүд манайхныг илүүтэй сонирхдог бололтой. Сүүлийн үед Ази хүүхнүүд Европт “моодонд” орж байгаа гэсэн цуурхлаар бүсгүйчүүд “европ тивийн залуутай гэр бүл болоход алдахгүй нь” гэж гэнэнээр мөрөөдөх болжээ. Тэр атугай Герман үндэстэй л бол нас, боловсрол хамаарахгүй танилцана гэсэн зар саяхны нэг сонин дээр гарсан байна. Бодвол дээрх ярианы үр дүн биз. Энэхүү ярианд итгэж гадаадад гарч зовж зүдэрсэн нэгэн бүсгүйн тухай өгүүлье.

Өнгөрсөн жил Б бүсгүй Германд хүүхэд асруулах ажилд Монголын нэгэн компаниар зуучлуулан явжээ. Гэтэл очсон айлд нь хүүхэдгүй, ганц бие герман залуу байсан ажээ. Зуучлагч компани нь үүнийг мэдмэгц нутаг буцаах гэсэн боловч бүсгүй нэгэнт ирчихсэн учраас ганц хоёр сар энд байж байгаад буцъя гэж гуйжээ. Ийнхүү нөгөө герман залуутай хамт амьдарчээ. Гэтэл нөгөөдөх нь түүнийг найзуудаараа хүчирхийлэн зугаагаа гаргаж эхэлсэн ажээ. Мэдээж хүүхдээ харуулна гэж худал мэдээлсэн герман эр бол хүний наймаачдын нэг нь байсан гэдэг нь гарцаагүй.

Гэвч бас Монголд амьдарч буй гадны иргэнтэй хуурамчаар гэрлүүлсэн тохиолдол гарчээ. Нэгэн эмэгтэй Б 17 настай охинтойгоо амьдардаг. 1995 оноос хойш худалдаа наймааны хэргээр гадны нэгэн иргэнтэй хамтран ажиллажээ. Наймаа эхлэхдээ тэр хүнээсээ их хэмжээний мөнгө зээлж авсан байна. Харамсалтай нь Б-гийн наймааны ажил бүтэлгүйтжээ. Ингээд аргагүйн эрхэнд тэр хүнийхээ шахалтаар өөрийн охиноо түүнтэй хуурамчаар гэрлүүлсэн байна. Гэтэл тэр охиныг нь нутаг руугаа хүчээр авч явахаар завдсанд Б тусламж гуйжээ. Олон нийтийн байгууллагад хандаж тусламж гуйсан нь л энэ шүү дээ. Үүний цаана хэн нэгэнтээ хуурамчаар гэрлэчихээд харийн нутагт очин зовж зүдэрч яваа монгол бүсгүйчүүдийн тухай бид сонсч л байдаг шүү дээ.

Өлсгөж байснаас үрчлүүлсэн нь дээр гэж үү.

Үр хүүхдээ өсгөж чадахгүй юм бол юунд төрүүлсэн юм бэ хэмээн эгдүүцэн бодохоос өөр аргагүй. Гэхдээ л хүний амьдрал юм хойно алдаж эндэхийг алийг тэр гэхэв хэмээн зөвтгөхийг оролдоё л доо. Хүүхэд гэнэн томоогүй, ухаан нь төлжиж гүйцээгүй учраас сайхан хувцас хунар, амттан шимттэнг хараад эргэж буцна гэж үү. Тэд зөвхөн үүний төлөө л төрсөн юм шиг өөрт нь тавьсан болзол бүхнийг хүлээн зөвшөөрнө. Мэдээж өөдөөс нь харж инээсэн бүхэн тэдэнд сайхан сэтгэлт ах, эгч нар шүү дээ. Иймээс өөрийнхөө төрсөн гэрээ орхиж бусдад үрчлэгдэхдээ толгой сэгсрэхгүй дагаад л явна. Эцэг эх нь ч хөгжилтэй улсад очиж эрдэм номтой сайн хүн болох болтугай хэмээн залбираад л хоцорно. Тэднийгээ хэрхэн амьдарч байгаа талаар ямар ч мэдээлэл авах боломжгүй л үлддэг. Магадгүй сайн хүмүүс таарч, тэднийхээ хайрыг булаан жаргалтай амьдардаг нь байдаг л биз. Гэвч ихэнх тохиолдолд аз жаргал дүүрэн байхгүй. Манайд саяхан хуулийн дагуу үрчлүүлсэн нэрийн дор хүүхдээ худалдчихсан тохиолдол гарчээ. Н 30 гаран настай, таван хүүхэд, нөхрийн хамт амьдардаг. Амьдралын боломж тааруу, олон нялх хүүхэдтэй, нөхөр нь архаг архичин. 2001 онд хүү төрүүлсэн ч өөрөө өсгөх боломжгүй тул сайн хүнд үрчлүүлэхээр шийджээ. Гадаадын нэгэн иргэн бие эрүүл, бага насны ази хүүхэд худалдаж авна гэсэн зарлал өгснийг уншиж түүнд хүүхдээ үрчлүүлэхээр тохиролцжээ.

Хүүдээ эрүүл мэндийн шинжилгээ хийлгэж зохих бичиг баримтыг нь бүрдүүлэн илгээжээ. Өнөөдөр зарлал өгсөн гадны хүмүүс нь Монголд ирчихсэн хүүг нь өөрсөд дээрээ аваад эхтэй нь ч уулзуулахгүй байгаа ажээ. Тэд хүүгийн эхэд урьдчилгаа болгож мөнгө өгсөн бөгөөд хүүг албан ёсоор үрчилж авсан бичиг баримтаа бүрдүүлсэн цагт нь үлдэгдэл мөнгийг өгөхөөр амласан байна. Тэрээр хүүгээ ингэж өлсгөж зовоож байснаас гадны хүмүүст өргүүлчихвэл өөрт нь дээр. Тэгээд ч хэдэн төгрөг нь үлдсэн ах, эгч нарынх нь амьдралд нэмэр болно хэмээн бодсоноо ярьж байлаа. Ямар ч тохиолдолд энэ бүхний цаана хүний эрх, эрх чөлөө хөсөр хаягдаж байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд хүнийг худалдах, худалдан авах гэмт хэргийн тухай заалт орсон боловч дээрх халхавчууд энэ гэмт хэргийг нуун дарагдуулаад байх юм биш биз.

1.21 50 МЯНГАН ТӨГРӨГӨНД ХАЗГААРЛАГДСАН ЭРХ

Д.Батзаяа

Үнэн, 2003.01.03, №001

Монголчууд бид өргөн уудам газар нутагтай атлаа дэндүү цөөхүүлээ. Өндөр уул, толгод, цэлгэр их тал, хөндий цөм биднийх. Хоолойгоо сөөтөл хашгирч, хөлийн хурдаараа гүйхэд ч торох юмгүй. Бид эх орныхоо дөрвөн зүг, найман зовхисын хаана ч очиж амьдрах эрхтэй. Нэг газартаа удаан хугацаагаар оршин суухгүй, дуртай цагтаа говьдоо очиж, хүссэн үедээ хангай нутагтаа ирэхэд хэн ч саад хийхгүй. Тэр байтугай Монгол Улсын Үндсэн хуульд монгол хүн эх орныхоо хаана ч, хэдий хугацаагаар ч хамаагүй амьдрах эрхтэй хэмээн баталгаажуулаад өгчихсөн. Гэвч хүн сайн сайхан, элбэг дэлбэг амьдрахад газар нутгийн хэмжээ даанч нэг тус дэм болохгүй юм. Энэ бол зөвхөн өнөөдрийн Монголчуудын хөгжил дэвшлийн үед. Бидний хувьд одоо газар нутгаас илүүтэй соёл, боловсрол, эмнэлэг үйлчилгээ хэрэгтэй байна. Гэтэл энэ бүхэн ганцхан нийслэл хотод бусдаас илүү давамгайлж байна. Хүүхдээ сайн боловсрол эзэмшүүлэхийг хүсвэл хүссэн сургууль, өвдвөл мэргэжлийн эмч, тохилог орон сууц, боломжийн ажлын байр гээд бидний тэмүүлж буй сайхан амьдралын эхлэл нийслэлд байна.

Монгол Улсын хүн амын гуравны нэг нь зөвхөн нийслэлдээ амьдарч байна. Хотын хүн ам ихдэж, агаар бохирдож, байшин сав нь багтааж шингэхээ болилоо хэмээн уулга алдацгаах болжээ. Үнэхээр ч тийм дээ. Нийслэл хотод оршин сууж буй гурван хүн тутмын нэг нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд байдаг гэнэ. Тэрхүү агаарын бохирдол, хүн амын хэт бөөгнөрөлд хэн буруутай юм бэ? Хөдөөнийхөн үү?

Бид, тэд адилхан л Монгол Улсын иргэн учраас нийслэлдээ эсвэл хөдөөдөө амьдрах нь өөрсдийнх нь сонголт. Энэ бол хүний эрх. Тэд энэхүү эрх чөлөөгөө л эдэлж байгаа. Гэтэл үүнийг эдлэхэд мундахгүй л саад бэрхшээл учрах болсон. Хөдөөнөөс шилжин ирэгсэд нийслэлийн иргэн болохын тулд насанд хүрэгчид 50000, бага насны хүүхэд 25000 төгрөг тушаана. Хэрэв үүнийг төлөхгүй бол тэд энд эмнэлэг, сургууль, ажил гээд олон зүйл хаалттай. Оршин сууж байсан орон нутгаасаа хүн амын бүртгэлээсээ хасуулаад, нутгийнхандаа хотод очиж амьдарна гээд гайхуулаад ирсэн тэдэнд энэ бүхэн дэндүү хатуу. Мэдээж үр хүүхэд, гэр бүлээрээ л ирнэ. Гэтэл эхнэр, нөхөр хоёр 100 000, хоёр хүүхэдтэй айл 50000 нийлээд 150000 төгрөгийн цаана гарч байж нийслэлчүүдийн эгнээнд нэгдэн хүүхдээ сургуультай, өөрсдөө ажилтай байх үүд нь нээгдэнэ. Гэвч дээрх мөнгийг төлөхөөсөө төлөхгүй нь их. Хотын захад айлын хашаанд гэрээ бариад л авбал тэр мөнгө төгрөгийг нь тушаах ч яамай. Өвдөж зовтол хаа ч байсан юм, харин хүүхдээ таньдаг хүнээрээ яриулж сургууль соёлын мөр хөөлгөвөл барав хэмээн дэндүү хялбараар мөрөөднө. Худлаа үнэн хэлж байж аргалж ажил тань таны бичиг баримтыг шаардана, хэлж ирдэггүй хийс ч ирдэг өвчин зовлон гэнэт дайрахад яах вэ? Энэ бүхнийг давж гарахад нийслэлийн иргэн болох анхны босго гэж хэлж болох өнөө бөөн мөнгө хэрэгтэй. Үнэхээр амьдралын төлөө тэмцэж, азаа сорьж ирсэн хөдөөгийнхөнд 50000 төгрөгийг олно гэдэг амаргүй. Нэн ялангуяа нүүдэл суудал хийж чамгүй мөнгө зарцуулаад ирсэн тэдэнд ямар хүнд байх нь ойлгомжтой.

Хөдөөнөөс шилжин ирсэн зарим хүмүүстэй уулзаж энэ талаар санал бодлыг нь сонссон юм.

Д.Батболд: Би МУИС-ийн сэтгүүл зүйн ангийг төгссөн. Дадлага хийж байсан сонин маань намайг ажилд авсан. Говь-Алтай аймгийнх л даа. Өнөөдрийг хүртэл хотын иргэн болж чадаагүй л явж байна. Эхлээд ажилд ороод цалингаараа 50000 төгрөгөө тушаачихна гэж бодож явсан. Гэвч үүнд миний сарын цалин бүгдээрээ явчихна. Хоол, байрны мөнгөө яах билээ. Гэтэл одоо ажлаас бичиг баримт шаардаж эхэлсэн. Хэрэв хотын бүртгэлгүй, хотын иргэний үнэмлэхгүй бол ажлаас хална гэж хэлсэн. Надад үнэхээр хүнд байна.

Д.Сүрэн: Бид гэр бүлээрээ наймдугаар сард Ховдоос ирсэн. Одоо Хайлаастанд амьдарч байна. Гэхдээ хотын иргэн болж амжаагүй л явж байна. Үнэндээ эхнэр, бид хоёр нийлээд 100000 төгрөг тушаана гэдэг хүнд байна. Саяхан миний бие муудаад эмнэлэгт хэвтэх гэтэл хөдөөнийхөн 36 дугаар маягтаар эмнэлэгт хэвтэх ёстой гээд... Нутаг руугаа үүнийг захисан боловч орон нутгийн бүртгэлээс хасагдсан учраас өгөх боломжгүй гэж

байна. Одоо 50000 төгрөгөө тушааж байж л эмнэлэгт хэвтэх болж байна. Одоохондоо энэ их мөнгө алга. Гэрээрээ тариулаад ч бие сайжрахгүй нь байна.

С.Жаргал: Би Архангай аймагт төрж өссөн. Хотод ирээд жил гаруй болж байна. Нэг жил гаруй ажил хайгаад саяхан ажилд орсон. Хамгийн гол нь хөдөөний бичиг баримттай гээд ажил олдохгүй байсан. Уг нь 50000 төгрөг тушаагаад хотын иргэн болох ёстой юм билээ. Яагаад би эрхээ эдлэхийн төлөө ийм их мөнгө тушаах гэж? Бид эх орныхоо хаана ч очиж амьдрах, оршин суух эрхтэй биз дээ. Улаанбаатарт амьдруулахын тулд ийм их мөнгө шаардах нь шударга ёсонд нийцэхгүй гэж үзэж байна.

Д.Туул: Хотод ирээд бусдын адил амьдрахын тулд зүтгэж явна.

Хоёр хүүхэдтэй. Нэг охиноо захын нэг сургуульд оруулчихсан. Эрэгтэй юм гээд хүүгээ сургуульд оруулах гэж нэг их зүтгэсэнгүй. Дараа жилээс бичиг баримтаа Дарханаас шилжүүлэн авчирч, тэр мөнгийг нь тушаагаад хүүгээ сургууль соёлын мөр хөөлгөхөөс. Хүүгээ л золиосолчихлоо доо.

Тэд ийн ярьж байна.

Аль ч улсын нийслэлд амьдарна гэдэг том шалгуур, өндөр босготой байх ёстойг үгүйсгээгүй. Ер нь ч нийслэлийн иргэн гэдэг нь илүү бахархал нөгөө талаас хариуцлага, үүрэг тээдэг. Энэ үүднээс нийслэлийг зүглэсэн хэн бүхэнд <тавтай морилохыг> уриад байх нь нэг талаас хэцүү байдаг нь мэдээж. Тийм ч учраас төр, засгаас хөдөөг хотжуулах, нийслэл рүү чихэлдэж, бөөгнөрөл үүсгэх биш хөдөөд хотын хөгжлийг бий болгохоор зорьж байгаа. Хотод хөгжил байгаа ч хөдөөд бас ирээдүй бий.

Дээр хэлсэнчлэн Монгол Улсын иргэн бүр оршин сууж амьдрах газраа өөрсдөө сонгох эрхтэй. Гэвч энэ эрхийг дагаад бас үүрэг байдгийг санаж, сонголтоо хийхдээ анхаарах зайлшгүй шаардлагатай юм байна гэдгийг дээрх хүмүүсийн яриа анхааруулж байна.

Улсын нийслэл гэх утгаараа Улаанбаатарт амьдралын өртөг их, бас босго, шалгуур өндөр. Энэ утгаараа хэрэв та Улаанбаатарчуудын эгнээнд нэгдэх гэж байгаа бол юуны түрүүнд хэтэвчээ бас амьдрах чадвараа дахин нэг нягтлаад үзээрэй.

1. 22 ЗАРЛАЛД “ДАРЛАГДСАН” ХҮНИЙ ЭРХ.

Ш.Батболд

Үнэн, 2002.12.13, №244

“Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц” хэмээх олон улсын эрхзүйн бичиг баримт бий. Манай улс ч энэ конвенцид нэгдсэн. Гэтэл үүнийгээ зөрчиж эхэлжээ. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийг зарим талаар ялгаварлан гадуурхах болжээ. Энэ удаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн тухай асуудлыг хөндөж байна. Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн хуульд иргэнийхээ эрх ашгийг хамгаалах нааштай заалтууд олон бий. Харин энэ маань бодит амьдрал дээр өөр байна.

Зөрчигдөж буйг нь анзаардаггүй эрх

Сонин хэвлэл, радио, телевизээр 18-25 насны, 170 см-ээс дээш өндөр охид, эмэгтэйчүүдийг ажилд шалгаруулж авна гэсэн зарлалыг өдөр бүхэн уншиж, сонсч болно. Гэтэл 25-аас дээш настай ч юм уу, 170 см-ээс намхан эмэгтэйчүүд маань хаана, юу хийх билээ гэдэг асуудал гарна. Энд өнөөх нас, хүйс, шашин шүтлэг хамаарахгүй ажил, хөдөлмөр эрхлэх тухай эрх зөрчигдөж буй юм. Улаанбаатар хотын 3 дүүрэгт 300 хүний дунд явуулсан судалгаанд оролцогсдын 28.5 хувь нь эмэгтэй учраас, 23.5 хувь нь насаар ялгаварладаг, 8.5 хувь нь бага насны хүүхэдтэй учраас, 13.5 хувь нь тодорхой шалтгаангүйгээр ажилд авдаггүй хэмээцгээжээ. Ажиглалтаас харахад ч ерөөсөө манай ажил олгогч нар гол төлөв 25-аас доош насны эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолтой байдаг гэдэг нь ч тодорхой байна. Иймээс 25-аас дээш настай эмэгтэйчүүд хөдөлмөрийн биржид бүртгүүлэн ажилд орох сонирхолгүй болжээ. Ажил эрхлэлтийн төвшин, оролцоо ч сүүлийн үед тогтмол буурч байна. Жишээ нь: 1992 онд энэ байдал 67.6 хувь байсан бол, 1998 онд 60.5 хувь болтлоо буурсан аж. Өнөөдөр нарийн судалгаа гаргавал үүнээс ч бага тоо гарна хэмээн судлаачид үзэж байна. Хүнийг нас, хүйс, бие галбираар нь онцолж ажилд авна хэмээж байгаа нь зарлуулж буй ажил олгогчийн хувьд ч, зарладаг хэвлэл мэдээллийн хувьд ч хууль зөрчиж буй юм. Энэ нь иргэнийхээ журмаар хүсвэл шүүхэд ч хандаж болох асуудал билээ. Даан ч иргэд маань хэвшмэл сэтгэлгээнээсээ одоо хүртэл

салж чадаагүй, дээр нь эрх зүйн мэдлэггүйгээс эрхээ зөрчигдөж буйг ч анзаарахгүй явж байна.

30 настай эмэгтэйд ажил олдох уу?

Дөчөөс дээш настай эрэгтэй, гучаас дээш настай эмэгтэйд ажил олно гэдэг хамгийн хүндрэлтэй асуудлын нэг байдгийг бүгд л хүлээн зөвшөөрч байна. Тэд ажил хийж чадахгүйдээ биш гэдэг нь ойлгомжтой. Харин ялгаварлан гадуурхалт яагаад тэд нар руу чиглэв ээ гэхээр хөгшин, нөхөр, хүүхэд гэх мэт ардаа татлаа ихтэйгээс хөдөлмөрийн чадвар буурч яваа гэж олонхи нь тайлбарлаж байна. Нэгэн жишээ дурдахад, миний мэдэх нэгэн эмэгтэй наймдугаар анги төгсөөд л 16 настай сүлжмэлийн үйлдвэрт ажилд орон тасралтгүй 20 жил ажилласан. Тэгээд улсад 20 жил ажилласан, дөрвөн хүүхэдтэй хэмээн 1990 онд 36-хан насандаа тэтгэвэрт гарчээ. Энэ нас бол тухайн хүний хувьд залуу нас. Тиймээс ч тэтгэвэрт гарсан гээд гэртээ суухыг хүссэнгүй, ажил хайж эхэлсэн юм. Сонин дээрээс “цай зөөгч авна” гэсэн зарлал уншаад хаягийн дагуу очиход захирал нь “Өө, та энэ ажилд тохирохгүй” гэжээ. Гайхсан тэрбээр “Яахаараа би зөөгчийн ажилд тохирдоггүй билээ” гэхэд нь “Тань шиг нь манайд хэрэггүй” гэх шахуу үг хэлжээ. Гэтэл захирал ээжийгээ дагаж яваа хорь орчим настай охиныг нь хараад “Харин чи зөөгч хийхгүй юм уу” гэжээ. Иймэрхүү байдлаар эмэгтэйчүүдийг ялгаварлан хандаж, эрх чөлөөнд нь халдах явдал өдөр бүр гарч байгаа гэдэгтэй хэн ч маргахгүй байх. Магадгүй таныг ч хэн нэгэн дээрх жишээний адилаар үдсэн байж болох юм. Намхан, царайлаг бус бол хөдөлмөрлөх эрхээ зөрчүүлэхгүй гэх ч баталгаагүй. Хүний эрхийн төлөө ажилладаг байгууллагууд зарлалын дагуу утасдаж, цаана нь хэн байдгийг тодруулах гэж үзсэн байна. Тэдний ихэнх нь гар утастай, тогтмол бус хаягтай хүмүүс байжээ. Бас гадаадад ажиллуулна хэмээн нас, зүсээр сонгож байгаа нь тухайн оронд нь аваачаад биеийг нь үнэлүүлэхгүй гэх баталгаагүй юм. Бид нас, зүс зааж ажилд сонгон авдаг газруудыг ихэвчлэн үйлчилгээний газрууд гэж ойлгодог. Гэтэл Монголд ийм сонголтоор сүлжмэлийн үйлдвэр хүртэл ажилд авна хэмээн зарладаг байна.

Эрхээ яаж эдлэх вэ?

Уг нь үүн шиг амархан юм байхгүй. Яагаад чамайг ялгаварлан гадуурхав гэдгийг нь тодруулахаар шүүхэд өргөдөл гаргахад л болоо? Зөрчигдөж буй эрхээ та л өөрөө тэмцэж байж хамгаална. Тэгэхгүй бол нас гэр бүлийн тань байдлыг асуудаг, өндөр нам царай зүсийг тань харж эрхэнд тань халдсаар л байх болно. Нөгөө талаар залуу, эрч хүчтэй дээр тань хүч хөдөлмөрийг чинь ашиглачихаад, нэг л өдөр халагдах хүмүүсийн нэрсийн жагсаалтын эхэнд удирдлагын үзэмжид нийцээгүй, эмэгтэй учраас гээд л нэрийг тань тавьчихсан байх вий. Ажилтай болох гэсэн хүслийг чинь далимдуулж хэдэн жил хүүхэд гаргахгүй гэсэн гэрээ байгуулж ч магад. Энэ бүхэн хуулиар хориотой байдаг болохоор хүн бүхэн зөрчигдсөн эрхийнхээ төлөө тэмцэж чадвал хэн байх нь хамаагүй хүссэнээрээ ажил, мэргэжлээ сонгож хүссэнээрээ амьдрах боломжтой билээ.

1. 23 КОНДУКТОРАА, БИ НЭГЖҮҮЛМЭЭРГҮЙ БАЙНА.

Ш.Батболд

Үнэн, 2002.12.27, №254

Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах хорих, мөрдөх, мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй... /Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг, 13 дугаар заалтаас/

Найзын минь дүү оюутан. Гэртээ олуулаа болохоор амьдрал нь тэр бүр хүрэлцээтэй бус. Тиймээс энэ жил Монголын Оюутны холбооноос олгодог хөнгөлөлтийн картыг нь авч чадаагүй юм. Нэгэнт хөнгөлөлтийн карт аваагүй болохоор автобусаар үнэгүй зорчих эрхийн билетгүй хоцорсон. Тэгээд л ихэвчлэн 100 төгрөгөөр автобусанд сууна. Үүндээ их дургүй. Учир нь кондукторууд хэл амаар доромжилно. Дээр нь өдөр бүхэн шахуу автобусны билетний шалгалттай таарна. Зарим үед ч яахав хэл амаа ололцоод

явчихна. Харин зарим үед бөөн хэл ам болно. Шалгах нэрийдлээр кондукторууд өмд, цамцнаас татаж, чангаан хэл амаар доромжлон хүчээр буулган шууд л нэгжиж гарна. Ямар их дархан эрхтэй гээч. Бүх халаас, өвөр түрүүг нь нэгжээд улмаар барьж яваа цүнх сав руу дайрна. Хичнээн ч эсэргүүцэж, ямар ч үг хэлээд нэмэргүй. Тэд яг л “Али баба дөчин дээрэмчин” хэмээх Арабын нэгэн үлгэрт гардаг шиг л аашилна. Ингээд л өнөөх хүний эрхийг уландаа гишгэчсэн нэгэн тоглоом эхэлнэ дээ.

Саяхан тэрбээр өглөө хичээлдээ явах замдаа автобусны билет шалгагчидтай таарчээ. 100 төгрөгийн билет авсан учир шалгалтын автобусанд сууж нэгжүүлсэн байна. Нэгжигчид түүний оюутны үнэмлэх, иргэний үнэмлэх хоёрыг хурааж, 2000 төгрөг авчраад бичиг баримтуудаа аваарай гэжээ. Ингээд тэрбээр хичээлээ ч тасалж хоёр хоногийн дараа 2000 төгрөгтэй очиж бичиг баримтаа авсан юм. Энэ мэт жишээ даанч олон. Ялангуяа оюутнуудын хувьд хөнгөлөлтийн картаа аваагүй л бол нэгжлэгд өртөхгүй гэх баталгаагүй болсон. Ийм байдал миний л мэдэхийн сүүлийн найм, есөн жил үргэлжилж байгаа юм. Бүр автобусаар үнэгүй зорчиж яваад шалгалтад баригдсан хүмүүсээр өвөл замын цас цэвэрлүүлж байсныг хүртэл санаж байна. Тэднийг яг л хоригдол мэт харгалзан зогсч байсан тэр явдал өнөөдөр ч давтагдахгүй гэх газаргүй билээ. Гэтэл кондукторууд ямар эрхтэй юм бэ? Автобусаар зорчигчдоос мөнгө хураах нь л түүний ажил. Тэрнээс бус хэнийг ч хэл амаар доромжлох, нэгжих эрхгүй. Монгол Улсын үндсэн хуульд “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заажээ. Ер нь Монголын нэг ч хуульд зорчигч ямар ч буруутай байлаа гэсэн кондуктор түүнийг нэгжиж болох тухай заагаагүй. Тэр байтугай цагдаа нар нэг үе мэсний үзлэг гэх мэтийн операцийнхаа үеэр иргэдийг гудамжинд зогсоон хоморголон нэгждэг байснаа өнгөрсөн есдүгээр сарын нэгнээс шинээр шинэчлэгдэн мөрдөгдөж эхэлсэн таван хуулийн хүрээнд больчихсон. Энэ нь иргэдийнхээ эрх чөлөөг дээдэлж цагдааг иргэншүүлж байгаа явдал юм аа хэмээн удирдлагууд нь тайлбарлаж байсан. Гэтэл ямар ч эрхгүй кондукторуудын нэгжлэг үргэлжилсээр шинэ он гаргах гэж байна. Манай улс дэлхий дахинаа хүний эрхийг хамгаалдаг үзүүлэлтээрээ бас ч гайгүйд тооцогддог. Хүний эрхийг хамгаалах олон улсын конвенциудад ч нэгдсэн. Харин ийм жижигхэн зөрчлүүд хэнд ч анзаарагддаггүй. Анзаарсан ч хэн ч эрхээ хамгаалъя гэж хөөцөлдөхгүй байна. Өөрөөр хэлбэл, Монголд кондуктор нэр зүүсэн хүний эрх зөрчигчид дураараа дургиж байгаа нь энэ явдлыг өнөөдөр анзаарахгүй өнгөрч боломгүй асуудал болжээ. Мөнгөгүйгээр юм уу, эсвэл дутуу мөнгө төлөөд автобусаар зорчиж яваа нь тухайн хүмүүсийн буруутай явдал л даа. Гэхдээ үүнийхээ төлөө үг дуугүй нэгжүүлж, хэн нэгний нь бах тавыг хангаж, эрхээ зөрчүүлэх ёсгүй гэдгийг л хүн бүхэн мэдмээр байна. Үүнийхээ төлөө тэмцэж эрхээ хамгаалдаг болмоор байна. Иргэн та хэн ч бай хүссэн, шаардсан хэн бүхэнд нэгжүүлэх албагүй шүү дээ. Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрхийг иргэнийхээ өмнө төр нь хариуцахаар үндсэн хуульдаа заасан. Хэн дуртай нь бичиг баримт хурааж, амандаа орсон мөнгөнийхээ тоогоор торгууль ноогдуулах гэдэг нь бүдүүлэг төдийгүй, зүй зохисгүй хэрэг. 100 төгрөгийн төлөө, 200 төгрөгийн төлөө гэмт хэрэгтэн мэт хулганан зогсолгүй “Кондуктораа, би нэгжүүлмээргүй байна” хэмээн хэлэх зоригтой баймаар байна. Ингэх ч эрхтэй билээ. Хууль хэрэгжүүлэгч болон хяналтын албад кондукторуудад ямар ч дархан эрх оногдуулаагүй шүү гэдгийг нь ч сануулж, хүний эрхэнд аймшиггүйгээр халдсаных нь төлөө хариуцлага тооцох, үгүй ядаж хоморголон нэгждэг ажлыг нь зогсоох цаг болжээ.

1. 24 ХОРИОТОЙ “ТОГЛООМ”

Ш.Батболд

Үнэн, 2003.01.10, №006

*Г нь цэргийн газар ажилладаг байсан залуу эмэгтэй. Өөрөөс нь дээш цолтой, хамт ажилладаг нэгэн нь түүнийг шалгалтаар ирсэн хүмүүст үйлчил гэж албадсан байна. Хэрэв зөвшөөрөхгүй бол ажлаас чинь халуулна, чиний ажил, амьдрал миний гарт байгаа гэх мэтээр дарамталдаг байжээ. Энэ хэрэг маш ноцтой байдлаар даамжирснаас Г одоо ажилгүй болоод байна. **Хүний эрхийн зөрчлийн баримтаас***

Токио хотын дарга хэдэн жилийн өмнө нарийн бичиг бүсгүйнхээ биед зөвшөөрөлгүй хүрсний төлөө ажлаасаа халагдаж байсан. Хүний эрхэнд халдсан хэрэг. Бүр тодруулбал энэхүү явдлыг ажлын байран дахь бэлгийн дарамтлал гэдэг аж. Энэ ойлголтод шаардлагагүйгээр бусдын биед хүрэх, биеэр довтлох, бие галбир, хувцаслалт, нас хүйс, гэр бүлийн байдал, яс үндэс, шашин шүтлэг зэргээр нь өөчлөх, үг хаях, дохио зангаа хийх, дооглон тохуурхах, хурьцал үйлдэх талаар шууд ба шууд бусаар санал тавих, хүлээж авашгүй хүсэлт тавих зэрэг багтдаг аж. Мөн ширтэх, ичээх ч үүнд орох аж. Гэтэл манайд байдал ямар байдаг вэ? Бараг өдөр бүр ажлын газрынхаа хүнийг ичээж, дооглож тохуурхдаг, хэн нэгнийг дураараа ширтдэг. Ямар ч хориглох хууль эрхийн акт байхгүй. Нэг нь ичиж эвгүй байдалд ороод, нөгөө нь хэнэг ч үгүй явна. Уг нь хуучин Эрүүгийн хуульд “Албан тушаал, эд материалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүнийг тулган хавчиж хурьцал үйлдсэн бол гурван жил хүртлэх хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэлх төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэсэн заалт байсан. Энэ нь ганцхан бэлгийн харьцаанд хамааруулж оруулсан заалт байв. Гэтэл шинээр батлагдан мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд энэхүү зүйлийг бүрмөсөн хассан нь ийм төрлийн гэмт хэргийг цаашид ямар хуулийн, ямар заалтаар зохицуулах нь тодорхойгүй болгосон. Мөн шинээр хэлэлцэгдэж буй Захиргааны хариуцлагын тухай хуульд ч бэлгийн дарамтын асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь эргэлзээтэй байна. Ер нь манайхан бэлгийн дарамтлал гэгдээд буй нэр томъёог гэмт хэргийн шинжгүй гэж үзэж буй бололтой. Эмэгтэйчүүдтэй ажлын байранд нь удирдлага нь ч юм уу, хамт ажиллагсад нь дээрх байдлаар ханддаг нь манайд бол үүнийг дарамтлал гэж ойлгодоггүй. Нөгөөтэйгүүр албадан бэлгийн харьцаанд оруулсныг хохирогч нь хүч хэрэглэсэн гэж үзэн шүүхэд хандвал түүнийг “хүчингийн” хэрэгт хамруулан шалгана. Гомдол гаргахгүй бол тэгээд л нэг нь хохироод л үлдэх болжээ. Мөн ихэнх хүмүүс бэлгийн харьцаанд орохыг шаардахаас бусдыг нь “дармтлал” гэж үзэхгүй байгаа явдал ч үүнд нөлөөлж байна.

“Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Монголд” төслийн хүрээнд Улаанбаатар хотод ажиллаж, сурдаг 300 эмэгтэй, 200 эрэгтэйг хамруулсан судалгааг 2002 онд явуулжээ. Харамсалтай нь судалгаанд хамрагдагсдын дөнгөж 5.4 хувь нь ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг гэмт хэрэг гэж үзсэн байна. Мөн 4.1 хувь нь эмэгтэйчүүдийн нэр төрд халдаж хүйсээр ялгаварлан гадуурхсан хэрэг гэжээ. Харин 21 хувь нь, ялангуяа эрэгтэйчүүдийн олонхи нь “зөвхөн хоёр хүний хувийн асуудал” гэж хариулсан байна. “Амьдралд байж л байдаг зүйл” гэсэн бодолтой эрчүүд эмэгтэйчүүдээс хоёр дахин илүү буюу 7.6 хувь байна.

Амьдралд байж л байдаг зүйл. Энэ ойлголт хүний эрхийг бүдүүлгээр зөрчигчдийн бамбай болжээ. Жишээ дурдъя:

- Бүжигчин мэргэжилтэй Г-г байгууллагынх нь менежер нь байнга хоргоож, хүсэлтийг нь хүлээж аваагүйн улмаас гоцлол бүжигт оруулахгүй байх зэрэг илүү зэрэглэлийн ажил хийлгэлгүй, чадвараа үнэлүүлэх боломжийг нь хааж байжээ. Тэрбээр үүнээс болж ажлаасаа гарч, амьдрахын эрхээр жижиг хүнсний үйлдвэрт ажилладаг болсон байна. Уг нь Г өөрийн мэргэжлээр ажиллах сонирхолтой. Түүнийг ажлаа солиход менежерийн ёс зүйгүй, бүдүүлэг авир нөлөөлсөн байна.
- Нэр бүхий томоохон компаний захирал ажил тарах үеэр хувийн дэлгүүртээ орж ирээд, худалдагч охиныг авч явах гэж чангаан, хувцсыг нь урж тасдан, хүч хэрэглэжээ. Энэ халдлага дэлгүүрт байсан хүмүүс болон компаний зарим ажиллагсдын нүдэн дээр болсон байна. Үүнээс үүдэн худалдагч охин энэ явдлыг эсэргүүцэн, ажлын байрандаа зарга үүсгэсэн байна. Гэтэл бэлгийн дарамтлал үзүүлэх гэсэн компаний эзэн уг худалдагч охин болоод тэнд байсан гэрчүүд болох манаач зэрэг гурван хүнийг ажлаас халжээ...

Энэ мэтчилэн жишээ олон. Хэн ч хариуцлага хүлээгээгүй.

Шинэ Эрүүгийн хуулиар нэгэнт гэмт хэрэг биш болчихсон юм чинь хичнээн эмэгтэйчүүд дарамтлалд өртөж хаана хандахаа мэдэхгүй явааг төсөөлөхөд хэцүү. Нөгөө л царай зүс сайтай, залуухан эмэгтэйчүүд энэ төрлийн хүчирхийлэлд илүү их өртдөг судалгаа бий. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4-т иргэн бүр хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй гэж заасны дагуу хүний эрх, эрх чөлөө, ялангуяа эмэгтэйчүүдийн биеийн, сэтгэл санааны, бэлгийн эрх, эрх чөлөөнд халдах аливаа хүчирхийлэл, дарамтаас чөлөөтэй байх асуудал байдаг. Гэтэл ажлын байран дахь бэлгийн дарамтлал үйлдвэр, аж ахуйн газарт 38 хувь, олон нийтийн үйлчилгээний газарт 33 хувь, сургуулийн байгууллагад 23 хувь нь үйлдэгддэг гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Тиймээс ажлын байран дахь бэлгийн дарамтлал нь нийгэм, хувь хүнд бодитой хор хохирол учруулдаг гэмт үйлдэл хэмээн ойлгож, иргэнээ хамгаалах талаар Эрүүгийн хуульд ч, Хөдөлмөрийн хуульд ч ямар нэгэн байдлаар тусгах, тэгснээрээ хүний эрхийн талаар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой болох билээ.

1. 25 ХИЛСЭЭР ХОРИХОО ХЭЗЭЭ БОЛИХ БОЛ?

А.Баасандорж

Өнөөдөр 11, 2003.01.03, №001/1739/

Социалист систем гэж байх үеийг бодвол эдүгээ Монголд хүний эрх, эрх чөлөөний асуудал эрс дээшилсэн билээ. Үг хэлэх, хэвлэн нийтлэх, тахиж шүтэх, үйлдвэрлэл бизнес эрхлэх, гадаад, дотоодод зорчих, оршин суух болон ажлын байраа сонгох гэх мэт байнга зөрчигдөж байсан эрх чөлөөгөө бид эдүгээ хангалттай эдэлж байна. Гэвч энэ нь хүний эрх чөлөө огт зөрчигдөхгүй байгаа гэсэн үг бас биш юм. Энэ удаа шүүх, цагдаагийнхантай холбоотой хүний эрхийн зөрчлийн талаар өгүүлэе хэмээн саналаа.

Монголын цагдаа дарамталж хэрэг хүлээлгэдэг гэнэ. Энэ бол хүний эрхийн ноцтой зөрчил. 1930-40-өөд онуудын аймшигт харгислал үүд хаалгаа нээж эхэлбэл юу болох билээ. Тэр нэгэн цагт хэрэг хүлээлгэхийн тулд өлсгөх, олон өдөр нойргүйгээр байцаах, хурц гэрлээр шарах, хөл газар хүрэхгүй өндөр сандалд олон цагаар суулгах, зодох нүдэх гээд хүний санаанд багтамгүй аймшигтай яргалал, тамлал хийдэг байсан гэдэг. Гэтэл эдүгээ ийм юм бас гарч байна гэнэ ээ.

“Улс амьтан элдвийн л зүйл ярьдаг. Гэвч манай ажилтнууд тэгж хууль бус үйлдэл хийдэггүй” гэсэн хариуг цагдаа, хүчний байгууллагын удирдлагууд маань өгдөг байлаа. Гэтэл тийм зөрчил байгааг прокурорууд шалгаад тогтоосон байна. Зөвхөн 2001 оны эхний есөн сарын байдлаар Улсын Ерөнхий Прокурорын газарт дарамт шахалтаас болж ямар нэгэн хэрэг хүлээсэн, цагдаагийн ажилтан хууль бус арга хэрэглэсэн гэсэн утгатай 32 өргөдөл ирсэн аж. Мөн “Фүүд ланд”-ийн хоёр манаачийг алсан хэрэгт сэжиглэгдэн хоригдсон Одонтулга, Баатарцогт нар “Биднийг хэргээ хүлээ гэж цагдаагийн ажилтнууд янз бүрээр дарамталдаг байсан. Мөн хамт хоригдож байсан хүмүүс хэргээ ярь, эд зүйлийг нуусан газраа хэл гэж зодож тамладаг, дүүжилдэг, цахилгаанд цохиулдаг байснаас хилс хэрэг хүлээсэн” гэж шүүх хурал дээр болон прокурорт өгсөн мэдүүлэгтээ өгүүлсэн нь нилээд шуугиан дэгдээсэн. Үүний мөрөөр Цагдан хорих төвд шалгалт хийхэд тэдний гар хөл дээр түлэнхий сорвитой байснаас гадна хоригдож байсан өөрийнх нь хаалганы дээд талын решотконд гогцоо уяа үлдсэн, гэрлийн бүрхүүл, шил хоёрын завсраас кабель утасны тасархай гарч ирсэн байна. Мөн зарим нэг хоригдол хэрэг хүлээлгэх зорилгоор хүмүүсийг зодох, дарамтлах “үүргийг” цагдаагийн ажилтнуудаас авч байснаа хүлээжээ. Энэ бүхнээс үүдэн Цагдан хорих төвд хоригдогсод бие биенээ зодож дарамталдаг, нөгөө талаар цагдаагийн зарим ажилтнууд үүнийг өөгшүүлэн хууль бус арга хэрэглэж байжээ гэсэн дүгнэлтийг прокурорууд хийжээ.

Хэнд ч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй гэдгийг олон улсын дагаж мөрдөх хэм хэмжээ, Монгол Улсын Үндсэн хуульд тодорхой заасан байдаг. Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцид 2000 онд элсэн орсон нь ч бас том дэвшил. Гэвч үүнээс хоёрхон жилийн дараа буюу 2002 оны нэгдүгээр сарын найманд УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 02 тоот тогтоолдоо дээрх хууль бус үйлдэл буйг онцгойлон дурьдсан байдаг. “Урьдчилан хорих төвд хоригдож байгаа

сэжигтэн, яллагдагчийг хуульд заасан үндэслэлгүй, прокурорын байгууллагын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, давтан гэмт хэрэг үйлдсэн, удаан хугацаагаар хоригдсон хүмүүсийг ерөөнд оруулж тэднээр зодуулах зэргээр дарамт шахалт үзүүлдэг байдал нь эрүүгийн хэрэг хүлээлгэх зарим нэг арга хэрэгслэл болжээ” хэмээн тэр тогтоолд тодорхой заасан байна.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос томилж аймгуудад ажиллуулсан судалгааны багийн тайлангаас үзэхэд ч энэ байдал ихээхэн газар авсан нь илт байгаа юм. Булган аймгийн судалгааны багийн тайланд дурьдсанаар, судалгаанд оролцогчдын 71.4 хувь нь Урьдчилан хорих байранд хоригдогсдыг зориуд салхилуулдаггүй, 50 хувь нь хүчний байгууллагын зүгээс эрүү шүүлт тулгах, эсвэл бие махбодийг тарчлаан зовоох, сэтгэл санааны дарамтад оруулах явдал олон тохиолддог гэж хариулжээ. Ер нь бол энэ мэт явдал цаашид даамжрахгүй гэх баталгаа байхгүй. Хүний эрхийг дээдлэн хүндэтгэж, хүмүүнлэг энэрэнгүй нийгэм байгуулахаар зорьж байгаа бид ийм хууль бус үйлдэлтэй эвлэрч болохгүй. Ийм үйлдэл хийгчдийг цагдаа, хүчний байгууллагын эгнээнээс даруй зайлуулж, бусдад сургамж болгож байвал зүйтэй болов уу!

Дээрх хууль бус үйлдэлтэй уялдаатай ч байж болох өөр нэгэн асуудлыг одоо хөндье. Энэ нь зүгээр яваа хүнийг хэрэгт сэжиглэн барьж хорьчихоод дараа нь уучлаарай ч байхгүй орхидог явдал. Ийм жишээ бас л олон. Олны танихаар нь УИХ-ын гишүүн асан Э.Бат-Үүл, С.Зориг агсны гэргий Булган нарыг хорьсноор жишээлж болно. Тэднийг хорьж шалгаад юу ч тогтоогдоогүй. Гэтэл ийм явдлын ард бүхэл бүтэн хүний амьдрал сүйрэх тохиолдол бий. Ажил албагүй болж болно. Эрүүл мэндээр хохирно. Сэтгэл санааны хүчтэй цочролд орно. Эд хөрөнгийн зардал сүйтгэл ч бас чамлахааргүй гарна.

Энд олон жишээ дурьдаж болно. Нэгэн гэр бүлийн хоёрыг байгууллагын их хэмжээний мөнгө хулгайлсан хэрэгт сэжиглэн шоронд хорьжээ. Харамсалтай нь олон жилийн дараа тэдний буруугүй нь тогтоогджээ. Биегүй, амьдралгүй болсон тэднийг гарч ирэхэд зургаан хүүхэд нь аль хэдийн архаг архичин, гэмт хэрэгтнүүд болон хувирсан байсан эмгэнэлтэй жишээг Баабар “Хөөрхий Сайжаа” өгүүлэлдээ дурьдсан байдаг. Энд би нэг найзынхаа ахын тухай өгүүлмээр байгаа юм. Тэр сайхан хүн дөчин хэдхэн насандаа өнгөрсөн жил тэнгэрт одсон. Залуу зандан үед нь ямар ч гэмгүй түүнийг хүн амины хэрэгт холбогдуулан баривчилж, урьдчилан хорих төв, орон шоронд хоёр жил шахам хорьсон. Гэтэл тэрхүү хэргийг үйлдсэн хүн нь илэрч тэрбээр суллагдсан. Гэвч уушги нь устаж, сүрхий хүнд оёгтой болоод гарч ирсэн. Тэр өвчин нь түүнийг насан туршид нь шаналгаж, цэл залуухан насандаа өөд болсон доо.

Завхан аймгийн шүүх гэмт хэргийн бүрдэл хангагдаагүй, шүүгдэгчийн гэм буруу хөдөлбөргүй тогтоогдоогүй байхад иргэн Эрдэнэ-Очирт бусдыг санаатай алсан хэргээр цаазаар авах ялыг гурван удаа оногдуулсан байна. Харин таслан шийдвэрлэх тогтоолыг тухай бүрд нь дээд шатны шүүх хүчингүй болгож байсан нь аз завшаан. Батлаад гүйцэтгэхчигсэн бол яана! Энэ хүн саяхан суллагдсан. Гэвч тэр амьдралынхаа бүтэн зургаан жилийг алджээ. Эрүүл мэнд, сэтгэл санааных нь хохирлыг бол тооцох ч аргагүй.

Гэтэл барьсан, хорьсон хүчний байгууллага нь, төр, засаг нь болдог юм болж байгаа аятай байх юм. Уг нь ингээд байж болмооргүй л санагддаг. Гадаадын зарим оронд тийм тохиолдолд төр, засаг нь нөхөн олговор олгодог, алдаа гарсан, буруу ташаа явдал гарсныг албан газарт нь мэдэгддэг юм билээ л дээ. Хилс хэрэгт холбогдоод, урьдчилан хорих төвийн хүнд нөхцлийг давалгүй амиа алдаж байгаа хүн байна. Элдвийн өвчин авч нас нь богиносч байгаа хүн ч олон. “Монголд сүрьеэ “үйлдвэрлэдэг” албан ёсны газар нь шорон болжээ. Ганц худагт өвчин аваад гэр орныхондоо нялзааж, нийгэмд тэр чигт нь аюул авчирч байна. Уг нь болдогсон бол Ганц худгийг газрын хөрснөөс арчаад оронд нь хүн хэвийн хоригдож ялаа эдэлдэг шорон байгуулмаар байна” хэмээн Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж хэлсэн нь нэгийг өгүүлнэ бус уу. 1999-2000 онд 279 хоригдол нас барсан мэдээтэй бөгөөд 2000 онд нас барсан 97 хоригдлын 81 хувь нь өвчний учир, тэдний 90 орчим хувь нь сүрьеэгээр нас барсан байгаа юм.

Тиймээс урьдчилан хорих байр, орон шоронгийн нөхцөлийг сайжруулах, мөн хүнийг хилсдүүлээд байхгүйн тулд хүчний байгууллагад ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар дорвитой ажил зохиож, өндөр хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжөөр хангах нь чухал байна. Хэрэв чингэвэл хэрэг илрүүлэлтэд алдаа бага гарч, тэр хэрээр хүний эрх цөөн зөрчигдөх буй заа.

1. 26 СОНГОГДОХЫГ НЬ БАЙГ ГЭХЭД СОНГОХ ЭРХИЙГ НЬ ЭДЛҮҮЛЬЕ

А.Баасандорж

Өнөөдөр 15, 2003.01.10, №007/1745/

Энэ гарчигийг хараад “Энэ нөхөр юу хэлэх гээд байгаа юм бол. Бид 1999 оноос хойш сонгох, сонгогдох эрхээ бүрэн эдэлж байгаа шүү дээ” гэж мэтгэх хүн гарах байх л даа. Хуучинтай харьцуулбал бид дээрх эрхээ сайн эдэлж байгаа юу гэвэл байгаа. Гэвч энэ эрхээ эдэлж чаддаггүй хүн бас олон байна.

Социалист системийн үед сонгууль гэдэг баяр наадам шиг байлаа. Нэн ялангуяа хөдөөд бол бүр нижгэр болно. Тэр үед сонгууль зуны сайхан дэлгэр цагт болдгийг ч хэлэх үү, байдаг бүхнээрээ гоёж, хамгийн сайхан морьдоо унасан томчууд хөдөөнөөс сумын төв рүү орж ирдэгсэн. Сонгууль өгөхөөс татгалзсан хүн шүүх, сэргийлэхийн хаалга татахаас наагуур юм болдог болохоор хүн бүхэн тун идэвхтэй оролцож, үд өнгөрөөгөөд л бараг 100 хувийн саналаар АИХ-ын депутатаа сонгочихдог байж билээ. Депутатаа ард олон өөрийн бодлоор сонгочихгүй. Дээрээс нь тулгаад өгчихнө. Сонгууль болохоос сарын өмнөөс айлын жааз, гэрийн унь, байшингийн хананд депутатаар сонгогдох нэг нөхрийн зурагтай танилцуулга үзэгдэж эхэлдэгсэн. Манай сумынхан, аав, ээж хоёр маань МАХН-ын Төв хорооны хэлтсийн эрхлэгч Г.Чингэлийг мөн ч олон удаа сонгосон доо. Хөөрхий Чингэл гуайн “буруу” гэж юу байхав, тухайн үеийн систем нь тийм байж дээ. Ийм сонгууль нэгэнт түүх болон үлджээ.

Ардчилсан хувьсгал бидэнд их юм өгсөн. Өөрийнхөө санаа бодлоор хэн нэгнийг дэмжих, сонгох эрхийг бидэнд өглөө. Ямар ч дарамт шахалт, айлган сүрдүүлэлтгүй шүү. Бүр сонгууль өгөхгүй байж ч болох эрх чөлөөг хайрлалаа. Аль нэг нам эвслээс нэр дэвшүүлэхгүй бол 801 хүний гарын үсэг цуглуулаад төрийн дээд эрх барих байгууллага Улсын Их Хуралд нэрээ дэвшүүлчих боломж олголоо. Үүнээс өөр яах билээ дээ. Гэвч эрхээ эдэлж чадахгүй байгаа сонгогчид чамгүй олон байгаа нь харамсалтай.

“Иргэдээс төрийг удирдах хэрэгт оролцох хамгийн шийдвэрлэгч эрх бол сонгох, сонгогдох эрх юм. Сонгууль бол ард түмний хүсэл зоригоо илэрхийлэх арга хэрэгсэл бөгөөд тэр нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишиг шаардлагад нийцэх, жинхэнэ чөлөөтэй, шударга явагдсан цагт хүний улс төрийн эрхийг хангадаг тул хүний эрхийн хэрэгжилтийн чухал баталгаа болдог” гэж Хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл”-д өгүүлсэн байна. Гэтэл 1992 оноос хойш сонгуульд оролцогч иргэдийн тоо жилээс жилд буурсаар ирсэн байгаа юм. Энэ тухай ойлгомжтой болгохын тулд нэг хүснэгт харуулъя.

Иргэдийн сонгуульд оролцсон байдал

Сонгууль	Он	Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдын тоо	Хувь
Монгол Улсын Их Хурлын сонгууль	1992	1 085 129	1 037 392	95.60
	1996	1 147 260	1 057 189	92.15
	2000	1 247 033	1 027 985	82.43
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль	1997	1 106 403	1 025 970	92.73
	2001	1 155 228	982 640	85.06
	1993	1 205 885	1 000 110	82.94
Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль	1996	1 028 216	739 946	71.96
	2000	1 066 147	647 616	60.74

Иргэд маань сонгуульд оролцохдоо яагаад ийм хойрго хандаж байна вэ? Ойр ойрхон сонгууль болж буйгаас иргэд залхсан байхыг үгүйсгэхгүй. Бас надаар л дутаг гэж үү гээд гэртээ бүгчидхэг хөшин хойрго нөхдөөс болж байгаа байх. Гэхдээ л сонгуультай холбоотой хүний эрх зөрчигдсэн тохиолдол цөөнгүй гардаг байна.

1998 оноос хойш улсын хэмжээнд иргэний паспортын нөөц дууссан билээ. Үүнтэй зэрэгцэн паспортыг иргэний үнэмлэхээр солих асуудал өрнөж эхэлсэн. Энэ үйл явц удааширнаас, хөдөө орон нутагт хүрч чадахгүйгээс олон хүн сонгох эрхээ эдэлж чадахгүй хохирч байсан байна. Сонгогчийн бичиг баримтгүйн улмаас Ховд аймгийн сонгогчдын 2.1 хувь нь 2000 оны УИХ-ын сонгуульд, 1.5 хувь нь 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож чадаагүй байх жишээтэй. Бүх улс даяар тооцож үзвэл нэлээд өндөр хувьтай гарах буй заа.

Шилжилт хөдөлгөөнөөс болж сонгогчдын эрх бас ихээхэн зөрчигддөг байна. Нэн ялангуяа нийслэлд шилжин ирэгсдэд энэ нь бүр ч их хамаатай. Улаанбаатар хотыг бараадагсдын цөөхөн нь чадарсан улс байдаг аж. Олонхи нь ядарсан хүмүүс. Угийн ядуу зүдүү, аль эсвэл зуд, турханд хэдэн малаа алдсан гээд л тэдний зовлон их ээ. Тэднийг зүтгэсээр байж, өр зээл тавин замын зардлаа арай хийж олоод хотын бараа харахад данхийсэн төлбөр хүлээж байна даа. Нэг хүн 50000 төгрөг төлөх хэрэгтэй болно. Түүнийг төлж дийлэхгүй болохоор хотын иргэн болж чадахгүй. Ингээд харьяалал ч үгүй болсон түүнд санал өгөх эрхийн үнэмлэх ч олдохгүй. Ийнхүү сонгох эрх нь зөрчигднэ дөө.

Нэгэнт дийлэнх олонхийн санал аваад сонгогдоод гараад ирсэн хүнийг тухайн албан тушаалд томилохгүй гэдэг албан тушаалтан, эрх мэдэлтнүүд бас байх юм. Тэд тухайн хүний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хааж, боож буйгаа мэдсээр атлаа улс төрийн шахалтад ороо гэдгийг явдал бас байдаг. Үүний хамгийн тод томруун жишээг энд дурдъя. Ийм явдал олон давтагдахгүй ч байж болно. 1996 оны Улсын Их Хурлын сонгуульд “Ардчилсан хүчин” эвслийнхэн олонх болсон. Харин намар нь болсон орон нутгийн ИТХ-ын сонгуульд МАХН ялалт байгуулсан. Гэвч олонхийн санал аваад гараад ирсэн МАХН-ын гишүүн, зарим аймгийн Засаг даргыг Ерөнхий сайд батламжлахгүй гээд нэлээд юм болж байж билээ. Энд хэн байсан нь хамаагүй, хүний сонгогдох эрх зөрчигдөж л байгаа хэрэг. Сүүлийн үед төрийн бус болон, олон нийтийн байгууллагын сонгууль будлиантай болох нь олонтаа болж. Бас сонгуулийн дүнг санаатай будлиантуулах гэдэг, олныг уриалан сонгогчдын эрхэнд халдах явдал ч гарах болсон байна. Энд саяхан болсон Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүний сонгуулийг дурьдаж болно. Их зөийг төлөөлөгчдийн 90 нь хуучин тэргүүн Р.Нямдоржийн төлөө, 82 нь Б.Сүхбатын төлөө саналаа өгчээ. Гэвч төлөөлөгчдийн цөөнх нь болсон хүмүүс нууц санал хураалтын дүнг батламжлахгүй гээд хурлыг орхин оджээ. Одоо тэд Р.Нямдоржийг сайн дураараа огцрохгүй бол бид барилдахгүй гээд л мэдэгдэж байна. Ямар ч утгаараа босон төлөөлөгчдийн олонхийн санал авсан Р.Нямдорж өөрөө огцрох нь утгагүй. Тэр ганцаараа шийдвэр гаргаж болохгүй. Яагаад гэвэл түүнийг сонгосон олонхи төлөөлөгчийн эрх хөндөгдөнө. Аль ч сонгуульд ялсан нь ажил үйлээ хийдэг болохоос ялагдсан талынх нь хүмүүс нөгөөхөө загнаад, огцор гээд, элдвийн саад тотгор хийгээд давхчихдаггүй. Энэ бол ардчилсан сонгуулийн зарчим биш билээ.

Монгол Улсын иргэн бүхэн тэгш эрхтэй. Тиймээс тэдэндээ сонгох, сонгогдох эрхийг нь мөн тэгш олгохын тулд төр, засгаас ч тодорхой алхамууд хийдэг байх хэрэгтэй. Дээр дурьдсан зөрчлийг арилгаж, иргэн бүхнээ сонгуульд бүрэн хамруулах боломж төр засагт уг нь бий билээ л.

1. 27 БИ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДАРМААР БАЙНА

А.Баасандорж

Өнөөдөр, 2003.01.17, №013 /1751/

“Үндсэн Хуулийн арванзургадугаар зүйлийн нэгд Монгол улсын иргэн амьд явах эрхтэй” гэж заасан байдаг. Гэвч одоогийн манай нийгэмд хүний амьд явах эрхийн баталгаа тун муу байна.

Эмнэлэгт очъё баталгаа муутай. “Алтан гартай эмч” нарын маань дунд хариуцлагагүй мэдлэггүй нөхдүүд бас олноороо тууж явна. Эмчийн буруугаас алтан амиа алдсан хүмүүн цөөнгүй байна. Ийм асуудалд төрийн соёрхолтнууд маань хүртэл

орооцолдчихсон тохиолдол байх юм. Энэ сэдвээр сонин хэвлэлд байсхийгээд л санал гомдол гардаг. Үүний хамгийн тод томруун жишээ бол сувилагч Даваахүүгийн хэрэг. Үнэхээр харамсалтай явдал болсон. Шатахуун түгээх газар руу дайрсан гэмт хэрэгтнүүдийн гарт өртөж арав гаруй хутгалуулж амьд үлдсэн “Оюуны ундраа” ХХК-ын ажилтан бүсгүй ажилдаа хайнга хандсан сувилагчаас болоод нас барсан. Үнэхээр харамсалтай хэрэг шүү. Тэр олон мэсний шархийг давж гарсан хөөрхий бүсгүй хариуцлагагүй нэгний золиос болно гэж хэзээч бодоогүй буй заа.

Өөр нэг жишээ. Эмчийн мэргэжил ч үгүй анагаах ухааны анхан шатны мэдлэггүй нэгэн хятад иргэн Монголд ирээд эмнэлэг нээчихсэн тууж явжээ. Тэрбээр хичнээн хүний, хичнээн монгол иргэний эрүүл мэндээр тоглосныг мэдэх аргагүй. Эрүүл мэндийн яамныхан хожуу ч гэсэн түүний энэ зэрлэг үйлдлийг таслан зогсоосон. Хамгийн инээдэмтэй нь хэсэг эмчлүүлэгчид нь алтан гартай эмчийн минь эмнэлгийг хаалаа гэж бөөн дуулиан болсон гэж байгаа юм. Хөөрхийлөлтэй байгаа биз. Гэтэл нөгөө алтан гартай эмч нь ханиад томуунд ямар эм уудгийг нь ч мэдэхгүй байсан байгаа юм даа.

Саяхны жишээ. Хөдөөнөөс хотод ирээд байсан найзын маань дүүгийн архагшуулсан олгой гэнэт өвдөж түргэн дуудаж эмнэлэгт хүргэгджээ. Хагалгааны танхимын үүдэнд хүлээж суугаа найзын маань чихэнд дүүгийнх нь үе үе хашгирах дуун сонсогдож байлаа. Сувилагчаас учрыг лавлавал “Том хүнийг бүтэн нойрсуулдаггүй юм зүгээрээ хөө, жаахан янгууч нөхөр байгаа биз” гэж тайвшруулжээ. Тэгсээр байтал хагалгаа дуусч эмч нь түрүүлэн гарч ирж. Гэтэл эмчийн амнаас архи сэнгэнэж байх нь тэр. Найзын маань сэтгэл ч хачин болоод явчих нь тэр. Дүүгээ гарч ирэхэд нь очвол хөлс нь асгарчихсан “зүгээр”-ээ хэмээн дуулдах төдий хэлжээ. Харин нэг их хүндрэл гаралгүй маргааш өдрийг хүргэжээ. Үд дунд болж байхад хагалгаа хийсэн эмч нь түүний өрөөнд орж ирээд “Уучлаарай дүү хөө өчигдөр чиний хашгираад байсан нь аргагүй байж. Манай сувилагч нар гарын чинь булчинд хийх мэдээ алдуулах тариагаа мартчихсан байна билээ” хэмээн хэв нэг хэлжээ. Алах гэж байгаа биз. Мэдээ алдуулах тариаг нь дутуу хийж хөөрхийг тамлаад өнгөрсөн нь нэг талдаа аз. Нөгөө халамцуу эмч нь буруу эрхтнийг нь огтлоод хаячихаагүй нь л их юм. Энэ тохиолдолд ингэж хэлэхээс өөр аргагүй. Тэнгэрээс шуудай арвай асгахад дээш харуулаад босгочихсон зүүний үзүүр дээр нэг нь торж үлдэх шиг ховорхон заяадаг хүмүүний биеийг хэн нэгний хэнэггүй гарт үрүүлнэ гэхэд даанч харамсалтай юм даа.

Гудамжаар алхъя, баталгаа муутай. Нийслэл хотын зам нэгэнт ачааллаа даахаа больж. Хүн болгон шахуу машин тэрэг хөлөглөдөг болно хэмээн социалист нийгмийн үеийн хашигдмал сэтгэлгээтэй удирдагчид маань даанч бодсонгүй. Тэдний холыг хараагүйн балгийг одоо бид амсч байна. Зайгүй хөврөх машины урсгал дээр нь жолооны курсийг дутуу хагас дүүргэсэн огт суугаагүй, бас согтуу хөлчүү жолооч нар монголчуудын амьд явах баталгааг үгүй болгож байна. Сүүлийн үед микроавтобус гэж нэг аймшигт гарч ирлээ. Хурдан түргэн үйлчилж байгааг нь буруутгахгүй ч замын хөдөлгөөнийг улам бэрхшээлтэй болгож байна. Бие биеэсээ өрсч хүн авахын тулд галзуу мэт хурдлах, санаанд ормооргүй үйлдэл хийх нь олонтаа. Сүүлийн үед жолооч болох шиг амар юм үгүй болов. Сургах хоног, төлбөр нь багасч байна. Дээр нь сургалтыг нь оромдвол бүр ч аюултай. Уг нь жолооны сургалтыг дунд сургуулийн хөтөлбөрт оруулдаг олон улсын хөтөлбөр бий л дээ. Системтэй сургалтанд хамрагдсан хүүхдүүд дунд сургуулиа төгсөхдөө жолооны үнэмлэхтэй болдог жишиг рүү л бид алхам хиймээр байгаа юм. Гэвч ингэнэ гэхээр жолооны курс дамжаа хичээллүүлэгчдийн эрх ашиг хөндөгдөөд эсэргүүцээд давхичихдаг юм билээ. Бид цаг зуурын бус алс хэтийг харсан зүйл хиймээр байгаа юм.

Хоол идье, баталгаа муутай. Хүнсний аюулгүй байдал бол маш том асуудал. Улс орныг цэрэг зэвсгээр бус, хоол хүнсээр байлдан дагуулж сөнөөж мөхөөх цаг хэдийнэ хаяанд ирсэн. Дээр нь монголчууд бид хоол хүнсэндээ тун хайхрамжгүй ханддаг. Архи дарс уух, хувцас хунараар өрсөлдөх зэрэгт бол мөнгө хайр гамгүй зарна. Харин хоол идэх болохоор хоолой давж болох хамгийн хямдыг нь сонгоно. Сонин сэтгэхүй шүү. Харин өөр орны иргэд бол хувцас хунар, алт мөнгөөр өрсөлдөхгүй. Нэг их үнэ цэнэтэй биш ч гэсэн цэвэрхэн хувцас өмсчихөөд хоол хүнс жимс ногооны хамгийн сайныг нь сонгоно. Эрүүл хүнсэнд хэзээ ч гар татахгүй. Сүүлийн үед гуанз, цайны газар ёстой борооны дараах мөөг шиг олширч байна. Эдэн дунд сайн нь ч бий, бас хоол биш “хор” бэлтгэгчид байгааг үгүйсгэх аргагүй. Хөдөлмөрийн баатар, алдартай эмчээ хүртэл хоолны хордлогоор тавиад

туучихдаг ард түмэн шүү дээ бид. Саяхандаа Их Хурлын эрхэм гишүүн маань хүртэл хоолны хордлогод орж их л тэвдсэнийг бид дуулж сонссон. Жирийн иргэдээс маань хичнээн нь хоолны хордлогоор хорвоог орхиж буйг хэн мэдэх билээ.

Аюулгүй орчинг маань аюултай болгож байгаа олон хүчин зүйл бий. Зах зухаас нь дурьдахад л ийм. Бид зөвхөн Үндсэн хуульдаа “Амьд явах эрхтэй” гэсэн мундаг заалт оруулчихаад л явж байж болохгүй. Амьдрах орчныг нь аюулгүй байлгахын тулд төр засгаас шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байх ёстой. Төр засгийн эрхэм дээд удирдлагууд аа би, бид аюулгүй орчинд амьдармаар байна.

1. 28 ЭР ЦЭРГИЙН АЛБАНААС ЭСЭН МЭНД ИРЭЭРЭЙ

А.Баасандорж

Өнөөдөр, 2003.01.24, №019/1757/

Цэргийн алба хаах нь эр хүн бүхний үүрэг. Харин тэдний амь насыг баталгаатай байлгах, амьд явах эрхийг нь эдлүүлэх нь төр, засгийн үүрэг билээ

Цэргийн албанд мордох шиг бахархалтай зүйл эрчүүдэд нэг үе байгаагүй гэхэд хилс үг болчихгүй байх. Үнэхээр ч гурван жилийн албаа хаагаад ирсэн жавхалзсан сайхан нутгийн ах нарыг хараад хэзээ нэг эд нар шиг болох бол хэмээн мөрөөдөн боддог байсан хүүхэд ахуй цаг нэгэнт ард хоцорчээ.

Гурван жилийн хугацаатай, оны ялгаа, хал цэргийн дэглэмтэй асан үед амь нас, зодуур нүдүүрийн хэрэг тийм ч олон дуулддаггүй байсан сан. Гэтэл одоо ганцхан жилийн хугацаатай, оны ялгаа гэж байхгүй атлаа хэн нэгнийгээ хөнөөсөн, тахир дутуу болгосон аймшигтай мэдээ цөөнгүй сонсогдох юм.

Эр цэргийн албаа аавын олон хүүхдээс дутахгүй сайн хаагаад ирээрэй хэмээн захидаг байсан ижий аав нар маань сүүлийн үед эсэн мэнд л ирж үзээрэй хэмээн анхааруулах гуйхыг хослуулан хэлдэг болсон гэнэм.

Цэргийн алба хаах нь эр хүн бүхний үүрэг. Харин тэдний амь насыг баталгаатай байлгах, амьд явах эрхийг нь эдлүүлэх нь төр засгийн үүрэг билээ. Харийн дайсан халдаж довтолсон 1939 он биш, хилийн тулгаралт өдөр алгасалгүй гарч байсан 1945 оны баруун хил биш атал өнөөдөр бид цөөнгүй цэрэг эрсээ хариуцлагагүй байдлын золиосонд алдаж байна. Энд нэг их статистик тоо баримт, нэр ус дурьдаад баймааргүй байна. Дорноговийн Сулинхээр, Эрдэнэцагааны отрядын дуулианыг эргэн санацгаая. Ойр ойрхон гарсан гэмт хэргүүдийн золиосонд нэгээс нэлээн хэдэн хүн амь насаа алдаж байсан.

Бүр сүүлдээ цэргүүд нь нэг нэгийгээ хөнөөж байсан гэмт явдлыг буг чөтгөр, бурхан шашинтай холбох хандлага илэрч байсан билээ. Өөрөөр хэлбэл, отрядын байрыг хуучин сүм хийдийн материал ашиглаж барьсан, бас хааяа эмэгтэй хүний хангинатал дуулах сонсогддог зэрэгтэй ойр ойрхон гарсан гэмт үйлдлүүд холбоотой мэтээр тайлбарлах гэж оролдох явдал ч гарч байсан.

Саяхан бүр тодорхой хэлбэл нэгдүгээр сарын 14-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Хошууч генерал Ц.Тогоо тэргүүтэй удирдах бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзахдаа, нийт бие бүрэлдэхүүний хэмжээнд хүний амь настай холбоотой гэмт хэрэг гарсаар байна гээд үүний учир шалтгаан, нөхцлийг судлаж тогтоон дахин гаргуулахгүй байх талаар бүх талын арга хэмжээ авах ёстойг онцлон анхааруулсан билээ.

Гэвч тэнд цэргийн хатуу чанд сахилга бат, удирдлагын ур чадвар дутаж байсан нь одоо илт байна. Шинэ удирдлага томилогдож очсоноос хойш сэтгэл шимшрүүлсэн мэдээ сонсогдохгүй л байна шүү дээ.

Хамгийн сүүлийн жишээ гэхэд л Өвөрхангайд гарсан гэмт хэргийг дурьдаж болох байна. Манаанд гарсан хоёр цэрэг хоорондоо муудалцаад л нэг нь нөгөө рүүгээ буудчихаж. Хэвлийдээ хүнд шарх авсан цэрэг эр эргэж сэхсэнгүй.

Цэргийнхээ эрүүл мэндийг нь сахин хамгаалж байх ёстой удирдлагуудад дан ганц бурууг бас тохож болохгүй. Одоогийн манай эрчүүд, нэн ялангуяа залуус маань

яасан ч нялцгай болсон юм бэ дээ гэх харамсалтай бодол цэргүүд бие биенээ хөнөөсөн мэдээг сонсох бүрд надад төрдөг. Тэдэнд хүйтэн зэвсэг шүүрч, мод чулуу бариад үзэлцэхээс өөр аргагүй тийм айхтар өс хонзон байжуу гэхээр тийм биш байдаг. Тамхийг нь хэлэлгүй авчихснаас, үүрэг биелүүлсэнгүй гээд хальт алгадаад авсны төлөө л буугаа шүүрээд авдаг гээд бод доо ...

Ямартаа ч шинэ онд энэ асуудалд нилээд анхаарал тавих нь бололтой. Саяхан, бүр тодорхой хэлбэл нэгдүгээр сарын 14-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Хошууч генерал Ц.Тогоо тэргүүтэй удирдах бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзахдаа, нийт бие бүрэлдэхүүний хэмжээнд хүний амь настай холбоотой гэмт хэрэг гарсаар байна гээд үүний учир шалтгаан, нөхцлийг судалж тогтоон дахин гаргуулахгүй байх талаар бүх талын арга хэмжээ авах ёстойг онцлон анхааруулсан билээ.

Төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч энэ асуудалд онцгой анхаарал тавина гэлээ. Доод удирдлагууд нь шат шатандаа бас сайн анхаарал тавиад байвал тайван цагийн эмгэнэлт хохирол гарахгүй байх боломжтой билээ л.

1. 29 ЗОХИОГЧИЙН ЭРХИЙГ ЗӨРЧСӨӨР Л БАЙНА УУ

А.Баасандорж

Өнөөдөр, 2003.01.31, №025, 026

“Од” кинотеатрын баруун хойд талд нэгэн түргэн хоолны газар нээгдсэн нь ойрмогхон билээ. “Mondonalds” хэмээх нэртэй байсан тэр газар тун удалгүй “mononalds” хэмээх нэртэй болсон юм. Учир нь ойлгомжтой. Зохиогчийн эрхийн зөрчил. Хаяг, шалнаас авахуулаад бүх юмаараа манайхыг хуулбарласан байна хэмээн арван саяас доош хүнтэй хотод салбараа нээхийг огт зөвшөөрдөггүй түүхэндээ энэ жил анх удаа алдагдалтай ажиллаад байгаа алдарт “makdonalds” компани манай оюуны өмчийн газарт хандсанаар тэд “алдаагаа” зассан нь энэ.

Хэдэн жилийн өмнөхийн явдал. Сүүлийн үед уран бүтээлийн маш их онгодтой байгаа сэтгүүлч, яруу найрагч Ш.Гүрбазар тэр үед банкны зээлийн өрөнд орж орох оронгүй болж байлаа. Тэр их мөнгийг Гүрбазар аваад идчихсэнгүй, ууж үрээд хаячихсангүй, уран бүтээл хийжээ. 1960 -аад оны үед Икар гэдэг од дэлхийг мөргөж сөнөөх гэнэ хэмээх яриа их газар авч олон хүн итгэж байсан гэдэг.

Ш.Гүрбазар яг энэ үеэр энэ сэдвээр дэлхий сөнөх нь гарцаагүй болоход хүн яаж өөрчлөгдөж буйг харуулсан зохиол бичээд авсан зээлээрээ Икар гэдэг кино хийжээ. Гэтэл дөнгөж дэлгэцэнд гаргатад оюуны хулгайчид түүнийг нь камераар хуулж аваад хөдөөгүүр гаргачихсан тул шатсан гэдэг юм.

Зурхайч Л.Тэрбишийг мэдэхгүй хүн ховор. Түүний бүтээл сайн, чанартай болохоор борлуулалт ч сайтай. Гэтэл оюуны хулгайчид гараад ирэлгүй яахав. Жил бүр цагалбараа хэвлүүлэхэд оюуны хулгайчид зэрэгцээд л хувилаад зарж эхэлдэг гэнэ. Энэ жилийнхийг хэвлүүлэхдээ хонины нь дүрсийг нь товойлгох зэргээр их л нууцлах гэж оролдсон юм билээ. Бас л хувилаад зарж явааг үгүйсгэх аргагүй.

Саяхан оюуны өмчийн газрын хяналтын хэлтэсийнхэн Английн зохиолч эмэгтэй Ж.К.Рولينгийн “Харри Поттер ба гүн ухааны чулуу”, “Харри Поттер нууц өрөө” номнуудыг манай нэгэн хэвлэлийн компани орчуулан хэвлэсэн байсныг хураан авсан байна. Учир нь тус компанийнхан зохиогчоос нь уг номыг хэвлэх эрхийг нь аваагүй байсан аж.

Энэ мэтээр оюуны өмчийн хулгай, зохиогчийн эрхийн талаар маш олон, тодорхой жишээ татаж болно. Сонин хэвлэлийн өгүүлэлтэй бол ярих юм байхгүй. Энэ талаар би хэдэн жилийн өмнө “Луйварчид чимх чимхээр хулгайлах бус атга атгаар нь дээрэмдэж эхэллээ” гэсэн өгүүлэл хүртэл бичиж байсан билээ. Саяхан хүүхдийн зохиолч Долгорын Батжаргалын нэгэн өгүүлэгийг шууд хуулаад өөрийнхөө нэрээр хэвлүүлчихсэн тохиолдол гарсан байна. Яруу найрагч Барнангийн Доржпалам агсны гэр бүлийнхэн оюуны өмчийн газарт өргөдөл гаргаад байгаа юм билээ. Учир нь зарим хүн тэдэнд мэдэгдэлгүй зохиолчийн шүлгүүдээс эмхэтгээд “Хайрын эгшиглэн” гэдэг ном хэвлүүлчихсэн ажээ.

Зохигчийн эрхийн зөрчилтэй тэгвэл монголчууд хэрхэн тэмцэл өрнүүлж байна вэ?

Оюуны өмчийн эрхтэй холбоотой харилцааг Зохиогчийн эрхийн тухай хууль, Патентийн тухай хууль, Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Иргэний хууль болон яам агентлагийн баталсан арав орчим заавар, дүрэм, журмаар зохицуулж байгаа ажээ.

Монгол улс 1979 онд НҮБ-ын бие даасан төрөлжсөн байгууллага болох Дэлхийн оюуны өмчийн байгууллагад гишүүнээр элсч, уг байгууллагаас батлан гаргасан оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтад хамаарах Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисийн конвенц, Патентийн хамтын ажиллагааны гэрээ зэрэг олон улсын гучаад гэрээний аравт нь нэгдэн ороод байгаа юм байна. Ингэснээр Монгол Улсын оюуны өмчийн салбарт, олон улсын хэмжээнд бусад улс оруудтай хамтран ажиллах, эрхээ хамгаалуулах боломж нэмэгдэж байгаа ажээ. Монгол эдүгээ Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдсэн, оюуны өмчийн чиглэлээр байгуулагдсан гуч орчим төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа ажээ. Гэвч эдгээр байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө тийм ч сайн биш байна.

Зохиолчид, уран бүтээлчид өөрийн оюуны өмчөө хамгаалуулах зорилгоор төрийн бус байгууллага байгуулж болох тухай Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор Монголын хөгжмийн зохиолч, яруу найрагчдын эрхийг хамгаалах Мосрак холбоо 2000 онд байгуулагдсан. Гайгүйхэн юм хийсэн ганц байгууллага нь энэ гэхэд нэг их хэлсдэхгүй байх. Тус холбоо 50 гаруй зохиолч, уран бүтээлчийг гишүүнээр элсүүлж, тэдний 3000 гаруй бүтээлийг бүртгэн авчээ.

Гишүүдийнхээ бүтээлийг ашиглуулах талаар 30 орчим аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй гэрээ байгуулсан байна.

Тэднээсээ овоо хэдэн төгрөг хурааж хөгжмийн зохиолч, дууны үгийг зохиогч нарт хувааж өгсөн тухай хэвлэлээр мэдээлж байсан билээ.

Оюуны өмчийн газар ч нэлээд тэмцэл өрнүүлдэг аж. Жишээлбэл, Английн зохиолчийн эрхийг хамгаалахаар зөвшөөрөлгүй хэвлэсэн номыг хурааж авсан нь үүний нэг нотолгоо юм.

“Энэ номын зохиогч хэвлэх эрхийг нь Америкийн нэгэн компанид зарчихсан байгаа. Манайхан энэ номыг орос хэлнээс дам орчуулаад зогсохгүй хавтас, дизайныг нь яг л Англи хэлээр гарсныг нь дууриагаад хийчихсэн. Оросын компанийхан хэвлэх эрхийг нь авсан байх. Тэгэхээр манайхан Оросын компанийн эрхийг ч зөрчсөн байж магадгүй. Шалгаж байна” гэж Оюуны өмчийн газрын хяналтын улсын байцаагч О.Баярмаа ярьж байна. Тэр бүү хэл тус газарт АНУ-ын ЭСЯ ны Соёлын асуудал хариуцсан атташе нь Ж.К.Ролингийн зохиолоор хийсэн киног зөвшөөрөлгүй гаргаж байна хэмээсэн гомдол гаргаж ханджээ. Энэ дагуу тус газраас арга хэмжээ авч дахин хэд хэдэн сувгаар гаргах гэж байсныг зогсоож байжээ.

Энэ мэт бол зөвхөн эхлэл юм гэж би бодож байна. Оюуны хулгайчидтай, зохиогчийн эрхийг зөрчигсөдтэй, хуулбарлаж ашиглагсадтай зохиогч өөрөө ч бас хатуу тэмцэл өрнүүлж байх ёстой. Дуучин Б.Сарантуяа саяхан нэгэн FM-ээр дуугаа явуулахыг хориглосон яриа байна. Учир нь тэрбээр тус радиогийнханд “Та бүхэн миний дууг захиалгаар явуулахдаа гурав, дөрвөн мянган төгрөг авдаг юм байна. Надад түүнээсээ 500 төгрөг өгчихөж бай. Би тэр хуримтлалаар дууныхаа зохиогч нарыг урамшуулж байя” гэсэн бололтой юм. Харин цаад газар нь зөвшөөрсөнгүй. Тэгэхээр нь миний дууг явуулж болохгүй гэжээ.

Энэ бол маш үлгэр дууриалалтай жишээ. Бүх уран бүтээлчид ийм байх ёстой. Ардчилсан, зах зээлийн нийгэмд үнэгүй юм гэж үгүй. Тэр тусмаа оюуны үнэт бүтээлийн үнэлгээ бүр өндөр байх ёстой билээ.

1. 30 ХУУЛИАС ДЭЭГҮҮР ЭРХ ГЭЖ БАЙДАГГҮЙ

А.Баасандорж

Өнөөдөр 11, 2003.02.07, №029

Өмнө нь бид хүний эрхийн зөрчлийн асуудлаар олон өгүүлэл нийтэлсэн. Энэ удаа хүний эрхий зөрчил бус харин эрхээ хэтрүүлэгчдийн тухай цухас өгүүлнэ.

Энэ дэлхийд ер нь хязгааргүй, төгс юм гэж байдаггүй байна. Бүх юм хэмжээтэй, хугацаатай. Төгс эрх чөлөө гэж байхгүй. Экзистенциалист онолыг үндэслэгчдийн нэг Жан Поль Сартр төгс эрх чөлөө гэж байдаггүй гэдгийг “Герострат” хэмээх өгүүлэлдээ гайхалтай урнаар гаргасан байдаг билээ. Тэгвэл эрхээ эдлэх нь бас хязгаартай байдаг байна. Үүнийг саяхан Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж “Төрийн хуулийн алтан хилийг давсан хэний ч хөлийг хатуу гишгэх болно” гэж тун товчоноор тодоройллоо. Тэрбээр цааш нь “Өнөөдөр бид төрийн хуулийн хүрээнд ажиллаж, амьдарч сурах хэрэгтэй байна. Жирийн иргэнээсээ эхлээд төрийн тэргүүнээ хүртэл шүү. Зарим тохиолдолд хуулиас илүү эрх ашиг байдаг, ийм тохиолдолд хууль зөрчсөн ч яахав гэх ухааны юмыг Гончигдорж хэлж байсан. УИХ-ын дарга байсан хүний амнаас ийм үг гарна гэдэг бол харамсалтай. 1990 оноос өмнө хуулиас гадна асуудлыг зохицуулдаг улс төрийн бодлого байдаг гэж ярьдаг хуулийн байгууллагын хүн байсныг би мэднэ. Хуулиас дээгүүр улс төрийн ашиг сонирхол, эрх чөлөө гэж хаана ч байхгүй” хэмээн хэлсэн билээ.

Хүний эрх, эрх чөлөөний тухай ярьж хуулиас дээгүүр эрх эдлэх гэсэн янз бүрийн оролдлого одоо их гарах болж. Хамгийн тодорхой жишээ бол трактортой жагсаал. Эрх чөлөөний талбайд үгээ хэлж болно, харин Сүхбаатарын талбайд болохгүй, хуулийн заалт тийм байна гээд байхад заавал Сүхбаатарын талбайд жагсана гээд зүтгээд байсныг юу гэж ойлгох вэ? Хуулиас дээгүүр эрх эдлэх гэсэн хэрэг гэхээс өөрөөр тайлбарлах аргагүй. Компанийн захирал, баян хүмүүсийг дарамталж мөнгө салгах гэсэн оролдлого их гардаг болсон тухай сүүлийн үед нэлээд ярих болж. Нэг хэсгийнх нь асуудлыг шүүх ойрмогхон шийдсэн. Өөрөөр хэлбэл тэд хуулиас дээгүүр эрх эдлэх гэсэн хэрэг. Эд хөрөнгө, ер нь юуг ч шударгаар л олж авах хуулийн хүрээнд бид амьдарч байгаа шүү дээ.

Хөгжилтэй орнуудад, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэдэг гэж бидний үлгэр жишээ татах дуртай Америкт ч хуулиас дээгүүр эрх гэж байдаггүй гэдгийг иргэддээ ягштал ойлгуулдаг байна. Цагаан ордны ойролцоо жагсаал цуглаан хийж, өлсгөлөн зарлаж болдог гэж байгаа. Тэгэхдээ цагаан ордонд төчнөөн метрээс дотогш нэвтэрч болохгүй гэсэн заалттай. Түүнийг нэвтрэх гэж оролдвол цагдаа, харуул хамгаалалтынхан тэр этгээдийг барьж аваад хуульд заасан шийтгэл торгуулийг эдлүүлчихнэ. Харин хуулийн хүрээнд, тэг горигтноос халихгүй бол яах ч үгүй. Энэ бол нэг л жишээ юм.

Тиймээс бид иргэддээ хуулийг сайтар таниулж, хэвшүүлдэг болох хэрэгтэй байгаа юм. Хүний эрх, эрх чөлөө гэдэг үгээр дэндүү их гул барьж “дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэж болдоггүй” гэдгийг сайтар ойлгуулах хэрэгтэй байна. Эрхийг минь эдлүүл гэж шаардахдаа хүртэл бид хуулийн хүрээнд шаардаж байна уу, үгүй юу гэдгээ бас мэдэж байх ёстой билээ л.

1. 31 ЧАМЛАХААР ЧАНГА АТГА ЮУН ХҮНИЙ ЭРХ

С.Сосор

Улаанбаатар таймс, 2002.12-р сар, №146 /786/

Үндэсний статистикийн газрын даргын 2001 оны есдүгээр сарын 27-ны өдрийн 164 дүгээр тушаалаар хүн амын 2001 оны амьжиргааны доод түвшинг доорх үзүүлэлтээр тогтоож хавсралтаар баталгаажуулжээ. Үүнд:

Улаанбаатар хотын хүн амын амьдралын баталгаажих доод түвшин 23600 төгрөг

Баруун бүсийнх 18700 төгрөг

Хангайн бүсийнх 18200 төгрөг

Төвийн бүсийнх 19300 төгрөг

Зүүн бүсийнх 19900 төгрөг

Өнөөдөр улсын хэмжээнд өндөр насны тэтгэвэр авдаг 165 мянган хүн, үүний зэрэгцээ халамжийн тэтгэвэр, тэтгэмж авдаг хүн 250 мянган гаруй байдаг юм байна. Халамжийн тэтгэврийг асран хамгаалах хүнгүй, улсад хөдөлмөрлөөгүй буюу ажилласан жил нь гүйцээгүй өндөр настнууд, мөн хөдөлмөрийн чадваргүй тахир дутуу иргэд, гуравдугаарт тэжээгчээ алдсан хүүхдүүдэд өгдөг. Энэ нь 12000 төгрөг байдаг аж. (Халамжийн тэтгэмж бол өөр. Үүнд олон хүүхэдтэй эхчүүд, өнчин хүүхэд үрчилж авсан эхчүүд, тахир дутуу хүүхдээ асарч буй эхчүүд, жирэмсэн эх, хөдөлмөрийн баатар, улсын баатар, ахмад дайчид, гавъяатнууд зэрэг ордог.) Гэтэл өндөр насны тэтгэврийн доод хэмжээ 22800 төгрөг. Та бодоод үз дээ. Үндэсний статистикийн газраас судалж тодорхойлоод Засгийн газраар

баталгаажуулсан амьжиргааны доод түвшинг дээр дурдсан, гэтэл тэтгэвэр тэтгэмжийн доод хэмжээ нь хүн амын амьдралын баталгаажих доод түвшнээс хоёр дахин бага байна шүү дээ. Энэ 12-22 хон мянган төгрөгөөс өөр орлогогүй айл өрх олон байгаа. Уг нь энд хүний эрхийн тухай өгүүлэх гэсэн юм. Тэгээд юун тэтгэвэр тэтгэмжийн тухай өгүүлээд байгаа юм бэ гэж уншигч Та гайхаж болох юм. Хүний эрхийг хангах, хөгжлийн үйл явцыг түргэтгэх цаашлаад улс орнуудын болон тухайн улсын хүн амын дундах тэгш биш байдал нь ядууралтай холбоотой байдаг. Энэ нь манай орны хувьд төдийгүй дэлхий дахины өмнө тавигдаж буй тулгамдсан асуудлын нэг болоод байгаа. 1960-аад оноос хойш дэлхий дээр нэмэгдсэн хүн амын гурван тэрбум гаруй нь өдөрт хоёр ам доллараас бага орлогоор амьдарч байна гэсэн тооцоог НҮБ-ын Хүн амын сангаас 2002 онд гаргасан. Тэгвэл манайд энэ үзүүлэлтийг аваад үзье л дээ.

Үндэсний статистикийн газрын гаргасан тооцоо, үндэслэлээр гаргасан амьжиргааны доод түвшний 22000 төгрөгөөс өөр орлогогүй өрх байна гэж бодъё. Мэдээж байгаа. Тэгэхээр тэр мөнгөө сарын 30 хоногтоо хуваахад өдөрт 754 төгрөг ноогдож байгаа биз. За тэгвэл зөвхөн халамжийн тэтгэврээр амьдардаг өрхийн орлогыг бодохын ч хэрэггүй. 300-400 төгрөг болно. Өдөрт ганц талхаа л чүү ай авч хүчирч байна гэсэн үг. Цаана нь гэрэл цахилгаан хувцас хунар, хоол, хог, түлээ нүүрс гээд их асуудал бий. Тэгэхээр НҮБ-ын гаргасан нэг хүнд ноогдож буй хоёр ам доллараас ч хэд дахин бага орлоготой байна гэсэн үг. Үүнийг түр орхиод хүний эрхийн тухай ярья. Хүн амьд явах эрхтэй. Сайхан амьдрах эрхтэй. Ажил хөдөлмөр эрхлэх эрхтэй. Энэ бол Үндсэн хуулиар баталгаажсан эрх. Бид хүний эрх гэж ярих дуртай хэрнээ өөрсдөө эрхээ эдэлж чадаж байна уу, эрх нь зөрчигдөж байна уу гэдгээ тэр бүр мэддэггүй, анзаардагч үгүй. Заавал хэн нэгэнтэй нударга зөрүүлж, хэл амаа билүүдэж заналхийлэх зэрэг “бүдүүлэг” тохиолдлуудад эрхэнд халдлаа энээ тэрээ гэдэг. Гэтэл бид өдөр бүр бараг цаг тутам эрхээ хөндүүлж байдаг шүү дээ. Наад зах нь өглөө ажилдаа ирэхээр автобусанд суухдаа ч хэн нэгэн “хүчтэйд” нь суудлаа булаалгаж, нүүр нүд рүүгээ ёвруулж, хөл дээрээ гишгүүлж, өшиглүүлж, түмэн зүйлээр хараалгаж чичлүүлдэг. Та ч хүн, би ч хүн. Бид адилхан тэгш эрхтэй.

1. 32 АВЪЯАСЫГ ҮНЭЛЖ, АВЪЯАСТНАА ХҮНДЭЛЖ ЧАДДАГ БИЛ ҮҮ БИД

С.Сосор

Улаанбаатар таймс, 2002.12-р сар, №149 /789/

Дэлхийн хамгийн баян хүн хэн бэ гэдгийг Та мэдах үү? CD зардаг дэлгүүрийн сүлжээний эзэн Уоррен Баффет уу, эсвэл Египетийн Махомед Аль Файед уу? Аль нь ч биш.

Дэлхийн хамгийн баян хүн бол компьютерийн программ хангамжийн үйлдвэрлэгч, “Майкрософт” компаний ерөнхийлөгч АНУ-ын иргэн Билл Гейтс юм. Тэрбээр өв залгамжлагч азтан, айхтар сүрхий бизнесмен ч биш. Ердөө л оюун ухааныхаа чадлаар хэдэн зуун тэрбумаар тоологдох хөрөнгөтэй болсон хүн. Ер нь барууны орнуудад оюуны өмч, зохиолчийн эрхийг маш их хүндэлдэг. Жишээ нь: Финляндад гэхэд такси, автобус гээд нийтийн унаанаас хураамж авдаг. Тэр нь зорчигч тээвэрлэж байхдаа бусдын зохиосон дуу, хөгжим гэх мэт оюуны өмчийг ашиглаж үйлчилгээгээ сайжруулсны төлбөр хураамж гэнэ. Харин манайд оюун ухааныхаа хүч чадлаар Билл Гейтс шиг байг гэхэд монголдоо толгой цохих хөрөнгөтөн бий билүү? Байхгүй. Арга ч үгүй юм. Манайд оюуны өмчийг жинхэнэ утгаар нь үнэлж сураагүй. Бүр социализмын үеэс л бид оюуны өмчийг нийтийн өмч мэт ойлгосоор ирсэн. Гэхдээ үүнийг огт хайхардаггүй гэж хэлж болохгүй л дээ. Оюуны өмчийн эрхтэй холбоотой харилцааг Зохиогчийн эрхийн тухай хууль (1993), Патентын тухай хууль (1993), Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль (1996), Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль (2000), Технологи дамжуулах тухай хууль (1998) гээд иргэний болон яам агентлагийн баталсан арваад хууль дүрэм журмаар зохицуулдаг.

Монгол улс 1979 онд НҮБ-ын бие даасан төрөлжсөн байгууллага болох, Дэлхийн оюуны өмчийн байгууллагад гишүүнээр элсч уг байгууллагаас батлан гаргасан оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтад хамаарах Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисийн

конвенц, Патентын хамтын ажиллагааны гэрээ (1991) зэрэг олон улсын гучаад гэрээний аравт нь нэгдэн орсон юм байна. Хэдийгээр оюуны бүтээл туурвигчид бүтээлээ хамгаалуулах эрх зүйн зохицуулалт бий болсон ч манайд оюуны өмчийн эрхийг зөрчих явдал улам л өссөөр байдаг. Харамсалтай нь зохиогчийн оюуны өмчийн эрхийг зөрчиж, цаашлаад хүний эрхийг ноцтой зөрчиж байна гэдгээ манайхан мэддэг ч үгүй юм уу эсвэл мэдсэн ч тоодоггүй.

Зохиогчийн эрхийг зөрчсөн хэрэг манайд түгээмэл байдаг. Жишээ нь: 1991 онд Д. Алтангэрэлийн Англи, монгол толь бичгийг Хөх хотод 2000 ширхэгийг хуурамчаар үйлдвэрлэж зарж борлуулсан. Зохиолч З. Түмэнжаргалын “1-р ангийн сурах бичиг” –ийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлүүлсэн. Янз бүрийн рекламд клип киноноос оруулдаг. Түүнчлэн монголын телевизүүд гадаадын кинонуудыг зөвшөөрөлгүй үзүүлж байна. Дуучдын CD, хуурцгийг хувиараа хуулбарлаж зарж борлуулж, ашиг олох зэргээр оюуны өмчийг хулгайлж байна. Гэтэл энэ бүхнээс гадна хамгийн их эрх нь зөрчөгддөг хүмүүс бол хөгжмийн зохиолч, яруу найрагчид юм. Зохиолчдын бүтээл дээр “дөрөөлж” гарч ирсэн дуучид зохиолчдоосоо илүү хангалуун амьдралтай гээд хэлчихвэл нэг их хэтрүүлсэн болохгүй байх. Хувьдаа машингүй дуучид гэвэл хуруу дарам цөөхөн. Харин хувьдаа унаатай зохиолч, яруу найрагч гэвэл бас л хуруу дарам цөөхөн шүү дээ. Монголын хөгжмийн зохиолч, яруу найрагчдын эрхийг хамгаалах Мосрак холбоо 2000 онд байгуулагдсан. Автобус, микро, такси, рестарон, баар, цайны газар хаана л бол хаана хөгжим дуу цангинаж байдаг. Мөн Улаанбаатарын хэмжээнд гэхэд 10 гаруй FM радио байдаг. Тэр бүгдээр манай зохиолчдын дуу хөгжим эгшиглэж л байдаг. Энэ бүхэн бол хөгжмийн зохиолч, яруу найрагчдын оюуны өмч.

Тийм болохоор тэр өмчийг ашигласныхаа төлөө төлбөр төлөх ёстой. Хэрэв та хүний машиныг ч юм уу авч хэрэглэсэн бол түрээс төлнө гэдэг нь маргаангүй. Түүнтэй адил тэр дуу бол зохиогчийн хувийн л өмч шүү дээ. Зохиолч хувийн өмчөө бусдад ашиглуулсны төлөө хураамж авах эрхтэй. Баар, ресторан, FM радио, телевиз гээд зохиолчдын дууг үйлчилгээндээ ашигладаг бүх газрууд Мосрак холбоотой (Хэрэв тэр холбооны гишүүдийн бүтээлийг ашиглаж байгаа бол эсвэл аль нэг холбогдох газартай) гэрээ хийж албан ёсоор зөвшөөрөл авах ёстой. Манай хөгжмийн зохиолч, яруу найрагчид ихэнх нь даржигхан амьдралтай нь нууц биш. Алдарт хөгжмийн зохиолч Л. Мөрдорж гуай хүртэл амьдралынхаа сүүлийн мөчүүдэд яаж шуухан амьдарч байсан тухай сэтгэл шимширмээр яриа байдаг. Хэрэв манайд оюуны өмчийг зохих ёсоор үнэлж, цэгнэж чаддаг, бид ч хууль дүрмээ мөрдөж хэвшсэн, хүн бүр эрхээ эдэлж чаддаг, бас үүргээ ухамсарладагсан бол хөөрхий хэдэн авъяастнууд маань Билл Гейтс шиг тэрбумтан биш гэхэд одоо байгаагаасаа арай л дээр амьдрахсан даа.

1. 33 ДУТУУ БАЯР, ДУНДУУР СЭТГЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД...

С.Сосор

Улаанбаатар таймс, 2003.01.07, №803

... Цонхоор хотын гудамж харагдана. Яарсан хүмүүс нааш цааш холхиж, машин тэрэг зай завсаргүй сүлжилдэнэ. Шинэ он гарах гэж байгаа болохоор гадуур баярын уур амьсгал нэгэнт оржээ. Үүнийг бичигч миний бие яг энэ үеэр эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байлаа. Миний эмчлүүлж буй эмнэлэгт ихэвчлэн хүүхдүүд хэвтэж байсан юм. Хүүхэд л болсон хойно тоглож, наадаж, үймүүлж шуугина гэж жигтэйхэн.

Шинэ жил гэдэг хүн бүрийн сэтгэл догдлуулсан гэр бүлийн хамгийн сайхан баяруудын нэг болохоор эмнэлэгт хэвтэж байсан өвчтөнүүд ч чөлөө аваад гэр гэртээ гарцгаалаа. Харин миний хувьд гэртээ харих гэж нэг их яарсангүй. Нэг өдөр ч гэсэн чимээ шуугиангүй орчинд ганцаараа байж толгойгоо амраадаг юм билүү гэсэн шүү юм бодсон юм. Хүүхдүүд өглөөнөөс авахуулаад цонхон дээр шавж ээж, аавыгаа ирэхийг хүлээн догдолцгоож байгаад эхнээсээ хөөр баяр болон гэрлүүгээ явсаар сүүлдээ эмнэлэг ч эзгүйрэн нэг л эл хуль болоод ирлээ. Өвчтөн байхгүй болохоор эмч, сувилагч нарч үзэгдэхгүй юм. Би өрөөндөө хэсэг хэвтэж байгаад хонгилд гарлаа. “Энэ хүүхдүүд хэсэг ч гэсэн чимээгүй байгаад өгдөг болоосой чих амар байх юм сан” гэж заримдаа бүр халаглах дөхдөг байсан чинь хүүхдүүд гараад явчихаар чимээ аниргүй дүнсийгээд харин ч эвгүй юм. Эргэлтийн өрөөний цонхны дэргэд ганцхан хүүхэд цаашаа хараад зогсож байна. Энэ

хэн юм бол, яагаад гэрлүүгээ яваагүй юм бол гэж бодсоор очтол Алтанхундага хамгийн “болдоггүй” хүү байна. “Муу хүний дуу их гэж” энэ Алтанхундагын дууны чангыг яана гэж эмч, өвчтөнгүй л үглэнэ. Тэр хүү дэндүү сахилгагүй, нөгөө “Би эндээс явахгүй” кинонд гардаг нэг дүрсгүй хүү байдаг даа тэрнээс ч илүү гээч. Харин одоо хачин томоотой, шанаагаа тулаад уйтгартай зогсоно. Чи яваагүй байгаа юм уу гэвэл толгой сэгсэрч байна. Яваагүй байгааг нь харсаар байж дэмий юм асуух юм гэж бодоод яасан бэ, гэрээс нь хүн ирээгүй байна уу гэвэл бас л толгой сэгсэрч байна. Ярих дургүй байгаа бололтой. Би түүнтэй зэрэгцэн цонхоор гадагш харан зогслоо.

-Пөөх, тэр хүний барьж яваа бялууг хар даа. Ямар гоё том бялуу вэ?

-...

Тэр дуугардаггүй. Гайхаад хартал чимээгүйхэн уйлж зогсоно. Хоёр нүднийх нь нулимс хацраа дагаад бөмбөрнө. Битгий уйлдаа. Нааш ир. Хоёулаа манай өрөөнд орёе. Надад бас бялуу байгаа. Хоёулаа идье гэвэл хөдөлдөггүй. Би гараас нь хөтлөөд чирэх нь холгүй өрөөндөө дагуулан орлоо. Тэгээд бид хоёр ийн ярьсан юм.

-Чамайг өнөөдөр уг нь хэн ирж авна гэсэн юм бэ?

-Багш.

-Ямар багш?

-Манай асрамжийн газрын.

-Өө, миний дүү асрамжийн газар байдаг юм уу? Аль асрамжийх вэ?

-”Нарны хаан хүүхэд” нэртэй асрамж. Та мэдэх үү? Хайлаастын дунд буудалд байдаг. Японы Энх тайвны салхи гэдэг газар ивээн тэтгэдэг юм гэсэн.

-Чи яагаад асрамжийн газарт амьдрах болсон юм бэ? Аав ээж нь байдаг уу?

-Уг нь байдаг л даа. Аав, ээж хоёр маань аль эрт салчихсан юм. Ээж маань эгчийг аваад явсан. Би аавтайгаа үлдсэн. Тэгээд аав өөр хүнтэй суусан юм. Хойд ээж маань надад их дургүй. Ажил муу хийлээ, усанд удаан явлаа гээд байнга зодож загнадаг. Аав намайг өмөөрөхөөр төрүүлсэн эхдээ хүртэл гологдсон наад зулбадсагаа тэгвэл чи аваад зайлахгүй юу гэдэг юм. Тэгээд аав намайг нэг их өмөөрч чаддаггүй юм. Аав архи их уудаг болсон. Нэг удаа хойд ээжийн дүү залуутай хамт архи уугаад чиний эгч хүүг минь дандаа ад үздэг гээд тэр хоёр хэрэлдээд зодолдсон. Аав тэр ахыг хүнд бэртээчихсэн гэсэн. Тэгээд шоронд орчихсон юм. Аав байхгүй болохоор би гэртээ очихоос дургүй хүрээд гудамжаар тэнэж байгаад асрамжийн газар очсон.

-Миний дүү түрүүн яагаад уйлсан юм бэ?

-Ээжийгээ санаад ... Ээж эгчийг аваад явсан хэрнээ намайг яагаад хаячихсан юм бол доо. (Дахиад л нүдэнд нь нулимс дүүрээд ирэв)

-Чи ээждээ хайртай юу?

-Хайртай. Бас аавдаа, эгчдээ ч хайртай... Бид ийн ярилцсан юм. Гэтэл эргэлтийн цонхоор Алтанхундагаа гэж дуудлаа. Бид хоёр ч зэрэг ухас хийлээ. Найм, есдүгээр ангийнх юм болов уу гэмээр насны охин бас нэг багахан эрэгтэй хүүхэдтэй иржээ. Багш шинэ жилийнхээ юмыг бэлдэх гээд ажил ихтэй болохоор бид хоёрыг Хундагааг аваад ир гэж явуулсан юм гэж байна. Том цүнхээр дүүрэн хувцсыг нь бид хоёр аваад өрөөндөө орлоо. Гэтэл цүнхэнд шошгыг нь ч аваагүй шив шинэ гутал, малгай, бээлий өмд, цамц, оймс байлаа. Бүр дотуур хувцас нь хүртэл цоо шинэ гээч. Хувцаснууд нь эзэндээ таарч байгаа ч гэж жигтэйхэн. Японы “Энхтайвны салхи” байгууллагаас өгсөн шинэ жилийн бэлэг гэнэ. Хувцсаа өмсөөд Алтанхундага баяртай эгчээ гээд инээд алдан гүйж одлоо. Би ч баяртай хоцорлоо. Ийм сайхан сэтгэлтэй хүмүүс, буяны байгууллагууд байдаг нь сайхан юм даа. Гэхдээ л сэтгэлдээ гунигтай, зүрхэндээ “шарх”-тай хүүхдүүд дүүрэн сэтгэлээр бүрэн баярлаж чаддаг болов уу гэж бодогдсон.

Энэ бүхний эцэст би юу хэлэх гэсэн юм бэ гэвэл “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” гэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалын гуравдугаар зүйлд заасан байдаг. Тэгвэл ганцхан дээр өгүүлсэн хүүгийн гунигт амьдралын жишээг харъя л даа. Элгэн дотроо битүүхэндээ үрээ өмөөрсөн эцэг эрх чөлөөтэй байх эрхээ хасуулж, гэр бүлийн таагүй амьдрал хойд эхийн зодуур дарамтаас болж Алтанхундага хүүгийн сайхан амьдрах, халдашгүй дархан байх эрх зөрчигдсэн л байна. Иймэрхүү гунигт амьдралтай хүүхдүүд Монголд олон бий.

Хүн бүр тэгш эрхтэй. Гэвч манайд хүн бүр эрхээ бүрэн эдлэх нөхцөл, боломж даанч алга даа.

1. 34 ХАРЬД ҮРЧЛҮҮЛСЭН ХҮҮХДИЙН ХУВЬ ЗАЯА ХААШАА ЭРГЭХ БОЛ?

Д.Цээпилмаа

Улаанбаатар таймс, 2003.01-р сар, №17

“Хэнийг ч боолчлол буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй, боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно” /Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 4-р зүйл. /

Энэхүү тунхаглалыг уншихад та бидэнд төдий л хамаагүй мэт санагдаж болно. Учир нь бид чинь бүхэл бүтэн нийгмийг алгасч боол, боолчлолыг хэдий нь халчихсан улс хэмээн омогшин бахархдаг билээ.

Капитализм гэгч гай хөөтэй нийгэмд л баян хоосны ялгаа ноёрхож, харгис хэрцгий бүхэн бий гэдэгт бат итгэдэг байсан. Гэтэл нэг л өглөө сэрэхэд төр эргэж, итгэл, үнэмшил бүхнийг үлдэн хөөсөн байлаа. Зарим нь тэр дундаа хөгшид маань хуучин нийгмээ санагалзан сайн сайхнаар дурсдаг бол, залуучууд нь энэ нийгэм л “нүд” тайллаа гэдэг. Дээрх ярианы аль нэгийг нь дэмжих, эсвэл үгүйсгэх гэсэндээ олныг нуршсангүй. Гагцхүү хамгийн эхэнд дурдсан тунхаглал өнөөдрийн бидний амьдралд хамаатай, хамгаас их хамаатай болохыг л өгүүлэхийг хүссэн юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 4-р зүйлийн дэлгэрэнгүй тайлбарт “Боолчлох ёс нь хууль бус зүйл боловч зарим оронд байсаар байна. Хүмүүсийг зах дээр нээлттэй байдлаар үнэ хаялцуулан зардаггүй ч биеийг нь үнэлүүлэх, ажиллуулах, үрчлэн авах зэргээр бусдын эрхшээлд оруулж байна” гэжээ.

Одоогоос нэлээд хэдэн жилийн өмнөсөн. Манай сонины нэг сурвалжлагч “Боол” нэртэй нийтлэл сонинд хэвлүүлснийхээ төлөө шүүхийн хаалга татаж, бөөн зарга үүсч билээ. “Боол” нийтлэлийн баатар нь цагдаагийн эрх мэдэл бүхий томоохон албан тушаалтны гэргий байлаа. Тэр бүсгүйг нөхөр нь эрхшээлдээ байлгадаг төдийгүй дарлан доромжилдог байжээ. Харамсалтай нь гол баатар маань шүүх хурал дээр өгсөн ярилцлагаасаа буцаж манай редакц машины өрөнд унаад л өнгөрсөн юм. Өнөөдөр мөнөөх бүсгүй “Боол” байхаа больсон гэж бодогдохгүй л юм. Тэр явдал бол зүгээр “жишээ” байсан. Хайртай ханийхаа харгислалд орсон бүсгүйчүүд, цаашилбал хүүхэд багачууд ч цөөнгүй бий. Монгол оронд хүн наймаалах худалдаа төдийлэн дэлгэрээгүй. Гэвч нууц далд явагдаж байна гэх үндэслэлтэй.

Нэгэн эхийн яриаг энд иш татъя. Түүнийг С гээ.

-Цагтаа би багагүй орлоготой алба, ажил хашдаг сайн сайхан явсан юм. Нөхөр маань тээврийн жолооч байсныг хэлэх үү, идэх уух, өмсөх зүүхээр дутаж явсангүй. Хоёр хөгшнийхээ буянаар хүүхдүүдээ өсгөх гэж ч зовоогүй. Гай газар доороос гэдэг шиг ханиа автын ослоор, аав ээжийгээ хорвоогийн хатуу хуулиар алдаж, би усанд живэх шиг л болсон доо. Залуу насанд цалгиж явсны горьг нас тогтох үедээ л амсдаг юм байна. Хоёр хүүхэд маань сургуульд орж би өөрөө ажилч үгүй гар мухардлаа. Аргагүйдээ ирэхлээр хүн юу эсийг бодохов дээ?! Хуучны танил маань зуучилж гадаадын нэгэн орны залуу хостой уулзуулснаар 2 хүүхдээ тэжээх аргыг олсон доо. Би тэдний захиалгаар хүүхэд төрүүлсэн. Түүнийгээ эрүүл саруул тээж, төрүүлснээр овоо хэдэн “ногоон”-той болж том хүүгээ МУИС-д, охиноо хувийн дунд сургуульд оруулж бусдын дайтай авч явна даа хэмээн ярьсан юм.

Амьдралын эрхээр нэгэн Монгол хүү гадаадын иргэнд үрчлүүлсэн түүх ийм юм. Хүүгийн хувь заяа хэрхэн эргэснийг хэн мэдлээ. Магадгүй сайн эцэг, эх заяаж, аз жаргалтай явахыг үгүйсгэхгүй.

Улсын Их Хурлын түшээ Д. Мөрөн манай сонины редакцид зочлохдоо:

-Гадаадын иргэн Монгол хүүхэд үрчлэн авах явдал жилээс жилд нэмэгдэж байна. Тэрч бүү хэл нэг хүн найман Монгол хүүхэд өргөж авсан тохиолдол ч гарсан. Үүнд төрийн зүгээс хяналт тавих боломж байхгүй. Уул нь хүүхэд гэдэг утгаар тухайн оронд суух Элчин сайд уг асуудлыг хариуцаж хяналт тавих ёстой юм. Гэвч тэдэнд тодорхой судалгаа байдаггүй юм билээ гэж ярьсан юм. Энэ үг эрхгүй нэгийг бодогдуулна. Бид эзэн Чингисийн үр удам гэж бардамнах дуртай. Тэгвэл их эзний үр садаас хэд нь гадаад оронд үрчлэгдсэн бол?! Дэвшүүлэн зайлуулна гэдэг шиг монголын үрсийг үрчлэх гэдэг сайхан үгээр хууран авч явж чухам юунд ашигладаг бол доо гэсэн хартай бодол төрнө.

Дэлхий дээр 250 сая хүүхэд амьдрахын эрхээр хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 50-60 сая нь 5-11 насны хүүхэд байсан бөгөөд үүнээсээ болж сургуульд сурч чадахгүй байна гэсэн тоо гарчээ. Монголд ч хүүхдүүд ажилладаг. 14-16 насны хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо 5271 байгаа нь нийт хүүхдийн 0.6 хувьтай тэнцэж байна. Насанд хүрээгүй хүүхэд алт, нүүрсний уурхай зэрэг хүнд хүчир салбарт ажиллаж байгааг “Хүүхдийн хөдөлмөрийг сорон мөлжиж, боолчилж байгаагийн илрэл” гэжээ. Цалин хөлсний тухайд ч амьдралд хүрэлцэхгүй хэмжээнд байгааг мөлжлөгийн хэлбэр гэж үздэг юм.

Хөгжингүй орнуудад чадахгүй зүйл байхгүй. Ялангуяа хүний эрхтэнг шилжүүлэн суулгахдаа тэд гарамгай. Хөөрхий Монгол үрс маань харьд очоод сохор, доголлон, тахир дутуу хүн болон хувирч буйг ч үгүйсгэх аргагүй билээ.

Тас хар монгол нүдээр ертөнцийг тольдон яваа харийн хүн ч байгаа юм бил үү?! Малаа алдахдаа хүртэл эрэл сурал болдог хэрнээ үр ачаа харьд үрчлүүлчихээд нүдэн балай суумгүй санагдана.

1.35 НАС ӨНДӨРСӨХ ТУТАМ ХҮНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ ГОРТИГТ ОРЖ ХЯЗГААРЛАГДДАГ

Д.Цээпилмаа

Улаанбаатар таймс, 2003.2-р сар, №23

Монгол улсыг хүүхэд залуучуудын орон гэдэг.

Үнэхээр хаана ч явсан хүүхэд, залуучууд л нүднээ тусна. Хаа нэг тааралдах өндөр настнуудаа хүндэтгэн, хайрлахын оронд харин ч адлах маягтай харилцах нь даанч гунигтай.

Төр засгийн зүгээс ч нийгмийн эмзэг бүлгийн хүүхэд залууст чиглэсэн бодлогыг түлхүү анхаардаг. Гэтэл эмзэг бүлгийнхэн дотор өндөр настан, ахмадууд олон байдгийг судалгааны дүн харуулна. Орлого бол ядуурлыг хэмждэг үндсэн хэмжүүр. Түүнээс гадна хөрөнгө, эх үүсвэр, үйлчилгээ, мөнгөөр ядуурлыг хэмжих нь бий. Аль ч хэмжүүрээр “жигнэсэн” ахмадуудын маань олонх нь амьжиргааны баталгаажих түвшин гэсэн улаан шугамаас доогуур орж байгаа юм.

“Хүний эрх” –ийн сэдэвт өндөр настнуудын асуудлыг хөндөн тавих нь тийм ч зохистой биш мэт санагдаж болох юм. Гэвч түр хүлээнээд хэсэг эргэцүүлэе.

Хүн хөгшрөх тусам эрх нь хязгаарлагддаг гэдэгтэй та санал нэгдэх үү! Хүчээр албадан хязгаарлаагүй хэр нь өөрийн эрхгүй настан буурлуудын эрх, эрх чөлөө нь гортигт орж эхэлдэг.

Саяхан тэтгэвэрт гарсан нэгэн эмэгтэйн яриаг энд иш татъя. Түүнийг Ж. Нина гэдэг. Тэрбээр төр засгийн төлөө 32 жил ажиллаж, дээгүүр биш ч дундаж албан тушаалд зүтгэж явсан юм.

- Би сард 33 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг. Гэвч амьдралд хүрэлцэхгүй юм. Зээл авахыг хүсдэг ч барьцааны хөрөнгө, танил талгүй бол бүтэхгүй ажил. Тусламжийн тухайд бид мэт нь горьдолтгүй. Туслуулна гээд онгорхой цоорхойг өмсөлтэй нь биш дээ. Хүн ажил төрөлтэй явахад нэртэй, төртэй байдаг юм байна. Тэтгэвэр гэдэг чинь сайхан нэртэй ч нэг ёсны нийгмийн тусгаарлалт юм хэмээн өгүүлсэн юм.

Үг үнэндээ хатуу гэдэг. Үнэхээр тэтгэврийн хүмүүсийн өнөөгийн байдал тийм ч сайнгүй байна. Өнөөдөр нийслэлд 85702 хүн тэтгэвэр авч байгаа нь 2001 оныхоос 4100-аар нэмэгджээ. Тэдний тэтгэврийн дундаж хэмжээ 29505 төгрөг. Ганц биеэ аваад явахад ч хүрэлцээ муутай энэ мөнгөөр 3-5 ам бүлийг тэжээгч өндөр настнууд цөөнгүй байна. Сүүлийн жилүүдэд өндөр настнуудын тоо болоод хүн амын дундаж наслалт өсчээ. Энэ бол сайн үзүүлэлт. Гэвч настан буурлуудын ахуй амьдралд тус дөхөм болохуйц бүтээлч ажил өнөө хэр хийсэнгүй. Нийслэлийнхний тухайд ахмадууд жилд 210-360 мянган төгрөгтэй дүйцэхүйц хөнгөлөлтийн билетээр нийтийн тээврийн хэрэгслээр зорчдог. Нэг жилд 60 гаруй мянган иргэн энэ үнэмлэхийг авдаг ч одоогоор ердөө тал хувь нь л аваад байна. Эл билетийг авалгүй үлдэгсдэд энэ хөнгөлөлт огт хамааралгүй юм. Өөрөөр хэлбэл хотын дотор нийтийн тээврийн хэрэгслээр зорчдоггүй, гэртээ суудаг хүмүүс хөнгөлөлтийг хүртэж чаддаггүй гэсэн үг. Түүнчлэн хөдөө орон нутгаас хотод түр болон удаан хугацаагаар суурьшиж буй ахмадууд гэрээсээ гармагц л хүмүүсийн дургүйцэл, гадуурхлыг “амсана”. Автобусанд тэр дундаа хувийн унаанд суухаас эхлээд өөрийгөө хөрширч доройтсоныг

гунигтайгаар мэдэрч байдаг. Түүнчлэн ахмад настнуудын хүйсийн байдал эрс ялгагдаж эхэлдэг ажээ. Манай улсын тэтгэврийн насныхны 60.7 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд нас ахих тусам эрчүүдийн тоо эрс буурдаг байна. Монгол улсад 100 ба түүнээс дээш насны 19 хүн амьдарч буйн хоёроос бусад нь эмээ нар юм.

Өндөр хөгжилтэй орнуудад ч хүн амын хамгийн бага орлоготой бүлэгт ганц бие настайчууд багтдаг ба тэдний дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг байна. Эндээс настай хүмүүсийн гол бэрхшээл болох бэлэвсрэлийн асуудал урган гарна. Монгол хүний дундаж наслалт богино. Түүн дотроо эрчүүд маань бүр ч ахар насладаг. Тиймээс ахимаг, ахмад насныхан дунд бэлэвсэн эмэгтэйчүүд олон бий. Тэд хэрхэн ганцаардаж, шаналж явааг нас биед хүрсэн хүүхдүүд, ахан дүүс нь тэр бүр анзаардаггүй.

62 настай П. Рэгзэн гуай ярихдаа “Миний нөхөр нас барснаас хойш би долоон жил ганцаар амьдарч байна. Хүүхдүүд маань шилжээд явчихсанаас хойш надад хэн ч санаа тавьж, асууж байгаагүй. Би тэтгэврийн хэдээсээ өөр ямар нэгэн орлогогүй, тусалж дэмжих хүн ч ховор. Надад амьдрал байхгүй, би маш их ганцаардаж сул дорой амьдарч байна” хэмээн өгүүлэв. Хөөрхий хөгшний аньсага нойтон ч нулимс гарсангүй. Ийм өрөвдөлт байдалд орсон ахмадууд цөөн боловч байсаар л байна. Энэ мэтчилэн эрх, эрх чөлөө нь хязгаарлагдмал байдалд орсоор байгаа өндөр настнуудаа дэмжиж туслахсан.

Бид үр хүүхдүүдээ хөндлөнгийн хүнээр асруулбал хөлс мөнгө төлдөг. Гэтэл аав, ээжийгээ бол асрах ёстой мэт албадах шахам харуулдаг. Өвдөж, ядарсан үед нь эм тариагаар хуурчихаад ганцаардаж гомдож явааг нь ер анзаардагсан билүү! Хөгшин хүн, хүүхэд хоёр өчүүхэн зүйлд л баярлагдгийг мэдсээр хэр нь насан өндөр ижий, ааваа баярлуулахаасаа гомдоох нь их юм уу даа!

1. 36 ДААТГАЛГҮЙ, МӨНГӨГҮЙ ХҮМҮҮСТ ЭМНЭЛЭГ ДААНЧ ХОЛ...

Д. Цээпилмаа.

Улаанбаатар таймс, 2003. 2-р сар, №26

... Өвдсөн үедээ эмнэлгийн тусламж авах эрхтэй... /Хүний Эрхийн түгээмэл тунхаглал 22-р зүйл./

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй./Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 6 дахь хэсэг/.

Нийслэл хотод 112 өрхийн эмнэлэг “Нөхөрлөл” хэлбэрээр бие даасан аж ахуй нэгж болон ажиллаж, тэдгээрт 478 их эмч, 452 сувилагч ажилладаг. Түүнчлэн дүүрэг бүрт ор бүхий эмнэлэг байхын сацуу улсын чанартай клиник эмнэлэг нийслэлд гурав бий. Дээр нь хувийн хэвшлийн 853 эмнэлэг иргэдэд үйлчилдгээс 64 нь ор бүхий эмнэлэг юм. Манай улсын эм хангамжийн байгууллагын 80 хувь нь нийслэлд төвлөрдөг.

Эдгээр тоо баримтаас үзвэл нийслэлийн 821.8 мянган хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж хангалттай мэт санагдана. Гэвч нийслэлчүүд маань эмнэлгийн үйлчилгээ, тусламжид төдийлэн сэтгэл хангалуун байдаггүйг судалгаанаас харж болно.

Нийслэл дэхь “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” төслийн нэгжээс иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн төлөв байдлыг шалгаж судалжээ. Тус төслийн нэгжийн мэргэжилтэн М. Баянжаргалаас доорх мэдээллийг авлаа. Судалгаанд оролцогчдоос эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж буй эсэхийг тодруулахад ихэнх нь буюу 57 хувь нь тийм гэсэн хариулт өгсөн нь боломжийн үзүүлэлт юм. Эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийн 54.4 хувь нь эмнэлэгт хэвтэж үйлчлүүлсэн бол 45.6 хувь нь гэрээрээ эмчлүүлсэн байна.

Эмнэлгийн үйлчилгээг гэрийн нөхцөлд хийлгэх нь эрсдэл ихтэй байдаг. Гэтэл тал шахам хувь нь гэртээ эмчлүүлсэн нь эмнэлэгт орны хүрэлцээ муу байдагтай холбоотой юм.

Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүмүүсээс “Таныг эмнэлгээр үйлчлүүлэхэд ямар хүндрэл гарсан бэ?” гэсэн асуултад дараах хүндрэлийг тоочсон байна.

Эмнэлэгт хэвтэгсдийн тоо их байдгаас хүлээлт ихтэй, хүнд суртал, шат дараалсан чирэгдэлтэй /клиник эмнэлэг гэхэд заавал өрхийн эмчид үзүүлсэн байхыг шаарддаг гэх мэт/, эм тариаг өвчтөний ар гэрээс авчруулдаг, эмч нарын мэдлэг боловсрол, харьцааны соёл дутмаг, шинжилгээг олон салангид газар авдаг, даатгалгүй бол үздэггүй зэрэг хүндрэл

өвчтөнд түгээмэл тохиолддог байх юм. Түүнчлэн эмчийн хүрэлцээ муу, эмнэлгийн байршил оновчгүй, эмнэлгийн тоног төхөөрөмж шаардлага хангадаггүй гэсэн гомдол мэдүүлсэн хүн ч байлаа.

Хамгийн элбэг байдаг бэрхшээл бол ор хүлээлт. Тиймээс эмнэлэгт хэвтэхийн өмнө хэд хоног хүлээснийг нь дүүрэг тус бүрээр тодорхой судалж үзжээ. Эмнэлэгт хэвтэхийн тулд долоо хоног хүлээсэн 149, 8-15 хоног хүлээсэн 47, 16-20 хоног хүлээсэн 13, 21 ба түүнээс дээш хоног хүлээсэн гэж 12 хүн хариулжээ. Дүүргүүдийн хувьд Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргийн эмнэлгүүд хүлээлт ихтэй байдаг юм байна. Мөн 36-р маягтгүйгээс, шинжилгээний хариу хүлээгдсэнээс, танил талгүйгээс эмнэлэгт хэвтэх гэж удаан хүлээдэг байна.

Эмчилгээнд хувиасаа зарцуулсан мөнгөний хэмжээ харилцан адилгүй байна. Ихэвчлэн 10 хүртэлх мянган төгрөг зарсан бол 11-ээс 20 мянгыг 39, 21-30 мянгыг 12, 31-ээс дээш мянган төгрөгийг эм тарианд зориулсан гэсэн 9 хүн байжээ. Харин огт мөнгө зараагүй гэж ердөө 6 хүн хариулсан байна. Түүнчлэн хугацаанд баригдаад эдгээгүй байхад нь эмнэлгээс гаргадаг, эмчилгээг цагт нь хийдэггүй, эмч, сувилагч нарын харьцаа муу, “гар хардаг”, эмнэлэгт хөнгөн өвчтөн, сахиурууд архиддаг зэрэг шалтгаанаас болж өвчтнүүд эмнэлгээс сэтгэл дундуур буцдаг ажээ.

Эмнэлгийн хоол гэж төсвийн хөрөнгөнөөс чамгүй “хумсалдаг” зүйл бий. Гэтэл эмчлүүлэгчид хоолны чанарыг дундаас доош гэж үнэлсэн байх юм. Эмнэлэгт хэвтээд гэрээсээ хоол зөөлгөдөггүй хүн тун цөөхөн. Тэр хэрээр эмнэлгийн хоолны зардал буурч байх учиртай. Орны хэрэглэлийн тухайд ч ялгаагүй. Хэвтэж эмчлүүлэгчдийн 71 хувь нь гэрээсээ ор хөнжлийн даавуу авчирч хэрэглэсэн гэж хариулсан байна. Дээр өгүүлсэн эм тарианы зардлыг ч өвчтөнд эргүүлж олгох заалт бий. Гэвч амьдралд хэрэгждэггүй нь тун харамсалтай.

Эмнэлэгт хэвтэж, эмнэлгээр үйлчлүүлдэггүй хүмүүс дээрх зовлонг тэр бүр мэдэрдэггүй. Хэлж бус хийсч ирдэг зовлонгийн нэг нь өвчин билээ. Гэнэт өвдөөд эмнэлэгт хүргүүлэхэд хамгийн түрүүн эрүүл мэндийн даатгалын дэвтэр шаарддаг. Ажил албатай хүмүүсийн хувьд ЭМД-ын дэвтэр тэр бүр гар дээр нь байдаггүй. Зарим нэг байгууллага, аж ахуй нэгж даатгалын газарт өртэйгээс дэвтрийг нь бөглөөгүй байх нь ч энүүхэнд. Эрхэлсэн ажилгүй, тодорхой орлогогүй хүмүүсийн олонх нь ЭМД-ын дэвтэргүй байдаг. Эмч сувилагч нар энэ байдлыг үл ойшоон гагцхүү дэвтэртэй эсэхээр бүгдийг шийдэх нь гачлантай. Энэ нь өвдсөндөө шаналж, аврал эрэн очсон хүмүүст “даатгалгүй бол эрлэгт оч” гэсэнтэй адил сонсогддог. Тохойн чинээхэн нярай хүүхдэд хүртэл хатуурхан, харанхуй шөнөөр буцаан хөөх нь ч бий. Эмнэлгийн босго болсон “Хүлээн авах тасаг”-ийн дүр төрхийг зурвал ийм буюу.

Хүлээн авснаас хойшхи байдал өвчтнүүдийн судалгаанаас аяндаа дүрслэгдэж буй бизээ. Ийм нөхцөлд бид эрүүл мэндээ хамгаалуулах эрхээр бүрэн хангагдсан гэхэд бэрх юм. Зарим өвчтөн эмнэлэгт буцалгасан ус байнга байлгах, ариун цэврийг сайжруулах, төрөх тасгийн эмч, эх баригчдыг амаржиж буй эхчүүдтэй зөв харицдаг болгох, өвчтнийг баян ядуу гэж ялгалгүй харьцах гэсэн жижиг боловч анхаарууштай саналыг хэлжээ. Аль ч эмнэлэгт өгүүлэгддэг нэг зүйл бол тахир дутуу иргэнд зориулсан үйлчилгээ юм. Адаглаад бие засах өрөө нь өндөр босготой учир тэргэнцэртэй хүмүүс орох боломж байдаггүй. Угаалгын цорго, ор гээд тахир дутуу хүмүүст тохирох зүйл нэгээхэн ч үгүйгээс тэд асран хамгаалагчтай эмнэлэгт хэвтэхэд хүрдэг. Ядаж ганц өрөөг ч болов тэдэнд зориулан тохижуулахад болохгүй нь юу билээ. Энэ мэт эмнэлэг, эмнэлгийн үйлчилгээг тойрсон олон асуудлыг сөхөн харж, залж залруулах хэрэгтэй байна. Дутагдал доголдол бүхний цаана хүний эрх ноцтой хөндөгдсөөр байгааг анхаарууштай юм.

Хэсэг 2. Английн Хүүхдийг Ивээх Сан, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илчилж, хүчирхийллийг зогсооё” төслийн хүрээнд сонинуудад хэвлэгдсэн нийтлэлүүд

2.1. СУРГУУЛЬ БАЯР БАЯСГАЛАНГИЙН ГАЗАР Л БАЙХ ЁСТОЙ.

А.Баасандорж

Өнөөдөр, 2002.12.13

Тийм биш гэж үү хэмээн хэн нэг нь бас асуух байх л даа. Сургуульдаа явахгүй гэж зүтгэдэг, зарим багшийн нэрийг дуулахаараа айн чичирдэг хүүхэд зөндөө олон байна цаана чинь. Сурган хүмүүжүүлэх ухааны наад захын мэдлэггүй, энэ муу хүүхэд юу мэддэг юм гэсэн үл тоомсорлосон ихэрхэг зангаар хүүхдүүдэд ханддаг дарангуйлагч багш нар сургуулийг баяр баясгалангийн бус уйтгар гунигийн, айдас хүйдсийн газар болгон хувиргадаг байна. Багш болгоныг би дарангуйлагч, сургууль бүхнийг би айдсын газар гэж хэлэх гээгүй ч бас өгүүллийнхээ эхэнд онцлон хэлмээр байна.

Нэгэн зүйл: Манай ангийн багш сургууль дөнгөж төгсч ирсэн залуухан эмэгтэй байдаг. Тэгсэн хэрнээ хүүхдүүдийг баян ядуугаар нь, өнгө үзэмжээр нь ялгаварлан үздэг. Амьдралын бололцоо муутай, сурлагаар тааруу хүүхдүүдийг ад үзэж, ямар нэгэн шалтгаанаар өөр сургууль руу шилжихийг шаарддаг. Намайг л гэхэд байнга ад үзэн, нэг удаа сургуулиас тавьж өгсөн сурах бичгүүдийг хураан авч өөр хүүхдэд өгсөн. Ангийн засварт хэрэглэх 4500 төгрөгийг би хугацаанаас нь долоо хоног хожимдуулж өгсөн юм. Аав, ээжийн цалин буухгүй, амьдралын аргагүй байдлаас л болсон хэрэг л дээ. Түүнээс хойш л надтай ийм маягаар харьцдаг болсон юм. Би энэ ангид долоон жил суралцаж байна. Дасч ижилдсэн анд найз нар, анги сургуулиасаа ганц энэ багшаас болоод явмааргүй байна шүү дээ. (15 настай охины яриа)

Нэгэн зүйл: Наймдугаар ангид байсан үе. Би багаасаа алгебрийн хичээлдээ жаахан тааруу. Нэгэн удаа гэрийн даалгаварт өгсөн тоог өөрөө нухсаар байгаад зөв хариуг нь гаргачихлаа. Үүндээ би их ч баярлалаа. Маргааш нь багшийг даалгавраа шалгаж, самбарт хэн гарах вэ гэхэд би гар өргөөд бодсоноо үзүүллээ. Гэтэл багш “чи хэнээс хуулсан бэ?” гэж асуусан. Түүнээс хойш би нэг ч удаа өөрөө тооны хичээл хийхээ больсон бөгөөд бусдаас шууд л хуулчихдаг болсон. Тэгээд л алтан гурваа авдаг байлаа. (16 настай хүүгийн яриа)

Нэгэн зүйл: Би дөрөвдүгээр ангид байхдаа хичээлийн дундуур мухар олгойн хагалгаа хийлгэж эмнэлэгт хэвтсэн юм. Арваад хоногийн дараа хичээлдээ орохдоо би нилээд олон хичээлээс хоцорсон байлаа. Тэгээд монгол хэлний хичээл дээр мэдэхгүй зүйлээ арынхаа хүүхдээс асууж байтал А багш, “чи хичээл тасалж, тасалж ирчихээд юу ярьж хүүхэд үмүүлээд байгаа юм” гээд намайг ширээнээс татаж босгож ирээд ар нуруу уруу цохьж, хөл рүү хөшиглөсөн. Тэр үед би оёдолтой гэдсээ л хамгаалж, хагалгаа задарчих вий дээ гэж их айж байлаа. Харин азаар тийм азгүй явдал болоогүй. Гэртээ ирээд аав, ээждээ хэлэхэд тэд багштай уулзсан. Түүнээс хойш надад бүр муу болсон. Одоо бид хоёр хонь, чоно. (12 настай хүүгийн яриа)

Нэгэн зүйл: Манай ангийн багш Д гэдэг эмэгтэй маш ууртай. Тавьсан шаардлагыг нь биелүүлэхгүй л бол яахаас ч буцдаггүй. Доромжилж зодох бол энүүхэнд. Жинс өмслөө гээд миний өмдийг ангийн бүх хүүхдүүдийн нүдэн дээр тайлахыг оролдсон. Би чинь эмэгтэй хүүхэд шүү дээ. Хөвгүүдийнхийг бол шууд тайлдаг. Одоо манай ангийн хөвгүүд, багшийн ингэж аашлахаас айгаад бүгд бэлтгэлтэй болж, өмдөн дотуураа байнга шорт өмсдөг болсон гэж ярьцгаадаг. (13 настай охины яриа)

Нэгэн зүйл: Ц багш манай ангид бараг хичээл заадаггүй. Заагаагүй хичээлээрээ сүүлд нь шалгалт авч дүн гаргах нь олонтаа. Хүүхдүүдийг дүгнэхдээ царай зүс, хувцас эдлэлийг нь их харна. Жилийн өмнө шалгалтаа надтай яг ижилхэн алдаагүй өгсөн чинээлэг айлын хүүхдийг онц гаргаж, надад сайн тавьсан. Би үнэхээр их гомдсон. Ингэж ялгаварлаж үзэж болохгүй биз дээ. (9 настай хүүгийн яриа)

Нэгэн зүйлийг энэ мэтээр нилээд их үргэлжлүүлж болно. Гэвч ингээд азная. Уг нь багш нар хүүхдүүдийн дотны анд нөхөр нь байх ёстой. Харамсалтай нь тийм биш байх нь олонтаа. Үүнийгээ ч багш нар өөрсдөө хүлээн зөвшөөрч байна гээд бод л доо.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс 2001 онд явуулсан судалгаанд хамрагдсан 50 багшийн 38 хувь нь сурагчдаа зодож, дарангуйлдаа хүлээн зөвшөөрчээ. Мөн тэдний 60 орчим хувь нь хүүхдүүд сургууль дээр бусдын дарамтад ямар нэгэн байдлаар өртдөг хэмээн хариулцгаасан байна. Гэртээ тав тухгүй, байнгын дарамтанд байдаг хүүхдүүд олон байдаг тухай бид өмнөх өгүүлэлдээ тодорхой өгүүлсэн. Гэтэл тэд маань сургууль дээрээ ирээд хэн нэг багшийн харцан доор айж бэмбэгнэн суух нь мөн хэцүүеэ. Багшийн дарамт үнэхээр их байдаг нь дээрх судалгаанаас тод томруун харагдаж байгаа. Тавьхан багшийн 20 орчим хувь нь хүүхэд зодогоо

өөрсдөө хүлээсэн байна гээд л бодохоор тэр шүү дээ. Тийм үйлдлээ өөрөө илчлэхгүй, худлаа хариулаад өнгөрсөн багш цаана нь хичнээн үлдсэнийг хэн мэдэх билээ дээ.

Сургууль дээр зөвхөн багшийн дарамт байдаг гэвэл бас худлаа. Үе тэнгийнхний, ахмад хүүхдүүдийн айлган сүрдүүлэг, хүчирхийлэл гэж бас нэг аймшиг бий. Энэ үйлдэл бүр их газар авсан байна. Үүнийг би цээжний бангаар хэлэхгүй байна л даа. Дээр дурьдсан судалгааны дүнгээс үзэхэд хүүхдүүд үе тэнгийнхнийхээ дарамтад хамгийн их өртдөг гэж хариулсан байгаа юм. Өөрөөр хэлбэл янз бүрийн дарамтыг 100 хувь гэж үзвэл 26.8 хувийг нь ийм дарамт эзэлдэг байна. 14.3 хувийг нь төрөл садангийн, 14 хувийг багшийн дарамт, хүчирхийлэл эзэлж байх жишээтэй.

Ерөөс хүүхдүүдийн 34.4 хувь нь ахлах ангийн хүүхдийн, 20 хувь нь багш нарын, мөн 20 хувь нь ангийн хүүхдийн дарамтад өртдөг гэж багш нар хариулжээ. Мөн тэнэмэл хүүхдүүдийн, ойр орчны таньдаг болон танихгүй хүүхдүүдийн дарамтанд орох явдал байдаг гэж тэд хариулсан байгаа юм даа.

Хүүхдийн эрхийн конвенцид хүүхэд бүр үнэ төлбөргүй боловсрол эзэмших эрхтэй гэдгийг тунхагласан байдаг. Тэд энэ эрхээ эдлэхийн тулд сургууль соёлын газрыг зорих нь дамжиггүй. Харин тэднийг ирэхэд тайван амгалан, сэтгэл өөдрөг байлгаж, авъяас билэг, бие бялдрыг нь хөгжүүлэх, бүхий л боломжийг олгож байх орчныг нь сайн бүрдүүлэхсэн. Үүний төлөө хүн бүрийн, тэр тусмаа багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүчин зүтгэл асар их хэрэгтэй билээ. Сургууль зөвхөн баяр баясгалангийн л газар байх ёстой гэдгийг өгүүллийнхээ эцэст дахин нэг дурдсу.

2.2. СУРАГЧДЫНХАА ТАЛ ХУВИЙГ ЦАГААН ХУУДАСТАЙ ТӨГСГӨСӨН БАГШИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА БАЙХГҮЙ ГЭЖ ҮҮ?

Д. Цээпилмаа

Хүрээ & хэмнэл 2002.№02 /798/

Одоогоос олон жилийн өмнө юм даг. Бид долдугаар ангид сурч байхдаа ангийн багшаа голгүй гомдоон уйлуулж билээ. Уг нь багшаа биш жижүүрээ буруутгасан аястай захидал бичиж санал хүсэлтийн хайрцагт хийсэн юм. Гэтэл хэрэг бишдэж хөөрхий багш маань буруутан болчихсон байсан. Багш нэг хэсэгтээ бидэнд гомдож, бид багшаа баярлуулах гэж элдвээр хичээж байснаа ер мартдаггүй юм. Бас нэгэн явдлыг эргэн саналаа. Геометрийн багшийнхаа хагас сайн өдөр заасан томъёог нэг дэх өдөр нь нэг ч сурагч санасангүй. Ангийн гучин таван сурагч, тэр дундаа тоонд гайгүй хэдээс нь лавлахад мэдэх хүүхэд байгаагүй болохоор барагтайд хямардаггүй багшийн маань хоолой зангирч байсансан. Харин хожим нь тэр томъёог бид хэзээ ч мартахааргүй цээжилсэн. Одоо хэр нь " $L=2P/R$ " гэсэн тойргийн уртыг олдог томъёо цээжинд байдаг юм. Энд чухам юуг өгүүлэх гээд байгааг уншигч та гайхаж байна уу? Сургуулийн тухай, багш сурагчийн харилцааны талаар цаашлаад сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай хөндөн бичихийг хичээлээ.

Ялгаварлан гадуурхагдсан хүүхдүүд

Сургууль бол харилцааны орчин. Дээр өгүүлсэнчлэн багшаа гомдоох, багшдаа гомдох, сурагчид нь өөр хоорондоо шөргөөцөлдөх гэхчилэн харилцааны зөрчил бараг л өдөр тутам тохиолддог. Энэхүү жижиг зөрчил нь гүнзгийрвэл хүчирхийллийн нэг хэлбэр болдог төдийгүй хүүхдийн сурлага, хүмүүжилд муугаар нөлөөлдгийг харин хэн ч анзаардаггүй нь харамсалтай.

"Сүүлийн жилүүдэд хүүхдийн сурлагын амжилт, чанарын түвшин эрс доошилжээ. Ихэнх сургуулиудад дээрх үзүүлэлт 50 хувьд хүрэхгүй байгаа нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн, эцэг эхчүүдийн цаашлаад төр засгийн анхаарлыг татахгүй байхын аргагүйд хүрсэн" гэж БСШУЯ-ны Бага дунд боловсролын бодлого зохицуулалтын газрын дэргэдэх сургуулийн нийгмийн ажилтны нэгжийн мэргэжилтэн Б. Цэрэнлхам сэтгэл зовнин өгүүлсэн юм.

Хүүхэд ямар нэгэн асуудалтай байж гэмээнэ сэтгэл санаа тайван байж, өөдрөг сэтгэлтэйгээр сурч, боловсорч чаддаггүй байна. Ялангуяа сургууль дээрээ ямар нэгэн дарамт шахалттай учирдаг бол хүүхэд сурах нь бүү хэл хичээлдээ явахаас ч дургүйлэхэд хүрдэг ажээ.

Мэргэжилтнүүдийн судалгаа үүнийг нотолно. Нийслэлийн зургаан дүүргийн 19 сургуулийн 3408 хүүхдийн дунд "Сургуульд хүчирхийллийн хэлбэрүүд байдаг уу" сэдвийн дор судалгаа явуулжээ. 1792 хүүхэд буюу судалгаанд оролцогчдын 43.1 хувь нь багш нар хүүхдийг ялгаварлаж харьцдаг гэж хариулжээ. Багш нар сурагчдаа сурлага, сахилга, өмссөн хувцас, өнгө үзэмж, царай зүс, амьдралын боломж боллоцоогоор нь ялган ангилж, өөр өөрөөр харьцдаг үзэгдэл хотын төв, гэр хороолол, захын сургуулиудын аль алинд нь амь бөхтэй оршсоор байна. Дээрх хүүхдүүдийн 717 нь багшдаа хэл амаар доромжлуулдаг, 1020 нь үргэлж загнуулдаг байх юм. Тэглээ гээд хүүхдүүд багшдаа гомдоод өсөрхөөд байдаггүй гэнэн цагаахан амьтад гэдэг нь судалгаанаас бас харагджээ. Судалгаанд оролцогч 1032 хүүхэд багш шаардлага тавьх нь зүйтэй гэж хариулсан төдийгүй багшийгаа "өндөр, мэргэжил, өргөн мэдлэгтэй, биеэ сайхан авч явдаг" гэж тодорхойлсон байна.

Хүүхдийн хандлага ийнхүү ямагт багш руугаа тэмүүлж зан сайтай багш нараа, ялангуяа ангийн багшаа бусдаас илүү хайрладгийг Б. Цэрэнлхам олон жилийн туршлагаараа баталж байгаа юм. Гэтэл ганц нэг багшийн зан авираас болж хүүхдүүд доорх зүйлсийг өгүүлэхэд хүрч байна.

15 настай. С. (7 дугаар ангийн сурагч)

- Манай ангийн багшийг Д гэдэг. Багш маань эмэгтэй хүн мөртлөө маш ууртай. Тавьсан шаардлагыг нь биелүүлэхгүй л бол яахаас ч буцдаггүй. Доромжилж зодох бол энүүхэнд... Жинсэн өмд өмссөний төлөө миний өмдийг ангийн бүх хүүхдүүдийн нүдэн дээр тайлахыг оролдсон.

13 настай М. (6 дугаар ангид сурдаг)

- Зарим үед “Ц” багш заагаагүй хичээлээрээ шалгалт шүүлэг авч дүн гаргадаг. Тэр багш манай ангийнхны болон миний эрхийг боогдуулж байна.

10 настай Г. (4 дүгээр анги)

- Бид зааланд тоглож, давтлага авмаар байна. Давтлага өгөөгүй байж муу гаргадаг. Мөн төлбөргүй дугуйлантай болоосой.

Энэ мэт багшдаа гомдсон хүүхдийн өгүүллийг жагсаавал тоймгүй олон бий. Урмыг нь хугалахаар ууцыг нь хугал гэсэн мэргэн өвгөдийн сургааль ч бий. Алгебрийн багш нь хүүгийн хичээл зүтгэлийг үнэлээгүйгээс 10 дугаар ангиа төгсгөж чадалгүй ачигч болсон залуу насан туршдаа гомдлоо тээж яваа жишээ ч байна. Саяхан багш нараас асуулга явуулахад “багш байгаа учраас сургууль байгаа” мэт сэтгэгдэл төрүүлэхүйц хариулт өгчээ. Гэтэл үнэн хэрэг дээрээ “хүүхэд байгаа учраас сургууль байж, сургуульд багш ажиллаж цалин авч байгаа юм”. Нийгэмд эрдэмтэй чадалтай хүн хэрэгтэй. Тэднийг сургаж хүмүүжүүлэх, бүр гэгээрүүлэх үүрэг багш нарт ногддог гэсэн мэргэжилтний үг нэгийг бодуулна.

2001-2002 оны хичээлийн жилд Говьсүмбэр аймгийн 10 жилийн сургуулийг 228 хүүхэд төгссөнөөс 55.3 хувь нь “Цагаан хуудас”-тай төгсчээ. Энэ бол туйлын хангалтгүй үзүүлэлт. Гэтэл тэдгээр хүүхдийг сургах үүрэг хүлээсэн багш нар цалингаа авдагаараа авч, хийдгээ хийчихсэн улс шиг харц дээгүүр явцгаасан хэвээр. Үүргээ ухамсарлаагүй, биелүүлээгүй багш, сургуульд хүлээх хариуцлага баймаар. Хөөрхий хүүхдүүд л хохироод үлддэг жаягийг халах цаг болсон мэт санагдана.

Багш хүний ёс зүйд үл нийцэх авир араншин, байр байдал үзүүлсний учир 238 хүүхэд багштайгаа байнга зөрчилддөг, 1645 хүүхэд хаяа зөрчилддөг бол 1588 хүүхэд хүлцэнгүй хүлээн авдаг гэж хариулжээ. Хүүхэд хувь хүн болон төлөвшихэд хамгийн их нөлөөлдөг сургуулийн орчин ийм л байна.

“Ноёнтой тэрсэлбэл толгойгүй”-н үлгэрээр хүүхэд аливаад хүлцэнгүй байх, хүчирхийллийг ердийн зүйл мэт хүлээн авч, нийгэмд өөрийн гэсэн байр суурь эзэлж чадахгүй сул дорой нэгэн болохын эхлэл сургуулийн орчинд тавигдаад байх шиг. Багштайгаа маргаж, үзэл бодолдоо үнэнч байсан цөөн хэдэн хүүхдийг “ангийн дайсан мэт үзэх” үзэл сургуульд байсаар байна.

“Хочгүй хүүхэд”-ийн эрэлд

Үе тэнгийнхний дундах хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэр нь хочлох, шоолох явдал. Биднээс өмнө, бидний үед болоод өнөөдөр ч хочгүй хүүхэд олох нь өвснөөс зүй хайхын адил юм. Хочилж, шоолох нь харилцааны гажиг төдийгүй хүчирхийлэл гэдгийг хэн ч анзаардаггүй.

Хочлуулсаар байгаад аав, ээжийн хайрласан нэрээр биш элдэв хочоороо нэршчихсэн хүн ч олон байдаг ч хүний сул тал, гажиг согоогоор нь дуудах нь тухайн хүнд таагүй сэтгэгдэл төрүүлж, өөрийгөө бусдаас дорд үзэхэд хүргэдэг муу талтай. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гуравны нэг нь буюу 1361 хүүхэд хочлох, шоолох нь хүчирхийлэл гэж үзжээ. Мөн ахлах ангийнхан болон биеэр том хүүхдүүд мөнгө нэхэх, хувцсаа өгөхийг шаардах зэргээр дарамталдаг гэж хариулсан байх юм.

2.3. ҮГЛЭЖ ЗЭМЛЭХ НЬ ХҮҮХДЭД ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛДГИЙГ ТА МЭДЭХ ҮҮ?

Д. Цээпилмаа

Хүрээ & хэмнэл 2002.№146 /786/

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл. Энэ үгийг сонсоод хүмүүс цочрохоо хэдий нь больжээ. Гудамж талбайд санал солилцсон хүн бүр л ам уралдан ярихаас үзэхэд “хүүхдийн эсрэг хүчирхийлэл”-ийн талаарх ойлголт нилээд түгээмэл болжээ гэж үзэж болох юм. Тэдгээр хүмүүс:

- Ядуу дутмаг амьдралтай, архичин эцэг эхчүүд үр хүүхдээ хүчирхийлдэг
- Монголын уламжлалт зан үйл болох өдөржин хонь хариулах, хурдны морь унах зэрэг нь хүчирхийллийн нэг хэлбэр
- Багш нар сурагчдаа дарамтлах, хөрөнгө бэлээр ялгаварлах нь хүчирхийлэл

гэхчилэн өгүүлж байлаа.

Эндээс нэг зүйлийг анзаарч байна уу? Надтай ярилцагчдаас хэн нь ч би хүүхдээ загнаж зоддог, энэ бол хүчирхийлэл гэж хариулсангүй. Хүүхдийг загнаж зодох нь хүчирхийлэл мөн үү? Хэрэв мөн бол энэ үйлдлээс ангид эцэг, эх тун ховор. Тиймээс бүх аав, ээж хүчирхийлэгч үү? Энэ тухай цөмөөрөө хэлэлцье. Юун түрүүн хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж чухам юуг хэлээд байгааг мэргэжилтнүүдээс тодрууллаа.

Өөрийн хүч чадал, эрх мэдэл, давуу талаа ашиглан хүүхдийг эрхшээлдээ байлгах гэсэн хүүхдийн эрхийг зөрчсөн албадлагын шинжтэй аливаа үйлдлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг байна. Энэ тодорхойлолтод бидний хүүхдээ хүмүүжүүлэхдээ түгээмэл хэрэглэдэг аргууд ч багтаж байгааг судалгааны дүнгээс харж болно. Зэмлэх, үглэж загнах, зодох, ажил хийлгэх, гар өргөж зогсоох, хэрэгцээгээр нь гачигдуулах найзуудтайгаа уулзах болон утсаар ярихыг нь хориглох зэргээр аав ээж хүчирхийлдэг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүд хариулжээ. Уншигч та дээр дурдсан үйлдлээс аль нэгийг нь хүүхдээрээ хийлгэж байгаагүй гэж үү? Тэрхүү үйлдлээ та мэдээж хүчирхийлэл гэж огт бодоогүй биз дээ. Тэгвэл яг энэ асуудалд та бүхний анхаарлыг хандуулах гэсэн юм. Бидний хэн маань ч огт анзаарахгүйгээр хүчирхийлэл үйлдэж, хүчирхийлэгч болж явдаг байна. Хүүхдээ алдаа гаргасны нь төлөө, эсвэл өөрийнхөө санаснаар байлгах гэсэндээ, үр хүүхдээ бусдын хүүхдийн адил байлгах гэж, сайн хүн болоосой гэхдээ бид зэмлэдэг, загнадаг гэж томчууд бид биеэ өмгөөлдөг. Зарим маань бид тэгж л өссөн, тэглээ гээд муу хүн болоогүй гэж зөвтгөх нь бий. Би ч тэдний л нэг. Тиймээс ярилцаж суусан мэргэжилтнийхээ өмнөөс “аавдаа шавхуурдуулчихаар хэд хоногтоо л хөл хөнгөн, сэтгэл сэргэлэн явдаг шүү дээ” гээд адраатхав.

- Аав, ээждээ зэмлүүлж, зодуулсан хүүхэд хэсэгтээ дуулгавартай болдог нь үнэн. Гэвч энэ бол хүний амьтанлаг шинжийн илрэл юм. Амьтан ч ялгаагүй яг энэ үйлдлийг хийдэг. Хүн бие махбодын зовиурыг төрөлхийн рефлексээр мэдэрч, дахин гуядуулахгүйн тулд сэргэг байдаг. Түүнээс биш ухамсарлан ойлгосон хэрэг огт биш юм гэлээ. Тэгэхээр эртнээс нааш хэлэлцэж заншсан “Алгадуулах аавтай байх сайхан”, “Хүүхэд эцэг, эхдээ зодуулж гэмээнэ барцад нь арилдаг”, “Хүүхэд загнуулж, зодуулж хүн болдог” зэрэг үгсийг, тэдгээр ойлголтыг таягдан хаях цаг нэгэнт болжээ.

Монголчуудын эцэг, өвгөдөөсөө өвлөсөн уламжлалт хандлага үеэс үед улирсаар ирсэн учир томчууд бид “Хүүхдийн эрх”, “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэдэг үгэнд дасаагүй, тэр тухай өөртөө хамаатуулж бодох тун ч дургүй байдаг байна.

Ингэхэд чухам яагаад эцэг эхчүүд хайртай бяцхан үрсээ дарамталж, хүчинд автуулаад байна вэ? Судалгаанд оролцогч томчууд уур хүрсэн үедээ, согтуудаа, буруу хэрэг хийвэл, хичээл таслахад, үгэнд орохгүй бол шийтгэхэд хүрдэг гэжээ. Эндээс хүүхэд буруу хэрэг хийвэл шийтгэх ёстой юу? Шийтгэл хүчирхийлэл хоёрт ялгаа байна уу? гэсэн асуулт урган гарах нь мэдээж.

Хүчирхийлэл, шийтгэл хоёрын ялгааны хувьд эцэг эхчүүдийн 82,2 хувь, багш сурган хүмүүжүүлэгчдийн 92 хувь нь ялгаатай гэсэн хариултыг өгчээ. Гэтэл эцэг, эхчүүдийн 60.7 хувь нь, багш нарын 67 хувь нь хүүхэд байхдаа буруу хэрэг хийснийхээ төлөө зэмлэл, шийтгэл хүлээдэг байсан байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс явуулсан судалгаанд оролцогч хүүхэд, багш, эцэг эхийн аль аль нь, тэр дундаа хүүхдүүдийн 57 хувь нь буруу үйлдэл хийснийх нь төлөө хүүхдэд шийтгэл оногдуулах нь зөв гэж үзжээ.

Харин бодууштай, нэг мөр ойлголтод хүрэх шаардлага зайлшгүй тулгарч буй нэгэн зүйл ажиглагдлаа. Энэ бол хүчирхийлэл шийтгэл хоёрын ялгаа юм. Судалгаанд тусгасан “Хүчирхийлэлд өртөж буй (байсан) хэлбэрүүд”, “Буруу хэрэг хийвэл ямар шийтгэл хүлээдэг вэ?” гэсэн хоёр асуултад хүмүүс яг адилхан хариулт өгсөн байна. Эндээс хүүхэд буруу хэрэг үйлдвэл ухамсарлуулах үүднээс шийтгэх нь зөв, гэхдээ яаж гэсэн асуулт эрхгүй гарч байна.

Монголын үндэсний телевизээр амралтын өдрүүдэд Германы “Тэнгэрлэг нэгэн гэр бүл” гэсэн цуврал кино гараад удаагүй ч томчууд хүүхдүүд зэрэгцээд үзүүштэй киноны нэг болоод байгаа. Кинонд гарч буй гэр бүлд бидний л адил үргэлж “проблем” үүсдэг. Таван хүүхэд нь том жижиггүй л алдаа гаргадаг. Тэглээ гээд аав, ээж хоёр нь хүүхдүүдээ загнаж, зодохгүй байгаа биз дээ. Хүүхдийг загнаж, зодох үйлдлийг эцэг эхчүүд дур сонирхолтойдоо үйлддэггүй нь мэдээж.

Хүүхдээ хүмүүжүүлэх гэсэн тэр үйлдлийнхээ төлөө эцэг эхчүүд өөрсдөө ч давхар яллуулдаг. Хамгийн наад зах нь уурлаж бухаймдсандаа зүрх толгой нь өвдөж, бие нь тавгүйрдэг. Зодож буй нь ийм байхад зодуулсан хүүхэд ямар байх нь ойлгомжтой. Ингэж давхар давхар “шок”-нд оролгүйгээр асуудлыг шийдэх арга байгааг дээр өгүүлсэн киноноос харж болох билээ. Энэ нь гадаадынхныг дуурайх гэсэн хэрэг биш гэдгийг дурдах нь зүйтэй болов уу!?

Бидний үеийнхэн аав, ээждээ зэмлүүлж, зодуулж өссөн, мөн хүүхдээ зодож зэмлэдэг. Тэгвэл бидний хүүхдүүд яг л энэ замаар явах уу?!

Хүчирхийлэл дарамтад өссөн хүүхэд хүчирхийлэгч болдог гэсэнтэй та санал нийлэх үү гэдэг асуултад судалгаанд хамрагдагчдын 31.3 хувь нь тийм, 17.2 хувь нь магадгүй, үлдсэн 50 гаруй хувь нь үгүй, мэдэхгүй гэж хариулжээ. Эндээс хүчирхийлэл, дарамтад өссөн хүүхэд бүхэн хүчирхийлэл үйлдэгч болох учиргүй, хэдийгээр хүүхэд буруу зан үйлийг орчноосоо суралцдаг ч хүчирхийлэл үйлдэх эсэх нь сонголт юм гэдгийг эцэг, эхчүүд тодорхой хэмжээгээр мэдэрчээ гэж дүгнэж болох юм. Ер нь хүмүүжүүлэх гэж хүч хэрэглэснээс болж хүүхэд өөрийн биеийг хэн ч халдашгүй дархан байх эрхтэй гэдгийг мэдрэлгүй өсдөг. Тийм эрх бий гэдгийг огт мэддэггүй. Тийнхүү өөрийгөө хайрлаж дээдэлж сураагүй хүн бусдыг хайрлаж хүндэтгэх нь юу л бол. Жижигхэн жишээ татъя л даа.

Автобус унаа, гудамж талбайд та хөл дээр гишгүүлэх, түлхүүлэх зэрэг эвгүй үйлдэлд өртөж байсан уу? Хөл дээр чинь гишгэсэн хүн танаас уучлал гуйлгүй гүйгээд явчих нь ч энүүхэнд. Энэ мэт жижиг боловч хүний эрхэнд халдсан явдал олонтаа тохиолддог. Түүнийгээ огтхон ч анзаардаггүй нь бүр ч харамсалтай.

XVIII зууны эхээр Английн эрдэмтэн Жон Локка “хүн бүр хүн болж төрөхдөө л аливаа дарангуйллаас чөлөөтэй байх эрхтэй байдаг” гэж хэлсэн нь бий. Иймд бүгдээрээ аьд эрдэнэ болсон хүүдийнхээ энэ эрхийг хүндэтгэж, хайр энхрийллээ харамгүй зориулахсан.

Эцэг эхийн хайр гэдэг хүүхдэд юугаар ч сольшгүй эрхэм зүйл билээ. Хайр хэтэрхий ихдэнэ, дуусаад алга болчихно гэж хэзээ ч үгүй билээ. Тиймээс “хайр нь дотроо, хал нь гаднаа” гэх улигт үгийг мартаж байгалиас заяасан гайхамшигт мэдрэмж болох хайраа харамгүй илэрхийлж, үр хүүхдүүддээ түгээж байя. Бидний дотроо хадгалсан хайрыг хүүхдүүд маань нэвт харах биш дээ. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил төдийгүй гэмт хэрэг байдаг гэдгийг ойлгож өнөөдрөөс эхлэн хүүхдээ загнаж зодохоо, хүч хэрэглэн сүрдүүлэхээ боливол ямар вэ?!

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ажилтнууд бараг цөмөөрөө хүүхнүүд. Тэдний олонхи нэгээс гурван хүүхэдтэй ээж нар. Би тэднээс та бүхэн өөрсдөө хүүхдээ загнадаггүй юу гэж асуухад “бид бүхнийг өөрсдөөсөө эхлэхийг хичээж байна. Гэр бүлийнхэндээ ойлгуулж байгаа” гэсэн юм. Би ч гэсэн хичээнэ. Уншигч та ч хичээгээрэй.

2.4 ХААЛГА ТОГШИХ, ХОНХ ДУУГАРАХ БҮРИЙД ХҮҮХДҮҮД ОРОН ДООР НУУГДДАГ

Д. Цээпилмаа.

Хүрээ & хэмнэл 2002. №149 /789/

Олон улсын жишгээр 80 мянган хүн тутамд нэг байх шаардлагатай хамгаалах байр Монгол улсын 2 сая 500 мянган хүний дунд цор ганц байгаа нь даан ч чамлалттай юм. Эгэл жирийн иргэдэд бол тийм ч танил биш энэ байрыг зөвхөн хүчинд автсан эмэгтэйчүүд, хүүхдүүд зорин очдог. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд харъяалагддаг, тус төвийн санал санаачлагаар байгуулагдсан хамгаалах байрыг чухам хаана байрлагдгийг хүмүүс төдийлөн мэддэггүй ч тэр байрыг зорин очигсодын мөр огт тасардаггүй ажээ. Бид зориуд үдшийн цагаар хамгаалах байрыг зорьсон нь учиртай. Хүчинд автсан эмэгтэйчүүд голдуу үр хүүхдүүдээ дагуулан очдог бөгөөд зарим нь 1-3 хүүхэдтэйгээ байрлах нь бий. Хаалга тогших чимээнээр ээлжлэн ирж хэн болохыг лавлах авч хэн ч хаалга онгойлгосонгүй. Хамгаалах байрны ажилтны нэрийг хэлж байж арайхийн нэвтрэв. Тэнд эгээ л цэцэрлэг адил хүүхдүүд шуугин бужигнана. Нялх хүүхдээ хөхүүлэн суугаа ээж ч харагдана. Хүүхдүүд зарим нь хөшигний цаанаас, ганц хоёр нь орон доороос цухалцан биднийг харангуутаа тайвширсан бололтой алгуур гарч ирлээ. Том хүүхдүүд нь хөзөр тоглож харагдана. Хамгийн түрүүнд хамгаалах байрны ажилтан З. Цойнзонтой цөөн мөч хөөрөлдсөн юм. Би энэ байранд 8 дах жилдээ ажиллаж байна. Байгуулагдснаас хойш 900 гаруй эмэгтэй болон тэдний 2000 хүүхдүүдэд тусламж үзүүлж хамгаалсан. Гэр бүлийнхнийхээ хүчирхийлэл, дарамтанд өртөөд амь нас эрүүл мэндэд нь аюул заналхийлсэн мөчид аврал эрсэн бүсгүйчүүд манайд ханддаг юм. Хүүхнүүд маань 1-2 хүүхэдтэй, зарим нь 4-5 хүүхдээ дагуулаад ч ирэх нь бий. Өвлийн хүйтэнд гэрийн халаадтайгаа гүйж ирэх нь энүүхэнд. Хүүхдүүдийн хувьд маш их айдастай, цочролд орчихсон ирнэ. Хаалга тогших, хонх дуугарахад хүртэл давхийн цочих нь ямар ерөвдмөөр харагддаг гэхэв. Уг нь бид 14-өөс доош насны хүүхдийг хамгаалах байрандаа авдаг. Гэвч аргагүй байдлыг харгалзан бүр 18 настай ч авч байгаа. Бүр оюутан охид ч хүчирхийллээс зугатан ирсэн тохиолдол бий.

Амьдралын нөхцөл байдлын хувьд ямар хүмүүс голдуу хүчирхийлэлд өртөж байна вэ?

Амьдрал ахуйн байдал хүчирхийлэлд огт хамаагүй нь харагдаж байна. Ахуйн амьдрал нь хангалуун айлын эзэгтэй ч зодуулчихаад ирдэг. Гарын дүйтэй дархан, хөрөнгө мөнгөтэй бизнесмэн, удирдах ажилтай эрчүүд хүртэл эхнэр хүүхдээ дарамтлан зовоодог. Хичнээн боломжийн амьдралтай ч бүсгүйчүүд маань аюул заналаас зугатан гарахдаа гар хоосон гүйж ирдэг. Танай байранд эрчүүд ирж байв уу? Хүчирхийлэлд өртөөд ирсэн эрчүүд бараг үгүй дээ. Тэгээд ч бид эрчүүдийг хамгаалах байрандаа авдаггүй юм. Нийт хүчинд автагчдын 98 хувь нь эмэгтэйчүүд шүү дээ. Харин буруугаа ойлгон эхнэрээ, хүүдээ авах гэж ирсэн эрчүүд цөөнгүй. Харамсалтай нь тэд хэлсэндээ эс хүрч эхнэр нь манайд дахиад л тусламж гуйн ирдэг. Нэг хүнийг хэдий хэр хугацаагаар хамгаалдаг вэ? Эндээс явсан эмэгтэйчүүд хаана очдог м бол? Энд долоо хоногоос нэг сарын хугацаанд байрладаг. Энэ хугацаа нь тун богино гэдэг нь ойлгомжтой. Гэвч олон хоног сараар хүчирхийлэлд өртөж бие сэтгэлийн хүнд дарамт авсан хүүхэд, эмэгтэйчүүд тайвширч тайтгаран хүч сэлбэдэг ч асуудлаа шийдвэрлүүлж чаддаггүй. Гэр бүлээ цуцлуулах өргөдөл өглөө ч шүүх шийдвэрлэж амждаггүй. Тиймээс хөөрхийс эргээд хүчирхийллийн орчиндоо очдог. Тэр даруйдаа биш ч хүчирхийлэл дахин давтагдах талтай. Тэгэхээр хамгаалах байрыг олшруулж нэгдсэн сүлжээтэй болгох зайлшгүй шаардлагатай. Хүмүүс танай хамгаалах байрыг мэдэхгүй юм. Нууцлах шалтгаан байдаг юм уу? Нууцлалгүй яахав. Эхнэр хүүхдээ энд байгааг мэдчихвэл нөхөр нь амар тайван байлдаггүй. Шөнөжин нэрийг нь дуудаад зогсчих жишээтэй. Харин энд агсан согтуу тавьж чаддаггүй. Цагдаагаас илүү биднээс эмээдэг нь цөөнгүй. Манай байр маш нууцлаг байх ёстой. Тиймээс ч хэд хэд нүүсэн. Хамгаалах байрны тухай Залуус сонин анх мэдээлсэн. Нэг бүтэн сайн өдөр сурвалжлагч бүсгүй нөхөр маань намайг дарамтлаад байна гэсээр ирсэн юм. Уг нь төвийн ажилтнуудаас зөвшөөрөл авах учиртай ч би ерөвдөөд хамгаалах байрандаа авлаа. Бүсгүй хоёр хоноод асуудлаа шийдчихлээ гээд гарсан юм. Гэтэл удалгүй сонинд манай байрны тухай

нийтэлсэн байлаа. Тэр үедээ заль хэрэглэсэнд нь гомдож л байсан. Харин одоо талархаж явдаг юм. Бидний ажил үйлс энд ирдэг хүүхнүүдийн амьдрал байдлыг үнэн зөвөөр нийтэлж хүмүүст таниулсанд буруу юу байх вэ дээ. Хамгаалах байрны ажилтан ийн ярьлаа. Найман жилийн турш бусдын зовлонг хуваалцан цаашид амьдрах итгэл, гэрэл гээг бүсгүйчүүдэд бэлэглэгч энэ эмэгтэйн сэтгэлийн тэнхээ, тэвчээрийг гайхсан юм. Уулзсан хүүхэд бүсгүйчүүдийн яриаг доор сийрүүлэе.

Баянзүрх дүүргийн иргэн Г.

Энэ амьдрал миний хувьд хоёрдах нь. Харин нөхөр маань урьд нь гэрлэж байгаагүй. Хоёр хүүхэдтэй намайг хүний дайтай аваад явчихна гэж итгэсэндээ ханилсан. Гэтэл гэр бүл болсноосоо хойш таван сарын дараагаас намайг зодох болсон. Архи огт уудаггүй, цоо эрүүл хэрнээ элдэв шалтаг тоочин хүчирхийлдэг. Хамгийн сүүлийн удаа 11 дүгээр сарын 11-нд толгой дээр нь ус хийхдээ халуун ус байсныг нь анзаараагүйгээс зодуулсан. Зарим үед хэнтэй ч хамаагүй хардаж зодно. Автобус тормозлоход нэг залуутай мөргөлдсөний төлөө зодуулсан тохиолдол бий. Энэ бүгдэд би өөрийгөө л буруутгаж хөдөлгөөн үйлдэл болгоноо хянадаг, өөртөө л бурууг тохдог байлаа. Хүчирхийллийн төвд хандсан хойноо хүчирхийлэгчид шалтгаан мунддаггүй юм байна. Миний буруу зүйл хийсэн эсэх нь огт ялгаагүй юм байна гэдгийг ойлголоо. Бага хүүг минь илүүтэй адлаж аавд нь өг гэж шахаж шаарддаг.

Баянгол дүүргийн иргэн Ө.

Бид аав, ээжээс гурвуулаа. Отгон дүү бид хоёр эмэгтэй, дундах нь хүү. Аав, ээж хоёр эрэгтэй дүүг хоёр охиноосоо илүү хайрлаж өсгөсөн. Дутуу хомсын зовлонг бид мэдэхгүй өссөн. Гэвч нэг л мэдэхнээ нас биед хүрч би хүүхдээ төрүүлсэн. Хань бүлгүй тул аавын гэрээс өрх тусгаарлаагүй. Тун удалгүй дүү нар маань эрийн цээнд хүрсэн. Тэр үеэс бидний аж жаргалтай үе дурсамж болон үлдэж бид биеэ ад үзэх болсон. Хөөрхий хоёр хөгшин хэнийг ч гэх билээ. Энэ байдлыг ойлгосон эрэгтэй дүү бүхнийг өөрийнхөө атганд оруулж дураараа дургиж эхэлсэн. Хүү бид хоёрыг ад үзэж хүүг маань байнга дарамтална. Арга ядаж хамгаалах байранд ирсэн билээ. Хойшдоо хэрхэхийг мэдэхгүй байна. Хүүхдийн хичээл сургууль хэцүүдлээ. Ямартай ч өөрөө ажил хийе, хүүгээ өөр сургуульд шилжүүлэе гэж бодож байв. Надад Хүний эрхийн үндэсний төвийнхэн тусална гэсэн. Биднийг ярилцаж суутал гаднаас хижээл насны авгай 18 насны охинтойгоо ирлээ. Тэд айж цочирдсоноос дагжин чичирч үг хэлэх ч сөхөөгүй байлаа. Харин хамгаалах байр их тохилог юм. Хүүхдийн тоглоомын өрөөтэй, унтлагын өрөө нь айлын гэрээс ялгаагүй тохь тухтай, багтаамжийг нь бодсоноос тэрүү орыг давхарлан тавьжээ. Хүүхэд, багачууд хань ижлээ хөөж явуулсан эрчүүд хамгаалах байрыг эрж хайж явсаар давхар ор, төмрөөр бэхэлсэн цонх, өдөр шөнөгүй татаастай хөшгөөр нь таньж ирдэг гэнэ. Тэд голдуу хүүхдээрээ түрий барьдгаас, хүүхдүүд нар салхинд ч гарах эрхгүй болдгийн дээр сургууль, цэцэрлэг нь завсардаж хохирдог байна. Эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болдог бол хүүхдүүд золиос болдог юм уу гэсэн бодол эрхгүй төрснөө нуух юун. Биднийг очих үед есөн ээж арван зургаан хүүхэд хамгаалах байранд байлаа. Хамгийн бага нь ой хагастай, том нь 16-18 насныхан. Тэд аав ахдаа байгаа газраа мэдэгдэхгүйн тулд аргагүйн эрхэнд хичээлээ тасалжээ. Хүүхэд өөрийн төрж өссөн гэртээ хамгийн тухтай, сэтгэл тэнүүн байх нь мэдээж. Гэр оронд нь хэрүүл зодоонтой, байнгын түгшүүртэй байдгаас хүүхдийн амгалан тайван орчинд өсөж хүмүүжих эрх нь зөрчигдөж эхэлдэг. Хүчинд автсан ээж нь хүүхдээ дагуулан аав ээж, ах дүүс, найз нөхдийнхөөрөө хэсүүчлэн тэнүүчилж, наашаа гэх хүнгүй болсон үедээ л Хүчирхийллийн эсрэг төвд ханддаг. Энэ үеэс хүүхэд гэр орноосоо хөндийрөн дайжихийн эхлэл тавигддаг гэж мэргэжилтнүүд үзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөөс болж олон хүүхэд сургууль завсардах, дасч сурсан орчин, найз нөхдөөсөө хөндийрөн өөр сургуульд шилжих зэргээр хохирол амсч байна. Бие сэтгэлдээ хэзээ ч марташгүй гүн шархтай үлдэж байна.

Хамгаалах байранд очсон бяцхан хүү ярихдаа:

Би ганцхан ээждээ л хайртай. Яагаад гэвэл аав миний ээжийн нүүрийг гурвалжин болтол нь (хавдар үүсч гэмтэснийг хэлэв бололтой) цохьсон. Би том болоод аав болохгүй. Болсон ч хүүхдээ, хүүхдийнхээ ээжийг зоддог хүн болохгүй гэсэн юм.

Харин 13 настай М охин:

Хамгаалах байранд байгаадаа ангийхнаасаа ичиж байна. Манай аав ээж хоёр шиг хэрэлдэж мууддаг хүмүүс цөөн байх аа. Манай найз охиных зөндөө олуулаа. Гэхдээ аав ээж хоёр нь огтхон ч муудалцдаггүй. Гэтэл би айлын ганц охин хэрнээ хэн хэнийх нь охин биш юм шиг “чиний хүүхэд чамайг дуурайсан” гэж хэрэлдэхэд нь их гомддог. Гэхдээ ээждээ арай бага гомддог. Уурлахаараа ээжийг зоддогт нь бүр их гомддог. Хүчинд автсан хүүхдүүдийн санаа сэтгэл хямралд орж эцэг эхийнхээ хэнийг өмгөөлөх хайрлахаа мэдэхгүй тээнэглээхэд хүрдэг нь дээрх ярианаас харагдана. Хэдийгээр аавдаа гомддог, хайргүй гэж ярьж байгаа ч элэг нь эцгээ гэдэг л юм байна лээ. Эндээс л хүүхэд эвдэрч эхэлдэг. Одоогоос сар гаруйн өмнө 16 настай охин ганцаараа уйлж иржээ. Учрыг лавлатал охины ээж цайны ханьтай болоод удаагүй бөгөөд ээж нь охиноо урьдийн адил хайрлахгүй байх шиг санагдаж гоморхох болжээ. Ээжийнхээ хайрыг хэнтэй ч хуваалцахыг хүсээгүй охиноо ээж нь ойлгоогүйгээс зөрчил үүсч охин Хүний эрхийн үндэсний төвд хандсан нь энэ билээ. Энэ мэтчлэн томчуулын зовлон, жаргалын золиосонд хүүхдүүд өртөж хүчирхийллийн буруутан нь өөрийгөө гэж ойлгосноос хүүхэд хүчгүй, сул дорой өөрийгөө бусдаас дорд үздэг, ирээдүйдээ итгэлгүй хүн болон төлөвшдөг ажээ. Сэтгэлийн хат суугаагүй ийм хүн өрх гэрээ, улс орноо хэрхэн авч явах нь тодорхойгүй билээ. Хамгаалах байрны хананд Америкийн Нэгдсэн Улсын далбай, төрийн нарийн бичгийн даргын хатагтай Мадлен Олбрайтын зураг хадаастай байх нь нүдэнд туслаа. Хатагтай Мадлен М. Олбрайт Хүний эрхийн үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцаж хамгаалах байр байгуулах саналыг дэмжин туслахаа амлажээ. Удалгүй Америкийн Нэгдсэн Улсын Монгол дахь элчин сайдын яамнаас байр худалдан авах хөрөнгийг гарган өгсөн байна. Хамгаалах байр хэд хэдэн удаа бууриа сэлгэн нүүдэлжээ. Нууцлаг байдлаа алдаж хүмүүс мэддэг болмогц дахин шинэ байр луу нүүдэлдэг нь эднийхний нэг онцлог. Гэр бүл хүчирхийлэл гэдэг нэр томъёо саяхнаас дэлгэрсэн мэт, Хүний эрхийн үндэсний төв бий болсноор л хүчирхийллийн тухай ярих болсон мэтээр ойлгодог хүмүүс мэр сэр байдаг. Гэвч бидний багад ч согтсон, хөлчүүрсэн үедээ авгай, хүүхдээ айлгаж ичээдэг хүмүүс байсан. Аав маань 26 жил цагдаа явсан хүн. Миний ухаан орох үеэс тэтгэвэртээ гарсан хэдий ч хамар хашаа, гудамжныхан маань аюул учрахад аавыг дууддаг байсансан. Олонх нь гэр бүлийн маргаан, авгай хүүхэддээ дээрэлхэж айлгасан хэрэг байдаг байж. Тэр үед одоог бодоход цаг хатуу байснаас ч тэр үү хүчирхийллийн талаар нийтлэг ойлголтогүй байсан болов уу гэж боддог юм. Авгай хүүхэддээ хайртайдаа биш гэхнээ намаас хөөгдөх, ажлаасаа гарахаасаа айдаг хамт ажиллагсдаасаа ичдэг байсан биз ээ. Өнөөдөр эрчүүдийн олонх нь ажилгүй, ажилтай байлаа ч ар гэрийн амьдрал ахуй сонин биш болсноос хүчирхийлэл илүү газар авсан санагдана.

Хүчирхийллийн орчинд өссөн хүүхдүүдийн 29.7 хувь нь сэтгэл санааны хувьд гутранги, 10.1 хувь нь хичээлдээ сонирхолгүй болсон, 8.7 хувь нь тэнэмэл зам руу орсон, 8 хувь нь эрүүл мэндээрээ хохирсон, 6.9 хувь нь сургууль завсардсан байдаг ажээ. Зөвхөн эмэгтэйчүүдийг төдийгүй хүүхдүүдийг хүнд байдалд оруулж буй хүчирхийлэл газар авсаар атал хүчирхийллийн эсрэг хийж буй дорвитой ажил хомс, тэр чиглэлээр дагнасан төрийн байгууллага ч алга. Ганц ХЭҮТ хаанаа ч хүрэлцэхгүй нь ойлгомжтой юм. Хамгаалах байр л гэхэд улсад цор ганц байна. ХЭҮТ 10 салбартай ч хөрөнгө мөнгөний хомсоос хамгаалах байрыг нэмэгдүүлж чадахгүй байгаа юм. Ганц байгаа хамгаалах байр нь “гал унтраах” төдий үүрэг гүйцэтгэдэг ч хойшид өргөжүүлэх, тоог нь олшруулан нэг сүлжээнд холбох зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм. Нэг удаа 20 хүн байрлуулахаар тохижуулсан ч өнөөдрийн байдлаар 25 хүнтэй байна. Заримд нь ор хүрэлцэхгүйгээс эвхдэг ор болон газраар гудас дэвсэн унтдаг ч хүн сэтгэл тайван орчинг хамгаас эрхэмд үздэг нь ажиглагдсан юм. 2002 оноос Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Яамнаас эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 3 сая төгрөгийг тус төвд хандивлажээ. Тэр мөнгийг хамгаалуулагчдынхаа хоол хүнс, ая тухтай байлгах үйлчилгээнд зарцуулсан байна. Ирэх онд хандивын хэмжээг 5 саяд хүргэх тухай таатай мэдээг саяхан сонсчээ.

Олон улсын Энэрлийн байгууллага 1.6 сая төгрөгийн хөрөнгө гарган хамгаалах байрыг тохижуулж өгсөн байна. Түүнчлэн япон, солонгосчууд тусламжийн гараа харамгүй сунгадаг ажээ. Саяхан японы нэг иргэнээс тусламжийн хувцас, хүнс иржээ. 8.3 сая хүн амтай Швед улсад байнгын ажиллагаатай 150 хамгаалах байр байдаг гээд бодохоор манай улсад хамгаалах байрыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг улам өргөжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Хэсэг 3. Өдөр тутмын сонинуудад хэвлэгдсэн хүний эрхийн асуудлыг хөндсөн зарим нийтлэлүүд

3.1 Д. ПУНЦАГ: ЭВЛЭРЭЛ МАНАЙ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЦОО ШИНЭЭР ОРЖ ИРСЭН

Ш.Сүхбаатар

Өдрийн сонин, 2002.09.11

Эрүүгийн шинэ хуульд орсон өөрчлөлтүүдийн талаар уншигчдаас ирүүлсэн асуултуудыг Монгол улсын Дээд Шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч Д. Пунцагт тавьж түүнтэй ярилцлаа.

-Хохирол төлбөр төлсөн байдлыг харгалзан ял шийтгэлээс чөлөөлөх асуудлыг Эрүүгийн хуульд шинээр хэрхэн тусгасан бэ?

-Эрүүгийн шинэ хуульд хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр цоо шинэ заалт оруулсан нь оновчтой шийдэл төдийгүй иргэд, хөдөлмөрчдийн хүсэн хүлээж байсан асуудал юм. Гэмт хэрэг үйлдэж бусдад их хэмжээний хохирол учруулчихаад түүнээ төлж барагдуулалгүйгээр ял шийтгэлээс чөлөөлөгдөх нь шударга биш юм. Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай ч учруулсан хохирол, гэм хороо арилгасан хүнд хуульд заасан хөнгөлөлт үзүүлье, хэрэв арилгаагүй бол наад захын хөнгөлөлт үзүүлэхгүй байх нь зүйтэй гэж хууль тогтоогч үзсэн байна.

Тухайлбал гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан тохиолдолд хуульд заасан дор дурдсан хөнгөлөлт эдэлж болно.

-Анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирогчтой эвлэрсэн, хэргээ сайн дураара илчилсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгож болохоор

-Анх удаа, хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй, ганц бие эрэгтэйд хорих ял оногдуулсан шүүхийн тогтоолыг биелүүлэхийг хойшлуулж болохоор

-Анх удаа, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдэд хорих ял оногдуулсан шүүхийн тогтоолыг хойшлуулж болохоор

-Хорих ял шийтгүүлсэн ялтан ялынхаа тодорхой хувийг эдэлсэн нөхцөлд ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллагдаж болохоор бол.

Эрүүгийн хуульд гэмт хэргээ сайн дураар илчилсэн бол зөвхөн ял шийтгэл ногдуулахдаа хөнгөрүүлэн үзэх нөхцөл байдалд хамааруулдаг байсан. Одоо хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд хэргээ сайн дураар илчилж ирсэн бол шууд хэргийг нь хэрэгсэхгүй болгох юм. Гагцхүү хэргээ өөрийн санаачлагаар, гадны шахалт хавчилтгүйгээр өөрөө илчилсэн байх ёстой. Эвлэрэл гэдэг нь огт шинээр манай Эрүүгийн хуульд орж ирсэн дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улс оронд түгээмэл хэрэглэгддэг ойлголт юм. Бас л хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд сайн дураараа хохирогчтой эвлэрсэн, хохирлоо нөхөн төлсөн байвал хэргийг нь хэрэгсэхгүй болгохоор хуульчилсан байна. Харин хохирогчийг айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх зэргээр хууль бусаар нөлөөлж эвлэрэхийг зөвшөөрөхгүй. Тэгэхээр хохирогч нь эвлэрснээ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхэд сайн дураар илэрхийлж бичгээр хүсэлт гаргах болон холбогдогчтой эвлэрлийн гэрээ байгуулсан байвал зохино.

Нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэсэн шинэ томъёолол хуульд оржээ. Энэ томъёоллын агуулга, учир холбогдлыг хүмүүс ихээхэн сонирхож байна.

Сонирхолтой хийгээд, практик ач холбогдолтой сэдэв шүү. Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэдэгт аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй гэж үзсэн. Хуучин хуульд аргагүй хамгаалалтыг хэтрүүлбэл гэмт хэрэгт тооцдог байсан бол одоо хэтрэх гэсэн ойлголт байхгүй болсон.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтныг шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, тэднийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед тэдэнд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй гэж үзэж байгаа. үүнийг хараад зөвхөн цагдаагийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх газрын ажилтныг хамгаалсан заалт гэж үзэж болохгүй. Манай иргэдийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх үүрэг ч хамаарч, хамгаалагдаж байгаа гэдгийг онцлон хэлэх

учиртай. Өөрөөр хэлбэл дээрх үйлдэл нь нийгмийн ашгийн төлөө хийгддэг шударга үйлдэл гэсэн агуулгатай юм.

Нийгэмд ашигтай үр дүнд хүрэхээр юм хийсэн үйлдвэрлэл, шинжилгээ, туршилт судалгааны ажлын явцад эрсдэл гардагийг үгүйсгэх аргагүй. Эрсдэл бүхий үйлдэл хийхгүйгээр ашигтай зорилгод хүрч чадахгүй байсан бөгөөд аюул учруулахгүйн тулд хангалттай арга хэмжээ авсан боловч эрсдэл гарсан бол үндэслэл бүхий эрсдэл гэж үзэж гэмт хэрэгт тооцохгүй. Харин олон хүний амь насанд гэмт хор учруулах, нийтийг хамарсан буюу байгалийн гамшигт үр дагаварт хүргэх аюул бодитой байхад эрсдэл хийснийг үндэслэлгүй эрсдэл гэж үзнэ. Үндэслэлгүй эрсдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.

Заавал биелүүлбэл зохих тушаал, захирамжийг биелүүлнэ гэдэг учиртай. Илт хууль бус хийгээд ноцтой үр дагаварт хүргэж болохоор байвал тушаалыг биелүүлэхгүй байж болох бөгөөд ийм тушаалыг өгсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох юм. Ер нь заавал биелүүлэх тушаал, захирамж биелүүлсэн нөхцөлд бусдад гэм хор учруулсныг шинэ хуулиар гэмт хэрэгт тооцохгүй гэж үзжээ. Анхааруулахад илт хууль бус тушаалыг бүү биелүүл. Түүний төлөө та хариуцлага хүлээхгүй шүү гэж зөвлөх байна. Гагцхүү аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, эрсдэл мөн үү биш үү, тушаал, захирамж илт хууль бус уу, үгүй юу гэдгийг мөрдөн байцаах байгууллага гарцаагүй тогтоосон л байх ёстой. Энэ бол хуулийн байгууллага, түүний ажилтан хуульчдын ур чадвараас хамаарна.

3.2 ХОТОД ШИЛЖИН ИРЭГСДИЙГ ХУРААМЖААС ЧӨЛӨӨЛӨХ ЗӨВЛӨМЖИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГАД ХҮРГҮҮЛЖЭЭ

С.Гантуул

Монголын мэдээ, 2002.02.09

Улс орон зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хөдөөгийнхний төв суурин газар бараадаж амьдрах гэсэн сонирхол тэмүүлэл эрс өссөн. Үүний зэрэгцээ цас, зуд, ган гачиг болж, малчид хэдэн малаа барж амьжиргааны эх үүсвэргүй болсон нь хот руу чиглэсэн их нүүдлийг улам дэвэргэлээ. Бид угаас нүүдэлчин удамтай, нүүж сууж сураагүй биш, үүнд гайхаж, эмзэглэх юм алга гэж бодож болох боловч энэ удаагийн нүүдэл нэг л биш ээ. Монгол улсын Үндсэн хуульд заасанчлан иргэн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй. Харин тэр газар нь хүн хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн халамж хүртэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, мэдээлэл олж авах зэрэг хүний эрхийн наад захын нөхцлүүдээр бүрэн хангагдсан байх ёстой. Гэтэл өнөөдөр хөдөөнөөс орж ирсэн ихэнх айл өрхийн гишүүд ийм эрхээ эдэлж чадахгүй байна. Шилжин суурьшигсдын эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй байгууллага алга гэхэд ч хилсдэхгүй биз ээ.

Нүүдэллэн ирэгсдэд өвдөх эрх байхгүй

Хөдөөнөөс орж ирсэн айлууд хотын гэрийн хорооллыг улам бүр тэлж байгаа нь нүднээ илхэн. Тэдний тухай материал бэлтгэж явахдаа нэлээд хэдэн айлаар орж ярьж хөөрөхөд хотод ирээд амьдрал нь сайжирч дээшилсэн нь хуруу дарам цөөхөн бололтой.

Дарь-Эхийн овооны Ганцийн задгай гэх хашаагүй гэр, жижиг шавар байшингуудын заримаар нь орлоо. Увс аймгийн Тэс сумаас хоёр жилийн өмнө шилжиж ирсэн.м Түвдэнгийнх гэдэг айлд ороход гал хөсгүй, гэрэл гэгээгүй хувьсгалаас өмнөх үеийн түүхийн кинонд гардаг дүр зураг нүднээ буусныг нуух шаардлагагүй биз. Гэрийн эзэн хотод ирээд амьдралаа дээшлүүлж, оюутан хүүхдээ сургуулийг нь төгсгөчихье гэж санаж ирсэн. Зуд, малын хулгайчид цөөн хэдэн малаа алдаж, юу л бол юу хийчихэж болохоор газар гэж наашаа ирсэн минь эндүүрэл байжээ. Өнөөдөр эхнэр маань өвчтэй хэвтэж л байна. Очоод үзүүлэх гэхээр эмнэлэг үздэггүй. Харин өчигдөр орой түргэн тусламж дуудаж үзүүлээд хэдэн эм бичүүлж авсан. Бичиг баримтаа шилжүүлээгүй болохоор сургуулийн хүүхдүүдэд ч хэцүү байх юм. Оюутан охиныхоо төлбөрийг төлж чадалгүй жилийн чөлөө авахуулаад цайны газар ажил хийлгэж байна. Би өөрөө эмээл хийж зардаг. Хотынхны

хэрэгцээтэй зүйл биш болохоор тэр бүр түргэн зарагддаггүй. Үлдсэн ганц нэг малаа зарж байж машин хөлслөн гэрээ нүүлгэж авчирсан болохоор хөрөнгө гэх юм алга гэж ярьсан юм. Гэрэл цахилгаанаа тавиулахгүй яагаав гэж асуухад манай энэ хавьд ойролцоо шон байхгүй л дээ, тэгээд гэрэл гэгээ яамай, хотынхныг дуурайх гээд яахав.

Шилжин суурьшигсдын хүүхдийг тэнэмэл амьдрал тойрсонгүй

Дөч орчим насны нэг гэр бүлийн хоёр жил гаруйн өмнө Баянхонгор аймгаас дөрвөн хүүхдээ дагуулан хотод иржээ. Хотод очоод хашаа байшин авчихна гээд нутагтаа гэр хашаагаа зараад ирж. Гэтэл хотынхны ханшинд өнөөх мөнгө нь яагаад ч хүрсэнгүй. Тэгээд л Баянхошууны Зүүнбаян уулын 5-ын задгай гэх газар зуны амбаар барьж ойролцоох жалганаас шар швар зөөж шавардаад амьдарч байгаа юм байна. Хэдий орох оронтой болсон ч хүүхдүүдэд нь сургууль олдсонгүй. Ойролцоох сургуулиудаар орж ярилцахад түвшин тогтоох шалгалт аваад тэнцвэл авъя гэжээ. Харин хүүхдүүд нь тэр шалгалтанд тэнцээгүй учир гэртээ суух болжээ. Гэрийн эзэгтэй Баасанхорлоотой хэдэн үг сольсон юм.

-Хүүхдүүд чинь сургуульгүй болохоор ирээдүйд нь муу л байх даа?

-Ирээдүйг нь бодох манатай болчихоод байна. 5, 7 дугаар ангид байх ёстой хоёр хүү маань гэр орондоо ирэхгүй, гадуур тэнэх болсоор удаж байна. Бид 2 хэлж, учирлаж, зодож ч үзлээ. Ямар ч нэмэр алга. Сурах сонсох нь энд тэнд бид ээж, аавгүй, манай гэрийнхэн хөдөө гэж ярьж явдаг бололтой. Тэнэмэл хүүхдүүдтэй нөхөрлөөд хаа сайгүй л явдаг болсон. Сүүлдээ ч эрүүл саруул, муу юманд өртчихгүй явбал боллоо гэж бодох юм.

-Танайх амьжиргаагаа яаж болгож байна вэ?

-Энд ирээд удаагүй байхдаа би нэг оёдлын цехэд ажилд орсон. Чамлахаар чанга атга гэж болоод л байна. Нөхөр маань хаалга цонх хийдэг нутгийн хүнийг бараадаж туслахаар ажиллаж байна. Уг нь ажил хийгээд л байвал амьдарч болохоор л газар юм.

-Албан ёсоор хотын иргэн болж чадсан уу?

-Том охин маань насанд хүрсэн болохоор гурван том хүний 150 000 төгрөг, гурван хүүхдийн 75 000 төгрөг шилжүүлэг хийлгэхэд орох юм. Бид энэ их мөнгийг бөөнд төлж дийлэхгүй учраас хэцүү л байна. Нутгаасаа гарахдаа шилжүүлгээ аваад ирсэн боловч өдий болтол Улаанбаатарын харъяат болж чадаагүй л байна. Биднийг энд гайгүй амьдарч байна гэж дуулсан юм байлгүй 70 гарсан хөгшин ээж маань ирэх гээд байгаа. Гэтэл манайх хүүхдүүдээ тэнэмэл болгочихоод сууж байдаг.

Нүүхийг шаардсан бичиг өгөх хүмүүс л үзэгддэг

Хотод шилжин ирж буй айл өрхүүдийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг байгууллага алга гэдгийг дээр дурдсан. Манай улс шиг хүн амынх нь тал хувь нь нийслэлдээ суурьшсан орон байхгүйг ч учир мэдэх хүмүүс ярьж л байдаг. Энэ их нягтралыг багасгахын тулд өргөн уудам нутаг дэвсгэртэй манай оронд бүсчилсэн бодлого хамгийн үр дүнтэй арга болох нь ойлгомжтой. Харамсалтай нь энэ асуудал дээр дорвитой алхам хийгдэж өгөхгүй л байна. Гэр хорооллын хаяаг тэлж гэр байшин, зарим нь орц овоохой ч бариад сууж байгаа. Цагаачдаа нийслэлчүүд нүд үзүүлэн харж нүүхийг шаардсан бичиг чулуудаж зовоохоос өөрөөр хандаж болох өөр арга арга зам, эрх зүйн зохицуулалтыг эрэлхийлэх цаг болсон санагдана. Миний уулзсан Лодой гуайнх зөвшөөрөлгүй газар буусан тул нүүхийг мэдэгдье гэсэн шаардах хуудас гурвыг авсан байх юм. Түүнтэй ярилцлаа.

-Танайх шаардах хуудас авсаар байж нүүдэггүйн учир юу вэ?

-Ерөөсөө манай энэ хавийн айлууд ийм бичиг хэд хэдийг авсан. Тэгээд нүүгээд хаа очих юм бэ? Бас л нэг хөөгдөхөөр газар бууна биз. Хөгшин болсон би үхэхийнхээ өмнө буусан бууринаасаа хөөгдөж явах хувьтай юм байлгүй. Одоо би тийм нүүдэл суудлын аян даахаасаа өнгөрсөн билээ. Өөр зүйл асуусан боловч тэр юу ч ярихыг хүссэнгүй. Та нар хөөх гэж л ирээ биз гэхчлэн цөхөрсөн аястай үгс чулуудав. Нэгэнт суудал, зардал чирэгдэл болж ирчихээд арай гэж төвхнөх гэтэл шаардах хуудас өгөөд хөөгөөд байхаар тайван амьдрахад нь бэрх байдаг бололтой.

Зөвшөөрөл өгөх боломжгүй, үерийн ам, онцгой объектой ойр буухаас нь өмнө тухайн хорооны удирдлагууд зохих арга хэмжээг авдаггүй атлаа өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгчийн үлгэрээр ажилладаг байдал амьдралд нийцэхгүй болох нь харагдаж байна.

Тэдний олонхи нь ядуучууд

Өнгөрсөн сард Хүний Эрхийн Үндэсний Комиссоос энэ чиглэлээр дүүргүүдийн 37 хорооны 4754 айл өрхөөр орж судалгаа хийхэд тэд нийслэлд орж ирэх болсон шалтгаанаа ихэвчлэн ажил хийж амьдралаа сайжруулахаар ах дүү хамаатан саднаа бараадаж, оюутны гэр бүл гэх зэргээр тайлбарласан байна. Мөн зудад малаа алдсан, хөдөөд амьдрах аргагүй болж зах зээл бараадаж ирсэн, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодож чанартай сургалтанд хамруулах, эмчилгээ хийлгэх гэх зэрэг шалтгаанаар ирсэн хүмүүс цөөнгүй байна.

Харин тэд бичиг баримтаа цэгцэлж албан ёсоор Улаанбаатарын иргэн болоогүй шалтгаанаа шилжилтийн хураамж төлөх бололцоогүй, аймаг сумаасаа шилжүүлгээ авч чадаагүй, авахаар хөөцөлдөж явах боломжгүй гэж хариулсан бол цөөнх хэсэг нь хаана хандаж хөөцөлдөхөө мэдэхгүй байна гэж хариулжээ.

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас саяхан нийслэлийн хүн амын үзлэгийг явуулж өндөр настан, нэн ядуу өрхийн гишүүдийг шилжүүлгийн хураамжаас чөлөөлөхөөр болсон ч асуудлыг бүрэн цэгцэлчихээгүй нь ойлгомжтой.

Тиймээс Хүний Эрхийн Үндэсний Комиссоос шилжилтийн өндөр хураамжийн асуудлыг хянан үзэж хүчингүй болгоно уу гэсэн зөвлөмжийг холбогдох газар явуулаад байгаа юм байна.

Нийслэлийн ядуучуудийн ихэнх хэсгийг шилжин суурьшигчид бүрдүүлэх болсон нь мөн л тэдний эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байгаагийн илрэл юм.

3.3 Ч.ЭРДЭНЭ-ОЧИР: ЦААЗЛАХ ЯЛ СОНСОХ БҮРТЭЭ БАРАГ Л УХААН АЛДДАГ БАЙЛАА

Галсангийн ЖАМЪЯН

Монголын мэдээ

Чойжилжав гуай гурван удаа цааз ял, гурван удаа 25 жилийн ял сонсон долоон жил мөрдөн, гянданд хоригдож амьдын тамлал гэдгийг бие сэтгэлээрээ үүрсэн хүүгээ дагуулаад шоронгоос гарч ирж байхад нь уулзлаа. Энэ өвгөнийг танихгүй мэдэхгүй хүн Монголд үгүй байх. 1996 оны долдугаар сарын бүгчим халуунаар хүүгийнхээ төлөө Завхан аймгийн Эрдэнэ-Хайрхан сумаас төрөлх нийслэлээ зорин хөдөлж байсан энэ хүн аймаг, хот хоёрын хооронд дөчөөд удаа явж азарга адуу, хоттой хонио бараад адаг сүүлд нь мөнгөн хэрэглэлтэй эмээл, хэт хутгаа хүртэл заран зардал хийж байсан гэдэг. Замын зардлаа хүч хүрэхгүй болохоороо хоёр жилийн өмнө хотод шилжин ирж автобусны буудлууд дээр “цагаан утас” барин зогсч хоногийн хоолтой залгадаг байсан ажээ. Сэтгэлийн шаналалд “хорчийсон хөх өвгөн” болтлоо элэгдсэн энэ буурал өнөөдөр суллагдсан хүүгээ хөтөлчихөөд Төрийн сүлд, дөрвөн ууландаа залбиран, уулзсан болгоныхоо өмнө баярын нулимс унагаж явна. “Цагаан мөртэй, үнэн юм заавал ингэх ёстой. Хүүг минь суллагдчихлаа” хэмээн тэрээр өгүүлж байна.

Долоон жил “алуурчин” хэмээх нэр зүүж Завхан аймгийн мөрдөнгөөс эхлэн “Ганц худаг”, “Авдрант”, “Тахир соёот”-ын гяндангуудыг дамжин хэцүү бүхнийг үүрч явсан Ч.Эрдэнэ-Очир анхныхаа ярилцлагыг манай сонинд өгч байна.

-Эрдэнэ-Очироо, өөрийн чинь хэрэг бараг домог, түүх шахуу болчихсон, хүн болгон янз бүрээр ярьдаг. Гэтэл өөрийн чинь амнаас сонссон хүн нэг ч байдаггүй. Иймээс болсон явдлыг чин үнэнээр нь яриулмаар байна?

-Би Завхан аймгийн Эрдэнэ-Хайрхан сумын төвд амьдардаг байлаа. Эхнэр, хоёр хүүхэдтэйгээ 1995 оны шинэ жилээс өмнөхөн 12 дугаар сарын 29-нд хөдөө хадам ах З.Очирхуягийндаа ирлээ. 30-нд амарч морио юүлж аваад 31-нд Очирхуяг ахын мал хариулдаг Даваасүрэнгийнд очлоо. Тэнд мал нядалгаа болж байсан учир тэдэнтэй хамжаад 25 хонь, нэг үхэр гаргалчихаад орой 16 цаг өнгөрч байхад алдчихсан дөрвөн хонио эрэхээр Бор-Бэлчир рүү явж байгаа юм. Зуур замд адуун дунд эмээл хазаартай, тушаатай морь байсан нь анхаарал татахгүй юу. Морь нь болохоор манай аавын, Дамбийн гуайн дээр байдаг адууных. Аавын унадаг л морь. Би ойр хавьд хүн харсан чинь огт хүн алга. Тэгэхээр нь санаанд ч үгүй тушааг нь аваад Дамбий гуайнд аваачаад өгтөл, “Хүү хаачив? Өглөө л энэ морийг унаад адуунд явсан юмсан” гэв. Тэгээд морины эзэн яачихав

ийчихэв болоод нэг хүү нь явсан чинь ойрхон газар алагдчихсан байна гээд шарилыг нь аваад ирлээ. Хутгалсан, хоолойг нь хэрчсэн байдаг гэдэг. Ингээд л талийгаач Пүрэвдоржийн алагдсан хэрэгт намайг сэрдэхгүй юу. Гайгаар би морийг нь авчирч өгснөөс л болсон юм.

Гэтэл энэ хэргийн эзэн бараг тодорчихсон юм шүү дээ. Яг энэ үеэр тэндхийн нэг залуугийн цус болчихсон эмээлтэй морь айлын гадаа очсон, эзэн нь явган ирж явсан, Баасанжаргал гэж эмэгтэй бүх зүйлийг харсан, тэгсэн чинь ээж нь “амьд хүний гэрч болохоор үхсэн хүний дэр бол” гээд үнэн мэдүүлэг өгүүлээгүй гэхчилэн их зүйл бий. Хүмүүсийн хоорондох гэр бүл, хардалт, сэрдэлтийн асуудал ч энэ дунд бий. Гэтэл Завхан аймгийн цагдаа хуулийн байгууллагын цөөн хэдэн хүн үг сүггүй надад “алсан гэдгээ хүлээ” гэж тулгаад хүлээх юм байхгүй болохоор анхны цааз ялыг 1996 оны 6 дугаар сарын 27-нд хүлээлгэж байгаа юм даа. Гурван шүүгч орсноос Загдаа, Ням хоёр нь намайг алсан болгож цааз ял тулгаад, шүүгч Цогт-Зандан “Нотлох баримтгүй ийм хэргийг тасалж болохгүй. Энэ чинь хүн алаагүй хүн байна” гэж зүтгээд ганцаардсан гэсэн. Дараагийн шүүх хуралд шударга биш юманд холбогдохгүй гээд ороогүй юм билээ. Жинхэнэ шударга үнэний шүүгч болсон Цогт-Зандан гэдэг хүн одоо Баянзүрх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчээр ажиллаж байгаа юм билээ.

-Урьд өмнө нь хэрэг төвөгт холбогдож байсан биш. Гэв гэнэт цааз ял сонсоход ямаршуу болов?

-Би сонсоод бараг ухаан алдсан. Нэг хэсэг хугацаанд юу болсноо ч санадаггүй юм. Нойр ч хүрэхгүй хоолой уруу ч юм давахгүй. Ёстой л сүг болдог юм билээ. Настай ээж, аавыгаа, ханиа, хоёр муу домбон чинээ хүүхдээ бодохоор нулимс сул урсаад л байсан. Дээд шүүхэд давах өргөдөл биччихээд хариуг нь хүлээнэ гэдэг ямар их шаналал гээ. Зүүрмэглээд, буудуулж байна гээд цочиж сэрдэг байсан. Миний өргөдөл мөн л Ням, Загдаа хоёр шиг хүн дээр очвол үзэх ч үгүй хэвээр баталчих байх даа гэхээс хамаг бие шархирна. Хоёр буурлын минь, ханийн минь, хоёр хүүхдийн минь буян заяа тэгшлээ биз дээ. Сайн шүүгч дээр очсон байсан. Дээд шүүхийн Батсайхан гэж шүүгч “нотлох баримт бүрдээгүй” гээд нэмэлт мөрдөн байцаалтад буцаажээ. Дээд шүүх чинь аргагүй л дээд шүүх юм билээ. Тэнд Монголын сор сүлд болсон шүүгчид байдгийг тэгэхэд л би ойлгосон.

-Намайг “Улаанбаатар” сонинд байхад анх аав чинь орж ирж байсныг санаж байна. Талийгаач Ж.Барамсай, сэтгүүлч О.Лхагвадорж бид гуравт нэг оройжин ярьж билээ. Мөрдөн байцаагч, шүүгч, прокурорууд хуйвалдаад гэмгүй залууд цааз ял оноон устгачихаад, цаана нь хэн нэгэнд ял зэм завшуулах гэсэн санаа байна гэж бичээд Лхагвадорж маань цагдаа хуулийнхны хараанд орж ажил амьдралгүй болсон шүү дээ. Ж.Барамсай ч тийм өнгө аясаар бичиж л байсан. Ер нь чамайг түргэхэн шиг цааш нь харуулчихаад гол буруутныг аваад үлдье гэсэн бодол хэсэг хүнд байсан юм биш үү?

-Хүмүүс янз янзаар л ярьдаг юм гэсэн. Өнөөдөр надад хэн нэгнийг буруутгах, өшөөгөө авах гэсэн бодол алга. Би бол ганц л өчиг өгдөг байсан. Та нар дэндүү нэг талыг барьж байна. Амьдрал гэдэгт чинь арав хорин нугачаа бий. Намайг цаазлахаа битгий яараач. Би ганц л жижиг тугалганы дор амьдарч байгаа хүн шүү дээ. Цагдаа хуульчид минь уужуу тайван, ухаалаг хандаач гэдэг байсан. Миний үгийг огт хүлээж авдаггүй юм. Анхны мөрдөн байцаагч Галзагд “өөрөөс чинь мэдүүлэг авна” гэж аваачаад л шууд гавлаад бариад авсан. Би уг нь талийгаайн оршуулганд очсон юм. Хохирогчид гээд байгаа хүмүүс талийгаач бид чинь төрөл, тэр л нутаг нугад олон үеэрээ амьдарсан хүмүүс байхгүй юу. Намайг буруутгадаг гол үндэслэл нь талийгаач манай аавын хайртай морийг унаж явсан, түүнээс болж хөдөө маргалдаад намайг алчихсан байх гэдэг юм. Гэтэл манай адуу тэднийд байнга байдаг, түүнийг малладаг хүмүүс чинь дуртай үедээ л унаж эдэлнэ шүү дээ. Тийм юмны төлөө би хүн алж байх юм гэнэ. Ийм хачин юмаар намайг баривчилж байгаа юм. Алуурчнаас өөр нэргүй. Хилс хэрэг хүлээлгэх гэж янз бүрээр дарамталж, зодож нүдэн зовоосон доо. Тэр байтугай хаа хамаагүй хол байсан хадам ах, дүү хоёрыг минь барьж аваачаад худал мэдүүлэг гаргуулах гэж хөх няц болтол нь зодсон байсан. Мэдэхгүй, үзэж хараагүй юм чинь юугаа хэлэх билээ дээ.

-Би гүтгэлэг доромжлол бүхнийг үзэж, эрүүл эрхтэнгүй болтлоо зовлоо. Гэхдээ өнөөдөр би хэнд ч хар буруу санах юм алга. Тэнд Баасанжаргал гэж эмэгтэй байгаа. Тэр л үзсэн харснаа үнэн шударгаар өчвөл энэ долоон жилийн ээдрээ тайлагдах юм шүү дээ.

-Гурван удаагийн цааз ял, гурван удаагийн 25 жилийн хорих ял сонсоход хэр баргийн хүн галзуурчихмаар л юм. Та өдий зэрэг байна гэдэг бас их тэсвэр тэвчээртэй хүн юм аа?

-Хүн зовлонг даадаг юм байна лээ. Цааз ял сонсохоос илүү зүрх урагдах явдал байсан л даа. Хоригдсоноос жилийн дараа хүү, охин хоёрыг минь уулзуулахаар авчирлаа. Үртэй, буянтай хүнд захираа юм тэр л билээ. Охин хоёрдугаар анги, хүү нэгдүгээр анги. Тэр хоёр ирээд аавыгаа зуурчихсан, энгэрт наалдаад мэгшээд байгаа. Охин минь “ааваа явъя” гээд зуураад салдаггүй. Тэгэхэд хүчээр салгаад хүүхдүүдийг минь аваад явж байгаа юм. Тэртээ хойно хүртэл хоёр хүүхдийн минь дуу чихэнд хадаад л байсан. Гэмгүй хүмүүсийн амьдралаар ингэж тоглож байсан хүмүүс ямар яваа, хойшид ямар явахыг мэдэхгүй юм даа. Ямар ч байсан гэгээн үнэн гэж байдаг л юм байна.

-Та ухаантай хуульчдын тухайлбал, Улсын дээд шүүхийн шүүгч Мөнхтуул, Доржготов, Зандраа нарын өндөр мэргэжил, шударга хяналтын үрээр суллагдлаа. Ял завшиж байгаа хүмүүс, зориуд мушгин цааз ял оноогоод байсан цагдаа хуулийнхныг илчилж арга хэмжээ авахуулъя гэж бодож байна уу?

-Тийм юм байхгүй. Манайхан ер нь удам судраараа зарга заальхай, хэрүүл, хэл аманд муу. Аргагүйн эрхэнд л аав бид хоёр ингэж явлаа. Аргатай, чаргатай бол хэр баргийн юмыг тоодоггүй хүмүүс шүү дээ. Төрийнхөө сүлдэнд залбирч төв төвшин амьдрахыг бодож байна. Цагдаа, хуулийн байгууллагынхан энэ шинэ хуулиудынхаа хүрээнд юу хийх нь өөрсдийнх нь хэрэг.

-Би нэг удаа “Тахир соёотод” ажлаар очиж билээ. Өөрийг чинь сурагласан. Уулзаад гаръя гэсэн чинь Ганболд зөвшөөрөхгүй “Та бичиг баримтаа ёсоор нь бүрдүүлээд хүрээд ир л дээ. Бид байнгын шалгалтад өөрсдөө буруудна шүү дээ” гээд уулзуулаагүй. Харин шоронгийн дарга өөрийг чинь нэлээд магтангуй аястай байсан. “Их ухаантай, сахилгатай, хэлсэн үгээр л байдаг юм. Хүн алчихмааргүй л хүн дээ” гээд байсан. “Тахир соёотын” амьдралаасаа товч танилцуулахгүй юу?

-Жинхэнэ гяндан гэдэг газар “Цааз ялыг 25 жил болгохоороо эхний таван жилийг гянданд, 20 жилийг чанга дэглэмтэй колони” гэж заадаг юм шүү дээ. Ганц худаг, Авдрант, Тахир соёт бүгд өөр өөр. Тахир соёотыг сүүлийн жилүүдэд хүний эрхийг дээдэлсэн дэлхийн хорих байгууллагуудын жишигт хүргэхээр зорьж байгаа юм. Нөхцөл байдал харьцангуй сайн. Хүмүүс нь тэр дундаа хурандаа Ганболдын хувьд бол үнэхээр сайн хүн дээ. ШШБЕГ, түүний харьяа урьдчилан хорих төв, гяндангуудаас надад муу хүн таарч байгаагүй. Намайг ойлгодог, хэр чинээгээрээ анхаарал тавьдаг хүмүүс байсан.

-Ганболдын ярьснаар бол Тахир соёотын гяндан их л сайхан болсон юм шиг?

-Хичнээн ч сайхан нөхцөл байлаа гэсэн хамгийн аймшигтай юм эрх чөлөөгүй байна гэдэг. Хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зов гэж яасан үнэн үг вэ. Монголчууд оноод хэлчихсэн шүү. Ганц ганцаараа нэг жижиг өрөөнд. Ор, хөнжил, гудастай. Телевизор үзнэ. Ном, сонин уншаад, юм бичээд байж болно. Өргөдөл бичвэл саадгүй явуулж өгдөг байсан. Жилд хоёр удаа 7-14 хоногоор англи хэл, арван дөрөв хоногт нэг удаа франц хэл заана. Олон улсын хорих байгууллагуудын нөхөрлөлийн суурин төлөөлөгч хатагтай Маргерита бол Монгол шоронг өөрчлөх гэж зүтгэж байгаа хүн. Хоригдлуудад хачин сайн. Би Маргерита ээж гэдэг юм. Яг л ээж шиг минь сургамжилна. Халамжилна. Ёстой “бурхан” авгай бий дээ. Манай дарга хурандаа Ганболд академид явчихсан юм. Маргерита ээж минь сая надтай уулзаад үнсч уйлж, Ганболдод цахилгаан явуулна гэж байсан.

-Гяндан гэдэг газар чинь ажил хийж болох уу?

-Гяндан дотроо “нээлттэй”, “хаалттай” гэж хоёр янз. Хаалттай гэдэг нь хамгийн хатуу дэглэмтэй гэсэн үг. Нээлттэй нь арай гайгүй. Сахилгатай, дэг журмыг хатуу мөрддөг нь нээлттэйд нь байна. Гэхдээ аль ч дэглэмд нь ажил хийхийг хориглоно. Өндөр боловсрол мэдлэгтэй хүмүүс тэнд тархиа ажиллуулаад байж болдог хэрнээ гарын уртай ч юмуу, хөдөлмөрийн чадвартай хүмүүс ажил хийж болдоггүй. Би гянданд орсноосоо хойш “дэглэмийг хатуу сахин, байрандаа ажил хийе” гэж гуйсан. Зөвшөөрдөггүй юм билээ. ШШБЕГ-т ч энэ саналаа тавьж байсан. Ер хүлээж авахгүй. Тэгээд сүүлдээ намайг “хэн бэ” гэдгийг бүгд ойлгосон л доо. Өрөөнийхөө үүдний жижиг зайд эсгий хийхийг зөвшөөрсөн. Би ноос зулаад гар аргаар эсгий хийж байлаа. Эсгийгээ ширээд ширмэл ширдэг хийдэг болсон.

-Ширмэл ширдгээр юу хийдэг юм бол?

-Гяндангийн дотоод хэрэгцээнд хэрэглэдэг байсан байх. Бас худалдаад хэдэн төгрөг болгосон ч болно шүү дээ. Цаг хугацаа амархан өнгөрдөг, их сайн талтай. Бас ядуу шоронгийн хэрэгцээнд тустай шүү дээ. Миний хийсэн эсгий ширдгийг гяндангийн давчуу мухарт хийсэн гэхэд тун сайн болж хэмээн үнэлдэг байсан.

-Бие чинь муудаж эмнэлэгт хэвтэж байв уу?

-Бие муудна л даа. Явах газаргүй, бөглүү, чийгтэй, умгар өрөөнд олон сар жилээр сууна гэдэг ямар ч сайхан залуу биеийг “мэрчихдэг” юм билээ. Хөдөө морь малтай ноцолдож, чийрэг өссөний хэрэг гарсан. Хичнээн ядарлаа ч эмнэлэгт хэвтээгүй. Харин эмчилгээ хийж байсан. Хичнээн эрүүл юм шиг байлаа ч гэсэн бие маань ерөнхийдөө хэврэгшчихдэг юм билээ. Нар агаарт чөлөөтэй гарсан чинь гуйваад явж болохгүй байсан.

-Аав чинь нэг удаа уулзаад “сайн өмгөөлөгчдийн хүчээр хүү минь алуулчихалгүй шиг байна” гэж явсан. Өмгөөлөгчтэйгөө үргэлж холбоотой байв уу?

-Нэлээд хэдэн өмгөөлөгч авсан. Миний өмгөөлөгчид хуулийн өндөр мэдлэгтэй сайн өмгөөлөгчид байсан. Тэд ч миний амийг авч үлдэхэд асар их нөлөө үзүүлсэн. Эхлээд Даваахүү гэж өмгөөлөгч авсан юм. Тэр хүнийг надтай уулзуулдаг ч үгүй байсан. Дараа нь генерал Авхиа гуайг өмгөөлөгчөөр авсан. Авхиа гуай надтай уулзахаар эндээс Завханд очсон чинь цагдаагийн даргын өрөөнд тэр хүний хатуу хяналтанд хэдэн үг солиулсан. Ер нь хамгийн хатуу “энэ хүн тэртэй тэргүй цаазлагдах юм чинь” гэсэн байр сууринаас хандаж байсан л даа. Би хамгийн сүүлд авсан өмгөөлөгч Н.Ламжав гуайнхаа тухай хэдэн үг хэлмээр байна. Тэр хүн хуулийн асар өндөр мэдлэгтэй, жинхэнэ өмгөөлөгч хүн. Миний төлөө байнгын анхаарал тавьж, уйгагүй явсан. Намайг ингэж суллагдахад Ламжав гуайн өндөр мэдлэг, ур чадвар их нөлөөлсөн гэж боддог. Намайг мөрдсөн, шүүсэн, хянасан цөөн хэдэн хүний хүрээнд “энэ бол зайлшгүй цаазлагдах хүн” гээд итгэчихсэн байсан юм билээ. Тэгээд ч нэмэлт мөрдөн байцаалтад буцаахаар бараг нэмж шалгалгүй, нөгөө л шүүгчид цааз ялаа дахиад өгчихдөг байсан. Мөрдөн байцаагч Эрдэнэбат нэг удаа “Чи бид хоёр эргээд уулзалдахгүй шүү дээ” гээд салж байж билээ. Тэр хурлын видео бичлэг алга болчихсоныг Завханаас олж ирсэн. Хадгалж байгаа.

-Та энэ долоон жилийн дотор цагдаа, хууль, шүүхийн шийдвэр биелүүлэх газрынхны дотор байдаг сайн, муу бүхнийг сайтар мэдэж ойлгож ээ дээ?

-Их л юм үзэж мэдлээ. Бие сэтгэлээрээ эдэллээ. Цагдаа, хуулийнхан гэдэг маань хүнд хэцүү ажилтай, хууль сахиулахын төлөө амь биеэ золиослон зүтгэж байдаг хүмүүс юм гэдгийг яс махандаа тултал ойлгосон. Гэвч тэр дунд төрийн нэр барьсан өөдгүй хүмүүс, мөнгө хөрөнгө, танил талын урхинд урхидуулсан цөөн тооны хүн байдаг, тэд нь цагдаа, хуулийнхны өндөр нэр хүндийг сэвтээгээд байдаг юм байна гэдгийг биеэр мэдэрлээ. Энэ завшааныг ашиглан Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн шүүгч Батсайхан, шүүгч Мөнхтуул, Доржготов, Зандраа, Баянзүрх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Цогтзандан, прокурор асан Энхцэцэг /одоо багш болсон гэсэн/, өмгөөлөгч Ламжав, Тахир соёотын дарга асан хурандаа Ганболд, дэд хурандаа Давхарбаяр, Авдрантын хорих ангийн дарга асан Энхбатын гэр бүлийнхэн, сэтгүүлч О.Лхагвадорж, Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төвийн Ичинноров, Маргерита ээж болон бусад хүмүүст баярласнаа хэлмээр байна.

-Аавыг чинь мэдэхээс биш таны гэр бүлийн амьдралыг тэглээ мэдэхгүй юм. Хаана ямаршуу амьдарч байна?

-Аав, ээж, дүү нар Толгойтод амьдарч байна. Эхнэр Нарангэрэл маань хоёр хүүхдээ аваад хот ороод ирчихсэн. Хэдүүлээ энд л суурьших санаатай байгаа. Эхнэр маань хоёр нялх хүүхэдтэй хоцорсон болохоор энэ долоон жилийн хугацаанд үнэн ядарч билээ. Хүү, охин хоёроо арай л нэг траншейнд оруулчихалгүй сургууль, соёлынх нь мөр хөөлгөсөөр найм, есдүгээр ангид оруулчихсан байна. “Алуурчны авгай” гээд ажилд ч авдаггүй байсан юм билээ. Манайх гэдэг айл төр түмнийхээ буянаар нэр цэвэр боллоо.

-Одоо суллагдчихлаа. Юу хийж, яаж шүү амьдаръя гэж бодож байна?

- Одоо тэгнэ, ингэнэ гэж бодсон юм алга. Юу ч болсон биеэ тэнхрүүлэе. Уг нь овоо хэдэн малтай, түүнийгээ харж хандаад боломжийн амьдарч байсан. Өнгөрсөн долоон жилийн дотор нэг хэсэг нь зудаад үхээд, ихэнхийг нь аав зардалдаа хэрэглээд дууссан байна. Мал маллаж амьдрах л лав өнгөрч. Биеэ гайгүй тэнхрэхээр ажил хийнэ. Шударгаар хөдөлмөрлөж “аймшигт алуурчин” гэгдэж явсан энэ хүн хэн байв аа гэдгийг төр, түмнийхээ өмнө үзүүлнэ гэж бодож байгаа гэснээр бид хоёрын яриа өндөрлөв.

3.4 ХИЛСЭЭР НЭГ ЖИЛ ХОРИГДСОН ХҮНД САЯ ТӨГРӨГ ОЛГОЛОО

У.Саран.

Зууны мэдээ. 2002. 04.24. №101

Сүүлийн үед цагдаагийн ажилтан иргэдийг дарамталдаг, гэмт хэрэг үйлдсэн эсэхийг баттай нотлох баримт дутуу дулимаг байхад хохирогчийн мэдүүлгээр тулган хэрэг хүлээлгэдэг талаар их ярих боллоо. нэгэн баримт дэлгэе.

1998 оны тавдугаар сарын 8-ны өдөр Х.Батхишиг Төв аймгийн Борнуур суманд явж байхдаа Г.Мөнхжаргалын бууж цай уугаад мордож. Гэтэл Х.Батхишигийг явсны дараа Г.Мөнхжаргалын хадам аав С.Дугарсүрэнгийн гартаам хөөрөг олдохоо больжээ. Бөөн эрэл сурал болсны эцэст түрүүнд орж ирсэн нэг нөхөр аваад гарсан юм биш байгаа гэж Х.Батхишигийг хардаж эхэлсэн байна. Асууж сураглавал түүнийг таньдаг хүн ер нь байсангүй. Харин ойролцоох айлд байна гэсэн сургаар Г.Мөнхжаргал явж Х.Батхишигтэй уулзжээ. Х.Батхишиг “Би ямар ч хөөрөг аваагүй” хэмээн үнэнээ хэлэхэд Г.Мөнхжаргал “Тэгвэл чамайг цагдаад өгнө” гэж сүрдүүлсэнд шууд л “Би хөөргийг чинь авсан. Олж өгье” гэж хэлээд сураггүй алга болжээ. Ингээд арваад хоногийн дараа цагдаа түүнийг баривчлан 1998 оны тавдугаар сарын 28-наас эхлэн сэжигтнээр цагдан хорьсон байна. Тэрээр, С.Дугарсүрэнгийн гартаам хөөргийг авснаа хүлээсэн бөгөөд ийм хөөрөг байсан гээд л барин тавин мэдүүлсэн байх юм. Ийнхүү түүнд хулгайн хэрэгт нь аймгийн шүүхээс нэг жилийн хорих ял ногдуулж, мань эр ч дээрх ялыг биеэр эдэлсэн байна. Гэтэл хөөрөг алга болж учиргүй эрэл сурал болсон өдрөөс нэг сарын дараа Г.Мөнхжаргалынх нүүх болж ачаалж байтал “хулгайд алдсан” гартаам хөөрөг номын шүүгээн дотроос гарч ирэх нь тэр. Олдох олдохдоо бүр Х.Батхишиг ялын тогтоол уншуулж, хорих анги руу ачигдахаас өмнө олдсон байлаа. “Хөөрөг алга болчихлоо” гэж цагдаад сүртэй тэмдэглүүлж бүр “гэмт этгээд”-ийг нь ч бариад өгчихсөн С.Дугарсүрэн, Г.Мөнхжаргал хоёр хөөргөө олсон талаар цагдаад мэдэгдэхдээ их л хойрго ханджээ. С.Дугарсүрэн хожим нь “Би тэр залууг ял аваад хоригдсон гэж мэдээгүй. Шүүх хуралд оролцоогүй. Тэгээд л өнгөрсөн” гэж ярьсан байна.

Х.Батхишиг иргэний журмаар шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “Хэсгийн төлөөлөгч, дэслэгч Ч.Ариунболд надаас байцаалт авахдаа айлган сүрдүүлж, хийгээгүй хэргийг хийсэн болгон хүлээлгэсэн. Намайг баривчилж, машинд чихээд авч явахдаа “хэргээ хүлээ” гэж зодож дарамталсан. Иймд хилс хэрэгт суусны улмаас учирсан нэр төр болон сэтгэл санааны хохиролд хоёр сая таван зуун мянган төгрөг гаргаж өгнө үү” гэсэн байна. Тэрээр хариуцагч байгууллагаар Төв аймгийн Цагдаагийн газрыг татсан аж. Алдагдсан гартаам хөөргийг олох талаар цагдаагийнхан хуруугаа ч хөдөлгөсөнгүй. Х.Батхишигээс хөөргийг яасан тухай асуухад анхлан “хаячихсан” гэж мэдүүлсэн аж. “Тийм үнэтэй зүйлийг хаядаггүй байхгүй юу, яасан бэ” гэж тулган асуухад “зарчихсан” гэж өчсөн байна. Эзэд нь 150 мянган төгрөгөөр үнэлсэн гартаам хөөргийг хэдэн төгрөгөөр зарсан гэхэд “20000” гэснээ, ердөө л минутын дараа энэ асуултыг давтан асуухад “10000 төгрөгөөр зарсан” гэж хоёр янзаар мэдүүлсэн байх юм. Гэтэл хэргийг шалгах явцад үүнийг төдий л анхаарч үзсэнгүй. Хэргээ хүлээсэн гэдгийг нь л хамгийн ихээр анхаарч, тодорхой эд мөрийн баримт, нотолгоогүй, зөвхөн хохирогчийн мэдүүлгээр Х.Батхишигийг хулгайн хэрэгт буруутган хорьжээ.

Хилс хэрэг хүлээн шоронд суусан Х.Батхишиг нэр төр болон сэтгэл санааны хохиролдоо хоёр сая таван зуун мянган төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийг Төв аймаг дахь сум дундын хоёрдугаар шүүх 2001 оны долдугаар сарын 23-ны өдөр хэлэлцээд Х.Батхишигт нэг сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Ингэхдээ цагдаагийн байгууллагын ажилтны буруугаас уг хэрэг гарсан тул харьяалах газар буюу Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, бодлого зохицуулалтын хэлтсийн улсын төсвийн хөрөнгөөс дээрх нэг сая төгрөгийг гаргуулахаар заажээ. Улсын Дээд шүүх саяхан хяналтын шатны хуралдаанаараа дээрх хэргийг хянан хэлэлцлээ. Уг хурлаас Х.Батхишигт нэр төр болон сэтгэл санааны хохиролд нь нэг сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна.

Бүтэн нэг жил байтугай нэг хоног ч иргэн хүнийг хууль бусаар цагдан хорьсон тохиолдолд буруутай хуулийн ажилтан хариуцлага хүлээх ёстой. Иргэд шүүх, цагдаагийн үүдийг элээж олон жил, сар явж, энэ хооронд хилсээр цагдан хоригдсон ч бай эргээд

ямар ч гомдол санал гаргалгүй орхидог нь эрх, үүргээ умартсан цагдаагийн ажилтныг улам өөгшүүлж байгааг хэлэхэд илүүдэхгүй биз ээ.

3.5 “ЧИ ХЭРГЭЭ ХҮЛЭЭСЭН Ч, ЭС ХҮЛЭЭСЭН Ч ТАВАН МЕТР ЦЕМЕНТЭН ЦОНОГИЙН ЁРООЛД Л ҮХНЭ “

-Хэнтийн Батширээтэд гарсан олон гал түймэрт хэн буруутай вэ?-

Н.Энхбаатар

Хэнтий аймгийн Батширээт сумын иргэн С.Цэвээнсүрэнтэй холбогдох хэрэг 2001 оны 7-р сараас эхлээд сонин хэвлэлийн нийтлэлийн дуулианы нэг болж байсан. Тухайлбал, сумын төвийн шинээр баригдсан Соёл гэгээрлийн төв /клуб/, гүүр, Цэрэн гэдэг айлын сууц шатаасан гээд 100 сая төгрөг хол давсан хохирол учруулсан хэргийг С.Цэвээнсүрэн үйлдсэн нь нотлогдсон тухай бичигдэж байв. Энэ хүн малтай, хөрөнгөтэй эр гэсэн яриа ч гарсан. Гэтэл түүнийг өнгөрсөн 7 хоногийн баасан гарагаас эхлэн Хэнтий аймгийн Батширээт суманд гарсан галын хэрэгт холбогдолгүй хэмээн үзэж уг хэргийг түдгэлзүүлсэн шийдвэр гарчээ. Ямар учраас түдгэлзүүлснийг Улсын мөрдөн байцаах газрын II хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Пүрэвдоржоос өчигдөр тодруулахад, “Хэргийг шийдвэрлэхэд тодорхой нотолгоо байхгүй учраас түдгэлзүүлсэн” гээд шүүх, прокурор эцэслэн шийдвэрлэдэг учраас аль нь үнэн эсэхийг хэлэх боломжгүй гэсэн хариулт өглөө. Уг хэрэгт сэжиглэгдэж байсан хүмүүсийг мөрдсөн тус хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Отгонжаргалтай уулзахад, “Хэрэг мөрдөн байцаалтын шатанд байгаа. Шийдвэрлэгдээгүй байхад ямар нэгэн хариулт өгөх боломжгүй. Харин иргэн Ч.Түмэндэмбэрэл, С.Цэвээнсүрэн, Ц.Нэргүйбаатар, Д.Амарсанаа, Д.Амарбаясгалан, Л.Батсэлэм нарыг Хэнтий аймгийн Батширээт суманд олон удаа гарсан галын хэрэгт холбогдуулан шалгасан боловч тэднийг буруутай гэж үзэх хангалттай нотлох баримт тогтоогдоогүй учраас энэ хэргийг түдгэлзүүлж байгаа юм” гэлээ. Энэ хэрэгт шалгагдсан иргэн Д.Амарсанаа, Л.Батсэлэм, Ц.Нэргүйбаатар нар урьд өмнө нь буюу 1998 онд мөн л галын хэрэгт холбогдож байжээ.

С.ЦЭВЭЭНСҮРЭН: Цагдаагийн хувцастай хүн харахаар л дотор хүйт оргидог болчихсон.

/2001 оны долдугаар сараас эхлэн дөрвөн сар гаруй Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа Ганц худгийн цагдан хорих төвд саатуулагдсан С.Цэвээнсүрэнтэй уулзаж ярилцлаа/.

-Таныг хэдэн газар шатаасан хэрэгт хэзээ, хаана байхад чинь анх баривчилсан юм бэ?

-Хэнтий аймгийн төвд эхнэрээ амаржуулаад сахиж байсан. Арваад л хонож байлаа. Тэгээд 2001 оны зургадугаар сарын 29-өөс 30-нд шилжих шөнийн 24 цагийн орчимд хамаатныдаа унтаж байтал тус аймгийн Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга, хошууч Цагаан ороод ирсэн. Тэр надад “Энд чиний машинтай холбоотой байж магадгүй нэг зөрчил гарчихаад байна. Түүнийг надтай хамт явж үзээч” гэсэн. Тэгэхээр нь “Би тэгвэл машинаа асаагаад хамт явах уу” гэтэл, “Үгүй ээ. Явган очъё” гээд намайг Цагдаагийн хэлтэст дагуулж очоод шууд л гавлан сахилгад хийсэн. Тэгээд “Чи бол галдан шатаагчдыг толгойлогч. Чи бид хоёр ч чангахан юман дээр уулзана” гэж хэлсэн. Маргааш өглөө нь хоёр гэрчтэй нүүрэлдүүлнэ гээд Ц.Нэргүйбаатар, Д.Амарсанаа хоёрын нэрийг хэлсэн. Эхлээд Ц.Нэргүйбаатарыг гаднаас оруулж ирэхэд тэрбээр, намайг “Та С.Агваансодов /С.Цэвээнсүрэнгийн төрсөн дүү/ ахын гэрийн зүүн талд надад “Чи Цэндийн байшинг шатааж өгөөч, чамд 100 гаруй мянган төгрөг өгье гэж хэлсэн биз дээ” хэмээсэн. Дараа нь Д.Амарсанаа орж ирэхэд Цагаан хошууч “Чи юу гэж хэлдэг билээ. Түүнийгээ хэлээч” гэтэл тэр “Та Бархын голын Жаал Гармаагийн бууцны арын гарман дээр Сэлэнгээ бид хоёрыг загас агнаж байхад хээр морьтой, Түмэн ахтай хамт хүрч ирээд 100 гаруй мянган төгрөг өгье. Батширээт сумын клубыг шатаагаад өгөөч гэсэн биз дээ” гэж худлаа гүжирдсэнд нь миний уур хүрч Д.Амарсанаа руу дайрсан. Гэтэл хошууч Цагаан намайг гавлаад аймгийн мөрдөнд хийсэн.

-Та хувьдаа ямар унаатай юм бэ?

-УАЗ-469 машинтай.

-Олон малтай юу?

-Нийтдээ 200-аад толгой малтай. Намайг анх баривчлахдаа л мал, машиныг минь битүүмжилчихсэн.

-Ганц худагт хэзээ хоригдов?

-2001 оны 7-р сарын 2-нд хорьсон. Тэгээд 7-р сарын 16-ныг хүртэл ямар ч хүнтэй уулзуулаагүй. Харин 16-наас УМБГ-ын II хэлтсийн ахлах мөрдөн байцаагч Б.Отгонжаргал шинээр мэдүүлэг авч эхэлсэн.

-Ямар хугацаагаар хоригдсон юм бэ?

-Дөрвөн сар 12 хоног хоригдсоны эцэст хоёр сая төгрөгийн барьцаатайгаар батлан даалтаар гарч, энэ 2002 оны 3-р сарын 8-ныг хүртэл гадуур байцаагдаж байгаад энэ галын хэрэгт холбогдолгүй гэдгийг тогтоосон. Би одоо 3 хүүхэдтэйгээ ам бүл дөрвүүлээ амьдардаг. Ээж маань энэ жил 88 нас хүрч байгаа. Гэрээсээ ах дүү арвуулаа. Хүнд гүтгүүлэн шоронд хоригдож байхад сонин хэвлэлээр “Олон жил баригдаагүй, онц ноцтой гэмт хэрэгтэн С.Цэвээнсүрэнг гарцаагүй нотлох баримтаар баривчиллаа” хэмээн гарч байсан.

Мөн баян, мал хөрөнгөө дарж нуудаг, хүнд мөнгө өгч айлын байр сав шатаалгадаг гээд санаанд оромгүй зүйл гарсан нь надад хэцүү байна.

-Шоронд дарамтлуулж байв уу?

-Дарамтлуулсан юм байхгүй. Харин ч Цагдаагийн Ерөнхий газрын даргаар Д.Сандаг-Очир томилогдсоноос хойш байдал өөр болж Ганц худгийн удирдлагууд ч ёс журмын дагуу харилцдаг байсан. Би тэнд хоригдсоноос хойш бөөрний өрөвсөлтэй, бухимдуу болж, гүжирдэж гүтгүүлснээсээ ч тэр үү цагдаагийн хувцастай хүн харахаараа л дотор хүйт оргидог болчихсон.

-Таныг цагдаа нар дарамталж байсан юм уу?

-ЭЦГ-ын хошууч Батсүх намайг 5 метр гүнзгий цементэн цооногийн ёроолд унагасан. Таваас зургаан хүн гэрчилж байхад “чи хүлээсэн ч, эс хүлээсэн ч тэр 5 метр цооногийн ёроолд л үхнэ” гэж Ганц худагт намайг хоригдож байхад хэлсэн. Би хариуд нь “Гэрчүүдийг хорьж байцаагаач” гэхээр тэднийг хорьж байцаах үндэсгүй гэсэн. Ийм үг дуулаад өөрийгөө хэлмэгдэж үхэх нь гарцаагүй боллоо, яаж гэрчүүдийг авчирч үнэн мөнийг нь олох вэ гэж гурав хоног бодож хамт хоригдогсодтойгоо ярилцсаны эцэст хуурамчаар хэрэг хүлээсэн.

-Хуурамчаар гэнээ?

-Тийм. Гэтэл 4 хоногийн дотор гэрч болоод байгаа хүмүүсийг авчраад хорьчих – сон байна лээ. Тэгээд л 2001 оны 7-р сарын 16-наас ахлах дэслэгч Д.Отгонжаргал шинээр байцаалт авч эхлэхэд нь гэрчүүдийг хорьж шалгуулах зорилгоор хуурамч хэрэг хүлээснээ мэдүүлсэн. Шоронд 4 сар гаруй хоригдоход би нэг ч удаа прокурорын бараа хараагүй. Харин манай ах С.Чойгомбо, өмгөөлөгч Т.Намжил нар Нийслэлийн прокурорын газрын орлогч прокурор Дамчаасүрэнтэй уулзсан байсан. Нийслэлийн прокурор энэ хэргийн талаар зөвлөлөөр оруулснаар намайг даалтад гаргасан юм. Энэ дагуу шалгагдаад суллагдах шийдвэр гарлаа.

-Барьцааны мөнгийг чинь буцааж өгсөн үү?

-Тоо ёсоор нь авсан.

Дүүгээ галын хэрэгт сэжиглэгдсэн цагаас эхэлж хэргийн үнэн мөнийг олох гэж хөөцөлдсөн хүний нэг нь С. Цэвээнсүрэнгийн ах С.Чойгомбо юм байна. Түүнтэй уулзахад маш их сэтгэл санааны дарамтад орж, эдийн засгийн хувьд ч их хохирч ядарлаа. Би одоо 62 настай. Уг нь математикийн багш мэргэжилтэй хүн. Гэхдээ одоо мал малладаг. Мянгат малчин. Дүүгээ гүжир хэрэгт орчихоор нь нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргидог гэгчээр ах дүүсээрээ хохирлоо. Гэхдээ төрийн хууль нүдтэй, ард түмэнд зөвөөр үйлчилдэг юм байна. Харин түүнийг сахиж мөрдөгч зарим нэг хүмүүсийн ухвар мөчид ажиллагаанаас болж хуулийн нэр хүнд унах ёсгүй. Бид хохирлоо хуулийн дагуу төлүүлнэ гэж ярив. Харин С.Цэвээнсүрэнг дарамталсан эсэхийг ЭЦГ-ын чиглэлийн ажилтан хошууч Батсүхээс өөрөөс нь асуух гэсэн боловч орон нутаг руу ажлаар явсан байв.

Д.АМАРСАНАА: Би С.Цэвээнсүрэн ахыг гүтгэсэн нь үнэн. Гэхдээ ...

-Чи С.Цэвээнсүрэн, Ц.Түмэндэмбэрэл хоёрыг яагаад гүтгэсэн юм бэ?

-Ц.Түмэндэмбэрэлийг гүтгэснээ санахгүй байна. Харин С.Цэвээнсүрэн ахыг гүтгэсэн.

-Юу гэж гүтгэсэн юм бэ?

-Би гүтгэе гэж гүтгээгүй.

-Тэгвэл чамайг хэн нэгэн хүн гүтгэ гэж ятгасан юм уу?

-Хамгийн анх намайг хошууч Цагаан барьж ирэхдээ ...

Өдгөө 21 настай энэ хүү ийм хариулт өгсөн. Ярилцлагыг УМБГ-ын хүлээлгийн танхимд авч байсан учраас цааш асуултдаа хариулт авч чадалгүй жижүүрийн цагдаад материалаа хураалгасан юм.

Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ: Батширээтэд гарсан галын хэрэг болгонтой бид хоёрыг холбосон

Галын хэрэгт гүтгэгдсэн гэх Ц.Түмэндэмбэрэлтэй уулзлаа. Тэрбээр одоо 34 настай ч бичиг үсэг мэддэггүй, цэрэгт яваагүй, урьд өмнө нь ямар нэг хэрэгт холбогдож байгаагүй юм байна.

-Таныг энэ хэрэгт холбоогүй гэдгийг тогтоосон уу?

-Ямар ч хэрэг хийгээгүй байхад 2001 оны долдугаар сарын дөрвөнд Хэнтий аймгийн Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга хошууч цагаан, ЭЦГ-ын төлөөлөгч Батсүх нар намайг баривчилж хот руу авч яваад Ганц худагт хорьсон. Би Д.Амарсанаа, Ц.Нэргүйбаатар нарт гүтгүүлснээс болж хэлмэгдлээ. одоо болохоор галын хэргийн эзэн олдтол та нарын хэргийг түдгэлзүүллээ. Эзэн нь олдвол та нарыг цагаатгана гэж мөрдөн байцаагч хэлсэн. Анх байцаахдаа хошууч Цагаан намайг “Чи галын хэргээ хүлээ. Чамайг хүлээдэггүй юм бол цагаан байшин дийлэхнэ үү /Ганц худгийг хэлсэн бололтой/ би дийлэх нь үү ходоодоор чинь хэлүүлнэ” хэмээн хэл үгээр доромжилсон. Тэгээд “гурван гэрчтэй байхад Цэвээнсүрэн та хоёр хаашаа ч зайлахгүй” гэж хэлсэн. Ер нь Батширээтэд гарсан эзэнгүй гал болгонд бид хоёрыг буруутгаж байсан. Намайг ганц худгийн 23 номерт хориход хамт хоригдож байсан хоригдлууд намайг тогоор цохиулж ухаан алдуулах, орос бакалийн өсгийг ханзартал толгой тархи руу цохих зэргээр эрүүл мэндээр хохироож байсанд гомдолтой байна. Одоо ч надад тэр бакал байгаа гэж ярив. Тэрбээр, бага байхдаа өнчирсэн учраас нутгийн айл, ах дүүгийнхээрээ хоног төөрүүлж явдаг. Өнгөрсөн жил батширээт сумын Онон багийн нэг айлын охинтой гэр бүл бололцсон аж. Харин хөрөнгийн эх үүсвэргүйгээсээ болоод өмгөөлөгч авч чадаагүй гэнэ.

ӨМГӨӨЛӨГЧ Т.НАМЖИЛ: Гэрч үү, хүн гүтгэгч үү гэдгийг нягталж нарийн шалгаагүйгээс алдаа гаргасан

Эцэст нь Монголын өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч Т.Намжилтай уулзлаа. Тэрбээр, галын хэрэгт шижиглэгдэж байсан Сандагийн Цэвээнсүрэнгийн өмгөөлөгчөөр ажилласан юм байна.

-Та хэзээнээс С.Цэвээнсүрэнг өмгөөлөх болов. Хэргийн талаар та ямар дүгнэлт гаргасан бэ?

-Хэнтий аймгийн Батширээт суманд олон удаа галын хэрэг гарсан юм билээ. Харин би 2001 оны арван нэгдүгээр сарын нэгнээс С.Цэвээнсүрэн нарын хүмүүстэй уулзаж гарсан хэргийн талаар өөрийнхөө дүгнэлтийг хийж үзсэн. Эцэслээд хэлэхэд энэ хүмүүсийг хэлмэгдүүлж, олон хоног сараар хорьж, эрүүл мэнд, сэтгэл санаагаар нь хохироожээ гэсэн сэтгэгдэл төрсөн. Ийм учраас С.Цэвээнсүрэнд холбогдох хэргийн талаар нийслэлийн прокурорт санал бичсэн юм. Нийслэлийн прокурор өмнөх хяналтын прокурорыг нь өөрчлөн хяналтын прокурор Донойг томилсон. Уг хэрэгтэй нийслэлийн прокурорын зөвлөл танилцаад богино хугацаанд шалгаж шийдвэрлүүлэх үүргийг мөрдөн байцаах газар, хэргийг шалгаж байгаа хүмүүст өгсөн. Энэ дагуу УМБГ шалгаад С.Цэвээнсүрэнг санаатайгаар галдан шатаах ажиллагаанд оролцсон гэсэн нотлох баримт бүрдээгүй учраас уг хэргийг түдгэлзэж С.Цэвээнсүрэнг батлан даалтад гаргах үед барьцаанд авсан хоёр сая төгрөгийг нь буцаан өгч, нутаг руу нь явуулахаар боллоо.

-Ингэтлээ удаашрах хэрэг үү?

-Ийм удаан хугацаагаар шалгагдах хэрэг биш гэж би ойлгодог. Тухайлбал, нотлох баримтад зөв үнэлэлт дүгнэлт өгөөгүйгээс нэг талыг барьж шалган хүний эрх, эрх чөлөөгөөр тоглож хэлмэгдүүлсэн байна гэж үздэг. Тухайн үед гэрчилж байгаа хүмүүс гэрч мөн үү эсвэл энэ хэрэгт холбогдогч С.Цэвээнсүрэнг гүтгэж байна уу, сумын клуб, иргэн Цэндийн байшин, шатаасан цаг хугацаанд С.Цэвээнсүрэн хаана байсан. Мөн С.Цэвээнсүрэнтэй

ойролцоо айл байсан хүмүүс ч энэ хэрэгт хамрагдан шалгагдах ёстой. Хэргийг шалгаж буй хүмүүс санаачилгатай шуурхай ажиллаагүйгээс удаарширсан. Нөгөө талаар хошууч Цагаан, Хэнтий аймгийн эрүүгийн цагдаагийн хэлтэс энэ хэрэгт хариуцлагагүй хандаж мөн л нэг талыг барьж шалгаж энэ хэрэгт үнэлэлт дүгнэлт буруу өгсөн. Мөрдөн байцаалтын явцад С.Цэвээнсүрэн нар энэ галын хэрэгт холбогдолгүй гэж тогтоосон явдал нь сайшаалтай боловч уг хэргийг удаасан явдал нь мөрдөн байцаах ажиллагааг шуурхайлж прокурорын хяналтыг ч сайжруулах хэрэгтэй юм.

-Тэгэхээр С.Цэвээнсүрэн энэ хэрэгт холбогдолгүй болчихлоо гэсэн үг үү?

-Тийм. Хэрэгт холбогдогч С.Цэвээнсүрэнг тухайн үед гүтгэж байсан хүмүүстэй уулзаж ярилцвал хэргийн дүр зураг тодорхой болно. Олон түмэн ч зөв ойлгох байх.

-Одоо С.Цэвээнсүрэнг хичнээн хүн гүтгэсэн нь тогтоогдоод байгаа юм бэ?

- Амарсанаа, Нэргүйбаатар нарын хүмүүс гүтгэсэн. С.Цэвээнсүрэн Хэнтий аймгийн Батширээт сумын иргэн Цэндийн байшин, шинээр баригдсан Соёл гэгээрлийн /клуб/ төвийг шатаасан хэрэгт 2001 оны 7 дугаар сараас эхлээд дөрвөн сар гаруй хугацаагаар Ганц худагт хоригдож, түүний дараа 2002 оны гуравдугаар сарын арваннэгий өдөр хүртэл гадуур байцаагдлаа. Энэ хугацаанд өөрийнхөө нэр төр, эрүүл мэнд, ажил хөдөлмөрөөрөө найман сар хохирсон. С.Цэвээнсүрэн ганцаараа хохироод зогсоогүй түүний ах, дүү, амраг садан, төрлийн хүмүүс нэгэн адил сэтгэл санааны гүн хямралд орж, нутаг орныхоо хүмүүсээс ч ичиж зовдог болчихсон байгаа. Үүний хариуцлагыг хүлээх эзэн байх л ёстой гэж бодож байна.

3.6 Г.ОТГОНБЯМБАА: НАМАЙГ С.ЗОРИГИЙГ ХӨНӨӨСӨН ХЭРЭГТ СЭЖИГЛЭН ХОРЬЖ АМЬДРАЛЫГ МИНЬ АЛДУУЛСАН

/тэргээр 6,5 сая төгрөг нэхэмжилж байна/

Э. Тэнгэр

Монголын мэдээ, 2002.05.12, №096

С.Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэргийн эзэд одоо болтол олдоогүй байна. Хоёр ч Засгийн газар дамжуулаад, хэдэн ч ажлын хэсэг солиод нэмэр алга. Цагдаагийн ажилтнууд энэ хэрэгт маш олон хүнийг хамруулан шалгасан байдаг. Одоо ч шалгаж байна. Тэдний нэг Г.Отгонбямбаатай уулзсан юм. Түүнийг уг хэрэгт сэжиглэн хорьж байцааж байжээ.

- Таныг хэдийд саатуулан хорьсон юм бэ?

- Хоёр ч удаа саатуулсан. Эхний удаад 1998 оны аравдугаар сарын зургаанд Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс орох замд Эрүүгийн цагдаагийн ажилтнууд намайг саатуулан баривчилсан. ЦЕГ-ын тусгайгынхны хараанд би арван цаг гаруй ямар ч шалтгаангүй хоригдсон. Эцэст нь намайг явуулсан л даа.

- Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс орох тийм онц хэрэг байсан юм уу?

-Би тэр үед Бошигт гуайн МНХ-ий гишүүн болж, 1998 оны нэгдүгээр сараас Ардын партизаны холбоо гэж байгуулан жагсаал цуглаан зохион байгуулах талаа хариуцан ажиллаж байсан. Энэ шугамаар ажил хөөцөлдөн цагдаагийн хэлтэс рүү явж байсан хэрэг.

- Дараагийн удаад хэрхэн баривчилсан бэ?

- Түүний дараахан аравдугаар сарын 23-ны 22.40 цагт ЭЦГ-ын ахлах төлөөлөгч Даваажав, Батбаяр нар прокурорын зөвшөөрөлгүй дахин баривчилсан. “Биднийг эсэргүүцэх хэрэггүй. Таныг баривчиллаа” гэсэн. “Ямар учраас тэр вэ?” гэтэл “Улс төрийн тэмцэлтэй чинь ямар ч холбоогүй. Ноцтой гэмт хэрэгт сэжиглэж байгаа” гэсэн тайлбар хэлсэн.

- Тэгээд яасан бол?

- Намайг 72 цаг саатуулаад Ганц худаг дахь урьдчилан хорих төвийн тусгай захиалгат гэгддэг 43 дугаарын камерт хорьсон. Арваад хоног хорихдоо гурван удаа байцаасан.

- Байцаалтын үеэр юу асууж байв?

- Та С.Зориг агсныг ямар учраас хөнөөсөн юм бэ, танай МНХ-ийнхөн ямар их мөнгөтэй юм гээд л байсан. “Та нар хүнээ ол. Би С.Зоригийг алаагүй. Шударга бус бүү загна” гэсэн. Ингээд 1998 оны арван нэгдүгээр сарын дөрвөнд хамгийн сүүлчийн байцаалт авч С. Зориг агсны гэргий Булгантай нүүрэлдүүлэх болсон. Гэвч түүнтэй намайг

уулзуулаагүй. Манай гэр бүлийн хүн, МНХ-ий нарийн бичгийн дарга Элембек нар тодорхойлолт гаргаж батлан даалтад авсан.

- **Хэдий хүртэл батлан даалтад явав даа?**

- Юу ч гэмээр юм бэ дээ. Намайг дуудсан цагт бэлэн бай гэдэг. Би өөрөө дуудахыг нь хүлээлгүй очиж уулздаг байлаа. Нэг жил гаруй ямар ч хариу өгдөггүй, төдөнд ир гээд өдөр заагаад явуулдаг. “Миний даалтад байх хугацаа дууссан уу” гэхээр “хүлээж бай” л гэдэг байв. Дараа нь би Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч Гандмаа гэж хүнд нөхөмжлэл гаргасан.

- **Ямар учраас тэр вэ?**

- Намайг хорьж шийтгэснээс хойш би амьдралгүй болсон. Урьд нь машин засварын компанид ажиллаж байлаа. Гараад иртэл ажлаас халчихсан. Энд тэнд ажилд орох гэхээр “С. Зоригийн алуурчин” гээд нэг нүдээр ч харж үздэггүй. Өдийг хүртэл хохирч явна.

- **Шүүх хэрхэн шийдэв дээ?**

- Байдлыг улам хүндрүүлсэн дээ. Дараа нь УИХ-ын дарга асан Л.Энэбиш гуайд хандлаа. Нэр төрийг минь сэргээж өгөөч гэж. Л.Энэбиш дарга УИХ-ын ХЗБХ-ны дарга Ц.Шаравдоржид үүрэг өгч миний асуудлыг шалгаж барагдуул гэсэн. Ц.Шаравдорж гишүүн цагдаагийн байгууллага уг хэргийг шалгаад хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг авах, надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон бол шүүхэд гомдлоо гарга гэсэн. Тэгээд Хүний Эрхийн Үндэсний Комисст хандсан. Тэгж байж л С.Зоригийн амь насыг бүрэлгэсэн хэрэгт холбогдолгүй гэсэн бичиг авлаа. Нэг үгээр миний нэр төр сэргэлээ. Одоо би эдийн засгийн хохирлоо цагдаагаас нэхэмжилнэ.

- **Хэдий хэмжээний мөнгө нэхэмжлэх вэ?**

- Би машин засварын ажил хийж байхдаа сард 30 мянган төгрөгийн цалин авдаг байсан. Хажуугаар нь гэртээ хоол хийгээд ажилчиддаа нэг бүрийг нь 500 төгрөгөөр зардаг байсан. Өдөрт арван хүнд тогтмол өгдөг байв. Өөрөөр хэлбэл, миний өдрийн орлого 6000 төгрөг байлаа. Тэгэхээр би энэ бүгдийг хохирсон 3,6 жилдээ тооцоод нийт зургаан сая 552 мянган төгрөг нэхэмжлэн шүүхэд хандана.

- **Энэ зургийг цагдаагийн хувцастай авахуулсан нь ямар учиртай юм бэ?**

- Би цагдаагийн байгууллагад 17 наснаасаа эхлээд тасралтгүй 24 жил ажилласан. Цагдаагийн онц сэргийлэгч, Аюулаас хамгаалахын хүндэт тэмдгээр шагнуулж байлаа. Гэсэн ч би энэ байгууллагаас тэтгэвэр авдаггүй. Харин ч амьдралаараа хохирогч болчихсон. “Ганц”-д байхад миний шалгаж байсан ноцтой гэмт хэрэгтнүүд ч тэнд байсан. Ер нь би цагдаагийн байгууллагад ажиллаж байгаагүй бол золиосонд гарчих байсан шүү.

3.7 АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАСАН ХЭРГИЙГ ХЭН ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОДОГ ВЭ

/УЕПГ-аас судалгаа хийжээ/

Р.Мөнхбат

-УЕПГ-ын мөрдөн байцаалтад хяналт тавих хэлтсээс 2000, 2001 онд улсын хэмжээнд гарсан албан тушаалаа урвуулан ашигласан гэмт хэрэгт судалгаа хийжээ. Энэ талаар тус хэлтсийн хяналтын прокурор Ү.Содномцогттой уулзаж ярилцлаа. Албан тушаалаа урвуулан ашигласан хэргийн судалгааг улсын хэмжээнд хийжээ. МБГ-ын дарга Д.Энх-Амгалан хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ төрлийн хэргийн дийлэнхийг прокурор хяналтын шатанд хэрэгсэхгүй болгож байна гэсэн байсан. Судалгааны дүнгээр хэрхэн гарсан юм бэ?

- Албан тушаалын гэмт хэрэг гэдэг нь Эрүүгийн хуулийн 192, 198 дугаар зүйлд заасан үйлдлийг хэлдэг. Бидний судалж үзсэнээр албан тушаалын гэмт хэрэг нь улсын хэмжээнд 2000 онд 191, 2001 онд 195 гарсан байна.

Эдгээр хэргийг хэрхэн яаж шийдвэрлэснийг судлаад үзэхээр сонин баримт гарч байгаа юм. Тухайлбал, 2000 онд гарсан 191 гэмт хэргийн 7,9 хувийг буюу 15-ыг нь прокурор хэрэгсэхгүй болгосон байхад 42,4 хувь буюу 81 хэргийг мөрдөн байцаагч хэрэгсэхгүй болгож, 44 хувь буюу 84 хэргийг шүүхэд шилжүүлсэн байдаг юм билээ.

Өнгөрсөн онд гарсан 195 хэргийн 4,6 хувийг буюу есөн хэргийг прокурор, 40,5 хувь буюу 79 хэргийг мөрдөн байцаагч хэрэгсэхгүй болгож, 34,9 хувь буюу 68 хэргийг шүүхэд

шилжүүлсэн байна. Одоо 28 нь ажиллагаанд, 11 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлчихээд байна.

Судалгааны дүн ингэж л гарсан. Гэтэл Мөрдөн байцаах газрын удирдлагууд, тухайлбал, тус газрын дарга, хурандаа Д.Энх-Амгалан албан тушаалын гэмт хэргийн дийлэнхийг прокурорууд хэрэгсэхгүй болгодог гэж юуг үндэслэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлснийг ойлгохгүй байгаа юм.

- Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавьж ажилладаг шүү дээ. Тэгээд мөрдөн байцаагч хэргийн дийлэнхийг хэрэгсэхгүй болгодог юм бол ямар үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байгаад прокурор хяналт тавьдаггүй юм уу?

- Прокурор хэдийгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавьж, заавар чиглэл өгч ажилладаг хэдий ч өөрөө гардаж хүн асууж байцаадаггүй болохоор яг санаандаа хүртэл хийлгэж чаддаггүй. Зөвхөн албан тушаалын гэмт хэрэг ч биш өөр бусад төрлийн гэмт хэрэг дээр мөрдөн байцаагчийн чадвар муу, бүрдүүлсэн нотлох баримт, материал хангалтгүйгээс гарцаагүй хэрэгсэхгүй болгохоос өөр арга замгүй болдог. Гэхдээ прокурор нэгэнт эрүүгийн хэрэг үүсгэчихсэн үйлдэл дээр сайн шалгаж, ямар үндэслэлээр хэрэгсэхгүй болгох, хэрэг мөн юм уу, биш юм уу гэдэг дээр үнэлэлт дүгнэлт өгдөг. Тэгэхээр МБГ-ын даргын мэдэгдлийг үндэслэлгүй гэж үзэхээс өөр аргагүй.

- Судалгаанаас харахад албан тушаалын гэмт хэргийн 60 гаруй хувийг хэрэгсэхгүй болгоод, 40-өөдхөн хувийг л шүүхэд шилжүүлдэг юм байна шүү дээ. Ер нь дийлэнхийг нь аль ч шатанд байсан хэрэгсэхгүй болгочихдог юм байна гэж ойлгож болох уу?

- Гол нь эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагааг хуулийн дагуу хийж чадахгүй байна гэсэн үг л дээ. Манай цагдаагийнхан хагас дутуу мэдээлэл, баримт олчихоод хүнийг нь цагдаж хориод сүржигнээд л хэрэг үүсгэчихдэг. Тэгээд л шалгана гээд баахан бужигнуулна. Түүнтэй прокурор тэмцдэг. Зүй нь яах ёстой гэхээр хөдөлшгүй нотлох баримт бүрдүүлж, тал талаас нь шалгаж байж одоо боллоо гэсэн үедээ л эрүү үүсгэх хэрэгтэй. Гэтэл одоо хүнээ цагдаж хорьчихож байгаад нотлох баримтаа олох гэж зүтгэдэг хэт буруу тогтолцоо бий болчихоод байгаа юм. Үүнтэй холбоотойгоор албан тушаалын хэрэг, тэр дундаа эдийн засгийн гэмт хэрэг дээр цагдаагийнхны мэдлэг, мэргэжил үнэхээр дутаж байгааг хэлэх хэрэгтэй. Тэгээд хагас дутуу шалгасан хэрэгтээ эрүү үүсгэх гэж зүтгээд байх шаардлагагүй л дээ.

- Албан тушаалаа урвуулан ашигласан хэргийн холбогдогч нь тодорхой албан тушаалтан, эрх мэдэл бүхий хүн байдаг учир мөрдөн байцаагч, прокуроруудтай ярьж зөвшөөд хэргийг хэрэг биш болгох, бүр хэрэгсэхгүй болгох ч явдал байдаг гэж харддаг. Энэ талаар Та юу гэж боддог вэ?

- Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьдаг прокурорын хувьд тийм зүйл байхгүй гэж хэлж болно. Хэрэг хэрэгсэхгүй болгохын хувьд дээр хэлсэн нөхцөл байдлаас болж байгаа. Түүнээс биш тодорхой албан тушаалтан гэмт хэрэг үйлдчихээд байхад түүнийг нь санаатайгаар хэрэгсэхгүй болгосон тохиолдол гарч байгаагүй. Прокурорын байгууллагын хувьд дээд шатны прокурор нь дунд, доод шатны прокурорынхоо ажлыг байнга хянадаг учир тийм зүйл гарах боломжгүй. Тэгэхээр санаатайгаар бусдын нөлөөнд автаж хэрэгсэхгүй болгосон хэрэг байхгүй.

- Аль аймагт албан тушаалын хэрэг их гарсан байна вэ?

- Судалгаанаас харахад Орхон, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт их гарсан байна. Тухайлбал, Орхон аймагт 2000 онд энэ төрлийн гэмт хэрэг 26 гарсан бол 2001 онд 19, Сэлэнгэ аймагт 2000 онд 21, 2001 онд мөн 21 гарсан байх жишээтэй. Хоёр оныг харьцуулсан дүнгээр үзэхэд дээрх хоёр аймаг нэг дүүрэгт тогтмол өндөр байгаа юм. Тухайн орон нутгийн онцлог байдал, үйлдвэр, аж ахуйн нэгж хэт их төвлөрсөн зэрэг нь нөлөөлж байгаа байх.

Албан тушаалын хэрэг хамгийн бага гарсан аймгийг үзэхэд Блган, Хөвсгөл, Завхан, Увс зэрэг аймаг байгаа.

3.8 ТӨР, ИРГЭН ХОЁРЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ МОНГОЛЫН ИРГЭДИЙН БОДОЛ САНАА

/Социологийн судалгааны дүн/

Философийн доктор Б.Батчулуун

Өнөөдөр, 2002.09.20

Энэ өгүүллийг ингэж гарчиглаж болно хэмээн бодож байна. Учир нь энэ социологийн судалгаа нь улс төрийн компани ажил, ялангуяа сонгуулийн үед намуудын захиалгаар хийгддэг, ямар үр дүн гаргахаа урьдчиллаад төлөвлөчихсөн байдаг “судалгаатай” адилгүй, үнэний элемент харьцангуй их, бодитой хийгдсэн юм. Энэ судалгааны асуулга, түүний утга агуулга, үр дүн бодитой эсэх тухайд гарах хариуцлагыг миний бие бүрэн хүлээнэ. Судалгаагаар Монголын нийт хүн амын бодол санааг мэдэх зорилго тавьсан авч харьцангуй цөөн хүнийг хамруулсан тул түүвэр дээр онцгойлон анхаарч анкетуудыг аль болох өөрийн биеэр бөглүүлэх зорилго тавьсан /90 орчим хувийг хоёр сарын хугацаанд өөрөө бөглүүлсэн/. Ялангуяа аймгуудад хийсэн судалгаанд онцгой анхаарч байлаа. Судалгааг 2002 оны найм, есдүгээр сард Улаанбаатар хот, Завхан, Дорноговь аймгуудад явуулсан болно.

Судалгааны анкет бөглүүлэх явцад Монголын нийт хүн амын сэтгэл санааны онцлог гэмээр зарим зүйл ажигласнаа энд дурдъя. Иймэрхүү социологийн судалгааг миний бие хоёр дахь удаагаа бие даан хийж байгаа /өмнө нь зүй ёсны нийгмийн талаар нэгэн судалгаа явуулж байсан/ тул социологийн судалгаа явуулахад ямар ямар хүндрэлтэй тал тулгардгийг мэдэх боллоо.

Манай монголчууд ерөнхийдөө социологийн судалгаанд “хаалттай” ард түмэн. Социологийн судалгаа явуулж байх үед тааралддаг үндсэн бэрхшээл бол монгол хүмүүс аливаа юманд их хардангуй ханддаг учраас асуулга бөглүүлэх явцад жинхэнэ бодол санааг нь гаргаж ирэхэд их төвөгтэй. Тэд өөрийн бодож байгаагаар бөглөхгүй, харин аль болох зөв гэж бодсон хариулыг олж бөглөхийг хичээдэг. Тийм ч учраас асуултыг бөглөх үедээ нэлээд хугацаагаар бодоод суучихдаг. Энэ асуулгаар “таны мэдлэгийг шалгаж байгаа юм биш, таны бодол санааг асууж байгаа юм” хэмээн хичнээн тайлбарлаад нэмэргүй. Нэлээдгүй хүмүүс өөрийн бодол санааг танихгүй хүнд мэдүүлэхгүйн тулд анкет бөглөхөөс аль болох зугатах хандлагатай байдаг. Ялангуяа 55-аас дээш насныхан их “сэжигч” зарим үед ярдаг ч гэмээр ааш зантай байдаг. Улаанбаатарт гэхэд л хоёр хүн хариулахаас шууд татгалзах жишээтэй. Анкет бөглөх явцад хүмүүс надад “та намайг алийг нь бөглөөсэй гэж бодож байна”, “миний бодол ч яахав, харин аль нь зөв хариулт юм бэ” гэх мэтээр судалгааны үр дүн гуйвсан байдлаар гарах асуулт ихээхэн тавьдаг. Мөн асуултыг нь ойлгохгүй байна хэмээн тайлбар шаардаж, урьдчилсан чиг хандлага авахыг хичээх ч тохиолдол гарч байлаа. Бас нэг ажиглагддаг зүйл бол нэлээн нэрэлхүү юм уу даа гэсэн сэтгэгдэл төрсөн. Энэ нь ажил төрөл, боловсролтой холбоо бүхий асуулт бөглөх үед ажиглагддаг. Энэ бүхэн бүх хүнд хамаарагдахгүй нь мэдээж, гэхдээ л нийтлэг харагддаг бэрхшээлтэй талууд. Судалгаа явуулж буй хүн энэ бүхнийг тооцоолж, арга эеийг нь олж байж /энэ нь мэдээжээр бөглөх үед нөлөөлнө гэсэн үг биш/ аль болох тухайн хүний өөрийнх нь бодож байгааг чөлөөтэй гарган, бодитой бөглүүлэхэд нэлээдгүй чармайлт гаргах болдог.

Энэ судалгаагаар миний олж харах гэж хүссэн зүйлийг уншигч авгай та доорх асуултнуудаас харах болно. Ерөнхийдөө төрийг хэрхэн үздэг юм, өөрөө төрийн өмнө ямар байр суурьтай байна, 1990 оноос хойш төрийг үзэх үзэлд нь өөрчлөлт гарсан байна уу, өөрөө иргэнийхээ эрх, үүргийг мэдэж байна уу, төрийн өмнө хэт хүлцэнгүй байна уу гэх мэт асуултын хариуг олж харахыг хүссэн. Үүнийгээ ч олж харж чадсан гэж найдаж байна. Социологийн судалгааныхаа боловсруулалтыг ШУА-ийн Философи, социологийн хүрээлэнгийн SPSS-10 программ дээр боловсруулсан бөгөөд нас, боловсрол, ажил эрхлэлт, намын харьяаллаар гаргасан бүх харьцуулалтыг энд жагсаах боломжгүй байна. Нарийвчилсан үзүүлэлт болон харьцуулалтыг харж, судалгаа шинжилгээндээ ашиглах хүсэлтэй хүмүүс өгүүллийг бичигчтэй эчнээ холбоо барьж болохыг сонордуулъя.

Судалгааны асуултууд хийгээд тэдгээрт хариулсан байдал.

I. Төр бол

- | | | |
|----|-----------------------------|-------|
| 1. | Намайг захирдаг байгууллага | 13,8 |
| 2. | Надад үйлчилдэг байгууллага | 35,3% |

3.	Аль аль нь мөн	40,1%
4.	Аль нь ч биш	4,4%
5.	Мэдэхгүй	6,4%

Хариултаас харахад, төр нь хувь хүнийг захирах төдий үүрэгтэй гэж ойлгох юм уу, аль эсвэл энэ талаар тодорхой ойлголтогүй байгаа иргэд 25 /13,8+4,4+6,4/ орчим хувийг эзэлж байгаа нь либерал ардчилсан зарчмын үүднээс бол тийм ч таатай үзэгдэл биш.

II. Төр, иргэн хоёрын

1.	Төр нь 1-рт, иргэн 2-рт байх ёстой	36,5%
2.	Иргэн 1-рт, төр 2-рт байх ёстой	59,2%
3.	Мэдэхгүй	4,%

Энэ асуулт судлаачдын дунд нэлээд маргаантай байдаг. Гэхдээ жирийн иргэдийн хувьд хувь хүн, төр хоёрын алийг нь эхэлж дээдлэх ёстой юм бэ гэсэн утгаар буух ёстой бөгөөд төрийг хувь хүнээс дээгүүр тавих ёстой гэж үзэгсдийг хуучинсаг үзэлтнүүд хэмээн томъёолж болно. Иргэнийг нэгдүгээрт тавигсдын дунд либерал үзэлтнүүдээс гадна улс төрийн тодорхой үзлийн үүднээс бус харьцангуй эгоист байр сууринаас хандагчид багтаж байгаа юм. Мэдэхгүй гэж хариулагсдын хувьд байгаа нь л төр.

III. Монголын түүхэн дэх төрүүдээс аль нь хамгийн сайн төр вэ?

1.	Чингисийн үеийн төр	34,3%
2.	Богд хаант засаг	0,7%
3.	1921-1990 оны хооронд байсан социалист төр	19,1%
4.	1990 оноос хойших ардчилсан төр	34,3%
5.	Мэдэхгүй	11,6%

Хачирхалтай, Чингисийн үеийн төрийг Монголын түүхэн дэх төрүүдээс хамгийн сайн төр байсан гэж үзэгсэд 34,3%-д хүрсэн! Энэ бол монгол судлаач, түүхч, шүлэгчдийн “Улс төрчдийн” хоосон магтаал, бахархлын цацсан “үр шим”. Үнэндээ жирийн нэг иргэний хувьд хамгийн халгаатай төрүүдийн нэг бол Чингисийн үеийн төр билээ. Амар тайван аж төрөх нөхцөлгүй, байнгын дайн байлдаанд хөөгдөн туугдаж, амьдрал үхлийн зааг дээр амьдарцгаана. Эс бөгөөс булаан дээрэмдэж, алж талж байж олж авсан зүйлсээр амьжиргааныхаа хэрэгцээг хангах болдог. Сайн төр гэдэг бол иргэдээ амар тайван ажиллаж хөдөлмөрлөн, аж төрөхөд тусалдаг төр байх ёстой бус уу! Судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь социализмийн үеийн төрийг сайн төр байсан гэж үзсээр байна. Эдгээр хүмүүст пролетарийн диктатур, хүчирхийлэл, хувьсгалын төмөр гар, анги-ард түмэн гэсэн нэрийн дор их хядлагыг явуулж байсан төрийн төмөр машины тухай ойлголт алга, эсвэл хэтэрхий иргэнлэг бус байдлаас асуудалд хандаж байна. Мэдэхгүй хэмээн хариулсан 11 орчим хувийг асуудалд хамгийн ухамсартай хандсан хүмүүс гэж ойлгож байна. Тэд шинээс сайн зүйл олж харж чадаагүй, хуучин нь болохгүй байсан нь мартагдаагүй хүмүүс. 1990 оноос хойших ардчилсан төр хэмээн хариулагсад /мөн 34,3%/ дотор ухамсартай хариулсан хүмүүс ч бий, орчин үе- олонхийг дагаж хариулагсад ч бий. Мөн өөрсдийнх нь амьдрал бололцоотой байгааг 1990 оноос хойш өөрчлөгдсөн төр-нийгэмтэй холбон ойлгодог янз бүрийн хүмүүс ч /наймаачид, пүүс-компанийн эзэд, улс төрийн хаялгаар ашиг хонжоотой байр суурь эзлэгсэд г.м/ бий.

IV. Монголын төр иргэдээ

1.	Хамгаалж, үйлчлэх үүргээ сайн биелүүлж байна	7,0%
2.	Захирч, удирдах үүргээ сайн биелүүлж байна	11,0%
3.	Энэ хоёр үүргээ хоёуланг сайн гүйцэтгэж байна	8,3%
4.	Энэ хоёр үүргээ хоёуланг муу гүйцэтгэж байна	58,1%
5.	Мэдэхгүй	15,6%

Энд тайлбар хэрэггүй. Шууд ойлгогдох асуулт, хариултауд. Харин төр гэсэн ойлголтонд хамрагддаг байгууллага, аппарат, институтуудад ажилладаг хүмүүс “манай төр иргэдээ хамгаалж, үйлчлэх болон захирч удирдах үүргээ хоёуланг муу гүйцэтгэж байна” гэж хариулагсад 58,1%-ийг эзэлж байгаад анхаарах хэрэгтэй болов уу!

V. Доорх зүйлсээс аль нь хүний эрхийг хамгийн их зөрчдөг гэж Та бодож байна вэ?

1.	Шүүх, цагдаа, тагнуулын гэх мэт байгууллагууд	42,0%
----	---	-------

2. Хулгайч, дээрэмчин, танхайрагчид гэх мэт хуулийн эсрэг этгээдүүд	36,1%
3. Миний харьяалагддаг яам, тамгын газар болоод миний удирдлага	5,3%
4. Надад үйлчлэх ёстой бусад байгууллагууд /дэлгүүр, тээврийн хэрэгсэл, эмнэлэг, холбоо гэх мэт/	10,3%
5. Мэдэхгүй	6,3%

Монголчуудын үздэгээр хүний эрхийг хамгийн их зөрчигч нийгмийн үзэгдэл бол шүүх, цагдаа, тагнуул гэх мэт төрийн байгууллагууд юм байна. Тэд хулгайч, дээрэмчин, танхайрагчдаас илүүгээр хүний эрхийг зөрчигчид болж байна. Миний тааварлаж байгаагаар бол энд хариулсан хүмүүсийн ихэнх нь шүүх, цагдаад холбогдуулан хэлсэн болов уу /IX асуултыг харна уу/. Тагнуулын байгууллага хүний эрх зөрчиж буйг тэр бүр жирийн иргэд ухамсарладаггүй бөгөөд уг нь хамгийн нухацтай хандах ёстой байгууллага мөн. Энд гайхаш төрөм нэг зүйл бол удирдлага, удирдах байгууллага нь хүний эрх зөрчиж байгаа асуудал дээр нэг их хариулт өгөөгүй байгаа явдал. Уг нь энд илүү цагаар ажиллуулах, удирдлагын зүй бус доромж харьцаа, нөхцөл байдалд тохироогүй хууль тогтоомж, тушаал, хөдөлмөрийн хуулийн зөрчилт гээд анхаарах ёстой нэлээд зүйлс энд байх шиг санагддаг. Гэтэл энэ утгаар хариу өгсөн хүмүүс ийм бага хувь эзэлж байгаа нь /5,3/ судалгаанд хамрагдагсад энэ асуултын утга учрыг ойлгоогүйтэй холбоотой байх, эс бөгөөс шүүх, цагдаа болон эрүүгийн этгээдүүдийн хүний эрхийг зөрчиж буй байдал санааг хэт зовоож явдаг учраас энэ хариултыг хоёрдугаар зэрэгт үзэхээс өөр аргагүй болсон биз. Үйлчилгээний байгууллагуудын тухай дөрөвдүгээр хариулт анкетыг зохиогч миний буруугаас болж тийм сайн асуулт болж чадаагүй. Учир нь би энд төрийн болон хувийн үйлчилгээний байгууллагуудыг хольж хутгаснаа хожим нь анзаарсан болно. Одоо нэгэнт төрийн хариуцаж буй дэлгүүр хоршоо гэж бараг үгүй болжээ. Мэдэхгүй хэмээн хариулсан 6,3%-д хамрагдагсад бол хэт амарлингуй буюу хэнэггүйчүүд. Эд бол нийгэм дэх төрийн дарангуйллыг давраагсад мөн. Иргэнлэг хүмүүсийн тэмцлээр бий болсон нийгмийн үнэт зүйлсийг завшигчид, өөрийнхөө төлөө өөрөө бус, бусдын хөдлөхийг хүлээн суугчид. Эдний мэдэхгүй гэсэн хариулт цаанаа асар их хор урхагтай. Асуултыг ойлгоогүйн улмаас юм уу, таалагдаагүйн улмаас тийн хариулсан хүмүүс тун цөөн байгаа болов уу.

VI. Аль тохиолдолд Таны эрх зөрчигдөж байна вэ?

1. Та хувийн шалтгаанаас болж ажил тасалснаар ажлаасаа халагдвал	5,9%
2. Та гачигдлын улмаас маргаашийн онгоцоор явах гэтэл онгоцны билет дууссанаас болж явж чадахаа боливол	5,2%
3. Та байрныхаа хөлсийг тогтмол төлдөг атал улс орны хүндрэлтэй байдлаас болж танай байранд гэрэл-цахилгаан, халуун, хүйтэн усны хязгаарлалт хийвэл	53,5%
4. Дээрх бүх тохиолдолд	35,4%

Энд ихэнх хүмүүс зөв байр сууринд байж, зөв эсэргүүцэл илэрхийлдэг бололтой. Гэхдээ бас эрх, үүргээ, өөрийнхөө бурууг мэддэггүй хүмүүс ч бас байна. Ялангуяа $5,9+5,2=11,1\%$ бол эдлэх ёсгүй эрхийг эдлэх гэж оролдогсод.

VII. Та нэгэн зоогийн газраас гарч явтал цагдаа ирж байцаан, нэгжлэг хийвэл Таны эрх зөрчигдсөн хэрэг мөн үү?

1. Гадуур гэмт хэрэг их байгаа тул ингэх нь зөв, миний эрх зөрчигдөх ч яахав.	2,2%
2. Тэдэнд нэгжүүлснээр надад хохироод байх зүйл байхгүй тул миний эрх зөрчигдсөн юм алга	29,0%
3. Миний эрх зөрчигдсөн хэрэг мөн	54,8%
4. Мэдэхгүй	4,0%

VIII. Та төсвийн нэгэн байгууллагад ажилладаг гэж бодъё. Гэтэл танай байгууллагын сарын цалин өгөх хугацаанаасаа долоо хоногоор хоцорвол Таны эрх зөрчигдөж байгаа хэрэг мөн үү?

1. Улсын төсөв хүндрэлтэй байвал үүнийг уучилж болно	35,3%
2. Долоохон хоног юм бол миний эрх зөрчигдөх ч яамай	6,7%
3. Миний эрх зөрчигдөж байгаа хэрэг мөн	54,7%
4. Мэдэхгүй	3,3%

Дээрх хоёр асуултын 1, 2, 4-р хариултыг сонгогчид бол мөн л нөгөөх “хэнэггүйчүүд”. Өөрсдийн хэнэггүй байдлаараа өөрсдийгөө алж, нийгмийн нөхцөлөө муутгагчид. Ийм хүмүүс нийт иргэдийн тал шахуу хувийг эзэлж байгаа үед иргэд хүний эрхийн төлөө зөв байр суурин дээрээс тэмцэж чадна гэж үү дээ гэсэн эргэлзээ төрснөө нуух юун.

IX. Хэн нэг сайд Та хоёрын хооронд иргэний маргаан гарч, шүүхээр хэргээ шийдүүлэх болбол шүүх аль талд шийдвэр гаргана хэмээн бодож байна вэ?

1. Сайдын талд	52,5%
2. Миний талд	1,3%
3. Хэний зөв байна тэр талд шударгаар шийднэ	38,6%
4. Мэдэхгүй	7,6%

Энд миний нэг найз дээрх асуултны хариултанд “хэн нэг мөнгөтэй баян компанийн эзэн та хоёрын хооронд маргаан гарсан бол” гэсэн асуулт оруулсан бол шүүхийн нүүр царай илүү тод харагдах байсан гэж хэлсэн. Ямар ч байлаа гэсэн төрийн хамгийн гол байгууллага болох шүүхэд итгэх итгэл үнэхээр алдагджээ. Энэ нь хамгийн сэтгэл түгшим төдийгүй гутрам статистик мөн. Төрийн захиргаа нь Байгалийн захиргаанаас (State of Nature) ялгагдах хамгийн гол ялгаа бол хуульт амьдрал билээ. Хууль цаазгүй аль эсвэл түүнийг хэрэгжүүлдэггүй нийгэмд төр байна гэж үзэхэд хэцүү. Төр оршин байгааг хэдэн хүн ямар нэг байшинд суучихаад хуралдах юм уу, ямар нэг албан тушаалтан оршин буйгаар хэмждэггүй, тухайн төрийн үйл ажиллагаа болох хуулийн хэрэгжилтээр мэдэрдэг.

X. Төр, улсад өгч буй миний татварын мөнгө

1. Надад өөрт минь илүүтэй зарцуулагддаг	6,0%
2. Төрийн зардалд илүүтэй зарцуулагдаж байна	39,5%
3. Өөр хэрэггүй зүйлд зарцуулагдаад байна	27,9%
4. Мэдэхгүй	26,6%

Энд татварын тухай Харвардын профессор Р.Нозикийн маргааныг илэрхийлсэн асуулт оруулсангүй. Хэтэрхий философи шинжтэй тиймэрхүү асуулт ард нийтийн саналыг гаргах социологийн судалгаанд тохиромжгүй мэт санагдсан. Ард олон хэдийгээр Засгийн газрын гишүүд, яам, тамгын газрын элдэв дарга, түшмэл, УИХ-ын гишүүдийн гадаад, дотоодын элдэв хурал цуглаан, семинар, томилолтын зардлын талаархи санхүүгийн тооцоог мэддэггүй ч өөрсдийн татварт өгсөн мөнгийг өөрт нь зарцуулахаас илүүгээр төрийн зардал хийгээд бусад хэрэггүй зүйлд их зарцуулаад байна гэсэн таамагтай байдаг байна.

XI. Иргэн хүн хэзээ нэг цагт төрийг эсэргүүцэж болох уу?

1. Ямар ч тохиолдолд болохгүй, энэ нь хэрээс хэтэрсэн зүйл	7,3%
2. Буруу зүйл хийсэн бол болно, төр нь бидний бий болгосон зүйл	84,1%
3. Мэдэхгүй	8,6%

Энд нэгдэх хариултыг сонгосон 7,3 хувь бол өөрийгөө “юу ч биш” хэмээн үздэг нийгмийн хамгийн хүлцэнгүй хэсэг. Төр бол тэдний хувьд “ер бишийн хүч” бараг л тэнгэрлэг гаралтай зүйл. Азийн диспотизм хийгээд “нийт ард түмний төр” гэсэн ойлголтууд энэ хүмүүсийн дунд амь бөхтэй оршдог.

XII. Та улс орноо удирдах хэрэгт оролцож чаддаг уу?

1. Энэ нь төрийн байгууллагуудын хэрэг, миний хийдэг зүйл биш	18,3%
2. Би өөрийн сонгосон УИХ-ын гишүүнээр дамжуулан энэ хэрэгт оролцдог	51,3%
3. Мэдэхгүй	29,3%

Анкетанд байгаа дээрх 3 хариулт таалагдаагүй бололтой, шууд “би улс орноо удирдах хэрэгт оролцож чаддаггүй” хэмээн гараар бичиж өгсөн анкет нэлээд хэд байлаа. Тэгж бичсэн хүмүүс бараг 1,0% болж байна. Энд “мэдэхгүй” хэмээн хариулт өгсөн хүмүүс бараг 30-аад хувь болж байна. Тэдний эргэлзэх чанар нь давамгайлсан нь сайн талтай байгаа юмаа. УИХ-ын гишүүний сонгуульд оролцоод нөгөөдөх нь төр удирдаад байгаа болохоор улс орноо удирдах хэрэгт дам боловч оролцоод ч байгаа юм шиг, гэтэл яг үнэндээ өөрөө төрийг удирдалцаад байна гэхээр үнэмшилгүй санагдсан болов уу.

XIII. Буддын шашин Монголын төрийн шашин мөн үү?

1. Мөн	56,7%
2. Биш	23,2%
3. Өөр ямар нэг шашин байх	1,0%
4. Мэдэхгүй	19,1%

Уг нь энэ асуултаар Буддын шашнаас бусад шашин шүтэх эрх чөлөө, улмаар оюун санааны эрх чөлөө байна уу гэдгийг олж харахыг олж харахыг хүссэн юм. Тэгэхдээ тийм сайн асуулт болж чадсангүй бололтой. “Мөн” хэмээн хариулагсад Монголд оюун санааны эрх чөлөө байхгүй хэмээн хэлж байгаагаа төдий сайн ухамсарлаагүй л болов уу!

XIV. Та төрийн талаархи доорх баримтлалуудын алийг зөв гэж бодож байна вэ?

1. Төр бол муу зүйл, гэхдээ бид төргүй амьдарч чадахгүй	30,4%
2. Төр бол муу зүйл, бид төргүй амьдарч чадна	1,3%
3. Төрд муу зүйл огт байхгүй, төр нь зайлшгүй хэрэгтэй сайн зүйл	53,2%
4. Мэдэхгүй	15,1%

Нэг дэх хариултыг сонгосон 30,4% бол зөн билгийн хувьд ч юмуу, эс бөгөөс улс төрийн боловсролын хувьд цэвэр либерал үзэлтнүүд. Хоёрдугаар хариултыг сонгосон хүмүүсийг либертариан үзэлтнүүд гэмээр байгаа юм. Гэтэл харьцуулалтаас харахад 1,3 хувьд хамаарагдах хүмүүс бол ихэвчлэн бага, дунд боловсролтой байв. Гуравдугаар хариултыг сонгосон 53,2 хувь бол төрийг шүтэх фетишист үзэлтнүүдийн сонгодог илэрхийлэл. “Мэдэхгүй” гэж хариулагсдад мөн талтай хандаж байгаага муний зүгээс энд илэрхийлмээр байна. Мэдэхгүй байгаага мэднэ гэдэг сайн хэрэг бөгөөд асуудалд ухамсартай хандаж, тааж хариулахаас аль болох зайлсхийсэнд тэдний сайн тал оршино. Паспортын асуултнуудын тухайд. Судалгааг хийгч паспортын асуултуудыг аль болох цөөлөх хүсэлтэй байлаа. Гэхдээ л харьцуулалт хийх үед зайлшгүй гарах шаардлагатай хэдэн асуултанд хариулт авахаас өөр аргагүй байв. Судалгаанд оролцогчийн

3.9 МОНГОЛЫН ШОРОНД БАЙГАА ХОРИГДЛУУД АЛБАН ХААГЧДЫН ЗОДУУРТ ТАРЧИЛДАГ

Б.Энхзаяа

Мааньт, Зүүнхараа, Багануур, Тахир соёот, Амгалангийн хорих ангиудад ял эдлээд гарсан Цэрмаагийн Нямдаваа гэгч залуу манай сонинд хандсан юм. Тэрээр шоронд байх хугацаандаа зургаан удаа нийт 81 хоног өлсгөлөн зарлаж байжээ. “Шоронд ял эдэлж буй хүний нэр төр гэж юу байдаг юм бэ гэж зарим хүмүүс боддог. Гэвч тийм биш. Хоригдолд ч өөрийн гэсэн нэр хүнд байдаг юм” хэмээн ярьж буй энэ залуугийн яриаг толилуулъя.

- Эхлээд та өөрийгөө танилцуулахгүй юу?

- Намайг Цэрмаа овогтой Нямдаваа гэдэг. Одоо 31 настай. Улаанбаатар хотод төрж, өссөн. Наймдугаар анги төгсөөд хуучнаар Барилгын тавдугаар ТМС-д орж суралцсан юм. ТМС-д бетон арматурчны мэргэжил эзэмшсэн. Гэвч мэргэжлээрээ ажил хийж байсан удаагүй. Ер нь би их сахилгагүй хүүхэд байлаа. Товчхон хэлэхэд би шоронд орохоосоо өмнө болж бүтэхгүй бүх чанар шингэсэн хүн байсан. Архи ууна, зодоон нүдээн хийнэ. Худлаа ярина. Тэгж яваад согтуугаар хүн хутгалсан хэргээр шоронд суусан.

- Хэдэн жилийн ял сонссон бэ?

-Эрүүгийн хуулийн 239-ийн гурваар шийтгүүлж, чанга дэглэмтэй хорих ангид 4 жил хоригдох ял авсан.

- Тэгээд авсан яландаа гомдолтой байдаг юм уу?

- Үгүй ээ. Харин ч надад хамгийн бага жил өгсөн юм. Бас дээр нь 123 дугаар зүйлтэй байсан л даа. Хамгийн гол нь би хийсэн хэрэгтээ ял авсан. Төрийн хууль намайг шийтгэсэн. Би шоронд ороод тэнд хүний эрх ямар их зөрчигддэгийг нүдээрээ үзсэн. Ер нь хамгийн харгис газар гэх үү дээ. Шоронгийн ажилтнуудад зодуулж, тарчилсан хүн маш олныг харсан.

- Тэгвэл яриагаа шоронд анх орсноос чинь эхлэх үү?

-Анх 1999 оны дөрөвдүгээр сард Мааньт дахь хорих 415 дугаар ангид очсон. Бусдын л адил шорон гэдэг газрын тухай юу ч мэдэхгүй байсан. Идэх хоолтой, яс амар байхын төлөө л арга ядсан арчаагүй хүн явж байлаа. Ингэж явахад минь “Мангас Бек” хочтой олон жил шоронд суусан эр сайн, мууг суралцаж, биеэ авч явах арга ухаан зааж өгсөн юм. Мааньтын шоронд буюу хийдэг байлаа. Буюу гэдэг нь шохой хийдэг газрыг хэлдэг юм. Том нүхийг тойруулаад нэг үе байгалийн түүхий шохой, нэг үе нүүрс хийгээд шатаана. Нүүрсний угаар, шохойны манарсан цагаан тоосон дунд ажиллана. Хувцас тэсэхгүй. Хааяа хорих ангиас бакал тавьж өгдөг ч нэг сарын ая даахгүй. Тэнд миний бие муудсан. Чангын шоронд зургаан сар хэртэй зовсон доо. Уг нь гэрээсээ эргэлт тойролт авдаг байсан үе. Гэвч эргэлт аваад ч нэмэргүй амьтан байлаа.

- Бие чинь муудаад эмчлүүлсэн үү?

- Бие муудаад ажилд гарч дийлэхгүй болсон учраас ахлах ахлагч, баюуны мастер Энхбатад хэлсэн юм. Тэр намайг “Ажилд авч гарна” гээд үхтэл зодсон. Тэгээд гомдлын өргөдөл бичсэн учир эмнэлэгт хэвтээд эмчилээний хэсэгт оруулсан.

- Та анх хэзээ, ямар зорилгоор өлсгөлөн зарласан юм бэ?

- 2000 оны зургадугаар сарын 21-нд “Өршөөлийн хууль гаргуулж өгөөч” гэж өлсгөлөн зарласан. Тэр үед онцгой дэглэмтэй шоронгоос Нямлхагва тэргүүнтэй хүмүүс өргөх бичиг гаргасан байсан. Түүнийгээ сонинд нийтлүүлснийг нь уншсан л даа. Нэг тийм занасан маягийн зүйл бичсэн байсан. Тэгээд би төрийн хуулиар шийтгүүлж буй хүмүүс ингэж болохгүй гэж бодсон. Би өршөөлийн хуулийг баталж өгөх хүсэлтээ гуйлт маягаар бичсэн.

- Хэнд хандаж бичсэн юм бэ?

- УИХ, ХЗДХЯ, ШШБЕГ-ын эрх мэдэл бүхий хүмүүст хандан 40 хүний гарын үсэгтэй бичиг ээлжийн дарга Цогоод өгсөн юм. Ингээд өлсгөлөн зарласан.

- Хариуг нь хүлээлгүй шууд л өлсгөлөн зарласан юм уу?

- Тийм. Өлсгөлөн зарлах хугацаандаа аюулгүй байдлаа хангаж тусгай байлгаж өгөхийг хүссэн. Бас гэдэс дотроо цэвэрлүүлж, эмчийн хяналтад байлгахыг хүссэн. Аль алиныг нь тоогоогүй.

- Өлсгөлөн зарласан явдлыг чинь хорих ангийн удирдлагууд яаж хүлээж авав?

- Хоригдол өлсгөлөн зарлах явдлыг шоронд албан ёсоор зөвшөөрдөггүй ч бас хориглосон хууль байдаггүй юм. Намайг дарга нар ээлжээр дуудаж “Ганц хоригдолтой ирж уулзах зав чөлөөтэй хүн байхгүй. Тэртээ тэргүй өршөөлийн хууль гарах гэж байгаа” хэмээн ярьж ухуулж байлаа. Эхлээд тэд аядуу зөөлөн хандаж байсан. Гэвч би ямар нэг төрийн түшээтэй уулзаж байж л болъё гэж бодож байсан. Долоо хоног өнгөрлөө.

- Танд эм тариа хийж байв уу?

- Үгүй. Тамир тэнхээ ч барагдсан. Нааран дээр хэвтээд өгсөн юм. Сүүлд нь Тамир гэдэг төлөөлөгч “Өргөх бичгийг чинь явуулсан” гээд эмнэлэгт хэвтүүллээ. Өлсгөлөн зарлахаа болиогүй л байсан юм. Нэг өдөр бусад хоригдлууд “Тамир төлөөлөгч “диаграм” хийж байна. Чамайг тоонд гар гэж байна” гэлээ.

- “Диagram” гэж юу гэсэн үг вэ?

- Дэглэхийг хэлдэг. Хүнээр түшүүлээд тоонд гарлаа. Тамир төлөөлөгч намайг зааж “Энэ нөхрийн буруу. Та нар төрийн гэмт хэрэгтнүүд. Байх ёстой газраа л байгаа хүмүүс. Та нарыг яая ч гэсэн бидний дур: Ер нь ихээхэн бослого, үймээн гаргах гээд байх юм бол Тянмины талбайд болсон явдал шиг дарна. Дөрвөн харуулын цэг дээр пулёмёт зоож байгаад шүршихэд буруудахгүй” гэсэн юм. Би ч өлсгөлөнгөө зогсоохгүй гэдгээ хэлсэн. Дараа нь миний хэвтэж байсан гуравдугаар палатад Тамир төлөөлөгч орж ирсэн. Тэр “Чи муу л... өлсгөлөнгөө зогсоо. Алаад хаяна” гээд намайг орон дээр баахан зодсон. Би зугтаад эмч дээр очиж байж гайгүй өнгөрсөн. Ингээд байж байтал УИХ хуралдаж хоёр дахь өдрөө буюу долдугаар сарын дөрвөнд өршөөлийн хууль баталсан.

- Та өлсгөлөнгөө зогсоосон уу?

- Шоронгийн удирдлагууд “За Өршөөлийн хууль чинь батлагдлаа. Чи өлсгөлөнгөө тавь” гэсэн. Өлсгөлөн зарласнаас хойш 13 хоног дээрээ миний бие муудаж эмчилгээнд явсан. Тэр үед анги ч эм тариагаар муу байсан юм. Хорих ангийн жилийн төсвийн эм тариа нь зургаан сар хүрэхгүй л дуусдаг. Нэг удаагийн тариурыг хэд буцалгаад тарина. Түүгээрээ хүний өгзөг рүү хатгахад махийчихна. Гараараа эргүүлж тэгшлээд л шууд тарьдаг юм. Ер нь би энэ мэтийг нь хэлчихдэг байсан. Тэд “Төсөв хүрэхгүй байна” гээд намайг хэлтэй амтай гэх зэргээр элдэв нэр хоч өгнө.

- Эмч нар нь тэгдэг юм уу?

- Эмч нар ч тэгнэ. Шоронгийн зарим нэг албан хаагчийг хараад байхад яг л хулгайч шиг харилцаатай байдаг. Уг нь Хууль зүйн яамнаас баталсан Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын “Хорих ял эдлүүлэх газруудад биелүүлэх тогтоол журам” байдаг юм билээ. Хоригдол хүний таван үүрэг найман эрх байдаг. Таван үүргээ зөрчөөгүй тохиолдолд найман эрхийн дагуу амьдрах боломжтой. Гэтэл энэ найман эрх маш их зөрчигддөг.

- Та яагаад ганцаархнаа өлсгөлөн зарласан юм бэ?

- Намайг хулгайч нар аймаар дэмждэг байсан. Тэднээр миний өлсгөлөн зарласныг болиулах гэдэг байлаа. Энэ тухай дуучин Үнэнхүүгийн дүү Чаминхүү, Азжаргал, Архангайн Чулуундаваа, гал хам Ж. Алтанцоож нар мэднэ. Тэднийг бас дарамталдаг байсан л даа.

- Дахиад яагаад өлсгөлөн зарласан юм бэ?

- Зайсангийн эмнэлэгт эмчлүүлж байгаад гарч ирэхэд засгийн эрхийг Хувьсгалт нам авсан байлаа. Хоригдлуудын загалмайлсан эцэг Санжаасүрэн хурандаа огцорсон юм. Үүнийг эсэргүүцэж чанга дэглэмтэй таван шоронг төлөөлсөн хоригдлын гарын үсэгтэй өргөх бичиг “Шар сонинд” нийтлүүлсэн. Ингээд дахиад л өлсгөлөн зарласан даа.

- Та ингээд янз бүрийн шалтгаанаар өлсгөлөн зарлаад байжээ. Үр дүнг нь үзэв үү?

- Өөрөө л хохирч үлдсэн дээ. Би бүх шатны албан тушаалтанд хандаж 20 удаа өргөдөл бичсэн. Эзэндээ хүрсэн эсэхийг нь мэдэхгүй. Нэг ч удаа өргөдлийнхөө хариуг авч үзээгүй. Ийм учраас өлсгөлөн зарлах нь миний эцсийн арга зам байсан. Монголын шоронд хоригдлыг хүн гэж авч үздэггүй юм. Гэтэл хоригдолд ч гэсэн нэр хүнд гэж байдаг. Үүнийг хүмүүс яаж төсөөлөхөв дээ.

- Та шоронд хүмүүсийн захиа, өргөдлийг их бичиж өгдөг байсан гэсэн. Энэ тухайгаа яриач?

- Би шүлэг бичих сонирхолтой. Оролддог юм. Хүний ярьсныг найруулаад биччихдэг гэх үү дээ. Зарим хоригдлын хүсэлтээр өргөдөл, захиаг нь бичиж өгдөг байсан. Зайсан дахь Хорихын нэгдсэн эмнэлэгт хэвтэж байхдаа анх удаа шоронгийн ханын сонинг хийсэн. Эрүүлийг хамгаалахын 80 жилийн ойгоор тэнд эмчлүүлж байсан хоригдлууд эмч нарыг баярлуулах гэж чадахаараа оролдож байв. Надад хүнд өгчих чихэр, набор байх биш. Тэгээд эмнэлгийнхэнд ханын сонин хийж өгч баярлуулъя гэж бодсон юм. Эмнэлгийн дарга Баяржавхлан хурандаа их баярласан. Надад бүр П. Нямдаваа сайдын гарын үсэгтэй мэндчилгээ өгсөн шүү. Түүнээс хойш Зүүнхараа, Тахир соёотын хорих ангиудад ханын сонин гаргаж байгаа. Хоригдол ч гэсэн хүн учир өөрийгөө голохгүй хүүхнүүдэд захиа бичнэ ээ. Хоригдлууд ер нь захиа их бичдэг. Бүр захиа бичсээр байгаад шоронгоос гараад аваад суучихсан тохиолдол бий. Эмч хүүхэнтэй суусан өндөр Даамиа гэж залуу байдаг. Би тэр хоёрт зориулж “Халгам хайр” нэртэй шүлэг бичиж өгч байлаа.

- Та ер нь хэр сахилгатай хоригдол байв?

- Сахилгатай, дүрмээрээ байсан хүн гэж намайг л хэлнэ. Харин үнэнийг хэлэхэд хорихын ажилтнууд надад дургүйцдэг байсан. Жишээ нь мэдээлэл авах, үзэж харах зурагтгүй газар байлгана. Тэгээд л газрын дарга, прокурор нарыг ирэхэд зурагт үзэж баймаар байна гэдэг. Үүнийг л хэрүүл шуугиан тарьдаг гэж үзээд байдаг юм. Зүүнхараад очиход хоригдлуудынх нь амьжиргаа, албан хаагчдынх нь зан харилцаа ч гайгүй санагдсан. Харин тэнд хорих ангиас өгдөг хоол нь маш муу. Нэг хоригдолд өдөрт 400 грамм талх, 220 грамм гурил, 200 грамм мах, 20 грамм давс, 5 грамм цайны идээ өгөх ёстой байдаг. Зүүнхараад тийм юм байхгүй. Цайны идээ өгөлгүй жил болж байсан. Ямар ч өөх тосгүй цагаан хоол өгнө. Хоолны махаа яаж ч аргалаад хөргөгчгүй учир үнэр орж муудна. Тэгээд дандаа муудсан махтай хоол өгнө. Үүнийг нь хэлэхэд хэл, ам хийлээ гэгдсэн. Удалгүй бие муудаад эмчилгээнд явсан. Хорих ангиудын байр, хоолны талаар яриач гэсэн сонсох хүн байгаагүй учир улсын прокурортой уулзъя гэсэн. Зөвшөөрөөгүй учир хэвлэлийн бага хурал хийлгэх өргөдөл өгөөд өлсгөлөн зарласан. Эмнэлгээс шууд Багануур уруу ачигдсан.

- Багануурт очоод яасан бэ?

- Тэнд харин ч төлөөлөгч, дарга нар нь шат дараалан уулзаад өлсгөлөн зарлахад ч яг дүрмээрээ хандсан. Нэг хэцүү нь шинэ очсон хоригдлуудыг зоонд оруулаад хянагч нар нь “манай шоронтой танилц” гээд ташуурдаж эхэлсэн. Бас утга учиргүй өглөөнөөс орой хүртэл 32 тоот гимнастик хийлгээд байлаа. Үүнд нь халширсан зарим хоригдлууд акт бичүүлье, оргоё гэж ярьж байсан.

- Акт бичүүлнэ гэж юу гэсэн үг вэ?

- Дүрэм зөрчсөнд тооцохыг хэлдэг юм. Ангийн дарга хурандаа Пүрэвсүрэнг дуудаж уулзахад ингэж зодсон талаар нь хэлж, ярьсан. Тэр намайг худлаа ярилаа гэсэн юм. Уг нь Багануурын шорон маш цэвэрхэн, тохилог. Олон улсын зэрэглэлтэй шорон шүү дээ. Гэхдээ намайг хүний хэмжээнд авч үзээд сайхан харилцсан.

- Багануурт хэр удав?

- Тав хоноод л буцаад Зүүнхараад ирсэн. Шинэ жил ч дөхөж байсан. Англи улсын төслөөр Хэрэглээний эдийн засгийн сургалт явагдаж байлаа. Би энэ сургалтанд хамрагдаад шагналын хоног авч, дэглэм буурсан. Дахиад л бие муудаж эмчилгээнд ирлээ. Хорихын нэгдсэн эмнэлэг Зайсанд байдаг юм. Тэндээсээ Амгалангийн

хорих ангид очсон. Очоод л маргааш нь төлөөлөгч, ахлах дэслэгч Нямгомбоос “Төлөөлөгчидтэй харьцаж болох уу” гэж асуусан.

- Яагаад?

- Ер нь эхэлж тэгж асуугаад хэлэх зүйлээ хэлдэг дүрэмтэй. Бие муу байгаа тухайгаа л хэлэх гэсэн юм л даа. Гэтэл Нямгомбо төлөөлөгч шууд л үсдэж аваад газар дэвссэн. Чихнээс цус гарч, хоёр хавирга хугарсан. Ээлжийн даргаар ангийн их эмч дэд хурандаа Дамдинсүрэн гарч байсан. Тэр надад эмнэлгийн тусламж үзүүлсэн.

- Таныг яагаад зодсон юм бол?

- Мэдэхгүй. Ер нь л хоригдол гэдэг чинь хүний эрхэнд байдаг учир ямар нэгэн жижиг сажиг шалтгаанаар үхтэл нүдүүлэх нь элбэг. Нямгомбо намайг айхтар зодсон учир эмчилгээнд найм хоносон. Акт дууссан өглөө нааран дээр хэвтэж байтал ээлжийн ахлагч, хошууч Сүрэнжав “Тоонд гар” гэсэн. Тэр согтуу байсан л даа. Бас л бороохойгоор цохиж, зодсон. Согтуу хүний аргыг олох хэцүү. Тэгээд төрийн албан хаагч гэсэн үүднээс түрэмгий хандана. Ер нь хорихын албан хаагчид хоригдлыг заавал өөрийнхөө харцаар байлгах гэдэг. Үнэндээ энэ хүн өвдөж зовсон байна уу, үгүй юу гэдгийг магадлахыг хүсдэггүй. Хоригдол хүн яаж ч байсан хамаагүй гэж л хандана. Ингээд ямар ч шалтгаангүй зодуулснаа прокурорт хэлсэн. Сүрэнжав прокурорын ерөөнд их өрөвдөлтэй зогсч байлаа. Түүнийг хараад ажил албаас нь салгачих вий гэж их өрөвдсөн л дөө. Би өөрөө ямар ч гомдолгүй гэж гуйсан. Хэд хоногийн дараа зоонд хоригдлуудтай танилцаад “Гал хамтай” болоод би арай гайгүй байсан юм. Нэг өдөр бие засах гээд жижүүрийн байр өнгөрч явтал дэд ахлагч Наранхүү “муухай харлаа” гээд хоёр хөлийн шилбэ рүү зогсоо зайгүй өшиглөсөн. Нүүр рүү мөргөж хамар муруйлгасан. Хөлийн шилбэ аймаар том хавдаж маш хэцүү болсон. Тэгээд яах вэ дээ. Бас л Наранхүүтэй сайндсан. Хамгийн анх намайг Нямгомбо зодоход би “Одоо танай хорих ангийнхан намайг ээлж дараагаар зодно доо” гэж хэлж байсан. Тэгдэг юм. Сүүлд сонсоход Нямгомбо мундаг мотортой хүн байсан. Тэр олон хүний ясыг хэмхэлж, чихний хэнгэргийг хагалсан юм билээ. Одоо Дарханы хорих ангийн дэд дарга хийж байгаа гэсэн. Одоо ч бас олон аавын хүүгийн махыг идэж байгаа байх даа.

Амгалангийн хорих ангид тоосгоны тусгай салбар гэж байдаг. Тэнд болж бүтэхгүй гэж үзсэн хоригдлыг явуулдаг. Намайг тийш нь ачлаа. Тусгай тасагт хийх ажил байхгүй учир ажлын хоног авах ямар ч боломжгүй. 400 грамм талх ч олдохгүй. Жирийн дэглэмтэй мөртлөө буутай цагдаа манана. Өдөрт зургаан сав ус авчирч 100 гаруй хоригдлын өглөө, оройн хоолонд тааруулна. Юмаа угааж, ариун цэвэр сахих ямар ч боломжгүй. Энэ тусгай салбарыг би гайхдаг юм. Ийм хүмүүс бэлдэж нийгэмд гаргаж байгаа юм уу хаашаа юм. Бүү мэд. Тэнд арав хоноод эмчийн үзлэг ирсэн. Сүрьеэ туссан байж магадгүй гээд Тахир соёот руу яв гэсэн. Тахир соёот дахь 429 дүгээр ангид сүрьеэтэй хоригдлуудыг байлгадаг юм. Тэндхийн хоолыг хүн байтугай нохой ч тоож иддэггүй. Хоол их муутай. Хамгийн сүүлд энэдээс суллагдсан.

- Хэзээ суллагдсан бэ?

- 2003 оны нэгдүгээр сарын 27-нд. Энэ бүхний эцэст ганц л зүйлийг хэлэх гэсэн юм. Би өнөөдөр нийгэмд харш зүйл хийгээд төрийн хуулиар шийтгүүлсэн. Ялаа эдэлсэн. Хорих ангийн албан хаагч болгон ял авсан ялтныг засан хүмүүжүүлэх үүрэгтэй гэж боддог юм. Гэтэл зарим нэг зан харилцаа муутай албан хаагч эрх мэдлээ ашиглан хувийн зан чанар, тухайн өдрийнхөө ааш араншингаар, эсвэл согтуу үедээ хоригдол хүмүүсийн зан аашийг эвддэг. Бие махбодид нь хэзээ ч арилшгүй хохирол учруулдаг. Сэтгэл санааны хүнд дарамтад оруулдаг. Энэ нь л надад шударга бус санагддаг юм. Дээр намайг зодсон Нямгомбо төлөөлөгч “Тэр өдөр би ууртай байсан” гэж хэлсэн. Тэртээ тэргүй ял аваад шийтгүүлж буй хүмүүсийг зодож тарчилгах ямар хэрэг байна вэ? Эсвэл шүүхийн тогтоол дээрээ ингэж авирлаж болно гэдгийг заах хэрэгтэй шүү дээ.

- Дандаа шалтгаангүй зодуулдаг юм уу?

- Үгүй л дээ. Өөрсдийн буруугаас болж зодуулдаг л юм. Тэр яахав. Би хоригдлыг ерөөс зодож болохгүй гэх гээгүй. Зодуулах үе зөндөө шүү дээ. Зодуулдаг л юм. Харин яагаад шалтгаангүй зодох ёстой гэж. Эмчилгээнд байгаа өвчтөнүүд хүртэл аймаар зодуулна. Нэгийг нь зодож байснаа бүгдийг хамруулна. Хоригдолтой “Хулгайчууд аа, лалрууд аа” гэж харилцана. Энэ бүхнээс харахад засангийн ажилтнууд өөрсдөө хоригдлыг хүмүүжүүлэх бус эвддэг. Би бол сар болгон л аймаар зодуулаад орилж, хашгирч байгаа хүн хардаг. Хорихын ажилтнууд ухуулга сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажил муу явуулдаг. Ганц нэг хийж байгаа ажил бий л дээ. Гэвч тааруухан.

- Энэ бүхнийг үзлэг шалгалтаар ирэх дарга нарт нь ярьж болохгүй юу?

- Дараа нь хэцүү шүү дээ. Дарга нар ирэх нь гээд шөнөжингөө “диаграм” хийнэ. Энэ нь бидэнд бөөн ядаргаа болдог. Цэвэрлэгээ хийж, ядарсан хоригдлуудыг хувцаслана. Хоолныхоо цэсийг их сайхан хоолны нэрээр сольдог. Хүж асаагаад л сүйд болно. Бид өөрсдөө нэр төрөө хичээж л таараа шүү дээ. Сурвалжлагч ирэхэд ямар хүн уулзуулж яриулахаа товлочихно. Иймээс шоронгийн дотоод байдал гадагшаа хаалттай байдаг. Хорихын зарим ажилтнууд үзлэг хийж яваад сонгино, сармис хүртэл аваад явчихна. Уг нь хутга, мэс л хураах ёстой. Нэг дургүй хоригдлоо өө хайж байгаад зодно. Энэ тухай баримт надад зөндөө бий. Уг нь хоригдол ч гэсэн хүн шүү дээ. Зурагтаар кино үзээд л олон эр хүн уйлж суухыг би харсан. Хэн нэг хорихын ажилтан хүүхдээ дагуулаад ирвэл гар дамжуулж өхөөрдөөд л өгөх байх юмаа олж ядна. Хүүхнүүдийг мөн эр хүний ёсоор шохоорхдог. Хүн болсон хойно тэгж л таараа. Би нэг удаа нэг бүсгүйд зориулж шүлэг бичив ээ. Гэтэл түүний үерхдэг залуу нь хянагч байж. Мэдчихээд намайг байнга өөлж зоддог байсан. Яагаад үгүй гээд байхад зодох үе бишгүй. Энэ хурууг хугалсан юм (Үзүүлэв). Ашгүй тэр шилжиж яваад яс амарч билээ. Би хамгийн гол нь өөрийнхөө тухай шоронд яасан тухайгаа ярих гээд байгаа юм биш шүү. Шоронд ингэж хүний эрх зөрчигддөг талаар өөр дээрээ жишээлж ярилаа. Энэ тухай ШШГЕГ-ын дарга хурандаа Чойжанцан, Хорих ангиудын дарга генерал Л. Гарамжил нарт сониноос дамжуулан хэлэх гэсэн юм.

- Шоронгоос гараад амьдрал ямар байна.

- Хэцүү юм аа. Хүмүүс хүн чанар муутай болжээ. Бараг нийгэм маань шоронгийн хоригдлоос илүү хахир болчихсон санагдаад бухимдал төрдөг. Манай залуус эр эмгүй шалтгаангүйгээр архи уух юм. Намайг уухгүй гэхээр “Хэзээ ийм байсан юм бэ?” гэнэ. Гэтэл би яагаад өөрчлөгдөж болохгүй гэж. Би одоо хууль зөрчилгүй сайхан амьдрахыг хүсч байна. Архичин харахаар залхаж байна. Хоосон хоноод унааны мөнгөгүй байгаа хэрнээ архи олддог гэнэ. Би ч өөрөө архи их уудаг байсан. Одоо уухгүй байж болж л байна. Бас энд хогийн саванд зуурсан гурил хаяжээ. Талх хатаагаад хаясан байна. Тэгэхэд шоронд үхэх гэж байгаа хүн талхны булан мэрээд сэхэж байхыг харж л байлаа. Гэтэл сониныхон очоод сурвалжлага хийгээд хоригдлуудыг гэмт хэрэгтэн, алуурчин мэтээр л сурталчилж бичдэг.

- Авдрант дахь онцгой дэглэмтэй шоронд ноднин жил Нямлхагва гэж залууг олон удаа хутгалж хөнөөсөн. Үүний шалтгааныг шоронгийнхон юу гэж ярьдаг вэ?

- Нямлхагва бусдыг дарамталснаасаа болж алуулсан. Үнэхээр томорчихсон залуу байсан л даа.

- Одоо шоронгоос гарлаа. Юу хийж амьдрах вэ?

- Хоригдлуудын захиаг авч яваад ар гэрт нь баталгаатай хүргэж өгдөг сайн дурын байгууллага байгуулах санаатай хөөцөлдөж явна. Ер нь хоригдлууд захиа л хардаг юм. Ирэхгүй байсан ч горьддог. Хэрвээ шоронгоос суллагдсан, архины мөн чанарыг ойлгосон залуус байвал би тусална. Ингээд сониноор дамжуулан Хорихын нэгдсэн төв эмнэлгийн хурандаа Баяржавхлан, эмч Нараа, дэслэгч Намгэрэл, Тахир соёот дахь хорихын дэд хурандаа Батбаатар нартаа баярлаж талархаж явдгаа хэлье. Хамт хоригдож байсан хүмүүстээ түргэн гарахыг ерөөе.

Хэсэг 4. ХАВСРАЛТ

4.1 ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

19-р зүйл

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана.

4.2 ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ

19-р зүйл

1. Хүн бүр өөрийн санал бодлыг чөлөөтэй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг багтаана.
3. Энэхүү зүйлийн 2-т дурьдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг ногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь:

А/ бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх;

Б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна.

4.3 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван зургадугаар зүйл

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

4.4 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно..

3 дугаар зүйл. Мэдээлэлд хяналт тавихыг хориглох

3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй.

3.2. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй..

4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох

Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

*Улсын Дээд Шүүхийн иргэний хэргийн
танхимын 2000 оны 6 дугаар сарын
25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэв*

4.5 ИРГЭНИЙ ХУУЛИЙН “7”, “392” ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ¹

Манай улсын нийт шүүхүүд 1991 онд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэх эрх зүйн маргаантай 31 хэрэг шийдвэрлэж байсан бол 1996 онд 66 хэрэг, 1999 онд 140 хэрэг шийдвэрлэснээс үзэхэд энэ төрлийн хэргийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.

Монгол улсын иргэний хуулийн 7 дугаар зүйлээр нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гутаагдсан гэж үзвэл уг мэдээг няцаах, учирсан хохирлыг арилгах, гэм хорын хэмжээ, арилгах аргыг шүүх тодорхойлохоор хуульчилсан байна. Түүнчлэн мөн хуулийн 392 дугаар зүйлд зааснаар хохирогчид учирсан эд хөрөнгийн бус хохирлыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах, ийнхүү хохирлын хэмжээг тогтоохдоо худал мэдээг тараасан арга, хэрэгсэл, тарсан хүрээ, сэтгэл санааны үр дагавар, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг харгалзахаар тусгажээ.

Иргэний шинэ хуулиар энэ төрлийн хохирлын хэмжээг шүүх тогтоох болсноор шүүх, шүүгч бүр олон янзаар шийдвэрлэж байна. Жишээлбэл, нэр төрийн хохиролд Баянгол дүүргийн шүүх 180000 төгрөг, Чингэлтэй дүргийн шүүх 1.0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн шүүх 500000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэжээ.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн шүүх 1995-1997 онд нэр төр гутаасан гэх 69 нэхэмжлэл хүлээн авсны 20 хэргийн зохигчид эвлэрч, 49 хэргийн нэхэмжлэлийг хангах, хэрэгсэхгүй болгох зэргээр шийдвэрлэсэн байна. Эдгээрээс 16 хэрэгт бүгд 142.8 сая төгрөг нэхэмжилсний 8.6 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Баян-Өлгий аймгийн шүүх 1996 онд энэ төрлийн 18.0 сая төгрөг нэхэмжилсэн 9 хэрэг шийдвэрлэсний 2 хэрэгт 350 мянган төгрөгийг хохирол гаргуулах болжээ. Нэхэмжлэгч нар өөрийн нэр төр, алдар хүндийг доод тал нь 250.0 мянган төгрөг, дээд тал нь 83.0 сая төгрөгөөр үнэлсэн байна. Харин шүүх эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн гаргуулахдаа доод тал нь 50.000 төгрөг, дээд тал нь 1.0 сая төгрөг гаргуулсан байна. Энэ талаарх дэлгэрэнгүй судлагааг Дээд Шүүхийн мэдээлэл сэтгүүл /1997 оны №2/-ээс үзэж болно.

Энэ төрлийн маргаан гарч байгаа гол шалтгаан нь иргэд Үндсэн хуулийн 16-р зүйлд заасан үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ эдлэхдээ мөн хуулийн 17-р зүйлийн бусдын нэр төрийг хүндэтгэх үүрэгтэй гэсэн заалтыг эс биелүүлснээс болж байна.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн талаарх онолын тодорхойлолтыг Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, ОХУ-ын Иргэний эрхийн сурах бичиг, Эрх зүйн мэдлэгийн товч толь, Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь, Хууль зүйн ухааны доктор С.Нарангэрэлийн Англи-орос хууль зүйн толь номонд хэрхэн тусгасныг авч үзье.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалгад:

Нэр төр, алдар хүнд гэдэг бол хамт олон, нийгэм төрөөс тухайн хүний хувьд өгсөн үнэлгээ юм. Хувь хүн нь нийгмийн гишүүний хувьд алдар хүндтэй байж, нийгэм төрөөс оногдуулсан үүргийг нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ бие хүний тухайд нэр төрөө бодож түүнийг ямагт ариун байлгаж алдраа цуурайтуулах ёс суртахууны хийгээд хууль зүйн ач холбогдол бүхий эрхтэй, үүрэгтэй гэж тайлбарлажээ.

ОХУ-ын иргэний эрхийн сурах бичигт:

Алдар хүнд гэдэг нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, ертөнцийг үзэх үзэл, зан чанарын илэрхийлэлд үндэслэсэн тухайн хүний субъектив, хувь хүний өөрийн үнэлэлт юм.

Нэр төр гэдэг нь нийгмээс иргэн хүнд, түүнчлэн хуулийн этгээдэд хандаж буй

¹Улсын Дээд Шүүхийн мэдээлэл, 2001/01

харилцаан дээр түшиглэсэн хувь хүний /объектив/ дүгнэлт юм.

Албаны нэр хүнд гэдэг нь нийгэмд эзлэх байр суурь, мөн чанарын үнэлгээн дээр түшиглэсэн хохирсон гэх этгээдийн үзэл санаа юм.

Эрх зүйн мэдлэгийн товч толинд:

Нэр төр бол бие хүний талаар нийгмийн зүгээс өгч буй тодорхой үнэлэлт бөгөөд түүний нийгмийн бодит шинж юм. Бие хүний нэр төрийг түүний үйл ажиллагаа, үйл хэрэг үзэл бодлоор тодорхойлно. Алдар хүнд нь бие хүний өөрийн үнэлгээнд илэрхийлэгдэнэ. Энэ үнэлэлт бол бие хүний ухамсар дахь бодит зүйлийн тусгал байдаг ч гэсэн түүнийг тусгайд нь авч үздэг. Иймд нэр төр, алдар хүндийг хооронд нь салгахгүйгээр авч үзэх ёстой. Өнөө үед нийгмийн ёс суртахууны зарчим, иргэд байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаалах явдал нийгэм улс төрийн асар их холбогдолтой юм. Иргэний хууль тогтоомжоор иргэд, байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаална. Иргэд, байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаалах явдал нийгэм улс төрийн асар их ач холбогдолтой юм. Иргэний хууль тогтоомжоор иргэд, байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаална. Иргэд, байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол уг мэдээг няцаахыг дээрх иргэн буюу байгууллага шүүхэд шаардах эрхтэй. Хэрэв дурдсан мэдээг хэвлэлд нийтэлсэн бол зохих няцаалтыг хэвлэлээр дамжуулан гүйцэтгэнэ. Бусад тохиолдолд няцаалт хийх журмыг шүүх мэдээ тараасан аргыг харгалзан тогтоодог.

Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь номондоо:

-ес суртахуун-хэвшсэн тогтсон зан суртал,

-зан суртал-уламжлан заншиж ирсэн ёс, дүрэм, хүн нийтээр хүлээн зөвшөөрсөн дадал заншил

-зан суртахуун-ямар нэгэн нийгэмлэгийн шаардлагад тохирсон хүний ааль, авир, дүрэм, төлөв

-алдар 1. Нэрийн хүндэтгэл

2.Олонд тарсан, дурьдсан нэр /алдар хүнд/

3.Үнэгүй бөгөөтөл хуурам бадруулсан цуурхал

-нэр алдар-ногдсон үүргээ нэр төртэй биелүүлэх

-сэтгэл-элдвийг сэтгэх ухааны эрхтэний санаа, бодол, дур хүсэл

-санаа сэтгэл-сэтгэл гэмтний санаа, амаргүй зүйр

санаа-бодол сэтгэж буй зүйл гэсэн тайлбарыг хийжээ.

Хууль зүйн ухааны доктор С.Нарангэрэл, Англи-монгол-орос хууль зүйн толь номондоо:

-нэр төр-доброе имя

-нэр хүнд-авторитет честь

-алдар хүнд-достоинства

-ёс суртахуун-мораль

-зан суртахуун-нравственность

-нэр алдар-репутация гэжээ.

Сэтгүүл зүйн хүрээнд мэргэжлийн сэтгүүлчийн ёс зүйн зарчимд үнэн зөв мэдээллийг шударга аргаар олж авах, бусдын нэр төрийг хүндэтгэх, худал зүйл мэдээлэх, гүтгэх, үндэслэлгүйгээр буруушаах, аливаа мэдээлэлд хувийн атгаг санаа оруулах, мушгин гуйвуулах, мэдээллийн үнэн зөвийг нотлох явдал хамаардаг байна.

Олон нийт үнэн зөв мэдээлэл авах эрхтэй бөгөөд энэ мэдээллийг цаг алдалгүй тараах үүргийг хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрийн сэтгүүлч нар хүлээдэг. Энэ мэдээллээс үүссэн хэрэг маргаан, эд хөрөнгийн бус хохирлыг үнэлэх талаар шүүхийн практик харилцан адилгүй байгааг харгалзан нэг мөр болгох, хуулийг зөв хэрэглэх зорилгоор

Иргэний хэргийн Танхимаас ЗӨВЛӨХ нь:

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад аргаар гутаасан гэх мэдээлэл бодит үнэнд нийцэхгүй болох нь шүүхээр тогтоогдвол няцаалт хийх журмаар тэдний нэр төрийг хуулиар хамгаалах, харин мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдвол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй

болгох зарчмаар хариуцагчийн хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг хамгаалах, олон ургальч үзэл бодлыг дэмжих журмыг шүүн таслах ажиллагаандаа удирдлага болгоно. Ингэхдээ аливаа мэдээлэл бодит үнэнд нийцсэн байх ёстой гэсэн сэтгүүл зүйн зарчмыг тухайн мэдээлэгч баримталсан эсэхэд анхаарна.

2. Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан гэм хор...” гэдгийг тухайн хохирсон гэх этгээд болон түүний гэр бүлийн гишүүд болон ойр дотны хүмүүсийн санаа сэтгэл цочрох, олон түмнээс ичиж зовох, сэтгэцийн гутралд орох зэргээр ажил амьдралын хэвийн харилцаа алдагдах, үйлдвэрлэл удаашрах, ашиг орлого буурах, бизнесийн үйл ажиллагаанд зогсонги байдал үүсэх зэргээр сөрөг үр дагавар үүссэн байна.

3. Мөн зүйлийн “...учирсан гэм хорыг ... арилгах аргыг шүүх тодорхойлно” гэснийг иргэд, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж шүүх үзвэл мэдээ тараасан анхны аргаар буюу түүнээс илүү үр дүнтэй гэж үзсэн мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нэр төрийг сэргээн тогтоосон болохыг нийтэд мэдэгдэх, няцаалт хийхийг хариуцах эзэнтэйгээр шийдвэртээ тодорхой заана.

4. Иргэний хуулийн 392 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ ... эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэдгийг үндэсний болон гадаад валютаар төлбөр хийх, эсхүл үнэт цаас болон бусдаас авах авлага, хонжвороо шилжүүлэх, үнэ хөлсгүй ажил үүрэг гүйцэтгэх, олон дахин уучлал хүсэх, сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлэх зэргийг хэлнэ.

5. Иргэний хуулийн 392 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзана” гэдгийг доорхи утгаар ойлгоно.

а/ Эд хөрөнгийн бус хохирлын үнэлгээг тогтооходоо мэдээ тараасан аргыг харгалзан үзнэ. Мэдээг үгээр илэрхийлэх нь зургаар, дүрс бичлэгээр, фото зургаар, дуу авиагаар, бичгээр илэрхийлэхээс зарчмын ялгаатай юм.

б/ Мэдээлэл тараасан хэрэгсэл нь үнэлгээ тогтоох бас нэг нөхцөл мөн. Энэхүү арга хэрэгсэл гэдэгт шуудан, холбооны бүх төрлийн техник хэрэгсэл орохоос гадна приставка, видео, компьютер, факс гэх мэт зүйлс хамаарна. Утсаар ярих, факс илгээх нь хоёр өөр тул хохирлын үнэлгээг ялгамжтай тогтооно.

в/ Эд хөрөнгийн бус хохирлыг үнэлэхдээ мэдээлэл тархсан хүрээ, тодруулбал газар нутгийн байршил, нэвтрүүлэх хэрэгслийн хүчин чадлыг харгалзан үзвэл зохино. Жишээлбэл, мэдээг телевизээр нэвтрүүлэхдээ сум, аймаг, улс дэлхийд дамжуулах, олон захиалагчтай хэвлэлд нийтлэх нь цөөн захиалагчтай сонинд нийтлэхээс ялгамжтай болно. Түүнчлэн радиогоор нэвтрүүлсэн бол радио цэгийн тоо, сонсогчийн тоог ч ойролцоогоор тогтоож болох юм.

г/ Хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар гэдэгт нийгмийн амьдралд идэвхтэй оролцож чадахгүй болох, ажлаас халагдах, шагнал, урамшлаас хасагдах, гэр бүл, захидал харилцаа болон өвчний нууц алдагдах, гэр бүл, эцэг, эх, үр хүүхдийн сэтгэл санаанд нөлөөлөх, сэтгэцийн гутралд орох, ажил сургуульдаа явж чадахгүй байх, гудамжинд гарахдаа олон түмнээс ичих зэргээр сэтгэл санааны таагүй байдалд орсон байхыг ойлгоно.

6. Нэхэмжлэгч өөрийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр үнэлэхдээ чухам юуг, ямар үзүүлэлтийг иш үндэслэл болгосныг тогтоож байвал зохино /аргачлалыг зургаар хавсаргав/.

7. Төлбөр хариуцагчийн цалин, орлого, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хэмжээ, мэдээ тараасан санаа зорилго зэргийг харгалзах нь эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг тогтоох нэг нөхцөл мөн. Түүнчлэн тухайн улс, аймаг, орон нутгийн хэмжээнд нэг хүнд ногдох бодит орлого, цалингийн дундаж, амьжиргааны түвшин, мөнгөний ханшны уналт эдийн засгийн чадавхи, ард түмний амьдрал, нийгмийн тогтолцооны шилжилтийн үе дэх эдийн засгийн бэрхшээл зэргийг харгалзан үзнэ.

8. Хэвлэл мэдээллийн байгууллага тухайн мэдээг редакцийн нэрээр тараасан бол өөрөө хариуцагчаар оролцохоос гадна чөлөөт хэвлэлийн зарчмыг үндэслэн мэдээллийг зохиогчийн нэргүй, эсхүл нууц нэрээр нийтэлсэн боловч хэвлэлийн байгууллага зохиогчийн нэрийг заах албагүй, мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй тул өөрөө хариуцагчаар татагдана.

9. Шүүх эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулахын зэрэгцээ хохирогчийн нэр төрийг Иргэний хуулийн 7 дугаар зүйлээр сэргээж, эд хөрөнгийн бус хохирлыг ердийн журмаар хамтатган шийдвэрлэнэ.

Харин яллагдагчийг хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн явдал хохирогчийн нэр төрийг иргэний хэргийн журмаар сэргээхэд саад болохгүй.

Сонгуулийн хууль болон бусад хуульд зааснаар гэм буруутай этгээдэд захиргааны шийтгэл ногдуулахдаа иргэн, байгууллагын нэр төрийг дээрх журмын нэгэн адил хэрэглэх журмаар хамгаална.

10. Насанд хүрээгүй эсхүл эрх эдлэх, үүрэг хүлээх чадваргүй этгээд болон нас барсан хүний нэр төрийг сэргээх асуудлыг зөвхөн тэдний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх залгамжлагч нарын нэхэмжлэлээр шийдвэрлэнэ.

11. Бусдын нэр төрийг гутаасан мэдээг хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран зохиогчоор оролцож тараасан нөхцөлд хамтран хариуцагчаар татагдах боловч бодит үнэнд нийцээгүй тэр хэсгийг бичээгүй, огт мэдээгүй тохиолдолд тухайн хамтран зохиогчийг хариуцагчаас чөлөөлж болох юм.

12. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэх мэдээг зөвхөн өөрт нь мэдээлсэн бол тараасан гэж үзэхгүй. Харин хөндлөнгийн 3 дахь этгээдэд энэ мэдээлэл очсоноор тараагдсан гэж үзнэ.

13. Төр, засгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан нарын албаны үйл ажиллагаа, үзэл баримтлал, авч буй арга хэмжээг олон түмний зүгээс шүүмжилж байгаа явдал байгууллага, ажилтын нэр төрийг гутааж буй явдал биш болно. Гэхдээ хэм хэмжээнээсээ хэтэрсэн шүүмжлэл нь бусдын нэр төрийг гутаахад чиглэгдсэн буюу ийм байдалд хүргэсэн бол нэр төр гутаагдсан гэж үзнэ.

Түүнчлэн мэдээлэл нь уран зохиол, кино, театр, драм, дуурь зэрэг соёл урлагтай холбогдох шүүмж судлалын агуулгатай, эсхүл нөхөрсөг шог зураг, фото эвлүүлэг нь нэр хүндийг гутаасан мэдээлэлд хамаарахгүй”.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН ШҮҮГЧ
ШҮҮГЧ

Р.ЖАМЪЯНЧОЙЖИЛ
Б.ЦОГНЯМ

4.6 ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН ДҮРЭМ- ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХОРОО

“Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй”, Жозеф Антони МкГован, Эрх чөлөө төв ТББ, МННХ, Улаанбаатар хот, 2002 он

Дүрмээс авсан ишлэлүүд: “Чөлөөт хэвлэл гэдэг нь чөлөөтэй хүмүүс гэсэн үг. Ийм учраас дараах зарчмууд үндэсний хил хязгээрын дотор болон гадна хил хязгааргүй чөлөөтэй орших мэдээллийн урсгалын суурь болж, ардчилсан тогтолцоог олж авах хийгээд хамгаалахыг зорьсон бүх хүний дэмжлэгийг хүлээх ёстой”.

1. Цензур нь шууд болон шууд бусаар байж болзошгүй зүйл мөн. Тиймээс хэвлэл мэдээллийн мэдээллээ чөлөөтэй цуглуулах, түгээх аливаа эрхийг хязгаарласан хууль болон практик үйл ажиллагааг цуцлах ёстой. Мөн үндэсний болон орон нутаг, засгийн газрын эрх бүхий алба, үндэсний болон орон нутгийн засаг захиргааны байгууллага хэвлэмэл болон нэвтрүүлэх мэдээний агуулгад хөндлөнгөөс оролцох эрхгүй ба мэдээллийн аливаа эх сурвалжийг хааж хязгаарлах ёсгүй.

2. Хэвлэмэл болон нэвтрүүлгийн хэлбэрээр бие даасан мэдээ бэлтгэх мэдээллийн хэрэгсэл бүх оронд чөлөөтэй нэвтрэх, үйл ажиллагаагаа явуулах бололцоогоор хангагдах ёстой.

3. Засгийн газар нь үйл ажиллагаандаа эдийн засгийн болон аливаа өөр хэлбэрээр орон доторх мэдээний хэвлэл мэдээллийг ялгаварлан гадуурхаж болохгүй. Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл байдаг улс оронд бие даасан мэдээллийн хэрэгсэл нь өөрсдийн хэвлэн нийтлэх болон нэвтрүүлэх үйл ажиллагаандаа шаардагдах бүх материал тоног төхөөрөмжөөр албан ёсны мэдээллийн хэрэгсэлтэй ижил түвшинд хангагдах ёстой.

4. Улс орнууд мэдээг нийтлэх, хэвлэх тоног төхөөрөмж, хуваарилах систем, мэдээний агентуудын үйл ажиллагаа, нэвтрүүлгийн давтамжийн тоног төхөөрөмжүүдийг олж авах бололцоог хязгаарлах ёсгүй.

5. Харилцаа холбооны удирдлагын зүгээс хууль зүй, техникийн болон тарифийн зохицуулалтыг мэдээний хуваарилалтад саад болох, мэдээллийн урсгалыг хязгаарлах чиглэлд ашиглахыг хатуу цээрлэнэ.

6. Засгийн газрын хэвлэл мэдээлэл эрхлэн гаргах хараат бус байдлаа хадгалах ёстой ба олон ургальч үзэл бодолд нээлттэй хандана. Энэ нь хуулинд болон үйл ажиллагаанд тусгагдаж баталгаажих ёстой.

7. Улс орны дотоодод байгаа хэвлэмэл болон нэвтрүүлгийн мэдээний хэрэгсэл гадаад мэдээллийг чөлөөтэй хүлээн авах бололцоотой байх ёстой ба олон нийт ч мөн гадаадын хэвлэл, нэвтрүүлгийг хөндлөнгийн саад тотгоргүйгээр хүлээн авах эрх эдэлнэ.

8. Үндэсний хил нь гадаадын сэтгүүлчдэд нээлттэй байх ёстой. Сэтгүүлчдийг хилээр оруулах зөвшөөрсөн хувь хэмжээний дээд хязгаар байх ёсгүй ба виза хүссэн өргөдөл, хэвлэл мэдээллийн ажилтны бичиг баримт болон ажилд шаардагдах бусад баримт бичгүүдийг шуурхай гаргаж өгдөг байх ёстой. Гадаадын сэтгүүлчид нь ямарваа улс орон дотор чөлөөтэй аялах бололцоотой байх ёстой ба тэдэнд албан болон албан бус мэдээний эх үүсвэрт хүрэх бололцоо, мэргэжлийн хэрэгцээний бүх материал, тоног төхөөрөмжийг чөлөөтэй импортлож, экспортлох зөвшөөрөл олгогдох ёстой.

9. Сэтгүүлчдийг чөлөөтэй нэвтрүүлэх байрны хязгаарлалт эсвэл үүнээс гадна лиценз, зөвшөөрөл олгох замаар сэтгүүлчдийг нэвтрүүлэх аливаа практикийг халах ёстой.

10. Сэтгүүлчид нь бүх иргэдийн нэгэн адил хувь хүнийхээ хувьд халдашгүй байх ёстой ба хуулиар бүрэн хамгаалагдах ёстой. Дайны бүсэд ажиллаж байгаа сэтгүүлчийг энгийн иргэдийн нэгэн адил тооцох ба энгийн иргэдийн эдлэх ёстой хамгаалалт болон эрхийг сэтгүүлчид нэгэн адил эдэлнэ.

4.7 ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД

“Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй”, Жозеф Антони МкГован, Эрх чөлөө төв ТББ, МННХ, Улаанбаатар хот, 2002 он

◆ **Цензурын эсрэг Олон улсын төв.** Энэхүү төв нь үг хэлэх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, дэмжих зорилгоор 1986 онд байгуулагдсан. Энэ бол Их Британы Вант улсын буяны байгууллага бөгөөд олон улсын төв нь Английн Лондон хотод байдаг. Африкийн бүсийн салбар нь Иоханнесбургт байдаг.

Электрон шуудан: info@article19.org

Веб сайт: <http://www.article19.org/>

◆ **Сэтгүүлчдийг хамгаалах хороо.** Хэвлэл мэдээллийн эсрэг гаргасан зөрчилд хяналт тавих, хэвлэлийн эрх чөлөөг дэлхий даяар дэмжих зорилгоор 1981 онд байгуулагдсан. Сэтгүүлчдийг хамгаалах хороо нь Нью-Йорк хотод байрладаг.

Электрон шуудан: info@cpj.org

Веб сайт: <http://www.cpj.org>

◆ **Америк тивийн хэвлэлийн холбоо.** Америк тивийн бүх улсуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллага. Америк тивийн хэвлэлийн холбооны гол цөм нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хороо юм. Энэхүү хороо нь Америк тив дэх чөлөөт хэвлэлийн эсрэг гаргасан зөрчилд хяналт тавьж, хэвлэлийг боомилсон зөрчлүүдийн тухай жил бүр тайлан гаргадаг.

Электрон шуудан: info@sipiapa.org

Веб сайт: <http://www.sipiapa.org>

◆ **Олон улсын сэтгүүлчдийн холбоо.** 1926 онд байгуулагдсан. 100 гаруй орны 450 мянга гаруй гишүүдийг төлөөлсөн дэлхийн сэтгүүлчдийн хамгийн том байгууллага юм. Холбооны төв байр Бельги улсын Бруссель хотод байрладаг ба дэлхийн янз бүрийн тивүүдэд 6-н салбар ажилладаг. Олон улсын сэтгүүлчдийн холбоо нь хүчирхийллийн хохирогч болсон сэтгүүлчдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зорилгоор Олон улсын

Аюулгүйн сан байгуулсан. Холбоо нь хэвлэл мэдээллийн салбарыг төлөөлдөг бусад холбоодтой хамтран ажилладаг. Олон улсын сэтгүүлчдийн холбоо НҮБ-ын системд болон Олон улсын ҮЭ-ийн хөдөлгөөний хүрээнд сэтгүүлчдийн асуудлыг олон улсын түвшинд гаргаж тавьдаг юм.

Электрон шуудан: ifj@pophost.eunet.be

Веб сайт: <http://www.ifj.org>

◆ **Хил хязгааргүй сэтгүүлчид.** Парис хотод төвтэй олон улсын энэ байгууллага Станбул, Лондон, Вашингтон, Абиджан, Бангкок төвтэй, Герман, Белги, Испани, Итали, Швед, Швейцарт салбаруудтай юм. Энэхүү байгууллага хэвлэлийн эрх чөлөөнд халдсан аливаа халдлагын тухай дэлхий даяар мэдээлэл тайлан түгээдэг. Хил хязгааргүй сэтгүүлчид нь сонинуудыг хаасан, хязгааралсан үйл ажиллагааны тухай болон сэтгүүлчид гэмт хэрэгтний бүлэглэлүүд болон суурь үзэлтнүүдийн халдлага, аллагын золиос болсон тухай шинэ баримт нотолгоог цуглуулж газрын зураг дээр тэмдэглэн жил бүр олон нийтэд гаргадаг. Мөн цензурын шинэ хэлбэрүүдийг илчилдэг.

Электрон шуудан: rsf@rsf.fr

Веб сайт: <http://www.rsf.fr>

◆ **Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний хороо.** Энэхүү байгууллага нь хэвлэлийн эсрэг гарсан дарамттай тэмцэж буй сэтгүүлчдэд туслах үйл ажиллагаа явуулдаг. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний хороо нь хэвлэмэл хэвлэл болон өргөн нэвтрүүлгийн салбаруудтай. АНУ-д төвтэй уг байгууллага 6-н тивийн 44 байгууллагатай хамтын ажиллагаатай. Хэвлэлийн эрх чөлөөний дүрэм хэмээх баримт бичгийг эндээс батлан гаргасан ба энэ нь дэлхий даяар бүх орнуудад хэвлэлийн эрх чөлөөний зүг чиг заагчийн үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү дүрэм нь Араб, Хятад, Орос зэрэг нийт 7-н хэл дээр байдаг юм.

Электрон шуудан: freepress@wpfc.org

Веб сайт: <http://www.wpfc.org>

◆ **Фридом хаус. (Эрх чөлөөний байгууллага).** АНУ-д байрладаг фридом хаус нь эрх чөлөөний төлөөх тэмцлийн төв болсоор ирсэн. Нам бус олон нийтийн энэ байгууллага Америкт гарсан цэргийн дэглэм, Өмнөд Африкт гарсан аппаратед, Прагийн хаврын дарангуйлал, Зөвлөлт Холбоот Улс, Афганистанд цөмрөн орсон явдал, Босни болон Руандад гарсан үй олноор хөнөөсөн гэмт хэрэг, Куба, Бирм / Мянмар/, Хятад, Иракт гарсан харгис хэрцгий хүний эрхийн зарчлуудийг зоригтойгоор эсэргүүцэж байсан юм.

Электрон шуудан: fh@freedomhouse.org

Веб сайт: <http://www.freedomhouse.org>

◆ **Үзэл бодлоо солилцох Олон улсын эрх чөлөө.** Энэхүү байгууллага нь мэдээлэл нэвтрүүлэх албаныхаа дэргэд шуурхай мэдээллийн сүлжээ ажиллуулдаг. Мэдээлэл нэвтрүүлэх алба нь 7 хоног тутмын албан ёсны мэдээлэл гаргаж дэлхий даяарх хэвлэлийн эрх чөлөөний байдлын тухай шинэ мэдээллийг уншигчдадаа хүргэдэг.

Электрон шуудан: ifex@ifex.org

Веб сайт: <http://www.ifex.org>

◆ **Америк тивийн хүний эрхийн хүрээлэн.** Америкийн хүний эрхийн хүрээлэн бие даасан, хараат бус Олон улсын эрдмийн хүрээлэн бөгөөд 1980 онд Коста Рика улсад болсон Америк тивийн хүний эрхийн шүүхийн хэлэлцээрээр байгуулагдсан. Энэхүү хэлэлцээрийн дагуу Америк тивийн хүний эрхийн хүрээлэн нь Коста Рикагийн Сан Хосед байрлах болсон бөгөөд янз бүрийн төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын үүднээс олон улсын болон дотоодын хууль эрх зүйн байр суурьтай болсон. Энэ байгууллагын зорилго нь хүний эрхэд хүндэтгэлтэй хандах явдлыг дэмжих, ардчиллыг дэмжих, судалгаа, боловсрол, улс төрийн зуучлал болон техникийн туслалцаатайгаар дамжуулан хүний эрхийн салбарт өргөн мэдээлэлтэй тусгай хэвлэлүүдийг бэлтгэх, тараах, түгээхэд оршдог.

Электрон шуудан: instituto@iidh.ed.cr

Веб сайт: <http://www.iidh.ed.cr/front.html>

◆ **Олон улсын хэвлэлийн хүрээлэн.** Австрийн Вена хотод төвтэй Олон улсын хэвлэлийн хүрээлэн нь хэвлэлийн эрх чөлөөнд халдах аливаа халдлагыг дэлхий даяар ажиглах үүрэг хүлээдэг. Энэ хүрээлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний талаар жил бүр хурал семинар зохион байгуулдаг.

Электрон шуудан: ipi@freemedia.at

Веб сайт: <http://www.freemedia.at>

◆ **Радио өргөн нэвтрүүлгийн хоорондын дэлхийн холбоо.** Канадын Монреальд төвтэй энэ холбоо нь радио өргөн нэвтрүүлгийн хороодтой өргөн хүрээнд ажиллаж тэдэнд тулгардаг тодорхой асуудлаар туслалцаа үзүүлдэг.
Электрон шуудан: amarc@amarc.org
Веб сайт: <http://www.amarc.org>

◆ **Шоронд байгаа зохиолчдын холбоо.** Английн Лондонд байрладаг энэ байгууллага шоронд хоригдож байгаа зохиолчдын бүртгэлийг хөтөлж тэднийг шоронгоос чөлөөлж эрх чөлөөтэй болгоход үйл ажиллагаагаа чиглүүдэг.
Электрон шуудан: intpen@gn.apc.org
Веб сайт: <http://www.oneworld.org./internatpen>

4.8 СЭТГҮҮЛЧИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

“Ардчилсан сонгууль, хэвлэл мэдээлэл”, Глоб Интернэйшнл ТББ, “Сэтгүүлч ба хууль” цуврал №02, Улаанбаатар хот, 2001 он

1. Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлч хүний нэн тэргүүний үүрэг мөн.
2. Энэ үүргээ биелүүлэхдээ сэтгүүлч мэдээ сэлтийг зүй зохисынх нь дагуу цуглуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөө, шударгаар хэлж шүүмжлэх эрхийн зарчмуудыг цаг ямагт хамгаалах.
3. Сэтгүүлч цаад эх сурвалжаар нь мэдэх зөвхөн тийм л баримтуудад тулгуурлан бичиж мэдээлж байх. Сэтгүүлч чухал мэдээг нуун дарах юмуу баримт сэлтийг мушгин гуйвуулж болохгүй.
4. Шинэ сэргэг мэдээ, гэрэл зураг, баримт мэтийг олж авахдаа сэтгүүлч гагцхүү шударга аргыг хэрэглэх учиртай.
5. Аль нэг хэвлэгдсэн зүйл хор уршиг тарихуйц хуудуутай болох нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийнэ.
6. Итгэл хүлээж олж авсан мэдээллийн уг сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч хадгалж байх.
7. Мэдээллийн хэрэгслээр дэвэргэсэн ялгаварлан гадуурхалт ямар аюултайг сэтгүүлч хүн ухамсарлаж, улмаар арьсны өнгө, хүйсний ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн юм уу өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарлаар болон бас бус шалтгаанаар ялгаж гадуурхахаас сэрэмжлэхийн төлөө чадах бүхнийг хийх.
8. Дараах зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно. Үүнд:
 - Бусдын бүтээлийг хулгайлах.
 - Юмыг санаатайгаар мушгин гуйвуулах
 - Бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, элдвийн нэр хоч өгч доромжлох, хүнийг ул үндэсгүй буруутгах.
 - Юмыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хахууль авах.
9. Сэтгүүлчид эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзвэл зохино. Тухайн улс орны хуулийн хүрээнд сэтгүүлчид үзэг нэгт нөхдийнхөө асуудлыг зөвхөн мэргэжлийн үүднээс шүүн хэлэлцэхийг хүлээн зөвшөөрнө. Засгийн газар болон бусад эрх мэдэлтэн хөндлөнгөөс оролцох явдал байж болшгүй.

/Бруссельд төвтэй Олон Улсын сэтгүүлчдийн холбооны 1954 оны Их хурлаас баталж, 1986 оны Их хурлаас шинэчлэн засварлав./







2.1. СУРГУУЛЬ БАЯР БАЯСГАЛАНГИЙН ГАЗАР Л БАЙХ ЁСТОЙ.

А. Баасандорж

Өнөөдөр, 2002.12.13

Тийм биш гэж үү хэмээн хэн нэг нь бас асуух байх л даа. Сургуульдаа явахгүй гэж зүтгэдэг, зарим багшийн нэрийг дуулахаараа айн чичирдэг хүүхэд зөндөө олон байна цаана чинь. Сурган хүмүүжүүлэх ухааны наад захын мэдлэггүй, энэ муу хүүхэд юу мэддэг юм гэсэн үл тоомсорлосон ихэрхэг зангаар хүүхдүүдэд ханддаг дарангуйлагч багш нар сургуулийг баяр баясгалангийн бус уйтгар гунигийн, айдас хүйдсийн газар болгон хувиргадаг байна. Багш болгоныг би дарангуйлагч, сургууль бүхнийг би айдсын газар гэж хэлэх гээгүй ч бас өгүүллийнхээ эхэнд онцлон хэлмээр байна.

Нэгэн зүйл: Манай ангийн багш сургууль дөнгөж төгсч ирсэн залуухан эмэгтэй байдаг. Тэгсэн хэрнээ хүүхдүүдийг баян ядуугаар нь, өнгө үзэмжээр нь ялгаварлан үздэг. Амьдралын бололцоо муутай, сурлагаар тааруу хүүхдүүдийг ад үзэж, ямар нэгэн шалтгаанаар өөр сургууль руу шилжихийг шаарддаг. Намайг л гэхэд байнга ад үзэн, нэг удаа сургуулиас тавьж өгсөн сурах бичгүүдийг хураан авч өөр хүүхдэд өгсөн. Ангийн засварт хэрэглэх 4500 төгрөгийг би хугацаанаас нь долоо хоног хожимдуулж өгсөн юм. Аав, ээжийн цалин буухгүй, амьдралын аргагүй байдлаас л болсон хэрэг л дээ. Түүнээс хойш л надтай ийм маягаар харьцдаг болсон юм. Би энэ ангид долоон жил суралцаж байна. Дасч ижилдсэн анд найз нар, анги сургуулиасаа ганц энэ багшаас болоод явмааргүй байна шүү дээ. (15 настай охины яриа)

Нэгэн зүйл: Наймдугаар ангид байсан үе. Би багаасаа алгебрийн хичээлдээ жаахан тааруу. Нэгэн удаа гэрийн даалгаварт өгсөн тоог өөрөө нухсаар байгаад зөв хариуг нь гаргачихлаа. Үүндээ би их ч баярлалаа. Маргааш нь багшийг даалгавраа шалгаж, самбарт хэн гарах вэ гэхэд би гар өргөөд бодсоноо үзүүлээ. Гэтэл багш “чи хэнээс хуулсан бэ?” гэж асуусан. Түүнээс хойш би нэг ч удаа өөрөө тооны хичээл хийхээ больсон бөгөөд бусдаас шууд л хуулчихдаг болсон. Тэгээд л алтан гурваа авдаг байлаа. (16 настай хүүгийн яриа)

Нэгэн зүйл: Би дөрөвдүгээр ангид байхдаа хичээлийн дундуур мухар олгойн хагалгаа хийлгэж эмнэлэгт хэвтсэн юм. Арваад хоногийн дараа хичээлдээ орохдоо би нилээд олон хичээлээс хоцорсон байлаа. Тэгээд монгол хэлний хичээл дээр мэдэхгүй зүйлээ арынхаа хүүхдээс асууж байтал А багш, “чи хичээл тасалж, тасалж ирчихээд юу ярьж хүүхэд үмүүлээд байгаа юм” гээд намайг ширээнээс татаж босгож ирээд ар нуруу уруу цохьж, хөл рүү хөшиглөсөн. Тэр үед би оёдолтой гэдсээ л хамгаалж, хагалгаа задарчих вий дээ гэж их айж байлаа. Харин азаар тийм азгүй явдал болоогүй. Гэртээ ирээд аав, ээждээ хэлэхэд тэд багштай уулзсан. Түүнээс хойш надад бүр муу болсон. Одоо бид хоёр хонь, чоно. (12 настай хүүгийн яриа)

Нэгэн зүйл: Манай ангийн багш Д гэдэг эмэгтэй маш ууртай. Тавьсан шаардлагыг нь биелүүлэхгүй л бол яахаас ч буцдаггүй. Доромжилж зодох бол энүүхэнд. Жинс өмслөө гээд миний өмдийг ангийн бүх хүүхдүүдийн нүдэн дээр тайлахыг оролдсон. Би чинь эмэгтэй хүүхэд шүү дээ. Хөвгүүдийнхийг бол шууд тайлдаг. Одоо манай ангийн хөвгүүд, багшийн ингэж аашлахаас айгаад бүгд бэлтгэлтэй болж, өмдөн дотуураа байнга шорт өмсдөг болсон гэж ярьцгаадаг. (13 настай охины яриа)

Нэгэн зүйл: Ц багш манай ангид бараг хичээл заадаггүй. Заагаагүй хичээлээрээ сүүлд нь шалгалт авч дүн гаргах нь олонтаа. Хүүхдүүдийг дүгнэхдээ царай зүс, хувцас эдлэлийг нь их харна. Жилийн өмнө шалгалтаа надтай яг ижилхэн алдаагүй өгсөн чинээлэг айлын хүүхдийг онц гаргаж, надад сайн тавьсан. Би үнэхээр их гомдсон. Ингэж ялгаварлаж үзэж болохгүй биз дээ. (9 настай хүүгийн яриа)

Нэгэн зүйлийг энэ мэтээр нилээд их үргэлжлүүлж болно. Гэвч ингээд азная. Уг нь багш нар хүүхдүүдийн дотны анд нөхөр нь байх ёстой. Харамсалтай нь тийм биш байх нь олонтаа. Үүнийгээ ч багш нар өөрсдөө хүлээн зөвшөөрч байна гээд бод л доо.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс 2001 онд явуулсан судалгаанд хамрагдсан 50 багшийн 38 хувь нь сурагчдаа зодож, дарангуйлдагаа хүлээн зөвшөөрчээ. Мөн тэдний 60 орчим хувь нь хүүхдүүд сургууль дээр бусдын дарамтад ямар нэгэн байдлаар өртдөг хэмээн хариулцагдсан байна. Гэртээ тав тухгүй, байнгын дарамтанд байдаг хүүхдүүд олон байдаг тухай бид өмнөх өгүүлэлдээ тодорхой өгүүлсэн. Гэтэл тэд маань сургууль дээрээ ирээд хэн нэг багшийн харцан доор айж бэмбэгнэн суух нь мөн хэцүүеэ. Багшийн дарамт үнэхээр их байдаг нь дээрх судалгаанаас тод томруун харагдаж байгаа. Тавьхан багшийн 20 орчим хувь нь хүүхэд зодогоо өөрсдөө хүлээсэн байна гээд л бодохоор тэр шүү дээ. Тийм үйлдлээ өөрөө илчлэхгүй, худлаа хариулаад өнгөрсөн багш цаана нь хичнээн үлдсэнийг хэн мэдэх билээ дээ.

Сургууль дээр зөвхөн багшийн дарамт байдаг гэвэл бас худлаа. Үе тэнгийнхний, ахмад хүүхдүүдийн айлган сүрдүүлэг, хүчирхийлэл гэж бас нэг аймшиг бий. Энэ үйлдэл бүр их газар авсан байна. Үүнийг би цээжний бангаар хэлэхгүй байна л даа. Дээр дурьдсан судалгааны дүнгээс үзэхэд хүүхдүүд үе тэнгийнхнийхээ дарамтад хамгийн их өртдөг гэж хариулсан байгаа юм. Өөрөөр

хэлбэл янз бүрийн дарамтыг 100 хувь гэж үзвэл 26.8 хувийг нь ийм дарамт эзэлдэг байна. 14.3 хувийг нь төрөл садангийн, 14 хувийг багшийн дарамт, хүчирхийлэл эзэлж байх жишээтэй.

Ерөөс хүүхдүүдийн 34.4 хувь нь ахлах ангийн хүүхдийн, 20 хувь нь багш нарын, мөн 20 хувь нь ангийн хүүхдийн дарамтад өртдөг гэж багш нар хариулжээ. Мөн тэнэмэл хүүхдүүдийн, ойр орчны таньдаг болон танихгүй хүүхдүүдийн дарамтанд орох явдал байдаг гэж тэд хариулсан байгаа юм даа.

Хүүхдийн эрхийн конвенцид хүүхэд бүр үнэ төлбөргүй боловсрол эзэмших эрхтэй гэдгийг тунхагласан байдаг. Тэд энэ эрхээ эдлэхийн тулд сургууль соёлын газрыг зорих нь дамжиггүй. Харин тэднийг ирэхэд тайван амгалан, сэтгэл өөдрөг байлгаж, авъяас билэг, бие бялдрыг нь хөгжүүлэх, бүхий л боломжийг олгож байх орчныг нь сайн бүрдүүлэхсэн. Үүний төлөө хүн бүрийн, тэр тусмаа багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүчин зүтгэл асар их хэрэгтэй билээ. Сургууль зөвхөн баяр баясгалангийн л газар байх ёстой гэдгийг өгүүллийнхээ эцэст дахин нэг дурдсу.

2.2. СУРАГЧДЫНХАА ТАЛ ХУВИЙГ ЦАГААН ХУУДАСТАЙ ТӨГСГӨСӨН БАГШИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА БАЙХГҮЙ ГЭЖ ҮҮ?

Д. Цээпилмаа

Одоогоос олон жилийн өмнө юм даг. Бид долдугаар ангид сурч байхдаа ангийн багшаа голгүй гомдоон уйлуулж билээ. Уг нь багшаа биш жижүүрээ буруутгасан аястай захидал бичиж санал хүсэлтийн хайрцагт хийсэн юм. Гэтэл хэрэг бишдэж хөөрхий багш маань буруутан болчихсон байсан. Багш нэг хэсэгтээ бидэнд гомдож, бид багшаа баярлуулах гэж элдвээр хичээж байснаа ер мартдаггүй юм. Бас нэгэн явдлыг эргэн саналаа. Геометрийн багшийнхаа хагас сайн өдөр заасан томъёог нэг дэх өдөр нь нэг ч сурагч санасангүй. Ангийн гучин таван сурагч, тэр дундаа тоонд гайгүй хэдээс нь лавлахад мэдэх хүүхэд байгаагүй болохоор барагтайд хямардаггүй багшийн маань хоолой зангирч байсансан. Харин хожим нь тэр томъёог бид хэзээ ч мартахааргүй цээжилсэн. Одоо хэр нь " $L=2P/R$ " гэсэн тойргийн уртыг олдог томъёо цээжинд байдаг юм. Энд чухам юуг өгүүлэх гээд байгааг уншигч та гайхаж байна уу? Сургуулийн тухай, багш сурагчийн харилцааны талаар цаашлаад сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай хөндөн бичихийг хичээлээ.

Ялгаварлан гадуурхагдсан хүүхдүүд

Сургууль бол харилцааны орчин. Дээр өгүүлсэнчлэн багшаа гомдоох, багшдаа гомдох, сурагчид нь өөр хоорондоо шөргөөцөлдөх гэхчилэн харилцааны зөрчил бараг л өдөр тутам тохиолддог. Энэхүү жижиг зөрчил нь гүнзгийрвэл хүчирхийллийн нэг хэлбэр болдог төдийгүй хүүхдийн сурлага, хүмүүжилд муугаар нөлөөлдгийг харин хэн ч анзаардаггүй нь харамсалтай.

"Сүүлийн жилүүдэд хүүхдийн сурлагын амжилт, чанарын түвшин эрс доошилжээ. Ихэнх сургуулиудад дээрх үзүүлэлт 50 хувьд хүрэхгүй байгаа нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн, эцэг эхчүүдийн цаашлаад төр засгийн анхаарлыг татахгүй байхын аргагүйд хүрсэн" гэж БСШУЯ-ны Бага дунд боловсролын бодлого зохицуулалтын газрын дэргэдэх сургуулийн нийгмийн ажилтны нэгжийн мэргэжилтэн Б. Цэрэнлхам сэтгэл зовнин өгүүлсэн юм.

Хүүхэд ямар нэгэн асуудалтай байж гэмээнэ сэтгэл санаа тайван байж, өөдрөг сэтгэлтэйгээр сурч, боловсорч чаддаггүй байна. Ялангуяа сургууль дээрээ ямар нэгэн дарамт шахалттай учирдаг бол хүүхэд сурах нь бүү хэл хичээлдээ явахаас ч дургүйлэхэд хүрдэг ажээ.

Мэргэжилтнүүдийн судалгаа үүнийг нотолно. Нийслэлийн зургаан дүүргийн 19 сургуулийн 3408 хүүхдийн дунд "Сургуульд хүчирхийллийн хэлбэрүүд байдаг уу" сэдвийн дор судалгаа явуулжээ. 1792 хүүхэд буюу судалгаанд оролцогчдын 43.1 хувь нь багш нар хүүхдийг ялгаварлаж харьцдаг гэж хариулжээ. Багш нар сурагчдаа сурлага, сахилга, өмссөн хувцас, өнгө үзэмж, царай зүс, амьдралын боломж бололцоогоор нь ялган ангилж, өөр өөрөөр харьцдаг үзэгдэл хотын төв, гэр хороолол, захын сургуулиудын аль алинд нь амь бөхтэй оршсоор байна. Дээрх хүүхдүүдийн 717 нь багшдаа хэл амаар доромжлуулдаг, 1020 нь үргэлж загнуулдаг байх юм. Тэглээ гээд хүүхдүүд багшдаа гомдоод өсөрхөөд байдаггүй гэнэн цагаахан амьтад гэдэг нь судалгаанаас бас харагджээ. Судалгаанд оролцогч 1032 хүүхэд багш шаардлага тавьх нь зүйтэй гэж хариулсан төдийгүй багшийгаа "өндөр, мэргэжил, өргөн мэдлэгтэй, биеэ сайхан авч явдаг" гэж тодорхойлсон байна.

Хүүхдийн хандлага ийнхүү ямагт багш руугаа тэмүүлж зан сайтай багш нараа, ялангуяа ангийн багшаа бусдаас илүү хайрладгийг Б. Цэрэнлхам олон жилийн туршлагаараа баталж байгаа юм. Гэтэл ганц нэг багшийн зан авираас болж хүүхдүүд доорх зүйлсийг өгүүлэхэд хүрч байна.

15 настай. С. (7 дугаар ангийн сурагч)

- Манай ангийн багшийг Д гэдэг. Багш маань эмэгтэй хүн мөртлөө маш ууртай. Тавьсан шаардлагыг нь биелүүлэхгүй л бол яахаас ч буцдаггүй. Доромжилж зодох бол энүүхэнд... Жинсэн өмд өмссөний төлөө миний өмдийг ангийн бүх хүүхдүүдийн нүдэн дээр тайлахыг оролдсон.

13 настай М. (6 дугаар ангид сурдаг)

- Зарим үед “Ц” багш заагаагүй хичээлээрээ шалгалт шүүлэг авч дүн гаргадаг. Тэр багш манай ангийнхны болон миний эрхийг боогдуулж байна.

10 настай Г. (4 дүгээр анги)

- Бид зааланд тоглож, давтлага авмаар байна. Давтлага өгөөгүй байж муу гаргадаг. Мөн төлбөргүй дугуйлантай болоосой.

Энэ мэт багшдаа гомдсон хүүхдийн өгүүллийг жагсаавал тоймгүй олон бий. Урмыг нь хугалахаар ууцыг нь хугал гэсэн мэргэн өвгөдийн сургааль ч бий. Алгебрийн багш нь хүүгийн хичээл зүтгэлийг үнэлээгүйгээс 10 дугаар ангиа төгсгөж чадалгүй ачигч болсон залуу насан туршдаа гомдлоо тээж яваа жишээ ч байна. Саяхан багш нараас асуулга явуулахад “багш байгаа учраас сургууль байгаа” мэт сэтгэгдэл төрүүлэхүйц хариулт өгчээ. Гэтэл үнэн хэрэг дээрээ “хүүхэд байгаа учраас сургууль байж, сургуульд багш ажиллаж цалин авч байгаа юм”. Нийгэмд эрдэмтэй чадалтай хүн хэрэгтэй. Тэднийг сургаж хүмүүжүүлэх, бүр гэгээрүүлэх үүрэг багш нарт ногддог гэсэн мэргэжилтний үг нэгийг бодуулна.

2001-2002 оны хичээлийн жилд Говьсүмбэр аймгийн 10 жилийн сургуулийг 228 хүүхэд төгссөнөөс 55.3 хувь нь “Цагаан хуудас”-тай төгсчээ. Энэ бол туйлын хангалтгүй үзүүлэлт. Гэтэл тэдгээр хүүхдийг сургах үүрэг хүлээсэн багш нар цалингаа авдагаараа авч, хийдгээ хийчихсэн улс шиг харц дээгүүр явцгаасан хэвээр. Үүргээ ухамсарлаагүй, биелүүлээгүй багш, сургуульд хүлээх хариуцлага баймаар. Хөөрхий хүүхдүүд л хохироод үлддэг жаягийг халах цаг болсон мэт санагдана.

Багш хүний ёс зүйд үл нийцэх авир араншин, байр байдал үзүүлсний учир 238 хүүхэд багштайгаа байнга зөрчилддөг, 1645 хүүхэд хаяа зөрчилддөг бол 1588 хүүхэд хүлцэнгүй хүлээн авдаг гэж хариулжээ. Хүүхэд хувь хүн болон төлөвшихэд хамгийн их нөлөөлдөг сургуулийн орчин ийм л байна.

“Ноёнтон тэрсэлбэл толгойгүй”-н үлгэрээр хүүхэд аливаад хүлцэнгүй байх, хүчирхийллийг ердийн зүйл мэт хүлээн авч, нийгэмд өөрийн гэсэн байр суурь эзэлж чадахгүй сул дорой нэгэн болохын эхлэл сургуулийн орчинд тавигдаад байх шиг. Багштайгаа маргаж, үзэл бодолдоо үнэнч байсан цөөн хэдэн хүүхдийг “ангийн дайсан мэт үзэх” үзэл сургуульд байсаар байна.

“Хочгүй хүүхэд”-ийн эрэлд

Үе тэнгийнхний дундах хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэр нь хочлох, шоолох явдал. Биднээс өмнө, бидний үед болоод өнөөдөр ч хочгүй хүүхэд олох нь өвснөөс зүй хайхын адил юм. Хочилж, шоолох нь харилцааны гажиг төдийгүй хүчирхийлэл гэдгийг хэн ч анзаардаггүй.

Хочлуулсаар байгаад аав, ээжийн хайрласан нэрээр биш элдэв хочоороо нэршчихсэн хүн ч олон байдаг ч хүний сул тал, гажиг согоогоор нь дуудах нь тухайн хүнд таагүй сэтгэгдэл төрүүлж, өөрийгөө бусдаас дорд үзэхэд хүргэдэг муу талтай.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гуравны нэг нь буюу 1361 хүүхэд хочлох, шоолох нь хүчирхийлэл гэж үзжээ. Мөн ахлах ангийнхан болон биеэр том хүүхдүүд мөнгө нэхэх, хувцсаа өгөхийг шаардах зэргээр дарамталдаг гэж хариулсан байх юм.

2.3. ҮГЛЭЖ ЗЭМЛЭХ НЬ ХҮҮХДЭД ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛДГИЙГ ТА МЭДЭХ ҮҮ?

Д. Цээпилмаа

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл. Энэ үгийг сонсоод хүмүүс цочрохоо хэдий нь больжээ. Гудамж талбайд санал солилцсон хүн бүр л ам уралдан ярихаас үзэхэд “хүүхдийн эсрэг хүчирхийлэл”-ийн талаарх ойлголт нилээд түгээмэл болжээ гэж үзэж болох юм. Тэдгээр хүмүүс:

- ядуу дутмаг амьдралтай, архичин эцэг эхчүүд үр хүүхдээ хүчирхийлдэг
- Монголын уламжлалт зан үйл болох өдөржин хонь хариулах, хурдны морь унах зэрэг нь хүчирхийллийн нэг хэлбэр
- багш нар сурагчдаа дарамтлах, хөрөнгө бэлээр ялгаварлах нь хүчирхийлэл гэхчилэн өгүүлж байлаа.

Эндээс нэг зүйлийг анзаарч байна уу? Надтай ярилцагчдаас хэн нь ч би хүүхдээ загнаж зоддог, энэ бол хүчирхийлэл гэж хариулсангүй. Хүүхдийг загнаж зодох нь хүчирхийлэл мөн үү? Хэрэв мөн бол энэ үйлдлээс ангид эцэг, эх тун ховор. Тиймээс бүх аав, ээж хүчирхийлэгч үү? Энэ

тухай цөмөөрөө хэлэлцье. Юун түүрүүн хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж чухам юуг хэлээд байгааг мэргэжилтнүүдээс тодрууллаа.

Өөрийн хүч чадал, эрх мэдэл, давуу талаа ашиглан хүүхдийг эрхшээлдээ байлгах гэсэн хүүхдийн эрхийг зөрчсөн албадлагын шинжтэй аливаа үйлдлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг байна. Энэ тодорхойлолтод бидний хүүхдээ хүмүүжүүлэхдээ түгээмэл хэрэглэдэг аргууд ч багтаж байгааг судалгааны дүнгээс харж болно. Зэмлэх, үглэж загнах, зодох, ажил хийлгэх, гар өргөж зогсоох, хэрэгцээгээр нь гачигдуулах найзуудтайгаа уулзах болон утсаар ярихыг нь хориглох зэргээр аав ээж хүчирхийлдэг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүд хариулжээ. Уншигч та дээр дурдсан үйлдлээс аль нэгийг нь хүүхдээрээ хийлгэж байгаагүй гэж үү? Тэрхүү үйлдлээ та мэдээж хүчирхийлэл гэж огт бодоогүй биз дээ. Тэгвэл яг энэ асуудалд та бүхний анхаарлыг хандуулах гэсэн юм. Бидний хэн маань ч огт анзаарахгүйгээр хүчирхийлэл үйлдэж, хүчирхийлэгч болж явдаг байна. Хүүхдээ алдаа гаргасны нь төлөө, эсвэл өөрийнхөө санаснаар байлгах гэсэндээ, үр хүүхдээ бусдын хүүхдийн адил байлгах гэж, сайн хүн болоосой гэхдээ бид зэмлэдэг, загнадаг гэж томчууд бид биеэ өмгөөлдөг. Зарим маань бид тэгж л өссөн, тэглээ гээд муу хүн болоогүй гэж зөвтгөх нь бий. Би ч тэдний л нэг. Тиймээс ярилцаж суусан мэргэжилтнийхээ өмнөөс “аавдаа шавхуурдуулчихаар хэд хоногтоо л хөл хөнгөн, сэтгэл сэргэлэн явдаг шүү дээ” гээд адраатхав.

- Аав, ээждээ зэмлүүлж, зодуулсан хүүхэд хэсэгтээ дуулгавартай болдог нь үнэн. Гэвч энэ бол хүний амьтанлаг шинжийн илрэл юм. Амьтан ч ялгаагүй яг энэ үйлдлийг хийдэг. Хүн бие махбодын зовиурыг төрөлхийн рефлексээр мэдэрч, дахин гядуулахгүйн тулд сэргэг байдаг. Түүнээс биш ухамсарлан ойлгосон хэрэг огт биш юм гэлээ. Тэгэхээр эртнээс нааш хэлэлцэж заншсан “Алгадуулах аавтай байх сайхан”, “Хүүхэд эцэг, эхдээ зодуулж гэмээнэ барцад нь арилдаг”, “Хүүхэд загнуулж, зодуулж хүн болдог” зэрэг үгсийг, тэдгээр ойлголтыг таягдан хаях цаг нэгэнт болжээ.

Монголчуудын эцэг, өвгөдөөсөө өвлөсөн уламжлалт хандлага үеэс үед улирсаар ирсэн учир томчууд бид “Хүүхдийн эрх”, “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэдэг үгэнд дасаагүй, тэр тухай өөртөө хамаатуулж бодох тун ч дургүй байдаг байна.

Ингэхэд чухам яагаад эцэг эхчүүд хайртай бяцхан үрсээ дарамталж, хүчинд автуулаад байна вэ? Судалгаанд оролцогч томчууд уур хүрсэн үедээ, согтуудаа, буруу хэрэг хийвэл, хичээл таслахад, үгэнд орохгүй бол шийтгэхэд хүрдэг гэжээ. Эндээс хүүхэд буруу хэрэг хийвэл шийтгэх ёстой юу? Шийтгэл хүчирхийлэл хоёрт ялгаа байна уу? гэсэн асуулт урган гарах нь мэдээж.

Хүчирхийлэл, шийтгэл хоёрын ялгааны хувьд эцэг эхчүүдийн 82,2 хувь, багш сурган хүмүүжүүлэгчдийн 92 хувь нь ялгаатай гэсэн хариултыг өгчээ. Гэтэл эцэг, эхчүүдийн 60.7 хувь нь, багш нарын 67 хувь нь хүүхэд байхдаа буруу хэрэг хийснийхээ төлөө зэмлэл, шийтгэл хүлээдэг байсан байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс явуулсан судалгаанд оролцогч хүүхэд, багш, эцэг эхийн аль аль нь, тэр дундаа хүүхдүүдийн 57 хувь нь буруу үйлдэл хийснийх нь төлөө хүүхдэд шийтгэл оногдуулах нь зөв гэж үзжээ.

Харин бодууштай, нэг мөр ойлголтод хүрэх шаардлага зайлшгүй тулгарч буй нэгэн зүйл ажиглагдлаа. Энэ бол хүчирхийлэл шийтгэл хоёрын ялгаа юм. Судалгаанд тусгасан “Хүчирхийлэлд өртөж буй (байсан) хэлбэрүүд”, “Буруу хэрэг хийвэл ямар шийтгэл хүлээдэг вэ?” гэсэн хоёр асуултад хүмүүс яг адилхан хариулт өгсөн байна. Эндээс хүүхэд буруу хэрэг үйлдвэл ухамсарлуулах үүднээс шийтгэх нь зөв, гэхдээ яаж гэсэн асуулт эрхгүй гарч байна.

Монголын үндэсний телевизээр амралтын өдрүүдэд Германы “Тэнгэрлэг нэгэн гэр бүл” гэсэн цуврал кино гараад удаагүй ч томчууд хүүхдүүд зэрэгцээд үзүүштэй киноны нэг болоод байгаа. Кинонд гарч буй гэр бүлд бидний л адил үргэлж “проблем” үүсдэг. Таван хүүхэд нь том жижиггүй л алдаа гаргадаг. Тэглээ гээд аав, ээж хоёр нь хүүхдүүдээ загнаж, зодохгүй байгаа биз дээ. Хүүхдийг загнаж, зодох үйлдлийг эцэг эхчүүд дур сонирхолтойдоо үйлддэггүй нь мэдээж.

Хүүхдээ хүмүүжүүлэх гэсэн тэр үйлдлийнхээ төлөө эцэг эхчүүд өөрсдөө ч давхар яллуулдаг. Хамгийн наад зах нь уурлаж бухаимдсандаа зүрх толгой нь өвдөж, бие нь тавгүйрхдэг. Зодож буй нь ийм байхад зодуулсан хүүхэд ямар байх нь ойлгомжтой. Ингэж давхар давхар “шок”-нд оролгүйгээр асуудлыг шийдэх арга байгааг дээр өгүүлсэн киноноос харж болох билээ. Энэ нь гадаадынхныг дуурайх гэсэн хэрэг биш гэдгийг дурдах нь зүйтэй болов уу!?

Бидний үеийнхэн аав, ээждээ зэмлүүлж, зодуулж өссөн, мөн хүүхдээ зодож зэмлэдэг. Тэгвэл бидний хүүхдүүд яг л энэ замаар явах уу?!

Хүчирхийлэл дарамтад өссөн хүүхэд хүчирхийлэгч болдог гэсэнтэй та санал нийлэх үү гэдэг асуултад судалгаанд хамрагдагчдын 31.3 хувь нь тийм, 17.2 хувь нь магадгүй, үлдсэн 50 гаруй хувь нь үгүй, мэдэхгүй гэж хариулжээ. Эндээс хүчирхийлэл, дарамтад өссөн хүүхэд бүхэн хүчирхийлэл үйлдэгч болох учиргүй, хэдийгээр хүүхэд буруу зан үйлийг орчноосоо суралцдаг ч хүчирхийлэл үйлдэх эсэх нь сонголт юм гэдгийг эцэг, эхчүүд тодорхой хэмжээгээр мэдэрчээ гэж дүгнэж болох юм. Ер нь хүмүүжүүлэх гэж хүч хэрэглэснээс болж хүүхэд өөрийн биеийг хэн ч халдашгүй дархан байх эрхтэй гэдгийг мэдрэлгүй өсдөг. Тийм эрх бий гэдгийг огт мэддэггүй. Тийнхүү өөрийгөө хайрлаж дээдэлж сураагүй хүн бусдыг хайрлаж хүндэтгэх нь юу л бол. Жижигхэн жишээ татъя л даа.

Автобус унаа, гудамж талбайд та хөл дээр гишгүүлэх, түлхүүлэх зэрэг эвгүй үйлдэлд өртөж байсан уу? Хөл дээр чинь гишгэсэн хүн танаас уучлал гуйлгүй гүйгээд явчих нь ч энүүхэнд. Энэ мэт жижиг боловч хүний эрхэнд халдсан явдал олонтаа тохиолддог. Түүнийгээ огтхон ч анзаардаггүй нь бүр ч харамсалтай.

XVIII зууны эхээр Английн эрдэмтэн Жон Локка “хүн бүр хүн болж төрөхдөө л аливаа дарангуйллаас чөлөөтэй байх эрхтэй байдаг” гэж хэлсэн нь бий.

Иймд бүгдээрээ аьд эрдэнэ болсон хүүдийнхээ энэ эрхийг хүндэтгэж, хайр энхрийллээ харамгүй зориулахсан.

Эцэг эхийн хайр гэдэг хүүхдэд юугаар ч сольшгүй эрхэм зүйл билээ. Хайр хэтэрхий ихдэнэ, дуусаад алга болчихно гэж хэзээ ч үгүй билээ. Тиймээс “хайр нь дотроо, хал нь гаднаа” гэх улигт үгийг мартаж байгалиас заяасан гайхамшигт мэдрэмж болох хайраа харамгүй илэрхийлж, үр хүүхдүүддээ түгээж байя. Бидний дотроо хадгалсан хайрыг хүүхдүүд маань нэвт харах биш дээ. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил төдийгүй гэмт хэрэг байдаг гэдгийг ойлгож өнөөдрөөс эхлэн хүүхдээ загнаж зодохоо, хүч хэрэглэн сүрдүүлэхээ боливол ямар вэ?!

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ажилтнууд бараг цөмөөрөө хүүхнүүд. Тэдний олонх нэгээс гурван хүүхэдтэй ээж нар. Би тэднээс та бүхэн өөрсдөө хүүхдээ загнадаггүй юу гэж асуухад “бид бүхнийг өөрсдөөсөө эхлэхийг хичээж байна. Гэр бүлийнхэндээ ойлгуулж байгаа” гэсэн юм. Би ч гэсэн хичээнэ. Уншигч та ч хичээгээрэй.

2.4 ХААЛГА ТОГШИХ, ХОНХ ДУУГАРАХ БҮРИЙД ХҮҮХДҮҮД ОРОН ДООР НУУГДДАГ

Д. Цээпилмаа.

Олон улсын жишгээр 80 мянган хүн тутамд нэг байх шаардлагатай хамгаалах байр Монгол улсын 2 сая 500 мянган хүний дунд цор ганц байгаа нь даан ч чамлалттай юм. Эгэл жирийн иргэдэд бол тийм ч танил биш энэ байрыг зөвхөн хүчинд автсан эмэгтэйчүүд, хүүхдүүд зорин очдог. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд харъяалагддаг, тус төвийн санал санаачлагаар байгуулагдсан хамгаалах байрыг чухам хаана байрладгийг хүмүүс төдийлөн мэддэггүй ч тэр байрыг зорин очигсодын мөр огт тасардаггүй ажээ. Бид зориуд үдшийн цагаар хамгаалах байрыг зорьсон нь учиртай. Хүчинд автсан эмэгтэйчүүд голдуу үр хүүхдүүдээ дагуулан очдог бөгөөд зарим нь 1-3 хүүхэдтэйгээ байрлах нь бий. Хаалга тогших чимээнээр ээлжлэн ирж хэн болохыг лавлах авч хэн ч хаалга онгойлгосонгүй. Хамгаалах байрны ажилтны нэрийг хэлж байж арайхийн нэвтрэв. Тэнд эгээ л цэцэрлэг адил хүүхдүүд шуугин бужигнана. Нялх хүүхдээ хөхүүлэн суугаа ээж ч харагдана. Хүүхдүүд зарим нь хөшигний цаанаас, ганц хоёр нь орон доороос цухалцан биднийг харангуутаа тайвширсан бололтой алгуур гарч ирлээ. Том хүүхдүүд нь хөзөр тоглож харагдана. Хамгийн түрүүнд хамгаалах байрны ажилтан З. Цойнзонтой цөөн мөч хөөрөлдсөн юм. Би энэ байранд 8 дах жилдээ ажиллаж байна. Байгуулагдснаас хойш 900 гаруй эмэгтэй болон тэдний 2000 хүүхдүүдэд тусламж үзүүлж хамгаалсан. Гэр бүлийнхнийхээ хүчирхийлэл, дарамтанд өртөөд амь нас эрүүл мэндэд нь аюул заналхийлсэн мөчид аврал эрсэн бүсгүйчүүд манайд ханддаг юм. Хүүхнүүд маань 1-2 хүүхэдтэй, зарим нь 4-5 хүүхдээ дагуулаад ч ирэх нь бий. Өвлийн хүйтэнд гэрийн халаадтайгаа гүйж ирэх нь энүүхэнд. Хүүхдүүдийн хувьд маш их айдастай, цочролд орчихсон ирнэ. Хаалга тогших, хонх дуугарахад хүртэл давхийн цочих нь ямар өрөвдмөөр харагддаг гэхэв. Уг нь бид 14-өөс доош насны хүүхдийг хамгаалах байрандаа авдаг. Гэвч аргагүй байдлыг харгалзан бүр 18 настай ч авч байгаа. Бүр оюутан охид ч хүчирхийллээс зугатан ирсэн тохиолдол бий.

Амьдралын нөхцөл байдлын хувьд ямар хүмүүс голдуу хүчирхийлэлд өртөж байна вэ?

Амьдрал ахуйн байдал хүчирхийлэлд огт хамаагүй нь харагдаж байна. Ахуйн амьдрал нь хангалуун айлын эзэгтэй ч зодуулчихаад ирдэг. Гарын дүйтэй дархан, хөрөнгө мөнгөтэй бизнесмэн, удирдах ажилтай эрчүүд хүртэл эхнэр хүүхдээ дарамтлан зовоодог. Хичнээн боломжийн амьдралтай ч бүсгүйчүүд маань аюул заналаас зугатан гарахдаа гар хоосон гүйж ирдэг. Танай байранд эрчүүд ирж байв уу? Хүчирхийлэлд өртөөд ирсэн эрчүүд бараг үгүй дээ. Тэгээд ч бид эрчүүдийг хамгаалах байрандаа авдаггүй юм. Нийт хүчинд автагчдын 98 хувь нь эмэгтэйчүүд шүү дээ. Харин буруугаа ойлгон эхнэрээ, хүүдээ авах гэж ирсэн эрчүүд цөөнгүй. Харамсалтай нь тэд хэлсэндээ эс хүрч эхнэр нь манайд дахиад л тусламж гуйн ирдэг. Нэг хүнийг хэдий хэр хугацаагаар хамгаалдаг вэ? Эндээс явсан эмэгтэйчүүд хаана очдог м бол? Энд долоо хоноогоос нэг сарын хугацаанд байрладаг. Энэ хугацаа нь тун богино гэдэг нь ойлгомжтой. Гэвч олон хоног сараар хүчирхийлэлд өртөж бие сэтгэлийн хүнд дарамт авсан хүүхэд, эмэгтэйчүүд тайвширч тайтгаран хүч сэлбэдэг ч асуудлаа шийдвэрлүүлж чаддаггүй. Гэр бүлээ цуцлуулах өргөдөл өглөө ч шүүх шийдвэрлэж амждаггүй. Тиймээс хөөрхийс эргээд хүчирхийллийн орчиндоо

очдог. Тэр даруйдаа биш ч хүчирхийлэл дахин давтагдах талтай. Тэгэхээр хамгаалах байрыг олшруулж нэгдсэн сүлжээтэй болгох зайлшгүй шаардлагатай. Хүмүүс танай хамгаалах байрыг мэдэхгүй юм. Нууцлах шалтгаан байдаг юм уу? Нууцлалгүй яхав. Эхнэр хүүхдээ энд байгааг мэдчихвэл нөхөр нь амар тайван байлгадаггүй. Шөнөжин нэрийг нь дуудаад зогсчих жишээтэй. Харин энд агсан согтуу тавьж чаддаггүй. Цагдаагаас илүү биднээс эмээдэг нь цөөнгүй. Манай байр маш нууцлаг байх ёстой. Тиймээс ч хэд хэд нүүсэн. Хамгаалах байрны тухай Залуус сонин анх мэдээлсэн. Нэг бүтэн сайн өдөр сурвалжлагч бүсгүй нөхөр маань намайг дарамтлаад байна гэсээр ирсэн юм. Уг нь төвийн ажилтнуудаас зөвшөөрөл авах учиртай ч би өрөвдөөд хамгаалах байрандаа авлаа. Бүсгүй хоёр хоноод асуудлаа шийдчихлээ гээд гарсан юм. Гэтэл удалгүй сонинд манай байрны тухай нийтэлсэн байлаа. Тэр үедээ заль хэрэглэсэнд нь гомдож л байсан. Харин одоо талархаж явдаг юм. Бидний ажил үйлс энд ирдэг хүүхнүүдийн амьдрал байдлыг үнэн зөвөөр нийтэлж хүмүүст таниулсанд буруу юу байх вэ дээ. Хамгаалах байрны ажилтан ийн ярьлаа. Найман жилийн турш бусдын зовлонг хуваалцан цаашид амьдрах итгэл, гэрэл гээг бүсгүйчүүдэд бэлэглэгч энэ эмэгтэйн сэтгэлийн тэнхээ, тэвчээрийг гайхсан юм. Уулзсан хүүхэд бүсгүйчүүдийн яриаг доор сийрүүлье.

Баянзүрх дүүргийн иргэн Г.

Энэ амьдрал миний хувьд хоёрдах нь. Харин нөхөр маань урьд нь гэрлэж байгаагүй. Хоёр хүүхэдтэй намайг хүний дайтай аваад явчихна гэж итгэсэндээ ханилсан. Гэтэл гэр бүл болсноосоо хойш таван сарын дараагаас намайг зодох болсон. Архи огт уудаггүй, цоо эрүүл хэрнээ элдэв шалтаг тоочин хүчирхийлдэг. Хамгийн сүүлийн удаа 11 дүгээр сарын 11-нд толгой дээр нь ус хийхдээ халуун ус байсныг нь анзаараагүйгээс зодуулсан. Зарим үед хэнтэй ч хамаагүй хардаж зодно. Автобус тормозлоход нэг залуутай мөргөлдсөний төлөө зодуулсан тохиолдол бий. Энэ бүгдэд би өөрийгөө л буруутгаж хөдөлгөөн үйлдэл болгоноо хянадаг, өөртөө л бурууг тохдог байлаа. Хүчирхийллийн төвд хандсан хойноо хүчирхийлэгчид шалтгаан мунддаггүй юм байна. Миний буруу зүйл хийсэн эсэх нь огт ялгаагүй юм байна гэдгийг ойлголоо. Бага хүүг минь илүүтэй адлаж аавд нь өг гэж шахаж шаарддаг.

Баянгол дүүргийн иргэн Ө.

Бид аав, ээжээс гурвуулаа. Отгон дүү бид хоёр эмэгтэй, дундах нь хүү. Аав, ээж хоёр эрэгтэй дүүг хоёр охиноосоо илүү хайрлаж өсгөсөн. Дутуу хомсын зовлонг бид мэдэхгүй өссөн. Гэвч нэг л мэдэхнээ нас биед хүрч би хүүхдээ төрүүлсэн. Хань бүлгүй тул аавын гэрээс өрх тусгаарлаагүй. Тун удалгүй дүү нар маань эрийн цээнд хүрсэн. Тэр үеэс бидний аж жаргалтай үе дурсамж болон үлдэж бид биеэ ад үзэх болсон. Хөөрхий хоёр хөгшин хэнийг ч гэх билээ. Энэ байдлыг ойлгосон эрэгтэй дүү бүхнийг өөрийнхөө атганд оруулж дураараа дургиж эхэлсэн. Хүү бид хоёрыг ад үзэж хүүг маань байнга дарамтална. Арга ядаж хамгаалах байранд ирсэн билээ. Хойшдоо хэрхэгийг мэдэхгүй байна. Хүүхдийн хичээл сургууль хэцүүдлээ. Ямартай ч өөрөө ажил хийе, хүүгээ өөр сургуульд шилжүүлэе гэж бодож байв. Надад хүний эрхийн үндэсний төвийнхэн тусална гэсэн. Биднийг ярилцаж суутал гаднаас хижээл насны авгай 18 насны охинтойгоо ирлээ. Тэд айж цочирдсноос дагжин чичэрж үг хэлэх ч сөхөөгүй байлаа. Харин хамгаалах байр их тохилог юм. Хүүхдийн тоглоомын өрөөтэй, унтлагын өрөө нь айлын гэрээс ялгаагүй тохь тухтай, багтаамжыг нь бодсноос тэрүү орыг давхарлан тавьжээ. Хүүхэд, багчууд хань ижлээ хөөж явуулсан эрчүүд хамгаалах байрыг эрж хайж явсаар давхар ор, төмрөөр бэхэлсэн цонх, өдөр шөнөгүй татаастай хөшгөөр нь таньж ирдэг гэнэ. Тэд голдуу хүүхдээрээ түрий барьдагаас, хүүхдүүд нар салхинд ч гарах эрхгүй болдогийн дээр сургууль, цэцэрлэг нь завсардаж хохирдог байна. Эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болдог бол хүүхдүүд золиос болдог юм уу гэсэн бодол эрхгүй төрснөө нуух юун. Биднийг очих үед есөн ээж арван зургаан хүүхэд хамгаалах байранд байлаа. Хамгийн бага нь ой хагастай, том нь 16-18 насныхан. Тэд аав ахдаа байгаа газраа мэдэгдэхгүйн тулд аргагүйн эрхэнд хичээлээ тасалжээ. Хүүхэд өөрийн төрж өссөн гэртээ хамгийн тухтай, сэтгэл тэнүүн байх нь мэдээж. Гэр оронд нь хэрүүл зодоонтой, байнгын түгшүүртэй байдгаас хүүхдийн амгалан тайван орчинд өсөж хүмүүжих эрх нь зөрчигдөж эхэлдэг. Хүчинд автсан ээж нь хүүхдээ дагуулан аав ээж, ах дүүс, найз нөхдийнхөөрөө хэсүүчлэн тэнүүчилж, наашаа гэх хүнгүй болсон үедээ л хүчирхийллийн эсрэг төвд ханддаг. Энэ үеэс хүүхэд гэр орноосоо хөндийрөн дайжихийн эхлэл тавигддаг гэж мэргэжилтнүүд үзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөснөөс болж олон хүүхэд сургууль завсардах, дасч сурсан орчин, найз нөхдөөсөө хөндийрөн өөр сургуульд шилжих зэргээр хохирол амсч байна. Бие сэтгэлдээ хэзээ ч марташгүй гүн шархтай үлдэж байна.

Хамгаалах байранд очсон бяцхан хүү ярихдаа:

Би ганцхан ээждээ л хайртай. Яагаад гэвэл аав миний ээжийн нүүрийг гурвалжин болтол нь (хавдар үүсч гэмтэснийг хэлэв бололтой) цохьсон. Би том болоод аав болохгүй. Болсон ч хүүхдээ, хүүхдийнхээ ээжийг зоддог хүн болохгүй гэсэн юм.

Харин 13 настай М охин:

Хамгаалах байранд байгаадаа ангийхнаасаа ичиж байна. Манай аав ээж хоёр шиг хэрэлдэж мууддаг хүмүүс цөөн байх аа. Манай найз охиных зөндөө олуулаа. Гэхдээ аав ээж хоёр нь огтхон ч муудалцдаггүй. Гэтэл би айлын ганц охин хэрнээ хэн хэнийх нь охин биш юм шиг “чиний хүүхэд чамайг дуурайсан” гэж хэрэлдэхэд нь их гомддог. Гэхдээ ээждээ арай бага гомддог. Уурлахаараа ээжийг зоддог нь бүр их гомддог. Хүчинд автсан хүүхдүүдийн санаа сэтгэл хямралд орж эцэг эхийнхээ хэнийг өмгөөлөх хайрлахаа мэдэхгүй тээнэглээхэд хүрдэг нь дээрх ярианаас харагдана. Хэдийгээр аавдаа гомддог, хайргүй гэж ярьж байгаа ч элэг нь эцгээ гэдэг л юм байна лээ. Эндээс л хүүхэд эвдэрч эхэлдэг. Одоогоос сар гаруйн өмнө 16 настай охин ганцаараа уйлж иржээ. Учрыг лавлатал охины ээж цайны ханьтай болоод удаагүй бөгөөд ээж нь охиноо урьдийн адил хайрлахгүй байх шиг санагдаж гоморхох болжээ. Ээжийнхээ хайрыг хэнтэй ч хуваалцахыг хүсээгүй охиноо ээж нь ойлгоогүйгээс зөрчил үүсч охин Хүний эрхийн үндэсний төвд хандсан нь энэ билээ. Энэ мэтчлэн томчуулын зовлон, жаргалын золиосонд хүүхдүүд өртөж хүчирхийллийн буруутан нь өөрийгөө гэж ойлгосноос хүүхэд хүчгүй, сул дорой өөрийгөө бусдаас дорд үздэг, ирээдүйдээ итгэлгүй хүн болон төлөвшдөг ажээ. Сэтгэлийн хат суугаагүй ийм хүн өрх гэрээ, улс орноо хэрхэн авч явах нь тодорхойгүй билээ. Хамгаалах байрны хананд Америкийн Нэгдсэн Улсын далбай, төрийн нарийн бичгийн даргын хатагтай Мадлен Олбрайтын зураг хадаастай байх нь нүдэнд туслаа. Хатагтай Мадлен М. Олбрайт Хүний эрхийн үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцаж хамгаалах байр байгуулах саналыг дэмжин туслахаа амлажээ. Удалгүй Америкийн Нэгдсэн Улсын Монгол дах элчин сайдын яамнаас байр худалдан авах хөрөнгийг гарган өгсөн байна. Хамгаалах байр хэд хэдэн удаа бууриа сэлгэн нүүдэлжээ. Нууцлаг байдлаа алдаж хүмүүс мэддэг болмогц дахин шинэ байр луу нүүдэлдэг нь эднийхний нэг онцлог. Гэр бүл хүчирхийлэл гэдэг нэр томъёо саяхнаас дэлгэрсэн мэт, Хүний эрхийн үндэсний төв бий болсноор л хүчирхийллийн тухай ярих болсон мэтээр ойлгодог хүмүүс мэр сэр байдаг. Гэвч бидний багад ч согтсон, хөлчүүрхсэн үедээ авгай, хүүхдээ айлгаж ичээдэг хүмүүс байсан. Аав маань 26 жил цагдаа явсан хүн. Миний ухаан орох үеэс тэтгэвэртэй гарсан хэдий ч хамар хашаа, гудамжныхан маань аюул учрахад аавыг дууддаг байсансан. Олонх нь гэр бүлийн маргаан, авгай хүүхэддээ дээрэлхэж айлгасан хэрэг байдаг байж. Тэр үед одоог бодоход цаг хатуу байснаас ч тэр үү хүчирхийллийн талаар нийтлэг ойлголтгүй байсан болов уу гэж боддог юм. Авгай хүүхэддээ хайртайдаа биш гэхнээ намаас хөөгдөх, ажлаасаа гарахаасаа айдаг хамт ажиллагсаасаа ичдэг байсан биз ээ. Өнөөдөр эрчүүдийн олонх нь ажилгүй, ажилтай байлаа ч ар гэрийн амьдрал ахуй сонин биш болсноос хүчирхийлэл илүү газар авсан санагдана.

Хүчирхийллийн орчинд өссөн хүүхдүүдийн 29.7 хувь нь сэтгэл санааны хувьд гутранги, 10.1 хувь нь хичээлдээ сонирхолгүй болсон, 8.7 хувь нь тэнэмэл зам руу орсон, 8 хувь нь эрүүл мэндээрээ хохирсон, 6.9 хувь нь сургууль завсардсан байдаг ажээ.

Зөвхөн эмэгтэйчүүдийг төдийгүй хүүхдүүдийг хүнд байдалд оруулж буй хүчирхийлэл газар авсаар атал хүчирхийллийн эсрэг хийж буй дорвитой ажил хомс, тэр чиглэлээр дагнасан төрийн байгууллага ч алга. Ганц ХЭҮТ хаанаа ч хүрэлцэхгүй нь ойлгомжтой юм. Хамгаалах байр л гэхэд улсад цор ганц байна. ХЭҮТ 10 салбартай ч хөрөнгө мөнгөний хомсоос хамгаалах байрыг нэмэгдүүлж чадахгүй байгаа юм. Ганц байгаа хамгаалах байр нь “гал унтраах” төдий үүрэг гүйцэтгэдэг ч хойшид өргөжүүлэх, тоог нь олшруулан нэг сүлжээнд холбох зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Нэг удаа 20 хүн байрлуулахаар тохижуулсан ч өнөөдрийн байдлаар 25 хүнтэй байна. Заримд нь ор хүрэлцэхгүйгээс эвхдэг ор болон газраар гудас дэвсэн унтдаг ч хүн сэтгэл тайван орчинг хамгаас эрхэмд үздэг нь ажиглагдсан юм. 2002 оноос Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Яамнаас эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 3 сая төгрөгийг тус төвд хандивлажээ. Тэр мөнгийг хамгаалуулагчдынхаа хоол хүнс, ая тухтай байлгах үйлчилгээнд зарцуулсан байна. Ирэх онд хандивын хэмжээг 5 саяд хүргэх тухай таатай мэдээг саяхан сонсчээ.

Олон улсын Энэрлийн байгууллага 1.6 сая төгрөгийн хөрөнгө гарган хамгаалах байрыг тохижуулж өгсөн байна. Түүнчлэн япон, солонгосчууд тусламжийн гараа харамгүй сунгадаг ажээ.

Саяхан японы нэг иргэнээс тусламжийн хувцас, хүнс иржээ. 8.3 сая хүн амтай Швед улсад байнгын ажиллагаатай 150 хамгаалах байр байдаг гээд бодохоор манай улсад хамгаалах байрыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг улам өргөжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.